

0000001

СЭХ
2021.09.26 өдөр
БҮРТГЭВ
№ 01



ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

2021 он

Тэргүүлэх
андеррайтер:

 **Бидисек ҮЦК ХК**
андеррайтер, Брокер, Хөрөнгө оруулалтын зөвлөх

Дэд андеррайтер,
санхүүгийн зөвлөх

 **MICC**
андеррайтер, Брокер, Хөрөнгө оруулалтын зөвлөх

© 2021 Энэтхэгний Хөрөнгө оруулалтын зөвлөл



ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД

Эрдэнэс-Таван Толгой Хаалттай ХК (цаашид "Үнэт цаас гаргагч" гэх) нь Монгол Улсын "Компанийн тухай хууль", "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль" болон Монгол Улсын Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн холбогдох журмуудын дагуу 20,000,000 хүртэл ширхэг бүхий нийт 2 их наяд төгрөг хүртэл үнийн дүн бүхий өрийн хэрэгслийг гарган нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгүүлэн, Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан нийтэд санал болгон нээлттэй арилжихаар хүсэлт гаргаж байгаа болно.

Энэхүү танилцуулгыг бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн ба холбогдох дүрэм, журмаар шаардагдах мэдээллүүдийг бүрэн агуулахыг зорьсон болно.

Танилцуулгад тусгагдсан ирээдүйн төсөөлөл, тооцоолол нь Үнэт цаас гаргагчийн итгэл үнэмшил дээр тулгуурласан бөгөөд санаатайгаар ямар нэгэн мэдээллийг орхигдуулаагүй болно. Үнэт цаас цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнууд нь танилцуулгад тусгагдсан мэдээлэл нь үнэн зөв, бүрэн гүйцэд бөгөөд хуурамчаар бүрдүүлсэн ямар нэгэн баримт байхгүй гэдгийг баталж байна.

"ҮНЭТ ЦААСЫГ МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ БҮРТГЭСЭН НЬ УГ ҮНЭТ ЦААСНЫ ЭРСДЭЛИЙН ТАЛААР АЛИВАА БАТАЛГАА ГАРГААГҮЙ БОЛОХЫГ АНХААРАХ НЬ ЗҮЙТЭЙ. ЭНЭХҮҮ ҮНЭТ ЦААСЫГ ХУДАЛДАН АВАХ ЗАМААР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ТАНЫ ХУВЬД ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ ҮЙЛДЭЛ БАЙДГИЙГ ОНЦГОЙЛОН АНХААРЧ, ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА, ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААГ САЙТАР АНХААРАН СУДАЛСНЫ ҮНДСЭН ДЭЭР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЙДВЭРЭЭ ГАРГАХЫГ ЗӨВЛӨЖ БАЙНА"


Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан мэдээллээс илүү дэлгэрэнгүй, нэмэлт мэдээлэл шаардлагатай болох, лавлаж тодруулах асуудал байвал Үнэт цаас гаргагч Эрдэнэс-Тавантолгой ХК болон Андеррайтер БиДиСЕК ҮЦК ХК, дэд андеррайтер, санхүүгийн зөвлөх Эм Ай Си Си ҮЦК ХХК-д хандаж тодруулна уу.

2021.03.30





0000003



ҮНЭТ ЦААСНЫ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Эрдэнэс-Тавантолгой ХК нь Компанийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1, 41.2 дахь заалт, 42 дугаар зүйлийн 42.1, 42.4 дүгээр заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх заалт Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2021 оны 02 сарын 02-ны өдрийн 03 тоот тогтоолыг үндэслэн нийт 2,000,000,000,000 /2 их наяд/ төгрөг хүртэлх үнийн дүн бүхий 20,000,000 ширхэг хүртэлх ерийн хэрэгслийг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгүүлэн Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан нийтэд санал болгон нээлттэй арилжихаар хүсэлт гаргаж байгаа болно.

Үнэт цаас гаргагч	"Эрдэнэс-Тавантолгой" Хаалттай ХК
Үнэт цаасны төрөл	Өрийн хэрэгсэл
Үнэт цаасны арилжаа	Нийтэд нээлттэй санал болгох
Нэгжийн нэрлэсэн үнэ	Төгрөгийн бонд: 100,000 төгрөг Долларын бонд: 100 доллар
Нийт тоо ширхэг	20,000,000 ширхэг хүртэлх
Нийт үнийн дүн /хүртэлх/	2,000,000,000,000 төгрөг хүртэлх /төгрөг, ам.доллар хосолсон/
Жилийн хүү	Төгрөг: 10% Ам.доллар: 6.8%
Хүү төлөх хугацаа	Хагас жил тутам
Хугацаа	24-36 сар
Эргүүлэн авах нөхцөл	Хугацаанаас өмнө эргэн дуудах нөхцөлтэй
Үндсэн болон хүүгийн төлбөрийн хугацаа хэтрэлт	Хүү төлөх өдрөөс хугацаа хэтэрсэн хоног тутамд хүүгийн төлбөрөөс 0.02%-р алданги нэмж тооцон хүүг алдангийн хамт Үнэт цаас эзэмшигчид төлнө
Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт	Бүтээн байгуулалтын төслүүдийг санхүүжүүлэх
Баталгаа	Борлуулалтын орлого
Арилжаалах зах зээл	Монголын хөрөнгийн бирж ТӨХК
Хадгаламж, бүртгэл төлбөр тооцоо	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК
Андеррайтер	Тэргүүлэх андеррайтер: БиДиСЕК ҮЦК ХК

2021.03.26





Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Улсын бүртгэлийн мэдээлэл	15
Хүснэгт 2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлт	16
Хүснэгт 3. Гаргасан хувьцааны бүтэц	17
Хүснэгт 4. Үнэт цаас гаргагчийн охин компаниуд	18
Хүснэгт 5. Тусгай зөвшөөрлийн мэдээлэл	24
Хүснэгт 6. Ордуудын геологийн нөөцийн мэдээлэл	27
Хүснэгт 7. Уурхайн ашиглалтын хугацаа	29
Хүснэгт 8. Цанхийн баруун, зүүн уурхайн нүүрсний чанар	33
Хүснэгт 9. Цанхийн баруун, зүүн уурхайн нөөц /JORC стандарт/	34
Хүснэгт 10. Цанхийн баруун, зүүн уурхайн нөөц /NI 43-101 стандарт/	36
Хүснэгт 11. Нийт борлуулалт худалдан авагч компаниудаар 2016-2018	44
Хүснэгт 12. Нүүрсний чанарын мэдээлэл	46
Хүснэгт 13. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд	55
Хүснэгт 14. ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны бүрэлдэхүүн	57
Хүснэгт 15. ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хорооны бүрэлдэхүүн	58
Хүснэгт 16. ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хорооны бүрэлдэхүүн	59
Хүснэгт 17. Гүйцэтгэх удирдлагад тавигдах шаардлага	61
Хүснэгт 18. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн мэдээлэл	62
Хүснэгт 19. Бусад эрх бүхий албан тушаалтны мэдээлэл	66
Хүснэгт 20. Үнэт цаас хариуцах, биржтэй харилцах этгээдийн танилцуулга	68
Хүснэгт 21. Компанийн засаглалын зарчмууд, хэрэгжүүлж буй байдал	71
Хүснэгт 22. Нийгмийн хариуцлагын хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлууд	74
Хүснэгт 23. Үнэт цаас гаргагчийн өөрийн хөрөнгө	80
Хүснэгт 24. Үнэт цаас гаргагчийн эргэлтийн бус хөрөнгө	80
Хүснэгт 25. Санхүүгийн байдлын тайлан	81
Хүснэгт 26. Орлогын дэлгэрэнгүй тайлан	82
Хүснэгт 27. Мөнгөн гүйлгээний тайлан	82
Хүснэгт 28. Өмчийн өөрчлөлтийн тайлан	84
Хүснэгт 29. Хөрвөх чадварын шинжилгээ	85
Хүснэгт 30. Үйл ажиллагааны үр ашигт байдлын шинжилгээ	86
Хүснэгт 31. Өр төлбөр, санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээ	86
Хүснэгт 32. Ашигт ажиллагааны шинжилгээ	86
Хүснэгт 33. 2019 оны аудитын дүгнэлтийн хураангуй	88
Хүснэгт 34. 2018 оны аудитын дүгнэлтийн хураангуй	88
Хүснэгт 35. 2017 оны аудитын дүгнэлтийн хураангуй	89
Хүснэгт 36. Дэлхийн коксжих нүүрсний эрэлт, нийлүүлэлт, балансын таамаглал (сая тонн)	91
Хүснэгт 37. Дэлхийн эрчим хүчний нүүрсний эрэлт, нийлүүлэлт, балансын таамаглал (сая тонн)	92
Хүснэгт 38. Жишиг үнийн сонголт	106
Хүснэгт 39. Нүүрсний үнийн төсөөлөл (ам.доллар/тн)	107
Хүснэгт 40. PEST шинжилгээ	108
Хүснэгт 41. SWOT шинжилгээ	109
Хүснэгт 42. Дэлхийн коксжих нүүрсний худалдаа (сая тонн)	114
Хүснэгт 43. БНХАУ-ын коксжих нүүрсний импорт (сая тонн)	114
Хүснэгт 44. Азид коксжих нүүрсний олборлолтын хэмжээгээр тэргүүлдэг компаниуд	115
Хүснэгт 45. Авто замын төслүүдийн ерөнхий мэдээлэл	120
Хүснэгт 46. Нүүрсний үнийн төсөөлөл, ам.доллар/тн (FCA Уурхай ам)	122
Хүснэгт 47. Нүүрсний үнийн төсөөлөл, ам.доллар/тн (DAP Ганцмод)	122




2021.03.19



Хүснэгт 48. Үнэт цаас гаргагчийн 2021-2025 оны орлого, ашгийн төлөвлөгөө	127
Хүснэгт 49. Норвест, Жохарко харьцуулалт 1	129
Хүснэгт 50. Норвест, Жохарко харьцуулалт 2	129
Хүснэгт 51. Норвест, Жохарко харьцуулалт 3	130
Хүснэгт 52. Норвест, Жохарко харьцуулалт 4	130
Хүснэгт 53. Уулын ажлын хэмжээ олборлолтын жилүүдээр	132
Хүснэгт 54. Уулын ажлын хэмжээ олборлолтын жилүүдээр	132
Хүснэгт 55. НБҮ-ээс гарах бүтээгдэхүүнүүд түүний эх үүсвэр	132
Хүснэгт 56. Хөрөнгө оруулалтын зарцуулалт	134
Хүснэгт 57. Өөрийн хөрөнгөөр болон зээлээр хийх санхүүжилтийн тооцоо	134
Хүснэгт 58. Нэгж бүтээгдэхүүнд ногдох шууд зардлын задаргаа /үйлдвэрлэлийн дамжлагаар/	134
Хүснэгт 59. Өнөөгийн мөнгөний үнэ цэнийн тооцоо	135
Хүснэгт 60. Уулын ажлын хэмжээ олборлолтын жилүүдээр	137
Хүснэгт 61. Хуурай аргын үйлдвэрлэлийн мэдээлэл	138
Хүснэгт 62. Нойтон аргын үйлдвэрлэлийн мэдээлэл	138
Хүснэгт 63. Эрсдэлийн удирдлагын зохион байгуулалт	143
Хүснэгт 64. Мөнгө шилжүүлэх заавар	152
Хүснэгт 65. Зарцуулалтын дэлгэрэнгүй задаргаа	154
Хүснэгт 66. Тэргүүн ээлжинд санхүүжүүлэх төслүүд	155
Хүснэгт 67. Төмөр замын төслүүдийн хэрэгжилтийн явц	157
Хүснэгт 68. 2021-2024 оны орлого ашгийн төлөвлөгөө /сая ам.доллар/	157
Хүснэгт 69. 2021-2024 оны бондын эргэн төлөлтийн төлөвлөгөө /сая ам.доллар/	157
Хүснэгт 70. Нүүрс борлуулалт, экспортын төрөл	158
Хүснэгт 71. Тэргүүлэх андеррайтер компанийн мэдээлэл	159
Хүснэгт 72. Эм Ай Си Си ҮЦК ХХК-ийн товч мэдээлэл	161
Хүснэгт 73. Үнэлгээний компанийн мэдээлэл	163
Хүснэгт 74.Хорогдуулсан мөнгөн урсгалын загвараар тооцсон үнэлгээний үр дүн	167
Хүснэгт 75.Хяналтын нэмэгдэлийн тохируулгын дараах нэгж хувьцааны үнэ	169
Хүснэгт 76. Хуулийн компанийн мэдээлэл	170
Хүснэгт 77. Хуулийн компанийн тусгай зөвшөөрөл	171
Хүснэгт 78. Хуулийн компанийн хуульчдын тусгай зөвшөөрөл	171
Хүснэгт 79. Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц	173
Хүснэгт 80. Улсын бүртгэлийн байгууллагад бүртгэгдсэн хувьцаа эзэмшигчдийн бүтэц	175
Хүснэгт 81. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад бүртгэгдсэн хувьцаа эзэмшигчдийн бүтэц	175
Хүснэгт 82. Эрх бүхий албан тушаалтнууд нь шаардлага хангаж буй эсэх тухай	179
Хүснэгт 83. Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн эзэмшиж буй хувьцаа, хөрөнгө оруулалтын задаргаа	189

2021.03.26





Графикийн жагсаалт

График 1. Ордуудын нөөц, нүүрсний ангиллаар	27
График 2. Ордын нөөц, зэрэглэлээр	28
График 3. Цанхийн уурхайн хөрс хуулалт, сая.мЗ.....	39
График 4. Цанхийн уурхайн олборлолт, борлуулалт сая.тн.....	40
График 5. Цанхийн уурхайн борлуулалт тэр.төг.....	41
График 6. Борлуулалтын бүтэц, бүтээгдэхүүнээр 2017-2020Q3.....	42
График 7. Борлуулалтын бүтэц, ордоор 2017-2020Q3.....	42
График 8. Экспортод эзлэх хувь.....	43
График 9. Цанхийн зүүн уурхайн борлуулалтад Чалко компанийн эзлэх хувь.....	44
График 10. Тээврийн компани болон рэйсийн тоо	45
График 11. Улс, орон нутагт төлсөн татвар, хураамж.....	47
График 12. Худалдан авалт, 2017-2019.....	48
График 13. Дотоодын худалдан авалт.....	48
График 14. Нүүрсний үнийн төсөөлөл – Ex-Stock Ганцмод үнэ (ам.доллар/тн).....	107
График 15. Олборлолтын зардлын хэмнэлт жил бүрээр (сая ам.доллар).....	117
График 16. 2021-2025 оны төлөвлөгөө /сая ам.доллар/	127

2021.03.19





Зураг 1. Тавантолгой ордын байршил 22

Зураг 2. Тавантолгой бүлэг ордын ордуудын байршил, тусгай зөвшөөрөл 24

Зураг 3. Цанхийн хэсгийн нүүрсний давхраасуудын тогтоц 31

Зураг 4. Тавантолгой бүлэг ордод хийгдсэн хайгуулын ажил, цаашдын төлөвлөгөө 38

Зураг 5. Борлуулалт-тээвэрлэлтийн схем 43

Зураг 6. 2015-2050 оны коксжих нүүрсний эрэлт (сая тонн) 91

Зураг 7. 2015-2050 оны коксжих нүүрсний эрэлт, улсаар (хувь) 91

Зураг 8. 2015-2050 оны эрчим хүчний нүүрсний эрэлт (сая тонн) 92

Зураг 9. 2015-2050 оны эрчим хүчний нүүрсний эрэлт, улсаар (хувь) 92

Зураг 10. БНХАУ-ын түүхий нүүрсний нийт олборлолт (сая тонн, %) БНХАУ-ын түүхий нүүрсний нийт олборлолт (сая тонн, %) 93

Зураг 12. Коксжих нүүрсний эрэлт (сая тонн) 94

Зураг 11. Коксжих нүүрсний нийлүүлэлт (сая тонн) 94

Зураг 13. Эрчим хүчний нүүрсний нийлүүлэлт (сая тонн) 94

Зураг 14. Эрчим хүчний нүүрсний эрэлт (сая тонн) 94

Зураг 15. БНХАУ-ын нүүрсний импорт ба экспорт (сая тонн) 95

Зураг 16. БНХАУ-ын коксжих нүүрсний импорт ба экспорт (сая тонн) 96

Зураг 17. БНХАУ-ын эрчим хүчний нүүрсний импорт ба экспорт (сая тонн) 97

Зураг 18. Япон Улсын 2015 болон 2019 он нүүрсний импорт (сая тонн) 97

Зураг 19. Япон улсын коксжих болон эрчим хүчний нүүрсний импорт 98

Зураг 20. Япон улсын нүүрсний импортын таамаглал (сая тонн) 98

Зураг 21. БНСУ-ын нүүрсний импортын бүтэц (сая тонн) 99

Зураг 22. БНСУ-ын коксжих болон эрчим хүчний импорт (сая тонн) 99

Зураг 23. БНСУ-ын нүүрсний импортын таамаглал (сая тонн) 100

Зураг 24. БНЭУ-ын нүүрсний эрэлт, төрлөөр (сая тонн) 100

Зураг 25. БНЭУ-ын нүүрсний импорт, төрлөөр (сая тонн) 101

Зураг 26. Дэлхийн улсуудын нүүрсний хэрэглээ (сая тонн) 101

Зураг 27. Монголын нүүрсний олборлолт (сая тонн), олборлолтын өсөлтийн хувь 102

Зураг 28. Монголын нүүрсний олборлолт (сая тонн) 102

Зураг 29. Монгол Улсын нүүрсний олборлолт (сая тонн) 103

Зураг 30. Коксжих болон эрчим хүчний зориулалттай нүүрсний жишиг үнэ (юань/тн) 106

Зураг 31. Нүүрс ачилтын байгууламжийн бункер, конвейер 116

Зураг 32. Мөчлөг урсгалт конвейерийн систем 117

Зураг 33. Төслийн талбайн ерөнхий төлөвлөлт 118

Зураг 34. Тавантолгой цахилгаан станцын 3D төлөвлөлт 121

Зураг 35. Кокс-эрчим хүчний үйлдвэрийн загвар зураг 122

Зураг 36. Үнийн таамаглалын хэлбэлзэл 123

Зураг 37. Дунд хугацааны борлуулалтын төлөвлөгөө (сая.тн) 123

Зураг 38. Борлуулалтын гэрээний төрөл 124

Зураг 39. Дунд хугацааны нүүрс борлуулалт, экспортын төрөл 125


Зураг 40. Нийт борлуулалтын орлогын задаргаа 126

Зураг 41. Бондыг анхдагч зах зээлд байршуулах явц 152

Зураг 42. Бонд захиалах заавар 152

2.0 2.0.30.4





Схемийн жагсаалт

Схем 1. Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн товч танилцуулга.....	14
Схем 2. Хувьцаа эзэмшлийн бүтэц	17
Схем 3. Зорилго, зорилт, үнэт зүйлс.....	20
Схем 4. Үнэт цаас гаргагчийн түүхэн замнал.....	21
Схем 5. Бүтээгдэхүүний нэр, төрөл.....	46
Схем 6. Бүтээгдэхүүний үнэ тогтох процесс.....	47
Схем 8. Компанийн хүний нөөцийн мэдээлэл.....	69
Схем 8. Компанийн засаглалыг хэрэгжүүлэх чиглэлүүд	71
Схем 9. Зүүн Цанхийн уурхайг ашиглах стратеги.....	131
Схем 10. Баруун Цанхийн уурхайг ашиглах стратеги	137
Схем 11. Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх алхмууд.....	145
Схем 13. Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт	153

2021.03.20 10:30.9





Товчилсон үгийн тайлбар


ХК	Хувьцаат компани
ҮЦК	Үнэт цаасны компани
JORC	Joint Ore Reserves Committee
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үнэлгээ
УИХ	Улсын их хурал
ЗГ	Засгийн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ААН	Аж ахуйн нэгж
IPO	Initial Public Offering/Олон нийтэд хувьцаагаа анх удаа санал болгох
ЭМД	Эрүүл мэндийн даатгал
ТТ брэнд	Таван толгой брэнд
ЗХУ	Зөвлөлт холбоот улс
ЭБМЗ	Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл
CRM	Customer risk management/Эрсдэлийн удирдлага
ISO	International organisation for standardization
ХАБЗА	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
FCA	Free Carrier/Уурхайн амнаас борлуулах үнийн бодлого
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
MNS	Mongolian Standard/Монголын стандарт
ХЭХ	Хувьцаа эзэмшигчдийн хурал
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
КТХ	Компанийн тухай хууль
СХД	Сонгинохайрхан дүүрэг
ЗДТГ	Засаг даргын тамгийн газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаа компани
ЭША	Эрдэм шинжилгээний ажил
ЗТХЯ	Зам, тээврийн хөгжлийн яам
МҮХАҮТ	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн тэнхим
МУБИС	Монгол Улсын Боловсролын Их Сургууль
МУИС	Монгол Улсын Их Сургууль
МАН	Монгол ардын яам
НИТХ	Нийтийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БГДИТХ	Баянгол дүүргийн иргэдийн төлөөлөгчийн хурал
ТАВАН ШУТИС	Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль
ЭРСЭНЭС ТАВАНТОЛГОЙ ХК	Хууль зүй, дотоод хэргийн яам
Олон Улсын Харилцааны Дээд Сургууль	Олон Улсын Харилцааны Дээд Сургууль

2021.05.13





0000010



СЭЗИС	Санхүү Эдийн Засгийн Их Сургууль
ЭЗХАХБ	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ҮЦТХТ	Үнэт цаас төвлөрсөн хадгаламжийн төв ХХК
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
НББ	Нягтлан бодох бүртгэл
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
OECD	The Organisation for Economic Co-operation and Development/Эдийн засаг хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага
ОУВС	Олон улсын валютын сан
ХКН	Хятадын коммунист нам
HSBC	Hongkong and Shanghai Banking Corporation
WEO	World economic outlook/Дэлхийн эдийн засгийн төлөв байдал
PCI	Pulverized coal injection
ТТ-ГС	Тавантолгой-Гашуунсухайт
ТТ-ЗБ	Тавантолгой-Зүүнбаян
МХБ	Монголын хөрөнгийн бирж
УИХ	Улсын их хурал
DAP	Delivered at Place
ROA	Нийт хөрөнгийн өгөөж
ROE	Нийт өмчийн өгөөж
MRC	Mongolian Resource Classification
ААНҮЦ	Аж ахуй нэгжийн үнэ цэнэ
ХТЭХӨА	Хүү, татвар, элэгдэл, хорогдуулгын өмнөх ашиг
ХТӨА	Хүү, татварын өмнөх ашиг
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
СЯ	Сангийн яам

20210304





0000011

**ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛПАГААНД ОРОЛЦСОН ЭТГЭЭДИЙН МЭДЭЭЛЭЛ****Тэргүүлэх
андеррайтер****БидиСЕК ҮЦК ХК**

Хаяг: "БидиСЕК ҮЦК" ХК-ийн байр, Залуучуудын өргөн чөлөө 27/1, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, Монгол улс

Утас: (976) 7555-1919

Вэбсайт: www.bdsec.mn

**Дэд андеррайтер,
санхүүгийн зөвлөх****Эм Ай Си Си ҮЦК ХХК**

Хаяг: Улаанбаатар 15170, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Явуухулангийн цэцэрлэг, JJ Тауэр, 7-р давхар

Утас: (976) 7011-2023

Вэбсайт: micc.mn

Хуулийн зөвлөх**Өмгөөллийн Батбаяр Энд Партерс ХХК**

Хаяг: 10-р давхар, 1001-1003 тоот, Монгол ТВ цамхаг, 14253 Чингисийн өргөн чөлөө-8, 1-р хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс

Утас: + 976 7611 9007

Вэбсайт: www.bnp.mn

Хараат бүс үнэлгээ**Бдо Аудит ХХК**

Хаяг: 1502 тоот, 15-р давхар, Юнион Бюлдинг В-Блок, Нарны зам-62, 1-р хороо, ЮНЕСКО-гийн гудамж, СБД, Улаанбаатар хот, Монгол улс

Утас: (976) 7740-4040, 7740-4041

Вэбсайт: www.bdo.mn

Аудит

ҮНДЭСНИЙ АУДИТЫН
ГАЗАР

Үндэсний аудитын газар ТБАГ

Хаяг: Засгийн газрын IV байр, Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар-15160, Монгол Улс

Утас: 51-263813

Вэбсайт: <https://audit.mn/>



2021.03.26

АГУУЛГА

НЭГ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ.....	14
1.1. Үнэт цаас гаргагчийн товч танилцуулга.....	14
1.2. Үнэт цаас гаргагчийн хуулийн этгээдийн улсын бүртгэл.....	15
1.3. Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгө.....	16
1.4. Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшлийн бүтэц.....	16
1.5. Үнэт цаас гаргагчийн холбоотой этгээдийн мэдээлэл.....	18
1.5.1. Төрийн эзэмшлийг хэрэгжүүлэгч этгээд.....	18
1.5.2. Үнэт цаас гаргагчийн охин, хараат компаниуд.....	18
1.6. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа.....	20
1.6.1. Компанийн эрхэм зорилго, алсын хараа.....	20
1.6.2. Түүхэн замнал.....	21
1.6.3. Тавантолгойн ордын танилцуулга.....	22
1.6.4. Уурхайн үйл ажиллагаа.....	39
1.7. Компанийн бүтэц зохион байгуулалт.....	51
1.8. Эрх бүхий албан тушаалтны мэдээлэл.....	62
1.9. Компанийн засаглал.....	70
1.10. Ногдол ашиг.....	73
1.11. Нийгмийн хариуцлагын хүрээнд хийж гүйцэтгэсэн ажил.....	74
ХОЁР. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ.....	80
2.1. Өөрийн хөрөнгө, биет болон биет бус хөрөнгө.....	80
2.2 Санхүүгийн байдлын тайлан.....	81
2.3. Орлогын дэлгэрэнгүй тайлан.....	82
2.4. Мөнгөн гүйлгээний тайлан.....	82
2.5. Өмчийн өөрчлөлтийн тайлан.....	84
2.6. Санхүүгийн шинжилгээ.....	85
2.7. Аудитын дүгнэлтийн хураангуй.....	88
ГУРАВ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ.....	91
3.1. Дэлхийн нүүрсний зах зээлийн төлөв байдал.....	91
3.1.1. Коксжих нүүрсний хэрэглээ, эрэлт, нийлүүлэлт.....	91
3.1.2. Эрчим хүчний нүүрсний хэрэглээ, эрэлт, нийлүүлэлт.....	92
3.1.3. Зорилтот зах зээл.....	92
3.1.4. Гуравдагч зах зээлийн шинжилгээ.....	97
3.2. Монгол улсын нүүрсний зах зээлийн төлөв байдал.....	101
3.2.1. Монгол Улсын нүүрсний нийлүүлэлт.....	102
3.2.2. Монгол Улсын нүүрсний тээврийн дэд бүтэц.....	107
3.3. Зах зээлийн үнийн судалгаа, ирээдүйн төсөөлөл.....	108
3.4. Нүүрсний үнэд нөлөөлөгч хүчин зүйлс.....	104



3.3.2.	Зорилтот зах зээл дэх нүүрсний үнэ, үнийн төсөөлөл	105
3.4.	Үнэт цаас гаргагчийн нөхцөл байдлын шинжилгээ	107
3.4.1.	PEST шинжилгээ	108
3.4.2.	SWOT шинжилгээ.....	108
3.4.3.	TOWS шинжилгээ.....	111
3.5.	Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны бизнес төлөвлөгөөний тойм	114
3.5.1.	Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн дэлхийн зах зээлд эзлэх байр суурь.....	114
3.5.2.	Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, хөтөлбөрүүд	115
3.5.3.	Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн нүүрсний үнийн төсөөлөл.....	122
3.5.4.	Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн борлуулалтын төлөвлөгөө.....	123
3.5.5.	Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн орлого, ашгийн төлөвлөгөө	127
3.6.	Техник эдийн засгийн үндэслэл	128
3.6.1.	Зүүн Цанхийн ТЭЗҮ.....	128
3.6.2.	Баруун Цанхийн ТЭЗҮ.....	136
3.7.	Эрсдэлийн хүчин зүйлс, удирдлага.....	143
ДӨРӨВ. ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ		149
4.1.	Бонд гаргах эрх бүхий этгээдийн шийдвэр	149
4.2.	Бондын нөхцөл.....	150
4.3.	Үнэт цаасаар гэрчлэгдэх эрх, үүрэг.....	150
4.4.	Бондын арилжаа	151
4.5.	Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт	153
4.6.	Бондын эргэн төлөлтийн эх үүсвэр	157
ТАВ. ҮНЭТ ЦААС ГАРГАХАД ОРОЛЦСОН ЭТГЭЭДИЙН ТУХАЙ.....		159
5.1.	Тэргүүлэх андеррайтер компанийн танилцуулга.....	159
5.2.	Дэд андеррайтер, санхүүгийн зөвлөх компанийн танилцуулга	161
5.3.	Үнэлгээний компанийн танилцуулга.....	163
5.4.	Хараат бус үнэлгээний тайлангийн хураангуй.....	166
5.4.1.	Бизнесийн үнэлгээ	166
5.4.2.	Хөрөнгийн үнэлгээ	168
5.5.	Хуулийн компанийн танилцуулга	170
5.6.	Хуулийн дүгнэлтийн хураангуй.....	172
Хавсралт материалын жагсаалт		191

2021.03.26





0000014



НЭГ ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ

1.1. Үнэт цаас гаргагчийн төвн танилцуулга

Үнэт цаас гаргагч Эрдэнэс-Тавантолгой ХК нь Тавантолгойн нүүрсний бүлэг ордод ашиглалтын үйл ажиллагаа явуулах зорилгоор Монгол Улсын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоол, Засгийн газрын 2010 оны 272 дугаар тогтоолын дагуу 2010 оны 12 дугаар сарын 23-нд үүсгэн байгуулагдаж 11 дэх жилдээ үйл ажиллагаагаа явуулж байна.

Эрдэнэс-Тавантолгой ХК нь сайн чанарын "Тавантолгой" брэндийн бүтээгдэхүүн бий болгож, аюулгүй тогтвортой, нээлттэй, хариуцлагатай уул уурхай, аж үйлдвэрийн цогцолбор үйлдвэрийг хөгжүүлэх, улс орны болон бүс нутгийн эдийн засгийн өсөлтөд бодитой хувь нэмэр оруулсан тэргүүлэх компани болох эрхэм зорилгыг өмнөө тавин ажилладаг.

2010 онд үүсгэн байгуулагдсанаас хойш хугацаанд компанийн үйл ажиллагаа тогтвортой өсч 2020 оны байдлаар Монгол улсын хамгийн том нүүрс олборлогч болоод борлуулагч компани болоод байна.

Таван толгой орд нь 2011 оны олон улсын JORC аргачлалын нөөцийн үнэлгээгээр 7.38 тэрбум тонн, 2018 оны Ашигт малтмал газрын тосны газрын Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр "Монгол Улсын ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, заавар"-ын дагуу батлуулсан нөөцийн үнэлгээгээр (A+B+C+P1) зэрэглэлээр 6.308 тэрбум тонн нүүрсний нөөц батлуулсан нь дэлхийд тэргүүлэх ордуудын нэг юм.

Үнэт цаас гаргагч компанийн хувьцааг Монгол улсын төр, 2,512,768 иргэд, 486 үндэсний аж ахуйн нэгж эзэмшиж байгаа бөгөөд Монгол улсын хамгийн олон хувьцаа эзэмшигчтэй компани юм. Компани 2019 онд Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд хаалттай хувьцаат компаниар бүртгэгдэн хувьцаа эзэмшигчдийн өмчийг төвлөрсөн хадгаламжийн төвд бүртгүүлэх ажиллагааг гүйцэтгэсэн.

Компани 2021 оноос уурхайн бүтээн байгуулалтын голлох ажлууд буюу уурхайн үндсэн дэд бүтэц болсон төмөр зам, авто зам, нүүрс баяжуулах үйлдвэр, цахилгаан станц зэрэг томоохон төслүүдийг хэрэгжүүлэх, ТЭЗҮ-г боловсруулах, бүтээн байгуулалтын ажлуудыг эхлүүлэхээр төлөвлөжээ. *Схем 1. Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн төвч танилцуулга*

Нүүрсний нөөц, чанараараа дэлхийд тэргүүлэх орд

Лицензийн талбайд хамаарах
Нүүрсний геологийн нөөц: 6.308 тэр.тн
Коксжих нүүрс: 3.32 тэр.тн
Эрчим хүчний нүүрс: 3.011 тэр.тн

Хамгийн олон хувьцаа эзэмшигчтэй компани

Монгол улсын төр
2,512,768 сая Монгол улсын иргэн, 486 үндэсний ААН



Монголын хамгийн том нүүрс олборлолт, борлуулалтын компани

2020 оны байдлаар
Нүүрс олборлолт: 75.3 сая.тн
Нүүрс борлуулалт: 70.1 сая.тн

Монгол улсын хамгийн өндөр борлуулалт, ашигтай компани

2019 онд Борлуулалтын орлого:
2.66 их наяд төгрөг

Цэвэр ашиг:
1 их наяд төгрөг

Томоохон төслүүдийг хэрэгжүүлэх

Нүүрс баяжуулах үйлдвэр
Төмөр зам

Авто зам
Усн хангамж, тухайн тусгай



2021.03.05





ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ ХК

1.2. Үнэт цаас гаргагчийн хуулийн этгээдийн улсын бүртгэл

Эрдэнэс-Тавантолгой ХК нь Монгол Улсын УИХ-ын 2010 оны 07 сарын 07-ны 39 дугаар тогтоол /Хавсралт 1/, Засгийн Газрын 2010 оны 10 сарын 20-ны өдрийн 272 дугаар тогтоол /Хавсралт 2/, Төрийн өмчийн хорооны 2010 оны 10 сарын 28-ны өдрийн 425 дугаар тогтоол /Хавсралт 3/, Эрдэнэс Монгол ХХК-ийн 2010 оны 12 сарын 07-ны өдрийн 07 тоот тогтоол /Хавсралт 4/-ын дагуу Таван толгойн нүүрсний бүлэг ордод үйл ажиллагаа явуулахаар үүсгэн байгуулагдсан.

Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн 2018 оны 10 сарын 19-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 01 дугаар тогтоол /Хавсралт 5/-ын хавсралтаар батлагдсан дүрэмд Үнэт цаас гаргагч нь төрийн өмчийн оролцоотой, хаалттай хувьцаат компани байхаар тусгажээ. Санхүүгийн Зохицуулах Хорооны зүгээс 2020 оны 01 сарын 03-ний өдөр ирүүлсэн 9/24 тоот албан бичиг /Хавсралт 6/-ээс үзэхэд Эрдэнэс Тавантолгой ХК нь "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК-д хаалттай хувьцаат компаниар бүртгэгдсэн байна.

Хүснэгт 1. Улсын бүртгэлийн мэдээлэл

Бүртгэгдсэн он, сар, өдөр	2010 оны 12 сарын 23
Улсын бүртгэлийн дугаар	9010001097
Регистрийн дугаар	5435528
Хувьцаа эзэмшигчид:	- Монгол улсын төр - 486 Үндэсний аж ахуйн нэгж - 2,512,768 Монгол улсын иргэд
Үндсэн үйл ажиллагаа:	Ашигт малтмалын хайгуул хийх Ашигт малтмалын ашиглалт
Тусгай зөвшөөрөл:	Ашигт малтмалын ашиглалт
Тусгай зөвшөөрлийн дугаар:	MV-011955A MV-011954A MV-011953A MV-011943A MV-011956A MV-016882A MV-016883A MV-016881A
Үнэт цаас гаргагчийн хаяг	Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын гудамж-8 Финанс төв
Холбоо барих утас:	70110735, 70110625
Факс:	70119595
И-мэйл хаяг:	info@erdenestt.mn
Цахим хуудас:	www.erdenestt.mn

Эрдэнэс Тавантолгой ХК нь улсын бүртгэлийн байгууллагад зохих ёсоор бүртгүүлж гэрчилгээ авсан бөгөөд хуулийн этгээдийг үүсгэн байгуулах баримт бичиг, хувийн хэргийн мэдээлэлд оруулсан өөрчлөлт нь тухай бүр бүртгэх байгууллагад бүртгэгджээ.

Дараах мэдээллийг Үнэт цаасны танилцуулгын хавсралт материалаас үзнэ үү.

Хавсралт 7. Улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар батлуулсан хувилбар
Хавсралт 8. Улсын бүртгэлд бүртгэгдсэн дүрмийн хуулбар



2021.03.26



0000016

ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ ХК
2021-03-19

1.3. Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгө

Үнэт цаас гаргагч нь улсын бүртгэлд бүртгэгдсэн компанийн дүрэмд зааснаар нэг бүр нь 933 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 15,000,000,000 ширхэг зарласан энгийн хувьцаа, үүнээс 12,000,000,000 ширхэг гаргасан энгийн хувьцаатай буюу 11,196,000,000,000 төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй байна.

Засгийн газрын 2012 оны 05 сарын 30-ны 181 дугаар тогтоол /Хавсралт 9/-ын дагуу хувьцааны нэрлэсэн үнийг 933 төгрөгөөр тогтоосон.

Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгөд гарсан өөрчлөлт

УИХ-ын 2010 оны 07 сарын 07-ны өдрийн №39 тогтоол, ЗГ-ын 2010 оны 10 сарын 20-ны өдрийн №272 тогтоол, Төрийн өмчийн хорооны 2010 оны 10 сарын 28-ны өдрийн 425 дугаар тогтоол, Эрдэнэс Монгол ХХК-ийн ТУЗ-ийн 2010 оны 12 сарын 07-ны өдрийн 07 дугаар тогтоолын дагуу Эрдэнэс-Тавантолгой ХК-ийг 300 сая төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгээр үүсгэн байгуулсан.

Засгийн газрын 2017 оны 05 сарын 30-ны өдрийн 154 тоот тогтоол /Хавсралт 10/, Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн 2018 оны 10 сарын 19-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 01 дугаар тогтоолын дагуу зарласан хувьцааг 15 тэрбум, гаргасан хувьцааг 12 тэрбум байхаар тогтоон хувьцааны бүртгэлийг компанийн дүрэм, санхүүгийн тайланд тусгасан.

Хүснэгт 2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлт


№	Тогтоол	Өөрчлөлт	Хувь нийлүүлсэн хөрөнгө
1	Засгийн газрын 2010 оны 10 сарын 20-ны өдрийн №272 тогтоол Эрдэнэс Монгол ХХК-ийн ТУЗ-ийн 2010 оны 12 сарын 07-ны өдрийн 07 дугаар тогтоол	Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийг "Эрдэнэс МГЛ" ХХК-ийн хөрөнгөөс гаргав.	300,000,000 төгрөг
2	Засгийн газрын 2017 оны 05 сарын 30-ны өдрийн №154 тогтоол Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн 2018 оны 10 сарын 19-ний өдрийн 01 дугаар тогтоол	Төр, Иргэд, ААН-үүдийн эзэмшиж буй хувьцааг хувь нийлүүлсэн хөрөнгөд тусгав.	11,196,000,000,000 төгрөг

1.4. Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшлийн бүтэц

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 07 сарын 07-ны өдрийн 39 дугаар тогтоолын дагуу Эрдэнэс-Тавантолгой ХК-ийг төрийн өмчит компани хэлбэрээр байгуулах, 20 хүртэлх хувийг иргэдэд, 10 хүртэлх хувийг дотоодын ААН-д эзэмшүүлэх, 20 хүртэлх хувийг гадаад дотоодын биржид санал болгохоор шийдвэрлэсэн.

Хуулийн дүгнэлтэд дурдсанаар нийт хувьцааны 65.20% нь төрийн өмч, 14.75%-ийг Монгол улсын иргэд, 0.05%-ийг дотоодын аж ахуйн нэгж эзэмшиж байгаа ба 20%-ийг зарласан хувьцаа эзэлж байна.

Компанийн тухай хуулийн 30.1 дэх заалтад "Тухайн компаниас хувьцаа эзэмшигчдэд эзэмшүүлсэн буюу гаргасан нийт давуу эрхийн болон энгийн хувьцааны нэрлэсэн үнийн дунд компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө гэх бөгөөд компанийн хувь нийлүүлсэн хөрөнгөд тухайн компанийн зарласан болон эргүүлэн худалдаж авсан халаасны хувьцаа



хамаарахгүй гэж заасан байдаг. Энэхүү заалтын дагуу хувь эзэмшлийг тооцвол гаргасан хувьцааны 81.51% нь төрийн өмч, 18.44%-ийг Монгол улсын иргэд, 0.06%-ийг дотоодын аж ахуйн нэгж эзэмшиж байна.

УИХ-ын 2018 оны 06 сарын 29-ний өдрийн 73 дугаар тогтоол /Хавсралт 11/-оор зарласан боловч гаргаагүй 3 тэрбум хувьцаа болон иргэд, ААН-үүдээс эргүүлэн худалдан авсан хувьцааг нэгтгэн нийт хувьцааны 30 хүртэлх хувийг гадаад дотоодын хөрөнгийн биржээр дамжуулан арилжаалахыг Засгийн газарт даалгасан.

Схем 2. Хувьцаа эзэмшлийн бүтэц



Хүснэгт 3. Гаргасан хувьцааны бүтэц

№	Хувьцаа эзэмшигчид	Хувьцаа эзэмшигчдийн тоо	Тоо ширхэг	Эзлэх хувь
1	Төрийн өмч	1	9,779,874,440	81.51%
2	Монгол Улсын иргэд	2,512,768	2,213,060,522	18.44%
3	Хуулийн этгээд	486	7,065,038	0.06%
	Нийт		12,000,000,000	100%

Улсын Их Хурлын 2018 оны 73 дугаар тогтоолоор Улсын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоолын 1 дэх заалтын 1 дэх дэд заалтаас "охин" гэснийг хасаж, тус тогтоолын "Эрдэнэс-Тавантолгой" компанийн толгой компани болох "Эрдэнэс МГЛ" компанийг ..." гэсэн агуулгатай 1 дэх заалтын 3 дахь дэд заалтыг хүчингүй болгосон. Үүнтэй холбоотойгоор Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 08 сарын 08-ны өдрийн 245 дугаар тогтоол /Хавсралт 12/-ын дагуу төрийн эзэмшлийн эрхийг хэрэгжүүлэгчээр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрыг томилжээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8.1.1, 21.2.3-д заасны дагуу төрийн өмчийг хэрэгжүүлэх этгээдийг Засгийн газар томилох ба төрийн захиргааны аливаа байгууллага, төрийн өмчит хуулийн этгээд нь зөвхөн Улсын Их Хурал, Засгийн газраас тогтоосон хэм хэмжээний хүрээнд төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх зохицуулалттай.


 ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ ХК


 ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ ХК

2021.03.26

1.5. Үнэт цаас гаргагчийн холбоотой этгээдийн мэдээлэл
1.5.1. Төрийн эзэмшлийг хэрэгжүүлэгч этгээд

Засгийн газрын 2018 оны 08 сарын 08-ны өдрийн 245 дугаар тогтоолоор Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг хувьцаа эзэмшигчийн эрхийн хэрэгжүүлэгчээр Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрыг томилсон.



**УУЛ УУРХАЙ
 ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**

Уул уурхайн хүнд үйлдвэрийн яам нь ил тод, хариуцлагатай уул уурхай, хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулж, эдийн засгийн тэнцвэртэй олон тулгуурт бүтцийг бий болгоход чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажилладаг.



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
 ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР**

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд төрийн болон орон нутгийн өмчийн талаарх хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, төрийн өмчит хуулийн этгээдэд компанийн засаглалыг хөгжүүлэх, төрийн өмчийн эзэмшилт, ашиглалтад хяналт тавих замаар төрийн өмчийн үр өгөөжийг нэмэгдүүлэх чиг үүрэгтэй засгийн газрын харьяа агентлаг юм.

1.5.2. Үнэт цаас гаргагчийн охин, хараат компаниуд

Үнэт цаас гаргагч нь Тавантолгой төмөр зам ХХК, Зүүнбаян төмөр зам ХХК гэсэн 2 охин компанитай, Гашуун сухайт авто зам ХХК, Тавантолгой дулааны цахилгаан станц ХХК гэсэн 2 хараат компанитай байна.

Үнэт цаас гаргагчтай зэргэлдээ компаниудын хувьд КТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.15 дахь хэсэгт заасны дагуу Эрдэнэс-Тавантолгой ХК нь төрийн эзэмшилд хяналтын багц нь байгаа төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой компаниудтай зэргэлдээ компанид тооцогдоно гэж хуулийн дүгнэлтэд дурджээ.

Хүснэгт 4. Үнэт цаас гаргагчийн охин компаниуд

№	Нэр	Үүсгэн байгуулагдсан огноо	Эзэмшлийн хувь	Үндсэн үйл ажиллагааны чиглэл	Хаяг
1	Тавантолгой төмөр зам ХХК	2018.08.08	66%	Төмөр замын суурь бүтэц барих, ашиглах, засварлах Төмөр замын тээвэр	Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, Юнион буюлдинг А блок, 5 давхар
2	Гашуунсухайт авто зам ХХК	2014.06.06	40%	Авто замын удирдлага, менежмент, төсөл хэрэгжүүлэх, гадаад худалдаа	Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, Энхтайвны өргөгч чөлөө, Моннис тауэр

Handwritten signature and red stamp of the Ministry of Energy and Heavy Industry of Mongolia.

Handwritten signature and red stamp of the company.

2021.08.26



Алсын хараа

"УУЛ УУРХАЙ - ДЭД БҮТЭЦ - АЖ ҮЙЛДВЭРЛЭЛ" ХӨГЖЛИЙН ЖИШИГ - ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ



Эрхэм зорилго

"Монгол Улсын эдийн засгийн тэргүүлэх салбарт уул уурхай, хүнд үйлдвэр, эрчим хүч, тээвэр, логистикийн чиглэлээр бизнесийн үндсэн үйл ажиллагаагаа явуулж, компанийн нэгдэл хэлбэрээр "Уул уурхай-Дэд бүтэц-Аж үйлдвэрлэл"-ийн хосолсон цогцолбор байгуулж, хөрөнгө оруулалтын үр ашигтай бодлогыг хэрэгжүүлж, ажиллагсдын болон түншүүдийн тогтвортой хөгжлийг хангаж, олон улсын стандартад нийцсэн, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг дэлхийн брэндийн түвшинд үйлдвэрлэж, зах зээлд хүргэн борлуулснаар Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний таваас дээш хувийг бүрдүүлж, хувьцаа эзэмшигчдэд хөрөнгийн үр өгөөжийг хүртээнэ.

Үнэт зүйлс

Байгалийн баялаг

- Тавантолгой нүүрсний бүлэг орд нь стратегийн ач холбогдол бүхий үнэ цэнэтэй, хязгаарлагдмал байгалийн баялаг бөгөөд Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн хурдасгуур нүүрс нь компанийн үнэт капитал мөн. Коксжих болон эрчим хүчний нүүрсээр олон улсын стандартад нийцсэн, нэмүү өртөг шингэсэн, дэлхийн брэндийн түвшинд, өндөр чанарын бүтээгдэхүүнийг БИД үйлдвэрлэнэ.
- Гадаргын болон гүний усны нөөцийн орд, эх үүсвэр нь байгаль, экологийн тэнцвэртэй байдлыг хангадаг үнэ цэнэтэй, ховор байгалийн баялаг бөгөөд уул уурхай-дэд бүтэц-аж үйлдвэрлэлийн цогцолборыг хөгжүүлэх хөгжлийн түлхүүр-"Ус чандмань эрдэнэ" мөн. Усны нөөцийг байгальд ээлтэй, хэмнэлттэй, үр ашигтай ашиглаж, зөв хэрэглээг хэвшүүлж, усны нөөцийн санг бүрдүүлж, дахин ашиглах, тэнцвэртэй байдлыг БИД ханган ажиллана.



Тогтвортой хөгжил

- Ажилчдын ур чадвар, мэргэшил туршлага, ажлын үр дүнг харгалзсан хариуцлага, урамшууллын бодлого, хөдөлмөр эрхлэлтийн тэгш нөхцөл боломжоор хангаж, чадварлаг, мэргэшсэн боловсон хүчнээр хамт олныг бүрдүүлнэ.
- Хүндэтгэл, итгэл, шударга, ил тод, хариуцлага, сахилга баттай байдлыг эрхэмлэсэн багаар ажиллах чадвартай, зөвсэг хамт олон нь өндөр үр дүн, амжилтын нийлмэл хүч байна.

Харилцан итгэлцэл

- Хамт олон, харилцагч, түнш, олон нийтийн болон тэдний хоорондын эрх ашгийг дээдлэн хүндэлнэ.
- Аливаа хамтын ажиллагаа, нээлттэй харилцааг эрхэмлэж, шударга, ил тод, хариуцлагатай байх зарчмыг чанд баримтална.
- Бизнесийн түншүүдтэй харилцан ашигтайгаар хамтран ажиллахдаа тогтвортой, урт хугацааны, харилцан ашигтай байх, сайн түншийн харилцааг эрхэмлэнэ.

Stamp: TAVAN ERDES
 ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ ХК
 УУЛ УУРХАЙ - ДЭД БҮТЭЦ - АЖ ҮЙЛДВЭРЛЭЛ
 ХААНГААТАЙ ТИШЭЭ АЖ АХУЙН ХӨГЖӨЛ
 ХӨГЖӨЛ ХӨГЖӨЛ ХӨГЖӨЛ
 JSC


АНИДЦУУЛГА

Stamp: МХБ-ийн гишүүн
 Мэдсэрийтэй
 Сөрөнхосонийн эрх зүйлс, үнэт зүйлс
 "ЭРДЭНЭС" ХК ХК
 111792447, 1052482
 Б. [Signature]

2021.09.15 09:30:51

1.6.2. Түүхэн замнал

Схем 4. Үнэт цаас зараачийн түүхэн замнал



20210304

Тавантолгойн ХК-ийн
ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ ХХК-ийн
Төрийн захирал
[Signature]

Эрдэнэс
Тавантолгой ХК-ийн
Санхүүжүүлсэн
сайжруулсан
шахмал тулшгийн
зүүн бүсийг
үйлдвэр
ашиглалтад оров
[Signature]

1.6.3. Тавантолгойн ордын танилцуулга

Эрдэнэс-Тавантолгой ХК нь Тавантолгойн бүлэг ордод ашиглалтын 6 тусгай зөвшөөрөл эзэмшдэг ба Цанхийн ордод олборлолт, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг, ордын бусад хэсэгт хайгуул, эрэл үнэлгээний ажлыг гүйцэтгэж байна.

Тавантолгойн бүлэг ордыг Монгол Улсын Их Хурлын 2007 оны 02 сарын 06-ны өдрийн 27 дугаар тогтоол /Хавсралт 20/-ын дагуу стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулсан байна.

Орд нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Цагаан-Овоо багийн нутаг Улааннуурын хөндийд Улаанбаатар хотоос өмнө зүгт 540 км, Өмнөговь аймгийн Даланзадгад хотоос зүүн тийш 98 км, Цогтцэций сумын төвөөс урагш 16 км, Монгол-Хятадын хилээс 200 км гаруй зайд байрладаг.


Зураг 1. Тавантолгой ордод байршил



Уул зүй

Тухайн бүс нутаг нь Монгол орны өмнөд хэсгийг эзэлсэн говь талын бэсрэг хэлхээ уулс, тэдгээрийн хооронд хотос тал хөндийнүүд зонхилсон нутагт оршино. Тухайлбал хамгийн өндөр цэг нь далайн түвшнээс дээш 1,791 м өргөгдсөн Цэций уул, Их шанхын нурууны оргил Өгөөмөр уул 1,789 м болон тэдгээрийн хэлхээ бэсрэг уулсууд баруун урдаас зүүн хойш чиглэн сунаж тогтоно.

Эдгээр бэсрэг уулсын хооронд далайн түвшинээс дээш дунджаар 1500-1520 м өргөгдсөн өргөн тал хөндийнүүд тэдгээрийн дунд хамгийн нам доор гадаргуутай хотгорууд-тойром үүсэн тогтох бөгөөд хамгийн том нь Улаан нуурын тойром, Оорцогын хоолой, Төхөмийн хөндий зэрэг болно. Дээрхи тал хөндий уулс-толгодын өндөршлийн зөрүү нь дунджаар 100 м-ээс үл хэтрэнэ. Энэ нь тус дүүрэгт агаарын хур тунадасны уул зүйн онцлог, зөрүү төдийлэн ялгагдахгүй жигд байх магадлалтайг харуулна. Өөрөөр хэлбэл газрын доорх усны бүрэлдэн тогтох байгалийн суурь нөхцөлд агаарын хур тунадасны нөлөөлөл, тоо хэмжээг харьцангуй жигд байх онцлог ажиглагдана.





0000023

МОНГОЛЫН ХӨГӨНТӨЙН ЗИРХ
MONGOLIA GEOTECHNICAL ENGINEERING
ЭРДЭНЭС, ТАВАНТОЛГОЙ ХК
2021-03-19

БҮРТГЭВ.02

Бүс нутгийн хүн ам, дэд бүтэц

Өмнөговь аймаг нь 2019 оны жилийн эцэст 69,902 хүн амтай болж 2018 оны жилийн эцсийн хүн амын мэдээнээс 1.1%-иар буюу 778 хүнээр өссөн байна. Нийт хүн амын 51.1%-ийг эрэгтэйчүүд, 48.9%-ийг эмэгтэйчүүд эзэлж байна. Хүн амын 38% Даланзадгад хотод, 31.4% нь Гурвантэс, Ханбогд, Цогтцэций сумдын төвд суурьшиж байна. Хөдөлмөр эрхлэх насаар нь ангилвал 31.8%-ийг 0-14 насны хүүхэд, 62%-ийг 15-59 насны, 6.2%-ийг 60-аас дээш насны хүн ам эзэлж байна. Тавантолгойн орд газар байрлах Цогтцэций сум нь засаг захиргааны анхан шатны нэгж болсон 4 багтай, тус сумын нийт хүн ам 8,111, өрхийн тоо 2,443-д хүрсэн байна.

Бүс нутгийн хэмжээнд дэлхийд тэргүүлэх томоохон алт, зэс, нүүрсний ордуудын ашиглалт эрчимтэй нэмэгдэж орон нутагт уул уурхайг дагасан олон компани аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаа явуулж байна.

Ордын геологийн тогтоц

Тавантолгойн синклиналь атирааны төв хэсэг дээд пермийн нүүрс агуулагч хурдсаар дүүргэгдэж дунд-дээд девон, доод карбон, хожуу карбон-түрүү пермийн вулканоген тунамал хурдсууд ордыг эмжээрлэн тогтох гүвээ толгод илэрнэ. Хязгаарлагдмал бага талбайд кайнозойн хурдас хөгжсөн байдаг.

Дээд пермийн тавантолгой формацын (P2 tb) нүүрс агуулагч хурдас, эдгээрийг уллаж буй дээд карбон-доод пермийн дөш овоо, цогтцэций формацын вулканоген, туф-тунамал гаралт чулуулаг оролцдог.

Тавантолгойн нүүрсний бүлэг ордыг агуулагч Тавантолгой формаф зүүн хойноос баруун урагш чиглэлээр 32 км урттай 10 км өргөнтэй талбайд хуримтлагдсан. Тавантолгой формац нь газрын гадарга дээр бага хэмжээгээр аргиллит, алевролит, элсэн чулуу, конгломерат хүртэлх янз бүрийн төрлийн хэмхдэст чулуулаг байдлаар илэрц ховроор үүсгэнэ. Ихэнх хэсэгт дөрөвдөгчийн сэвсгэр хурдсаар хучигдсан бөгөөд хотгор тал, нам рельеф үзүүлдэг.

Тавантолгой чулуун нүүрсний бүлэг орд нь 14 давхрааснаас бүрдэх бөгөөд Цанхийн хэсэгт 0-XI дугаартай 11 давхраас, Бортээгийн хэсэгт III-XIII дугаартай 11 давхраас, Оорцогийн /Баруун-Өмнөд/ хэсэгт 0-XI дугаартай 8 давхраас, Ончхараатын /Зүүн/ хэсэгт 0-VIII дугаартай 6 давхраас, Бортолгойн хэсэгт 0-XIII дугаартай 7 давхраас тус бүр ялгаж нөөцийг тооцоолсон.

Ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээнд гөлтгөнө, галд тэсвэртэй шавар, зам барилгын чулуу, нүүрс дэх бусад элементүүдийн агууламж, нүүрсний давхраасын метан хий зэрэг нүүрснээс бусад ашигт малтмал байна.



2.0 2.10.30.4

Тусгай зөвшөөрөл

Үнэт цаас гаргагч нь MV-016883, MV-0168818, MV-016882, MV-011953, MV-011943, MV-011954, MV-011955, MV-011956 дугаар бүхий хүчин төгөлдөр 8 ашиглалтын тусгай зөвшөөрлийг 68,471.43 га газарт эзэмшиж байна. /Хавсралт 21/

Хүснэгт 5. Тусгай зөвшөөрлийн мэдээлэл

№	Байршил	Тусгай зөвшөөрлийн дугаар	Талбай, га	Олгосон огноо	Хугацаа	Дуусах хугацаа
1	Шар тээг	MV-011955	23,813.10	2006.08.29	30 жил	2036.08.29
2	Бор тээг-1	MV-011954	22,901.37	2006.08.29	30 жил	2036.08.29
3	Бортолгой	MV-011953	12,864.47	2006.08.29	30 жил	2036.08.29
4	Тавантолгой	MV-011956	3,151.92	2006.08.29	30 жил	2036.08.29
5	Тавантолгой-1	MV-016882	2,447.13	2006.08.29	30 жил	2036.08.29
6	Тавантолгой	MV-011943	2,036.33	2006.08.28	30 жил	2036.08.28
7	Шар тээг	MV-016883	700.39	2006.08.29	30 жил	2036.08.29
8	Бор тээг-1	MV-016881	556.72	2006.08.29	30 жил	2036.08.29
Нийт талбай			68,471.43			

Ордуудын мэдээлэл

Тавантолгойн орд нь Цанхи, Бортолгой, Бортээг, Оорцог, Онч-хараат, Ухаа худаг гэсэн 6 үндсэн хэсгээс бүрддэг. Цанхи, Ухаа худгийн талбайд нарийвчилсан хайгуул, Бортээг, Оорцогийн талбайд урьдчилсан хайгуул, Онч хараат, Бор толгой талбайд эрэл, үнэлгээний ажил тус тус хийгдээд байна.

Зураг 2. Тавантолгой бүлэг ордын ордуудын байршил, тусгай зөвшөөрөл



Цанхийн уурхайн MV-011954, MV-016881, MV-011956, MV-016882, MV-016883, MV-011943 дугаар зөвшөөрлийн талбайг хамран байрладаг Тавантолгойн бүлэг ордын эрмөхөр ордуудын нэг юм.

Цанхи
ЭРДЭНЭС
ТАВАНТОЛГОЙ
JSC

ЭРДЭНЭС
ТАВАНТОЛГОЙ
JSC

20210304



2020 онд JORC аргачлалаар хийгдсэн Цанхийн хэсгийн нэгдсэн нөөцийн тайлангаар 2.59 тэрбум тонн нүүрсний нөөцтэй байхаар тогтоогдсон.

Зүүн уурхай

Компани 2010 оноос Цанхийн зүүн хэсэгт уурхайн үйл ажиллагааг эхлүүлж нүүрс олборлох, борлуулах ажил эхэлсэн ба 2020 оны эцсийн байдлаар нийт 47.1 сая тонн нүүрс тус уурхайгаас олборложээ. ТЭЗҮ-д жилд 15 сая тонныг олборлох хүчин чадалтайгаар тооцоолсон ба одоогоор жилд 5-10 сая тонн олборлож байна. 2021 оны 1, 2-р сарын байдлаар 2.04 сая тонн нүүрс борлуулсан.

Цанхийн Зүүн уурхайд компанийн 206 оператор гэрээт компанийн техник хэрэгсэл ашиглан олборлолт хийдэг.

Баруун уурхай

Эрдэнэс-Тавантолгой ХК нь Цанхийн баруун хэсэгт 2013 оноос уурхайн үйл ажиллагаа явуулж олборлолтыг эхлүүлсэн ба 2020 оны эцсийн байдлаар нийт 28.1 сая тонн нүүрс олборлосон байна. ТЭЗҮ-д жилд 20 сая тонн нүүрс олборлохоор тооцоолсон ба одоогоор 5-8 сая тонн нүүрс олборлох хүчин чадалтайгаар ажиллаж байна. 2021 оны 1, 2-р сарын байдлаар 1.26 сая тонн нүүрс борлуулсан.

Цанхийн Баруун уурхайд гэрээт операторууд өөрсдийн техник хэрэгслээр үйл ажиллагаа явуулдаг.

Бортээг

Бортээгийн уурхай нь MV-011956, MV-016882, MV-011943 тоот тусгай зөвшөөрлийн талбайд хамаардаг. 2020 оны 01 сарын 15-ний өдрийн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн ТС/20-01-01 дугаар дүгнэлт, 2020 оны ашигт малтмал, газрын тосны газрын даргын Т/07 дугаар тушаалаар ордын ТЭЗҮ батлагдсан ба компанийн бизнес төлөвлөгөөгөөр 2021 оноос тус ордод олборлолтын үйл ажиллагааг эхлүүлэхээр төлөвлөсөн.

2018 онд хийгдсэн нөөцийн тайлангаар (A+B+C) зэрэглэлээр цэвэр нүүрсний 1.260 тэрбум тонны нүүрсний нөөц тогтоогдсон. Цэвэр нүүрсний нөөцийн 26,369,427 тонн нь А буюу баттай нөөц, 690,229,452 тонн нь В буюу бодитой нөөц, 543,594,868 тонн нь С буюу боломжтой нөөц эзэлж байна.

Бортээгийн баруун хэсгийн VIII, IX давхаргуудын нүүрс нь үзүүлэлтээрээ MNS 6456: 2014 стандартын дагуу Ч6 марк буюу 1/3 коксжих нүүрсэнд, X, XI, XII, XIII давхраасын нүүрсүүд нь Ч7-Ч12 маркад буюу хийн тослогоос Урт дөлт нүүрсэнд хамаарч байна.

Бортээгийн ордын нүүрсний чанар, бүс нутгийн онцлогт тохирох технологийг нэвтрүүлэх нь чухал ач холбогдолтой байгаа бөгөөд уг төслийг хэрэгжүүлэхэд хэд хэдэн үе шатны хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтуудыг хийхээр төлөвлөсөн. Уурхайг ил уурхайн хэлбэрээр 30 жил ашиглах ба хүчин чадлыг үе шаттайгаар нэмэгдүүлэн 15 сая тоннд хүргэхээр төлөвлөжээ.



Энэхүү талбай нь MV-011954 тусгай зөвшөөрлийн талбайд хамаардаг ба нарийвчилсан хайгуул үнэлгээний ажил явагдаж байна. 2018 онд хийгдсэн нэгдсэн нөөцийн



2021.03.04



0000026



тайлангийн дагуу (A+B+C) зэрэглэлээр цэвэр нүүрс нь 103,563,350 тонн нүүрсний нөөцтэй байхаар урьдчилсан байдлаар тогтоогдсон.

Бортолгой

Бортолгойн орд MV-011953 тусгай зөвшөөрлийн талбайд хамаардаг ба эрэл, үнэлгээний ажил явагдаж байна. 2018 онд хийгдсэн ордын нөөцийн нэгдсэн тайланд (A+B+C) зэрэглэлээр цэвэр нүүрс нь 127,583,454 тонн нүүрсний нөөцтэй байхаар урьдчилсан байдлаар тогтоогдсон.

Ончараат

Энэхүү талбай MV-11955 тусгай зөвшөөрлийн талбайд хамаардаг ба одоогийн байдлаар эрэл, үнэлгээний ажил явагдаж байна. 2018 онд хийгдсэн нэгдсэн нөөцийн тайлангийн дагуу (A+B+C) зэрэглэлээр цэвэр нүүрс нь 420,857,352 тонн нүүрсний нөөцтэй байхаар урьдчилсан байдлаар тогтоогдсон.

Ордын нөөцийн мэдээлэл

Эрдэнэс-Тавантолгой ХК нь Ашигт малтмалын тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн Тавантолгойн ордын бүлэг ордын нөөцийн тайланг 2011 онд JORC стандартын дагуу, 2018 онд "Монгол Улсын ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, заавар"-ын дагуу бэлтгэж эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан. Компани нь 2020 онд Цанхийн Зүүн болон Баруун уурхайн нөөцийн тайланг Стантек Консалтинг Интернэйшнл ХХК /Стантек/ компаниар гүйцэтгүүлсэн байна.

1. Нөөцийн хэтийн төлөв, ангилал, зэрэг чанар

Нөөцийн хэтийн төлөв

Эрдэнэс-Тавантолгой ХК нь 2018 онд тусгай зөвшөөрөл бүхий талбай дахь ордуудын өмнөх судалгааны ажлуудыг нэгтгэн, нөөцийн нэгдсэн тайланг боловсруулж, орхигдсон болон давхардсан хэсгүүдийн зөрүүг арилган, ордын нөөцийг 300 сая тонноор нэмэгдүүлж, өмнөх жилүүдийн олборлолтын дүнгээр бууруулан "Монгол Улсын ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, заавар" /MRC/-ын дагуу нөөцийн тайлан /Хавсралт 22/-г шинэчилжээ.

Энэхүү тайлангаар Цанхийн эхний ээлжийн ашиглах талбайд гүйцэтгэсэн нарийвчилсан хайгуул, ашиглалтын хайгуул, чичирхийллийн судалгаа, нүүрсний техникийн шинжилгээ, баяжигдах шинж чанарыг судалсан лабораторийн технологийн туршилтын ажлын үр дүнг үндэслэн MV-011943, MV-016883, MV-016881, MV-016882 тоот тусгай зөвшөөрөлтэй талбайнуудад хамаарах нүүрсний давхраасуудын нөөцийг тус бүрт нь тооцоолон нөөцийг баталгаажуулах мөн ордын өөрийн компанийн ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайнуудад хамаарагдах урьдчилсан болон эрлийн ажлын үр дүнг нэгтгэн геологийн нийт нөөц баялгийг нэгтгэн тооцоолсон.

Өмнөх эрэл үнэлгээний, хайгуулын ажлууд ордод хэсэгчилсэн байдлаар хийгдсэн бөгөөд тус бүрдээ блок ялгаж дугаарлалт хийсэн байдаг. 2018 онд хийгдсэн нэгдсэн тайлангаар өмнө хэсэгчилсэн талбайд хийгдсэн нөөцийн дэвсгэр зургуудыг нэгтгэн, давхардлыг арилган, нөөцийн блокуудын дугаар, зэрэглэлийг шинэчлэн одоогийн нөөцийн тайлан буй "Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, заавар"-ын дагуу



2021.03.30

боловсруулж, нарийвчлан гаргасан нүүрсний жишгийн үзүүлэлтийг ашиглан, нөөцийн үнэлгээ хийгдээгүй хэсгийн нөөц, баялгийг бүрэн хамруулан тооцоолсон байна.

Тайланг одоогийн мөрдөгдөж буй 2015 оны Уул уурхайн сайдын 2015 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн тушаалаар батлагдсан "Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, заавар" /MRC стандарт/ мөн Уул уурхайн хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн тушаалаар батлагдсан "Ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааны журам" болон ГОСТ-25548-88, MNS6456:2014 нүүрсний чанарын ангилалд тулгуурлан боловсруулсан.

Энэхүү тайланг Ашигт малтмалын тухай хуулийн 4.1.26-д заасан мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчээр гаргуулсан /Хавсралт 23/ бөгөөд Монгол Улсын Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2018 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн өргөтгөсөн хуралдаанаар батлуулж, Ашигт малтмал, газрын тосны газрын 2019 оны 03 сарын 15-ны өдрийн Н/26 тоот тушаалаар нөөцийг бүртгүүлсэн байна. /Хавсралт 24/

2018 оны байдлаар ордын цэвэр нүүрсний геологийн нөөц 6.31 тэрбум тонн байгаа ба үүнээс 3.33 тэрбум тонн коксжих нүүрс, 2.98 тэрбум тонн эрчим хүчний нүүрсний нөөц байна.

Ордын хэмжээнд нүүрсний нөөцийг газрын гадаргаас 600 метр хүртэлх гүнд буюу 900-1500 метрийн үнэмлэхүй түвшин хүртэл жишгийн үзүүлэлтийн шаардлагыг хангаж байгаа нүүрсний давхраасуудын нийт нөөцийг тооцоолжээ.

Зүүн Цанхийн хэсгээс болон Баруун Цанхийн хэсгээс олборлосон нөөцийг 2010-2017 оны ашиглалтын үйл ажиллагааны баталгаажсан тайланд тусгагдсанаар хасалт хийж тухайн олборлосон блокоос нөөц бодсон түвшин тус бүрээс оногдох нүүрсний нөөцийг хассан байна.

Компанийн одоогийн олборлолт хийж буй Цанхийн уурхай болон 2021 оноос ашиглалтад оруулахаар төлөвлөж буй Бортээгийн уурхай нь томоохон геологийн нөөцтэй ордууд юм.

Хүснэгт 6. Ордуудын геологийн нөөцийн мэдээлэл

Орд	Нэгж	Геологийн нөөц
Цанхи	тэр.тн	2.46
Бортээг	тэр.тн	2.29
Ончхараат	тэр.тн	0.66
Оорцог	тэр.тн	0.49
Бортолгой	тэр.тн	0.39
Ухаахудаг баруун	тэр.тн	0.02
Нийт	тэр.тн	6.31




График 1. Ордуудын нөөц, нүүрсний ангиллаар

Цанхи, Бортээгийн давхраасуудын нүүрс нь антрацитаас (A2) коксжин тосжих (Ч6) маркт хамрагдаж, нүүрсний давхраасуудын харьцангуй тогтвортой байдал, тектоник хагарлын хор хэмжээ түүний нөлөөллийг харгалзан нүүрсний ордын ангиллын зааварчилгаагаар I бүлгийн хэсгийг I бүлэг бусад хэсгийг II бүлгийн ордод хамруулсан.

ЭРДЭНЭС ТАВАНТОГТОЙ
ХК
Улаанбаатар

МОНГОЛЫН ХОРОНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
ЭРДЭНЭС ТАВАНТОГТОЙ БИРЖ
Улаанбаатар
111520544-6 2021.03.19

2021.03.19

Нөөцийн зэрэглэл

"Монгол Улсын ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, заавар" /MRC/-ын дагуу нийт цэвэр нүүрсний нөөцийн 6% нь баттай буюу А зэрэглэл, 32% нь бодитой буюу В зэрэглэл, 26% нь боломжтой буюу С зэрэглэл, 36% нь баялаг буюу P₁ зэрэглэлд хамаарч байна.

График 2. Ордын нөөц, зэрэглэлээр



Ордын нөөцийг тооцоолж гаргахдаа өмнөх судлаачдын тооцоолсон нөөцийг зэрэг ахиулж (A+B→A; C₁→B; C₂→C; P₁+P₂→P₁) авсан байна. Уул уурхайн сайдын 2015 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн тушаалаар батлагдсан "Монгол Улсын ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, заавар"-ын дагуу хайгуулын цооногууд хангалтгүй, хагарал эвдрэлд өртсөн болон хайгуулын өрөмдлөгийн цооногт бага огтлогдсон нөөцийн блокуудын ихэвчлэн P₁ зэрэглэлээр тооцоолж үнэлгээг өгсөн байна.

Нүүрсний чанар

Тавантолгойн ордын нүүрсний давхраасуудын чийг 0.5-2.1%, үнс 17.1-31.4%, дэгдэмхий бодисын гарц 19.8-33.6%, хүхэр 0.44- 0.79%, дулаан ялгаруулах чадвар 5540-8800 ккал/кг –ийн хооронд хэлбэлзэж байна. Өмнөх тайлангуудад ЗХУ-н ГОСТ 25543-88 стандартад тулгуурлан ордын нүүрсний маржыг ангилж байсан бол энэхүү тайланд ЗХУ-ын ГОСТ 25548-88 стандарт болон Монгол Улсын MNS 6456:2014 стандартаар ангилсан.

Давхраасын дугаар	Чийг %	Анхдагч үнс %	Баяжмалын үнс %	Дэгдэмхий бодис %	Хүхэр %	Фосфор %	Илчлэг Мдж/кг
0A	0.64	25.6	12	19.8	0.54	0.021	35.5
0B	0.62	19.5	9.7	21.4	0.63	0.05	35.3
0B	0.58	20.8	10	23.3	0.6	0.084	35
III	0.6	17.6	9	24.6	0.58	0.053	35.1
IVA	0.5	19	9.5	27.3	0.59	0.092	34.4
IVB	0.7	17.8	9.2	28.1	0.78	0.074	34.6
IVAB	0.6	17.1	8.5	26.1	0.52	0.07	34.7
V	0.7	23	10.2	29.7	0.51	0.027	34.3
VII	1.2	21.9	7.5	30.5	0.44	0.017	34
VIIIA	0.85	23.3	11.5	29.7	0.66	0.03	33.8
VIIIB	1.03	22.3	11.5	30	0.79	0.004	33.8
VIIIB	0.99	20.56	8	31.8	0.56	0.08	34
TAVAN IXB	1.1	26.7	11.8	32.86	0.56	0.04	33.6
IXB	1.23	24	9.8	30.5	0.58	0.02	37.2
X	1	20.1	7.74	32.9	0.53	0.031	34.9

ЭРДЭНЭС ТЭВЭН ТӨВГӨЙ ХК
 JSC

ЭРДЭНЭС ТЭВЭН ТӨВГӨЙ ХК
 11115447

2021.03.05

0000023



X	1.22	24.2	12.1	30.6	0.64	0.061	33.6
XI	0.9	28.1	14.7	31.7	0.64	0.008	33.5
XII	2.02	31.4	12.5	32.8	0.49	0.025	32.4
XIII	2.1	28.4	13.4	33.6	0.67	0.009	32.6

Үнсжилт, нийт хүхрийн агуулга зэрэг үзүүлэлтүүд нүүрсний хувирлын зэргээс бус хүлэрт намгийн хуримтлалын нөхцөлөөс хамаарна. Цанхийн хэсэгт нарийвчлан судалснаар үнсжилтийн хэмжээ III, IVa болон IVb давхраасуудад хамгийн бага 13.18-16.65% бол VIIIaб, VIIIв дээд болон IXб давхраасууд хамгийн өндөр 35.78-41.71%, бусад давхраасуудад ойролцоогоор 22%-28% байна.

Дэгдэмхий бодисын гарц доороос дээш 15.73-27.29% хүртэл нэмэгдэж дулаан ялгаруулах чадвар 4594-7395 ккал/кг-ийн хооронд өөрчлөгдөж байна.

Нийт хүхрийн хэмжээ IVA, IVb болон IXb давхраас харьцангуй өндөр 1.5%-2.07%, бусад давхраасын хувьд 1%, түүнээс бага.

Ордын хэмжээнд коксжих нүүрсний чийгшилт 0.5-2.1%-ийн хооронд хэлбэлздэг бөгөөд давхарга зүйн эрэмбээр дээшлэх тутам ихэсдэг зүй тогтол ажиглагдаж байна.

Нүүрсний III, IVAb болон салаалсан IVA, IVb давхраасын нүүрс нь металлургийн үйлдвэрт хэрэглэгдэх хатуу коксжих нүүрс буюу кокс үйлдвэрлэхэд тохиромжтой гэж дүгнэжээ.

Нөөцийн ашиглалтын хугацаа

Уурхайн ашиглалтын хугацааг улс орны эдийн засгийн нөхцөл байдал, уурхайн хүчин чадал, нөөц ашиглалтын хэтийн төлөв зэргийг үндэслэн ашиглалтын хугацааг тооцсон байна.

Цанхийн хэсгийн нүүрсийг өндөр хүчин чадал буюу жилд 20-35 сая тн гэж тооцвол 100 гаруй жил, Бортээгийн хэсгийн нүүрсийг цаашид жилд 5 сая тн гэж тооцвол 230 гаруй жил, Оорцогийн хэсгийн нүүрсийг цаашид жилд 5.0 сая тн гэж тооцвол 100 орчим жил ашиглахаар тооцжээ.

Бортолгой, Ончхараатын хэсэгт эрэл үнэлгээ хийгдсэн тул урьдчилсан болон нарийвчилсан хайгуул хийгдсэний дараа ашиглалтын үеийн тооцоог хийх боломжтой байна.

I үе шат буюу эхний ээлжинд А, В, С ангиллын нөөцийг олборлохоор тооцоолсон бол II үе шатанд нэмэлт хайгуул, олборлолтын аргыг нарийвчилсан судалснаар баялаг буюу P₁ зэрэглэлд багтах нүүрсийг ашиглахаар тооцоолжээ.

Хүснэгт 7. Уурхайн ашиглалтын хугацаа


Орд	Үзүүлэлтүүд	Нэгж	I үе шат	II үе шат
Цанхийн Баруун	Хүчин чадал,	сая тн/жил	20	10
	Ашиглалтын хугацаа	жил	55-60	43
Цанхийн Зүүн	Хүчин чадал	сая тн/жил	15	10
	Ашиглалтын хугацаа	жил	30	43
Бортээгийн	Хүчин чадал	сая тн/жил	10	234
	Ашиглалтын хугацаа	жил	106-109	234



2021.03.26



0000030



Оорцог	Хүчин чадал	сая тн/жил	5	5
	Ашиглалтын хугацаа	жил	35-37	60

2. Цанхийн Зүүн болон Баруун уурхайн нөөцийн тайлан

2020 онд Эрдэнэс-Тавантолгой ХК нь Стантек Консалтинг Интернэйшнл ХХК /Стантек/ компаниар Цанхийн зүүн болон баруун уурхайд хамаарах талбайд JORC олон улсын стандартын дагуу геологийн хайгуулын болон нөөцийн хараат бус техникийн тайланг, нөөцийн тайланг JORC стандарт, болон NI 43-101 стандартын дагуу гүйцэтгүүлсэн байна.


Стантек Консалтинг Интернэйшнл ХХК нь ордын Баруун Зүүн цанхийн лицензийн эзэмшлийн газарт давхраасын геологийн моделийг боловсруулах, хайгуул, өрөмдлөг, нүүрсний чанарын судалгааг гүйцэтгэн JORC стандартын нөөцийн тооцоолол, ангиллыг Австралийн Хайгуулын Үр Дүн, Ашигт Малтмалын болон Ордын Нөөц Тайлагнах Код ("JORC 2012 Код" болон Хамтарсан Хүдрийн Нөөцийн Хороо et.al., 2012), Нүүрсний нөөцийг үнэлэх, ангилах Австралийн удирдамжийн (Шинэ Өмнөд Уэльсийн Нүүрсний ордуудын Геологийн зөвлөл, 2014 он) шаардлагуудын дагуу гаргах гүйцэтгэсэн бол NI 43-101 стандартын нөөцийн тооцооллыг уул уурхайн төсөлд зориулсан удирдамжийн үндэсний стандарт 43-101 (Канадын Үнэт Цаасны Зохицуулах Газар, 2011), Канадын Геологийн Судалгаа 88-21, (Hughes) болон Австралийн Хайгуулын Үр Дүн, Ашигт Малтмалын болон Ордын Нөөц Тайлагнах Код ("JORC 2012 Код" болон Хамтарсан Хүдрийн Нөөцийн Хороо et.al., 2012) шаардлагуудын дагуу хараат бус 2 тайланг боловсруулах зэрэг ажиллагааг компанитай байгуулсан гэрээний хүрээнд гүйцэтгэжээ.

Хараат бус тайланг Стантек компанийн геологийн хэлтсийн менежер, захирал, мэргэшсэн шинжээч Lawrance D.Henchele ахлагчтай баг боловсруулсан. Ноён Lawrance D.Henchele нь АНУ-ын Юта мужийн мэргэшсэн геологич, Америкийн уул уурхай, металлурги, газрын тосны институцийн гишүүн ба уул уурхай, геологи хайгуулын чиглэлээр 40 жил ажиллаж АНУ, Канад, Мексик, Монгол, Энэтхэг зэрэг улсуудын нүүрсний ордуудад тайлан гаргаж байсан туршлагатай.

Уурхайн талаар

Цанхийн уурхай дахь нүүрсний ихэнх нь гангийн үйлдвэрт ашиглагддаг сайн чанарын төмөрлөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлд хэрэглэгддэг коксжих нүүрсний шинж чанарыг агуулдаг. Тавантолгойн орд тэр дундаа Цанхийн талбайн гол шинж чанар бол гадаргын аргаар олборлоход тохиромжтой хатуу коксжих нүүрс. Монголын Засгийн Газраас 2009 онд Норвестийн хийсэн Цанхийн уул уурхай, эдийн засгийн бодит үндэслэл дээр суурилан олборлогдох боломжтой хоёр хэсэгт хуваасан. Энэхүү 2 уурхай нь зэргэлдээ орших нэг ордоос салбарласан хэсгүүд/уурхай/ бөгөөд өмнөх судалгаануудад хоёр тусдаа уул уурхайн төсөл болгон хөгжүүлэхээр санал болгосон.

Эрдэнэс Таван Толгой ХК нь Таван Толгойн уурхайн Цанхийн баруун, зүүн талбай /блок/-г багтаасан тусгай зөвшөөрлийг эзэмшдэг. Энэ 2 уурхай нь Дэлхийн хамгийн том ордын нэг болох Таван Толгой ордыг төлөөлөхүйц нөөцийн хамгийн үнэ цэнэтэй хэсгүүд нь гэж үздэг. Стантек компани дээрх хоёр төслийг газрын гадаргын олборлолтын журмыг ашиглан ил уурхай болгон хөгжүүлэх эдийн засгийн үндэслэлийг харуулсан судалгаа хийсэн. Эдгээр судалгаануудын ихэнх нь JORC 2012 кодчиллын стандарт, Лондоны




2021-03-26

хөрөнгийн бирж (LSE)-ээс тогтоосон стандартын дагуу тус уурхайн хосолмол ашиглалтын нөөц, нийт нөөцийг тодорхойлсон байдаг.

БҮРТГЭВ-02

Цанхийн хэсгийн геологийн тогтоц, нүүрсний тархалт:

Зураг 3. Цанхийн хэсгийн нүүрсний давхраасуудын тогтоц



Цанхийн ордод 0-14 хүртэл нийт 15 давхраасыг тогтоосон. Эдгээр 15 давхраасаас 10 давхраас нь нүүрс илрээгүй бие даасан дэд давхраасуудад хуваагдсан ба нийт 31 бие даасан дэд давхраасуудаас бүрдсэн.

- Давхраас 0

Давхраас 0 нь 3-4 бие даасан дэд давхраасуудад хуваагдаж байгаа бөгөөд тэдгээр давхраасын дундаж зузаан нь 6м-ээс бага байна.

- Давхраас 1, 2:

1, 2-р давхраасын хувьд хоёулаа нимгэн бүтэцтэй бөгөөд нүүрсний хувьд ерөнхийдөө борлуулах боломжгүй гэж үзсэн.

- Давхраас 3, 4:

3, 4-р давхраас нь тус тус 4 хүртэлх бие даасан дэд давхраас бүтсэн, холимог зузаан давхраасууд юм. Жишээ нь 3В бие даасан дэд давхраас гэхэд 28 м-с дэш зузаантай байна. 4-р давхраас нь мөн Цанхийн тайлбайн төв хэсэгт байх 40 м-ээс дээш зузаантай давхраас. Мөн 3, 4-р давхраас нь үнслэг чанар багатай, хануу коксжилт нүүрс


ЭРЭЭ-ӨС ТАВАНТӨЛГӨЙ
ХАМТООГЧИД
УХАА
ХАМГААГАХ
ХЭМЖЭЭГЧИД
СЭХ

Б. АНДАН
111520447

2021.03.19



0000032



үйлдвэрлэхэд хамгийн тохиромжтой хэсэг гэж үзсэн. Мөн Цанхийн баруун, зүүн уурхайн эхний жилүүдэд түүхийгээр зарахад ч гэсэн давхраас 4 нь өндөр чанартай гэж гарсан.

- Давхраас 5:

Давхраас 5 нь 3 бие даасан дэд давхраасуудад хуваагдсан бөгөөд эдгээр нь 20 м хүртэл зузаантай байна. Эдгээр бие даасан дэд давхраасууд нь чулуулгын 9 хуваагдал харуулсан.

- Давхраас 6, 7:

6, 7-р давхраас нь металлургийн коксжих нүүрснээс илүүтэй эрчим хүчний нүүрс байдлаар ашиглахад тохиромжтой нүүрс агуулсан давхраас юм. Давхраас 6 нь ямар нэгэн хуваагдал байхгүй, харин давхраас 7 нь дотор талдаа А, В гэсэн бие даасан дэд давхраасуудад хуваагддаг.

- Давхраас 8,9:

8,9-р давхраас нь хамгийн зузаан давхраасууд бөгөөд давхраас 8 нь 3, давхраас 9 нь 5 хэсэг хуваагдал харуулсан. 8, 9-р давхраас нь зөөлөн коксжих нүүрс гаргахад тохиромжтой хэсэг гэж үзсэн. Мөн эдгээр давхраасын нүүрсийг угааж өндөр чанарын эрчим хүчний нүүрс гарган авах боломжтой.

- Давхраас 10-13

Эдгээр давхраасыг хагас зөөлөн коксжих нүүрс байх боломжтой хэсэг гэж тогтоосон бөгөөд энэ нь өмнө хийгдсэн судалгаануудаар ч мөн батлагдсан. 11-р давхраас нь 2-3 дэд хэсгүүдэд хуваагддаг. Баруун цанхийн 10-р давхраас хагас зөөлөн коксжих нүүрс нөөцтэй хэмээн тогтоогдсон бөгөөд 11-13-р давхраасын нүүрс нь коксжих, өндөр чанарын коксжих нүүрс болох эсэхийг судлахад тохиромжгүй гэх үр дүн гарсан.

- Давхраас 14, 15, 16:

14, 15, 16-р давхраас нь Стантекаас гаргасан нүүрсний ордын тооцоололд тусгагдаагүй. 14-р давхраас нь зөвхөн 2 цооногт харин 15, 16-р давхраас нь сувгийн малтлаг /trenching/ хийх үед л илэрсэн.

Коксжих шинж чанарууд дээр үндэслэн 0С, 3, 4, 8, 9, 10-р давхраасыг өмнөх судалгаагаар металлургийн агуулгатай нүүрс, ялангуяа баяжуулалт хийсний буюу "угаасны" дараа ангилж, эдийн засгийн үнэлэмжийг нэмэгдүүлэх боломжтой гэж дүгнэсэн. Стантек компанийн гаргасан энэхүү судалгаагаар 0D, 5 давхраасыг мөн металлургийн таатай шинж чанарыг харуулсан нүүрсний давхраасын жагсаалтад нэмж оруулсан болно. Харин үлдсэн давхраалжилтууд нь эрчим хүчний нүүрс гаргах боломжтой хэсгүүд гэж үзсэн.

Нүүрсний чанар

Зүүн ба Баруун Цанхийн нүүрсний нөөцийг судлах ажлын хүрээнд нүүрсний түүхий эд чанарыг судалсан. Тавантолгойгоос олборлосон нүүрсний дийлэнх хэсгийг металлургийн шинж чанарыг нь сайжруулахын тулд нүүрсийг баяжуулах (угааж) боловч Стантек компаниас гаргасан уг техникийн тайлан түүхий нүүрсний нөөцийн талаарх тайлан тул төмөрлөгийн шинж чанарын талаар нарийвчлан авч үзээгүй болно. Түүхий нүүрсний чанар дараах анхдагч хэсгүүдэд/үзүүлэлтүүдээс хамаарч байна.



- Чийгшилт (%)
- Үнсжилт (%)
- Дэгдэмхий бодис агуулга (%)
- Хүхрийн агуулга (%)
- Илчлэг (Kcal/kg)
- Хуурай агаарын нягт (g/cm^3)

Дараах хүснэгтэд Зүүн ба Баруун Цанхийн нүүрсний нөөц, нүүрсний дундаж чанарыг геологийн моделдос хамааруулан түүхий нүүрсний, хуурай төлөвөөр тооцоологдсон. Үнсжилтийн дундаж үзүүлэлтүүд нь Монгол дахь ердийн Пермийн нүүрсний хувьд дунд зэрэг, илчлэг ихтэй, хүхрийн агууламж бага байгааг харуулж байна. Чөлөөт хөөлтийн зэрэг FSI (Free Swelling Index)-ийн үзүүлэлт нь тогтоогдсон коксжих нүүрсний давхраасын хувьд сайн үзүүлэлттэй байна. Давхаргын бүлэг тус бүрийн нүүрсний зэрэглэлийг үнслэг, чийг, хүхрийн агуулга, дэгдэмхий бодисын агууламж, илчлэгийн хэмжээ, зэргийг ашиглан ASTM стандартаар тооцсон болно. Эдгээр бүх тооцоолол нь өмнө Эрдэнэс Таван Толгой ХК-иас гаргасан техникийн тайланд дурдсан нүүрсний чанарын үзүүлэлтээс илт сайжирсан үр дүнг харуулсан.

Хүснэгт 8. Цанхийн баруун, зүүн уурхайн нүүрсний чанар

Давхраас	Чийгшилт (%)	Үнсжилт (%)	Хүхрийн агуулга (%)	Дэгдэмхий бодис агуулга (%)	Илчлэг (Kcal/kg)	FSI	Эрэмб (D338-99)2
14	0.97	32.13	0.46	21.76	5,568	n/d	mvb
13	1.18	35.96	0.67	21.40	5,097	1.0	hvAb
12	0.79	33.55	0.63	21.88	5,366	1.0	mvb
11	1.33	30.23	0.67	23.25	5,638	1.0	hvAb
10	1.35	23.38	0.93	26.52	6,237	3.0	hvAb
9	0.84	26.63	0.78	24.00	6,043	3.5	hvAb
8	0.69	28.79	0.80	23.00	5,869	3.5	mvb
7	0.61	29.19	0.72	23.11	5,897	4.00	mvb
6	0.56	35.87	0.52	20.92	5,336	3.00	mvb
5	0.70	32.49	0.78	21.65	5,524	4.00	mvb
4	0.59	25.81	0.86	23.01	6,171	4.50	mvb
3	0.57	24.45	0.86	22.69	6,316	4.00	mvb
2	0.44	25.49	0.71	21.20	6,253	3.50	mvb
1	0.46	29.04	0.58	20.20	5,946	3.00	mvb
0	0.50	25.92	0.79	20.74	6,174	2.00	mvb

- Цанхийн нүүрсний чийгшилтийн хувьд хамгийн чухал давхраасын хэсгүүдэд 0.4-0.8 хувь байгаа бол дэлхийн дундаж 0.6 хувь байдаг.
- Үнсжилтийн агууламж нь бүх давхраас дээр 40 хувиас бага байна. Хамгийн чухал хэсгүүд болох 0,3,4,8,9 давхраалжилтын дундаж үнсжилт нь бусад хэсгүүдээс харьцангуй бага буюу 30 хувь хүртэл үзүүлэлттэй байна.

Нийт цанхийн уурхайн нүүрсний илчлэгийн хувьд 5,000-6,000 Kcal/kg байгаа бөгөөд 0,3,4,8,9 давхраалжилтын хувьд хамгийн ихдээ 8,000 Kcal/kg хүртэл илчлэгтэй байх тооцоо гарсан.

Эрдэнэс Таван Толгой ХК
Төрийн захиргаа
Улаанбаатар

Анхруулагч
Эрдэнэс Таван Толгой ХК
111007447

- Цанхийн уурхайн нүүрсний дэгдэмхий бодисын агуулга мөн 40 хувиас бага үзүүлэлтэй гарсан.
- Хүхрийн агуулга дундаж нь 1 хувиас бага, хамгийн их нь 30 хувиас бага гарч байгаа бөгөөд нүүрсийг угаах замаар хүхрийн агуулгыг багасгах боломжтой.
- Цанхийн уурхайн нүүрсний чанарын эрэмбийн хувьд ASMT D388-99 ангилалд багтана гэж үзсэн.

Нүүрсний нөөцийн хэмжээ, ангилал – JORC стандарт

Тайланг Хайгуулын Үр Дүн, Ашигт Малтмалын болон Ордын Нөөц Тайлагнах Кодын шаарлагуудад нийцүүлж хийсэн ба нөөцийн хэмжээг тогтоохдоо доорх мэдээллүүдийг Эрдэнэс Тавантолгой ХК-с болон түүхэн тоон үзүүлэлтүүдээс ашиглав:

- Олборлолтын өмнөх гадаргуун топографи өгөгдөл/дата/
- 2019 оны 9 сарын 30-ны байдлаарх одоогийн гадаргуун топографи өгөгдөл
- 1,657 цооногоос авсан түүхий нүүрсний чанарын шинжилгээний дээжийн мэдээлэл
- Үл хөдлөх хөрөнгийн болон түүний ойр орчмын газрын гадаргуугийн геологийн зураглал
- Лицензийн талбайн хил хязгаар болон уурхайн одоогийн бусад байршлын дэд бүтэц: овоолго, уурхайн цооногууд.

Нөөцийн хэмжээг тогтоохдоо нүүрсний давхраасын хамгийн бага зузаан 0.5м, хамгийн их хуурай үнсжилтийг 40%, нүүрсний давхраас агуулагдах чулууны үеийн хамгийн их зузаан 0.3м, Зүүн Цанхид газрын гадаргуугаас хамгийн ихдээ 500м-ийн гүнд ашиглагдахаар, Баруун Цанхид илүү налуу учир гүн хамгийн ихдээ 400м-ийн гүнд ашиглагдахаар жишиг үзүүлэлтийг авсан байна. Хөрс хуулалтын харьцааг Зүүн болон Баруун Цанхид 3.1:1 болон 3.9:1 тус тус байхаар тооцоолов.

Нөөцийн ангиллыг тооцохдоо ерөмдөлгийн цооногоос хамгийн ойрын нүүрсний давхраасын огтлол хүртэлх зайнаас хамаарч 3 ангилсан. Тухайлбал,


- Measured - 250 метр хүртэл
- Indicated – 250-500 метр хүртэл
- Inferred – 500-2,000 метр хүртэл

Хүснэгт 9. Цанхийн баруун, зүүн уурхайн нөөц /JORC стандарт/

Орд	Нөөцийн ангилал	Зүүн Цанхи	Баруун Цанхи	Нийт
Кожжих нүүрс /сая тонн/	Measured	640.79	662.31	1,303.10
	Indicated	317.04	310.4	627.44
	Inferred	18.59	25.28	43.87
	Нийт	976.41	997.99	1,974.40
Эрчим хүчний нүүрс /сая тонн/	Measured	208.67	201.89	410.56
	Indicated	79.69	112.49	192.18
	Inferred	12.97	6.89	19.86
	Нийт	301.33	321.27	622.60
Нийт /сая тонн/	Measured	849.46	864.2	1,713.66
	Indicated	396.73	422.89	819.62



2021.03.19.304



Inferred	31.56	32.17	63.73
Нийт	1,277.75	1,315.26	2,597.00

Цанхийн 4 лицензийн эзэмшлийн газарт нийт 2,597 сая тонн нүүрсний нөөц тогтоогдсон ба 2,535 сая тонн нь Баттай ба Бодит нөөц бол 64 сая тонн нь боломжит нөөц гэсэн тооцоо гарсан. Нийт Цанхийн нөөцийн 1,931 сая тонн нь сайн чанарын коксжсон нүүрсний шинж чанартай байсан бол үлдсэн 605 сая тонн нь эрчим хүчний нүүрс байхаар тооцоолсон.

Нүүрсний нөөцийн хэмжээ – NI 43-101 стандарт

Нөөцийн тайлан, геологийн моделиг боловсруулахад дараах мэдээллүүдээс ашигласан:

- Литологийн интервалтай (гүний мэдээлэл агуулсан) өрөмдлөгийн дата, давхраасын ID
- Бүртгэл, тодорхойлолт, зураг, түүхий нүүрсний чанарын бүртгэл, геофизикийн мэдээлэл зэргийг харуулсан талбайн дата
- Топографи талбайн судалгааны дата
- 1999 оны ВНР, Норвест, 1987-1999 оны Монголоос боловсруулсан техникийн тайлан, 2019 онд Эрдэнэсийн гаргасан мэдээлэл зэрэг өмнөх тайлангийн төлөвлөгөө, геологийн хөндлөн огтлол

Стантек нь нүүрсний нөөцийн нарийвчилсан хүснэгтийг боловсруулж, Цанхийн зүүн, баруун уурхайн тусгай зөвшөөрлийн талбайн түүхий нүүрсний чанарыг тооцоолсон болно. Стантек компаниас нөөцийн тооцоог гаргахад JORC 2012 кодчиллын стандарт хамгийн тохиромжтой гэж үзсэн тул JORC 2012 кодчиллын стандартыг ашиглан NI 43-101 стандартын дагуу нөөцийн тайлан гаргасан бөгөөд энэхүү техникийн тайлангийн бусад бүх хэсэг, агуулга, дагалдах бичиг баримтууд нь NI 43-101 стандартын дагуу хийгдсэн болно.

Нүүрсний нөөцийн тооцоог гаргахад ашигласан нөөцийн үндсэн үзүүлэлтүүдийн хувьд давхаргын хамгийн бага зузаан нь 0.5м, хуурай үнсжилтийн дээд хэмжээ нь 40% байна. 0.3м-ээс дээш хэмжээтэй нүүрсний давхраасыг нөөцөөс хасчээ.

Нүүрсний нөөцийг төмөрлөгийн шинж чанарын хувьд 3-р давхраасын нөөцийн дээд хэмжээг бүтцийн хувьд таатай бүсэд багтааж, Цанхийн зүүн уурхайд 500 м хүртэл харин баруун уурхайд 400м хүртэл байхаар тооцоолсон. Цооногийн нийт талбайн хэмжээ, хөрс хуулалтын зохистой харьцааг харгалзан үзэхэд гүний хэмжээ нь хоёулаа ердийн олборлолтын хувьд бодит байна гэж үзсэн. Хөрс хуулалтын зохистой харьцааг Цанхийн баруун уурхайд 3.2:1, зүүн уурхайд 3.8:1 байна гэж тооцоолсон бөгөөд хөрс хуулалтын гүн нь 500м хүртэл байна гэж тооцсон.

Нөөцийн ангиллыг тооцохдоо өрөмдөлгийн цооногоос хамгийн ойрын нүүрсний давхраасын огтлол хүртэлх зайнаас хамаарч 3 ангилсан байна. Тухайлбал,

Measured - 250 метр хүртэл
Indicated – 250-500 метр хүртэл
Inferred – 500-2,000 метр хүртэл



2021-03-19

Орд	Нөөцийн ангилал	Зүүн Цанхи	Баруун Цанхи	Нийт
	Measured	645	692	1,337
Коксжих нүүрс /сая тонн/	Indicated	319	314	633
	Inferred	19	25	44
	Нийт	982	1,031	2,013
Эрчим хүчний нүүрс /сая тонн/	Measured	198	197	395
	Indicated	107	151	258
	Inferred	14	8	21
	Нийт	318	357	674
Нийт / сая тонн/	Measured	843	889	1,732
	Indicated	425	466	891
	Inferred	32	33	65
	Нийт	1,302	1,388	2,690

Цанхийн ордод хамаарах 4 лицензэд нийт 2,688 сая тонн нөөц батлагдсан, үүний 2,623 сая тонн нь Баттай ба Бодит нөөц бол үлдсэн 65 сая тонныг боломжит нөөцийн ангилалд оруулсан. Баттай ба бодит нөөцийн 1,970 сая тонн нүүрс коксжих нүүрс ба 653 сая тонн нь эрчим хүчний нүүрсний нөөцөд багтсан.

Мөн нүүрсний нөөцийг металлургийн бүтээгдэхүүнд эсвэл дулааны цахилгаан станцад ашиглах эсэхээс хамаарч коксжих, эрчим хүчний гэж 2 хуваасан. Өмнөх судалгаанууд болон металлургийн анхдагч шинжийг агуулсан эсэх үр дүн зэрэгт үндэслэн давхраасуудыг ангилж, өмнөх нүүрс боловсруулалтын судалгаа, металлургийн анхдагч шинжийг агуулж байгаа эсэх шинжилгээнд үндэслэн нүүрсний зарим давхраасыг коксжих нүүрсний ангилалд оруулсан. Тухайлбал, 0С, 3, 4, 8, 9, 10-р давхраасыг металлургийн шинжтэй буюу коксжих нүүрсний нүүрсний ангилалд оруулсан.

Үүнээс гадна Стантек компаниас өөрийн боловсруулсан судалгаа болон өмнөх 2012 онд хийгдсэн судалгаануудад үндэслэн зарим бие даасан дэд давхраасын хуваагдалыг металлургийн буюу коксжих нүүрсний ангиллаас хасаж, 0D, 5-р давхраасыг энэхүү ангилалд нэмсэн болно. Тодруулбал доорх давхраас, бие даасан дэд давхраас, хуваагдал нь металлургийн нөөцийн ангилалд багтсан болно.

- Давхраас 10 (S10B дэд давхраасыг хасна)
- Давхраас 9 (S9BT, S9AT хуваагдалуудыг хасна)
- Давхраас 8 (S8AT хуваагдалуудыг хасна)
- Давхраас 5 (S5AT хуваагдалуудыг хасна)
- Давхраас 4
- Давхраас 3 (S3DM хуваагдалуудыг хасна)
- Давхраас 0 (зөвхөн S0D, S0C бие даасан дэд давхраасуудыг оруулна)

Хайгуул, үнэлгээний ажил

Тавантолгойн коксжих нүүрсний ордод 1953-1956 онуудад ерөнхий эрэл, 1978-1990 онд ордуудын нүүрстэй хурдсын хил хязгаарыг нарийвчлан тогтоох, коксжих нүүрсний нөөцийг нэмэгдүүлэх, нүүрсний чанарыг нарийвчлан судлах үе шаттай геологийн хайгуулын ажлууд, 2011-2014 онд ашиглалтын хайгуулыг үе шаттайгаар гүйцэтгэсэн.



20210330



0000037

МОНГОЛЫН ХОРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE

1990-ээд он хүртэл Монгол болон ОХУ-ын хамтарсан геологич, шинжээчдийн баг Тавантолгой ордод олон судалгаа, шинжилгээг хийж гүйцэтгэснээс ордын давхарга зүй, нүүрсжилт, нүүрсний чанарын талаар Ф.К.Шипулин (1940), В.А.Бобров (1957), Н.А.Маринов (1957), Г.Л.Бородяев (1940), П.Д.Шкляев (1966), А.А.Храпов (1967), М.В.Дуранте (1976) В.И.Голденберг (1978), П.Хосбаяр, Ч.Ганхуяг нарын тайлан мэдээлэлд бичигдсэн байна.

Монголын геологичдын энэ ордод гүйцэтгэсэн хээрийн ажлын эрэл-үнэлгээ, урьдчилсан хайгуулын ажлыг ерөнхий геологич Д.Бат-Эрдэнэ (1978-1981), Ж.Жаргалсайхан (1981-1982), Д.Төмөрбаатар (1982-1983), Б.Адъяа (1983-1984), урьдчилсан болон нарийвчилсан хайгуул, зэргэлдээх талбайнуудын эрэл-үнэлгээний ажлыг Ч.Ганхуяг (1984-1990) нарын удирдлагаар гүйцэтгэсэн байна.

Мөн 1978-1981 онд гүйцэтгэсэн эрэл-үнэлгээний хайгуулын ажлын тайлангаар (АМГ-ын ГМТА № 3543), Д.Төмөрбаатар С.Жагар, Ж.Жаргалсайхан, Ч.Ганхуяг, Д.Эрдэнэ нар балансын нөөцийг С1+С2 зэргээр 2970.4 сая тн, таамаг нөөцийг 2103.3 сая тн-оор, Д.Оросоо 1977-1978 онд Тавантолгойн ордын нүүрсний VIII давхраасын нарийвчилсан хайгуулын тайланг (АМГ-ын ГМТА № 2713) бичиж нөөцийг А+В+С1 зэргээр 8,006.6 мян. тонноор, ордын Цанхи болон Баруун өмнөд хэсэгт 1981-1984 онд гүйцэтгэсэн урьдчилсан хайгуулын ажлын үр дүнгийн тайланд АМГ-ын ГМТА №3726), А.Чимэддорж, Б.Адъяа, Ч.Ганхуяг, В.П.Бабенко, С.Жагар, Р.Тогоо, Ч.Гомбосүрэн, Ө.Энхтөгс, Ж.Ганболд нар нөөцийг Цанхийн хэсгийн нөөцийг 1421 сая тн исэлдсэн 78.7 сая тн, баруун өмнөд хэсэгт 168.4 сая тн, исэлдсэн 10.3 сая тн-оор батлуулсан байдаг.

Тавантолгойн коксжих нүүрсний ордын Цанхийн хэсгийн эхний ээлжийн ашиглах талбайн 1984-1987 оны нарийвчилсан хайгуулын ажлын үр дүнгийн тайланд (Нөөцийн тооцоо 1988 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар), (АМГ-ын ГМТА № 4230), нөөцийг Ч.Ганхуяг, З.С.Цадер, Д.Эрдэнэ, А.Эвийхүү, Л.Л.Цадер, Т.Адъяа, С.Гомборагчаа нар А+В+С1+С2 зэргээр 1,445.3 сая тн, коксжих 828.7 сая тн, эрчим хүчний 543 сая тн, исэлдсэн 73.6 сая тн-оор батлуулсан.

Ч.Ганхуяг, П.Хосбаяр А. Эвийхүү нарын 1989-1993 онд гүйцэтгэсэн ордын Цанхийн зүүн ба баруун хэсгийн нарийвчилсан хайгуул, Бортээгийн хэсгийн урьдчилсан хайгуул болон Эрдэнэ булгийн ордын эрлийн ажлын үр дүнгийн тайланд (Нөөцийн тооцоо 1993 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар), АМГ-ын ГМТА № 4723), нийт нөөцийг Цанхийн хэсэгт А+В+С1+С2 зэргээр 1073.5 сая тонн үүнээс коксжих нүүрс 553.7 сая тн, эрчим хүчний нүүрс 463.7 сая тн, исэлдсэн 56.3 сая тн, Бортээгийн хэсэгт нийт нөөцийг В+С1+С2 зэргээр 1082 сая тн, коксжих нүүрс 307 сая тн, эрчим хүчний нүүрс 719.6 сая тн, исэлдсэн нүүрсийг 55.4 сая тн-оор тус тус тооцоолсон байна.

Эрдэнэс-Тавантолгой ХК нь тусгай зөвшөөрлийн талбайг эзэмшиж эхэлснээс хойш хайгуул, үнэлгээ судалгааны ажлыг шат дараалан гүйцэтгэн хайгуулын мэдээлэлд тоон болон чанарын үнэлгээ хийх, мэдээллийн сангийн менежментийг хөтлөх баталгаажуулалт хийн, орд газрын 2 болон 3 хэмжээст геологи, нүүрсжилтийн загварчлал хийх зэрэг ажиллагааг гүйцэтгэж байна.


Ч.Ганхуяг, Б.Гантулга нар 2011 онд Цанхи, Бортээгийн зүүн хэсгийн ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд нөөцийн тодотгол тооцооны тайлан



2021.03.26

- 2012 он Ч.Ганхуяг, Б.Гантулга, Г.Сумъяагарав нар 2012 онд Цанхийн баруун, Бортээгийн хойд, Ухаахудагийн баруун хэсгийн "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн тусгай зөвшөөрлийн талбайд нөөцийн тодотгол тооцооны тайлан
- 2013-2014 Цанхийн хэсэгт 40,000 тууш метр ашиглалтын хайгуулын өрөмдлөгийн ажлыг хийж гүйцэтгэсэн ба уг өрөмдлөгийн үр дүнг Цанхийн уурхайн ашиглалт, тэлэлтэд 3 хэмжээс загварчлал болгон ашигласан
- 2017-2018 2017-2018 онд Цанхийн хэсгийн 13,000 тууш метр ашиглалтын хайгуул, Бортээгийн хэсгийн 50,000 тууш метр нарийвчилсан хайгуулын үр дүнг тайланг гаргасан.
- 2019 2019 онд Цанхийн хэсэгт ашиглалтын хайгуулын 15,000 тууш метр, Бортээг, Оорцогийн хэсэгт нарийвчилсан хайгуулын 62,300 тууш метр, нийт 77,300 тууш метрийн өрөмдлөг, физик геологийн боловсруулалт судалгааны ажлыг хийж гүйцэтгэжээ.

Зураг 4. Тавантолгой бүлэг ордод хийгдсэн хайгуулын ажил, цаашдын төлөвлөгөө



Red stamp: TAVAN ERDENES TAVAN TOLGOI XK
 Handwritten signature in black ink over the stamp.

Red stamp: MNC-00010005
 Handwritten signature in black ink over the stamp.



1.6.4 Уурхайн үйл ажиллагаа

Эрдэнэс-Тавантолгой ХК нь Цанхийн Зүүн болон Баруун хэсгийн уурхайд хөрс хуулалт, нүүрс олборлолтын ажлыг Ашигт малтмал, газрын тосны газраар батлуулсан төлөвлөгөөний дагуу гэрээт олборлогч компаниудаар гүйцэтгүүлэн, технологи, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны шаардлагад нийцүүлэн ажиллаж байна.

Уурхай нь 14 хоногийн ростоор, өдөр шөнийн 4 ээлжээр зохион байгуулагдсан тул 7 хоногийн 24 цаг тасралтгүй ажилладаг.

Компани нь жил бүр техник тоног төхөөрөмжийн хүчин чадлаа нэмэгдүүлэн, олборлогч компаниудтай хамтран ажилласнаар 2010 оноос хойш 2021 оны 3-р сар хүртэлх хугацаанд Цанхийн уурхайд нийт 362.6 сая.м³ хөрс хуулалт хийжээ. 2020 онд 75.8 сая.м³ хөрс хуулсан. 2021 оны 1, 2 сард 15.4 сая.м³ уулын цулын ажил гүйцэтгэжээ.

График 3. Цанхийн уурхайн хөрс хуулалт, сая.м³



Ил уурхайд олборлолтын үйл ажиллагааг уламжлалт технологи буюу экскаватор-автосамосвалын хослол бүхий гадаад овоолготой ашиглалтын систем ашиглан гэрээт олборлогчдоор гүйцэтгүүлдэг ба ТЭЗҮ-д тусгагдсаны дагуу Цанхийн Баруун уурхайн хөрсний 1-р овоолго дүүрсэн тул хөрсний 2-р овоолгод уулын цул байршуулан ажиллаж байна.

2020 онд компани 13.06 сая тонн нүүрс олборлосон ба компани үйл ажиллагаагаа явуулж эхэлснээс хойш нийт 78.4 сая тонн нүүрс олборлож, 73.4 сая тонн нүүрс борлуулснаас 55.5 сая тонныг экспортолсон.

2020 онд Цанхийн баруун уурхайгаас 9.2 сая тонн, зүүн уурхайгаас 16.5 сая тонн нүүрс борлуулахаар төлөвлөсөн байсан ч цар тахлын нөхцөл байдлын улмаас эхний хагас жилийн борлуулалтын хэмжээ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад их дүнгээр буурсан тул 2020 оны төсөв, төлөвлөгөөнд тодотгол оруулж, Цанхийн баруун уурхайн төлөвлөгөөг 5.3 сая тонн, Цанхийн зүүн уурхайн борлуулалтын төлөвлөгөөг 7.3 сая тонн, нийт 12.6 сая тонн болгон өөрчилсөн байна.

2021 оны 1, 2-р сарын байдлаар 3.1 сая тонн нүүрс олборлож, 3.3 сая тонн нүүрс борлуулсан байна.

Handwritten signature and red stamp of Erdene-Tavan Tolgoi JSC.

Handwritten signature and red stamp of Erdene-Tavan Tolgoi JSC, including contact information: 111525447 & 2652447.

20210305

График 4. Цанхийн уурхайн олборлолт, борлуулалт сая.тн



2021-03-19
БҮРТГЭВ-02

Уурхайгаас олборлосон түүхий нүүрсийг агуулахад байршуулан нүүрсний овоолго үүсгэдэг. Үүсгэсэн овоолгоос гаалийн хяналтын бүсийн холбогдох хууль, дүрэм, журам, стандартад нийцүүлэн аюулгүй ажиллагааг мөрдлөг болгон нүүрс ачилтыг хийдэг.

2013 онд борлуулалтын орлого, нүүрсний экспортыг нэмэгдүүлэх үүднээс Цанхийн баруун уурхайг нээсэн бөгөөд олборлох нүүрсийг борлуулах талаар худалдан авагч талуудтай хэлэлцээр хийж 8 дугаар сараас нүүрсээ экспортонд гаргаж эхэлснээр хөрс хуулалт, олборлолтын хэмжээ эрс нэмэгдсэн байна. 2010-2015 онд 17 сая тонн нүүрс олборлож байсан бол 2016-2019 онд нүүрсний үнэ олон улсын зах зээл дээр тогтворжин үнэ нэмэгдсэнээр нүүрсний олборлолтын хэмжээ 2.6 дахин өссөн.

Уурхайн хөрс хуулалт, олборлолтын хэмжээ тухайн жилийн нүүрсний зах зээлийн нөхцөл байдал, эрэлт нийлүүлэлтээс хамааран хэлбэлзэж байна.

Борлуулалт

Компани үйл ажиллагаагаа явуулж эхэлсэнээс хойш 59.1 сая тонн нүүрс борлуулж, 7.33 их наяд төгрөгийн орлоготой ажилласан байна. Өнгөрсөн 9 жилийн хугацаанд борлуулалтын орлого жилд дунджаар 141%-иар өссөн нь компанийн үйл ажиллагаа өндөр өсөлттэй байгааг илтгэж байна.

2019 онд Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн борлуулалтын орлого 1 тэрбум доллар буюу 2.66 их наяд төгрөгт хүрч Монгол улсад хамгийн өндөр борлуулалт хийсэн компани болсон.


2020 онд коронавирус цар тахлын нөлөөгөөр экспорт зогссон, БНХАУ-ын коксжих нүүрсний үнэ өмнөх оны дунджаас 12 хувиар буурсан зэргээс шалтгаалан 3-р улирлын байдлаар олборлолт, борлуулалт огцом буурсан байна. 2020 оны 09 сараас Монгол, БНХАУ-ын хилийн боомтын "Ногоон гарц"-ыг хэрэгжүүлэх түр журам хэрэгжиж эхэлснээр нүүрсний экспорт нэмэгджээ.

Stamp: ТАВАН
ЭРДЭНЭС
ТАВАН
ТОЛГОЙ
ХК
Signature

Stamp: МХБ-ийн гишүүн
Андеррайтер
Брэкер, дилерийн
"МДНСХ"
ҮШКХ
1115205441 2052442
Signature

2021.03.26 10:30

График 5. Цанхийн уурхайн борлуулалт тэр.төг



Үйл ажиллагааны эхэн үед Цанхийн зүүн уурхайгаас олборлолт явуулж байсан ба 2013 онд Цанхийн баруун уурхайг эдийн засгийн эргэлтэнд оруулснаар олборлолт нэмэгдсэн ч тухайн үеийн түүхий эдийн зах зээлийн бууралт болон өр төлбөр их байснаас борлуулалтын үзүүлэлт харьцангуй бага байсан.

2012-2016 онд үргэлжилсэн дэлхийн түүхий эдийн үнийн уналтаас шалтгаалан нүүрсний үнэ буурч, эрэлт багассан ба 2016 оноос нүүрсний үнэ сэргэж эхэлсэн ба олон улсын томоохон судалгааны байгууллагуудаас үнийг цаашид тогтвортой байхаар таамаглажээ.

Компани нь 2012 онд Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэрээр "Хүний хөгжил сан"-аар дамжуулж иргэн бүрт олгосон халамжийн хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилгоор Эрдэнэс Тавантолгой ХК нь БНХАУ-ын "Чалко Трэйдинг Хонконг Лимитэд" компаниас нүүрсний борлуулалтын урьдчилгаа төлбөр 350 сая ам.доллар болон дотоодын арилжааны банкуудаас 129 тэрбум төгрөгийн зээлийг авсан.

Мөн компанийн үндсэн үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэх зорилгоор 2013 онд Хөгжлийн банкнаас 200 сая ам.доллар, 2014 онд 50 сая ам долларын зээлийг авсан бөгөөд эдгээр зээлийг 2018 онд төлж барагдуулсан байна.

2017 онд Чалко Трэйдинг ХонгКонг Лимитэд компанийн 350 сая ам.долларын зээлийг, 2018 онд Хөгжлийн банкны 300 сая ам.долларын зээлийг тус тус төлж барагдуулсан.

Чалко компанитай байгуулсан урьдчилгаа гэрээний дагуу Цанхийн Зүүн уурхайгийн нүүрсийг зах зээлийн үнээс хямд үнээр Чалко компанид борлуулан борлуулалтын орлого бодитоор орохгүй байсан нь борлуулалт, цэвэр ашигт сөргөөр нөлөөлсөн.

Компанийн борлуулалт, ашгийн үзүүлэлт 2017 оноос эрс өсөж байгаа нь олон улсын зах зээл дээр нүүрсний үнэ өсөж, тогтворжсон, компанийн томоохон өр төлбөрүүдийг төлж барагдуулсан зэрэг үзүүлэлтүүдээс голчлон хамаарч байна.

Борлуулалтын бүтэц

Компанийн борлуулалтын 90 гаруй хувийг коксжих нүүрсний борлуулалт эзэлдэг. Гол худалдан авагч БНХАУ-ын хувьд нүүрсний чанарт хатуу хяналт тавьдаг үндэслэлээр нүүрсний чанарыг авах сонирхол бага, үнэ хямд байдаг. Нүүрс тээврийн зардал 2018-2019



2021.03.04



онуудад хэлбэлзэл өндөртэй байсан тул исэлдсэн, эрчим хүчний нүүрсний борлуулалт бага байдаг.

График 6. Борлуулалтын бүтэц, бүтээгдэхүүнээр 2017-2020Q3



Компани 2019 онд 15 сая тонн коксжих нүүрс, 0.5 сая тонн эрчим хүчний нүүрс нийт 15.5 сая тонн нүүрс борлуулсан бол 2020 оны 3-р улирлын байдлаар нийт 0.11 сая тонн эрчим хүчний нүүрс, 3.1 сая тонн коксжих нүүрс борлуулсан байна.

Цанхийн Зүүн уурхай нь 2016 оноос өмнө борлуулалтын дийлэнх хэсгийг буюу 80-аас дээш хувийг эзэлдэг байсан бол сүүлийн жилүүдэд Баруун Цанхийн уурхайн олборлолт, борлуулалтын хэмжээ нэмэгдэж нийт борлуулалтын орлогын 30 гаруй хувийг эзэлж байна. Тодруулбал, 2017-2019 онуудад Цанхийн Зүүн уурхайн борлуулалт дунджаар 64 хувь, Баруун Цанхийн борлуулалт 36 хувь байна.

Баруун Цанхийн уурхай нь Зүүн Цанхийн уурхайгаас нөөц болон талбайн хэмжээгээр харьцангуй их, жилд 8 орчим сая тонн нүүрс олборлох хүчин чадалтай. Одоогоор тус уурхай нь бүрэн хүчин чадлаараа ажиллахгүй байна.


График 7. Борлуулалтын бүтэц, ордоор 2017-2020Q3



2019 онд 9.89 сая тонн нүүрсийг Цанхийн зүүн уурхайгаас, 5.6 сая тонн нүүрсийг Цанхийн баруун уурхайгаас нийлүүлсэн нь өмнөх оноос 17%, 20% тус тус өссөн үзүүлэлт. 2020 оны 3-р улирлын байдлаар 1.98 сая тонн нүүрсийг Цанхийн зүүн уурхайгаас, 1.25 сая тонн нүүрсийг Цанхийн баруун уурхайгаас нийлүүлжээ.

Экспорт

2018 онд зорилтот зах зээл болох БНХАУ-д Монгол улсаас 26.9 сая тн коксжих нүүрс экспортложээ. Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн нүүрсний экспортын хэмжээ 2019 онд 14.3 сая тонн нүүрс экспортлож Монгол улсын нүүрсний нийт экспортын 40 хувийг дангаараа бүрдүүлсэн.



2021.03.05

2016 оноос хойш коксжих нүүрсний экспорт тогтмол өсөж байгаа бөгөөд зорилтот зах зээл болох БНХАУ-ын коксжих нүүрсний импортод эзлэх Монгол улсын коксжих нүүрсний хувь хэмжээ нэмэгдсээр байна.

2020 онд коронавирус цар тахлын нөлөөгөөр хил хааснаас шалтгаалан нүүрс экспортын хэмжээ өмнөх оноос 22%-иар буурч 28.6 сая тонн болсон байна.


График 8. Экспортод эзлэх хувь



Борлуулалтын нөхцөл

Эрдэнэс-Тавантолгой ХК нь дундын зуучлагч компаниудаар дамжуулан БНХАУ-ын Ганц модны боомтоос тухайн бүс нутгийн угаах үйлдвэрүүдэд нүүрсээ борлуулж байна. Дундын зуучлагч компаниудад "FCA-Уурхайн ам" нөхцөлөөр нүүрсийг борлуулж ажилладаг.

Зураг 5. Борлуулалт-тээвэрлэлтийн схем



Эрдэнэс-Тавантолгой ХК нь дундын зуучлагч компаниудад БНХАУ-ын Ганц модны боомтоос тухайн бүс нутгийн үйлдвэрүүдэд нүүрсээ борлуулдаг. Цаашид хийгдэх төмөр зам болон авто замын бүтээн байгуулалттай холбоотойгоор борлуулалтын сувгийн өргөжилт үүсч DAP нөхцөлөөр, "Гуравдагч зах зээл"-д бүтээгдэхүүн борлуулах нөхцөл бүрдэх боломжтой.

Эрдэнэс-Тавантолгой ХК
11520544
2017

БНХАУ-ын Ганц модны боомтоос тухайн бүс нутгийн үйлдвэрүүдэд нүүрсээ борлуулдаг.
Цаашид хийгдэх төмөр зам болон авто замын бүтээн байгуулалттай холбоотойгоор борлуулалтын сувгийн өргөжилт үүсч DAP нөхцөлөөр, "Гуравдагч зах зээл"-д бүтээгдэхүүн борлуулах нөхцөл бүрдэх боломжтой.

Компани 2016-2018 онд нийт 29.1 сая тонн нүүрс борлуулснаас Чалко компанид 8.5 сая буюу 29%, E-commodities компанид 8.8 сая тонн буюу 30%, үлдсэнийг бусад худалдан авагч компаниудад нийлүүлсэн байна. Цанхийн баруун уурхайн хувьд нийт 8.98 сая тонн нүүрс борлуулснаас E-commodities болон Zi Tuo компаниудад тус бүр 1 сая тонн, үлдсэн нүүрсийг бусад худалдан авагч компаниудад нийлүүлсэн байна.

Хүснэгт 11. Нийт борлуулалт худалдан авагч компаниудаар 2016-2018

Худалдан авагч компаниуд	Баруун Сая тонн	Зүүн Сая тонн	Нийт Сая тонн
E-Commodities (HK) Holdings	1,166,511	7,645,322	8,811,834
Chalco trading hong kong	-	8,475,405	8,475,405
Inner Mongolia Wangjin Energy	434,384	608,998	1,043,382
Inner Mongolia Zi Tuo International Trade	1,015,736	84,138	1,099,875
Inner Mongolia Hao Xiang Coal Industry	769,411	160,433	929,845
Inner Mongolia Linhe Enegy	634,105	164,350	798,456
Inner Mongolia Bo Yuan Shidi Enegy	518,628	156,762	675,391
Бусад компаниуд	4,437,455	2,789,481	7,226,936
Нийт дүн	8,976,233	20,084,893	29,061,127

Компани нь 2017 оны 01 сараас нүүрс худалдан авагчийн нээлттэй сонгон шалгаруулалт зарлаж эхэлсэн ба Цанхийн баруун уурхайн нийт нүүрс, Цанхийн зүүн уурхайн нийт нүүрсний 20%-ийг сонгон шалгаруулалтын хүрээнд борлуулж байна.

График 9. Цанхийн зүүн уурхайн борлуулалтад Чалко компанийн эзлэх хувь



Дэд бүтэц, тээвэр ложистик

Эрдэнэс-Таван толгой ХК нь борлуулалтын гэрээний хүрээнд нүүрс ачиж, экспортлох ажлыг зохион байгуулж ажилладаг. Компани 2019 онд нийт 52 худалдан авагчтай байгуулсан 63 борлуулалтын гэрээний хүрээнд 216 тээврийн компанийн 8,068 тээврийн хэрэгсэлд 14.3 сая нүүрсийг ачиж экспортолжээ. 2018 онд 189,269 рейс, хоногт дунджаар 39,192 тн нүүрсийг 567 тэвшинд ачилтыг хийж гүйцэтгэсэн байна.

Handwritten signature and red stamp of ERDENES-TAVANTOLGOI CO., LTD.


Handwritten signature and red stamp of ERDENES-TAVANTOLGOI CO., LTD.



0000045

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ ХК

График 10. Тээврийн компани болон рэйсийн тоо



2019 онд Уурхайгаас Гашуунсухайтын чиглэлийн авто зам хүртэлх 18 сая.тн нүүрс тээвэрлэх хүчин чадал бүхий 8.2 км олон улсын стандартад нийцсэн хүнд даацын хатуу хучилттай авто замын барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн. Тухайн бүс нутагт тээвэрлэлтийн хямд бөгөөд үр ашигтай хэрэгсэл болох төмөр замын тээвэрлэлт хөгжөөгүй тул "Тавантолгой-Гашуун сухайт" чиглэлийн авто замын хүчин чадал, хил гаалийн нэвтрүүлэх чадвараас хамааран тээвэрлэлт, цаашлаад олборлолт, борлуулалтын хэмжээ хэлбэлздэг.

Компанийн төлөвлөөд буй авто зам, төмөр замын төслүүд хэрэгжсэнээр тээвэрлэлт, дэд бүтцийн өртөг бага, цогц шийдлийг бий болгон бүтээгдэхүүний зардал буурч, үнэ цэнэ нэмэгдэн компанийн санхүүгийн үзүүлэлтүүдэд эергээр нөлөөлнө.

Бүтээгдэхүүн

Тавантолгойн нүүрсний ордын онцлог нь дээд зэрэглэлийн коксжих нүүрсний нөөцтэй ба нүүрсний шинж чанарын хувьд хүхэр болон үнслэгийн агууламж багатай. Нүүрсний чанар одоо олборлож буй Зүүн Баруун уурхайн хувьд ялгаагүй бөгөөд давхаргаас хамааран харилцан адилгүй байдаг.

Эрдэнэс-Тавантолгой ХК дараах 5 төрлийн нүүрсийг олборлон дотоод болон гадаадын хэрэглэгчдэд нийлүүлж байна.

Компани цаашид нүүрс баяжуулах үйлдвэр, конвейерийн систем, төмөр зам зэрэг дэд бүтцийн бүтээн байгуулалтын төслүүдийг хийж гүйцэтгэсэнээр нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг бий болгох, бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх боломжтой.



02103059



БҮРТГЭВ-02

Бүтээгдэхүүний чанар

Тавантолгойн ордын нүүрсний давхраасуудын чийг 0.5-2.1 хувь, үнс 17.1-31.4 хувь, дэгдэмхий бодисын гарц 19.8-33.6 хувь, хүхэр 0.44-0.79 хувь, дулаан ялгаруулах чадвар 5,540-8,800 ккал/кг ийн хооронд хэлбэлздэг.

Компани нь үйлдвэрлэлийн дамжлага бүрээс сорьц авч шинжлэн, чанарын хяналтыг тогтмол хийдэг.

Хүснэгт 12. Нүүрсний чанарын мэдээлэл

Коксжих нүүрсний чанарын үзүүлэлт							
Давхраас №	Чийг	Үнслэг (ad)	Дэгдэмхий (daf)	Хүхэр (Ad)	G индекс	Чөлөөт хөөлт	Ккал/кг (arb)
Давхраас 3	3.2	16.04	27.2	0.9	65	5	6250
Давхраас 4	2.8	15.3	28.7	0.77	79	5.5	6380
Давхраас 5	3.1	17.8	30.1	0.89	70.3	5	6120
Давхраас 7	3.4	22.09	31.5	1.12	60	4	5685
Давхраас 8	3.9	19.8	32.3	0.75	72.5	5.5	5760
Эрчим хүчний нүүрсний чанарын үзүүлэлт							
Давхраас №	Чийг	Үнслэг (ad)	Дэгдэмхий (daf)	Хүхэр (Ad)			Ккал/кг (arb)
Давхраас 2	5.5	21.1	25.9	0.8			5920
Давхраас 4	5	17.4	29.2	0.72			5850
Давхраас 8	6	21.2	33.1	1.1			5585

Бүтээгдэхүүний үнэ

Үнэт цаас гаргагч нь FCA буюу уурхайн амнаас борлуулах үнийн бодлого баримталдаг. Бүтээгдэхүүний үнэ худалдан авагч компани, гэрээ, нүүрсний чанар зэргээс хамаарах харилцан адилаар байна.





Цанхийн зүүн уурхайн нүүрсийг Чалко Трейдинг Хонг Конг компанид нийлүүлэх урт хугацааны гэрээтэй тул талуудын хооронд тохиролцсон тусгай индекс ашиглан үнийг нь тогтоодог.

2021.03.18
БҮРТГЭВ-02

Компани Баруун цанхийн уурхайн нүүрсний үнийг нээлттэй дуудлага худалдааны зарчмаар тогтоодог бөгөөд тус уурхайд олборлолт хийх компанийг нээлттэй тендерийн сонгон шалгаруулалтаар сонгодог. Компанийн маркетинг, борлуулалтын хэлтэс нь бүтээгдэхүүний үнэ тогтоох, судалгаа, шинжилгээ хийх, худалдан авагчийг сонгон шалгаруулах, гэрээ хийх ажиллагааг дараах байдлаар гүйцэтгэж байна.


Схем 6. Бүтээгдэхүүний үнэ тогтох процесс



Одоогийн мөрдөж буй зах зээлийн зарчмаар тогтсон үнийг суурь үнэ болгох ба цаашид улирал тутам индекс тооцох аргачлалын дагуу үнэ шинэчилдэг.

Татвар, хураамж

График 11. Улс, орон нутагт төлсөн татвар.



Компани нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу татвар хураамжийг төсөвт төлдөг.

Эрдэнэс-Таван толгой ХК нь 2018 онд улсын төсөвт 478.8 тэрбум төгрөг, орон нутгийн төсөвт 10.3 тэрбум төгрөгийн татвар, төлбөр, хураамжийг төвлөрүүлсэн байна. 2019 онд 660 тэрбум төгрөг, 2020 оны эхний хагас жилийн байдлаар 59.5 тэрбум төгрөгийн татвар хураамжийг төвлөрүүлсэн байна.


Handwritten signature and red stamp of ERDENES-TAVAN TOLGOI JSC.

Handwritten signature and red stamp of ERDENES-TAVAN TOLGOI JSC.

Vertical text on the right edge of the page.

Худалдан авах үйл ажиллагаа

"Эрдэнэс-Тавантолгой" ХК нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу нээлттэй, ил тод, хэмнэлттэй байх зарчмыг баримтлан худалдан авалтыг хийж гүйцэтгэдэг ба жил бүр худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Төлөөлөн удирдах зөвлөл, Уул уурхай хүнд үйлдвэрийн яам, Монгол Улсын Сангийн яамаар батлуулж, компанийн хэвийн тасралтгүй үйл ажиллагааг ханган ажиллаж байна. 2017-2020 оны хугацаанд худалдан авалтын төлөвлөгөөний дагуу нийт 379 тендер шалгаруулалтаар



3.4 их наяд төгрөгийн бараа, ажил, үйлчилгээний тендер зарлаж, 3.3 их наяд төгрөгийн гэрээг байгуулж 119,5 тэрбум төгрөгийн төсвийн хэмнэлт гарган ажилласан


Компани 2020 онд Худалдан авах төлөвлөгөөний дагуу нийт 76 тендер шалгаруулалтаар 937 тэрбум төгрөгийн бараа, ажил, үйлчилгээний тендер зарлаж 927 тэрбум төгрөгийн худалдан авалт хийжээ.

Сүүлийн жилүүдэд компанийн үйл ажиллагаа идэвхжин, төсөл хөтөлбөрүүд

хэрэгжүүлэх шаардлага тулгарч байгаагаас худалдан авалтын хэмжээ өсчээ. Компанийн худалдан авалтын үйл ажиллагааны дийлэнх буюу 90 гаруй хувийг бусдаар гүйцэтгүүлэх үйл ажиллагаа буюу Цанхийн баруун, Зүүн уурхайн олборлолт, нүүрс ачилтын зардал эзэлж байна. 2020 онд Коронавирус цар тахлын нөлөөгөөр компанийн үйл ажиллагаа саатсантай холбоотой худалдан авалтын хэмжээ буурсан байна.

Мөн компани нь Засгийн газрын 2015 оны 08 сарын 17-ны өдрийн "Жагсаалт батлах тухай" 336 дугаар тогтоолыг мөрдлөг болгон дотоодын 15 гаруй үйлдвэр, аж ахуйн нэгж, байгуулагаас худалдан авалт хийн ажилласан.

График 13. Дотоодын худалдан авалт




Сүүлийн жилүүдэд дотоодын аж ахуйн нэгжүүдээс худалдан авсан худалдан авалтын хэмжээ эрс өсчээ. 2017 онд 140 сая төгрөгийн худалдан авалт хийж байсан бол 2020 онд 2.41 тэрбум төгрөгийн бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ авч 17.2 дахин өссөн байна.

Үнэт цаас гаргагч нь Худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланг цахим хуудастаа олон нийтэд нээлттэй байршуулан ил тод байдлыг ханган ажилладаг.

Төрийн ажлын байдал, эрүүл ахуй
JSC

Б. Дорноо
1115205447 д. 2052402



Эрдэнэс-Тавантолгой ХК нь үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм, журам, стандартыг мөрдлөг болгон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, танилцуулгыг тогтмол зохион байгуулах, багц дүрэм, журмуудыг батлан мөрдөх зэргээр хөдөлмөрийн аюулгүй байдлыг эрхэмлэн ажиллаж байна.

2018 онд Олон улсын Хөдөлмөрийн аюулгүй байдлын эрсдэлийн удирдлагын "CRM" хөтөлбөрийг нэвтрүүлэн, уурхайд мөрдөгдөж буй хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, журмуудыг 2020 онд шинэчлэн баталж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

2019 онд Олон улсын менежментийн тогтолцооны ISO 45001:2018 стандартын шаардлагад нийцсэн, үр дүнтэй хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоог нэвтрүүлж, улмаар , 2019 оны 09 сарын 10-ны өдөр баталгаажуулсан сертификатаа хүлээн авч, тогтмол сайжруулалт хийгдэж байна.

Компани жил бүр өөрийн ажилчид болон гэрээт, тэдгээрийн туслан гүйцэтгэгч компаниудын ажилчдыг эрсдэлийн удирдлагын хөтөлбөрийн сургалт, шинэ ажилтны сургалт, жолооны эрх олгох сургалт, нийт ажилтны сургалт зэрэг хөдөлмөрийн аюулгүй байдлын төрөл бүрийн сургалтад хамруулан ажиллаж байна.



Нийт ажилтны сургалт	Шинэ ажилтны сургалт	Жолооны эрхийн сургалт	Түр ажиллах ажилтны сургалт	Цахилгааны сургалт
----------------------	----------------------	------------------------	-----------------------------	--------------------

Тэргүүлэх үзүүлэлтийг хангах, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй ажиллагааг хангах зорилгоор сар бүр ХАБЭА-н хэлтсээс АЯН зарлаж осол, осолд дөхсөн тохиолдлын тоог бууруулах, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогоос урьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгах чиглэлээр нийт ажилтнуудыг урамшуулан идэвхжүүлж ажилладаг.

2020 онд Коронавирус цар тахлаас урьдчилан сэргийлэхтэй холбогдуулан өндөржүүлсэн бэлэн байдал ханган ажиллаж байна. Уг өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор гар угаалт, амны хаалт зүүх, халуун хэмжих, дархлаа дэмжих тухай цахим сургалт, зурагт хуудас байршуулах зэрэг ажиллагааг хэрэгжүүлж хяналт тавьж ажиллаж байна.

Байгаль орчны менежмент

Эрдэнэс-Тавантолгой ХК нь байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах, усны зохистой хэрэглээг бий болгох асуудал эн тэргүүний зорилт хэмээн үзэж, сөрөг нөлөөллийг хянах тогтолцоог хөгжүүлж хэрэгжүүлэн ажилладаг.

Компани нь байгаль орчинд учирч болохуйц сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, нөхөн сэргээх зорилготой менежментийн төлөвлөгөөг жил бүр БОАЖЯ-аар батлуулан Цанхийн уурхайн үйл ажиллагаанд хог хаягдал, ус, тоосжилт, хөрсний элэгдэл, эвдрэл нөхөн сэргээлт зэрэг чиглэлүүдээр төрөлжсөн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажилладаг.

2019 онд "Байгаль орчны удирдлагын тогтолцоо"-ны MNS:ISO 14001 стандартыг үйл ажиллагаандаа бүрэн нэвтрүүлж, 2019 оны 9 дүгээр сарын 10-ны өдөр





баталгаажуулалтын гэрчилгээг гардан авч, хэрэгжилтийг нь бүх шатанд мөрдүүлэн ажиллаж байна.

Түүнчлэн Цанхийн уурхайн цогцолбор нь говь нутгийн байгалийн өндөрсгийг харгалзан үзэж усны зохистой хэрэглээг чухалчлан үйл ажиллагаа явуулах үүднээс үйлдвэрлэлийн болон хэрэглээний ус ашиглалтын ухаалаг, дэвшилтэт системийг нэвтрүүлэн ажилласнаар өмнөх оноос 30 хувиар бага усыг ашигласан байна.

Цанхийн зүүн уурхайн хөрсний 1 дүгээр овоолго дээрх 5 дугаар шимт хөрсний овоолгыг MNS 5916:2008 стандартын дагуу хэлбэршүүлэн хамгаалах ажлын хүрээнд 13.9 мянган м³ шимэрхэг хөрс, 5.7 мянган м³ сажатай хольж сайжруулсан шимэрхэг хөрс, 6.3 мянган м³ шимт хөрсийг зөөж, нийт 41.2 мянган м³ материалыг зөөн байрлуулж хэлбэржүүлэх ажлыг хийж гүйцэтгэсэн. Мөн тус талбай дээр салхины хаалт үүсгэх зорилгоор 500 ширхэг улиас, 250 ширхэг голт бор тариалжээ.

2018 онд 3,414 тн усыг мод усалгаа болон ойжуулалтын зориулалтаар, Цанхийн зүүн уурхайгаас шавхан зайлуулсан буюу шүүрлийн ус 20,617 тн усыг тоосжилт дарах зорилгоор зам усалгаанд дахин ашигласан.

Уурхайн үйл ажиллагааны явц үүсэж буй тоосжилтыг бууруулах зорилгоор 2019 оны 06 сарын 25-ны өдрөөс гэрээт компаниудад тоосжилт бууруулах 1 сарын аян зарлан ажилласан ба тус аяны хүрээнд сул хөрс, түймэрийг тогтмол хусаж цэвэрлэх, усалгааны давтамж нэмэгдүүлэх, технологийн замуудад хайрга болон улаан шороог дэвсэх зэрэг ажлууд хийж гүйцэтгэсэн. Үр дүнд нь уурхайн тоосжилт буурч, 5 цэгт хэмжилт хийхэд тоосжилт 10-50 хувиар буурсан үзүүлэлт гарчээ.

Үйл ажиллагаа эхэлсэн цагаас хойш Цанхи хотхон, Эрдэнэс хотхон болон хотхон дундах цэцэрлэгт хүрээлэн, уурхайн оффисын гадна талбай, зочдын тавцан, мод үржүүлгийн талбай зэрэгт нийт 45291 ширхэг мод тарьсан байна.

Иргэдийн 1072 хувьцааг эргэлтэнд оруулах талаар



Эрдэнэс-Тавантолгой ХК нь 2018 онд "1072 хувьцаа мэдээллийн төв"-ийг байгуулж, улсын хэмжээнд давхардсан тоогоор 1.8 сая орчим иргэнийг компанийн үйл ажиллагааны өнөөгийн байдал, ирээдүйн стратеги төлөвлөгөө, IPO-н талаарх зөвлөгөө, мэдээллээр ханган ажилласан байна.

Зах зээлийн мэргэжлийн байгууллагууд болох Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороо, Үнэт цаасны компаниудтай хамтран "Үнэт цаасны зах зээлийн нээлттэй өдөрлөг"-ийг Дархан-Уул, Булган, Орхон, Ховд, Увс, Баян-

Өлгий, Хэнтий, Сүхбаатар Дорнод аймгуудад зохион байгуулж, 15,352 иргэнд данс нээх үйлчилгээг үзүүлэн Хөрөнгийн зах зээлийн сургалтад 13,293 иргэнийг хамруулжээ.


Түүнчлэн Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн "1072 Хувьцаа мэдээллийн төв" нь 2019 онд эрх бүхий этгээдийн зүгээс компанийн хувьцаатай холбоотой гаргасан тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах зорилгоор дараах арга хэмжээг зохион байгуулж ирсэн. Тухайлбал:



"Хуримтлалтай Хувьцаатай иргэн" аяныг 21 аймаг, 330 суманд амжилттай зохион байгуулж, 604 удаагийн уулзалт, сургалтад нийт 40,864 иргэнийг хамруулжээ.



2021.03.03



- Төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, аж ахуйн нэгж, боловсролын байгууллагын хүсэлтээр 746 удаа, нийт 28,402 иргэнийг хамруулсан хөрөнгийн зах зээлийн сургалтыг зохион байгуулсан.
- Хувьцааны талаарх бүхий л мэдээллийг компанийн албан ёсны фэйсбүүк хуудас болон 1800-1072 лавлах утсаар дамжуулан олон нийтэд хүргэж ажилласан бөгөөд лавлах утсанд нийт 49,512 иргэн, хувь хүн хандсан байна.

Дараах мэдээллийг үнэт цаасны танилцуулгын хавсралт 25-29-аас үзнэ үү.

- Хавсралт 25. 2016 оны үйл ажиллагааны тайлан
- Хавсралт 26. 2017 оны үйл ажиллагааны тайлан
- Хавсралт 27. 2018 оны үйл ажиллагааны тайлан
- Хавсралт 28. 2019 оны үйл ажиллагааны хураангуй тайлан
- Хавсралт 29. 2020 оны 3-р улирлын үйл ажиллагааны хураангуй тайлан

1.7. Компанийн бүтэц зохион байгуулалт

Үнэт цаас гаргагчийн бүтэц зохион байгуулалтыг ТУЗ-ийн 2020 оны 05 сарын 28-ны өдрийн 27 дугаар тогтоол /Хавсралт 30/-ын хавсралтаар баталжээ. Компани нийт 9 газар, 23 хэлтэс, 10 алба болон уурхайн салбараас бүрдсэн зохион байгуулалтын бүтэцтэй байна.

Эрдэнэс-Тавантолгой ХК нь 2020 онд Өмнөговь аймаг, Цогтцэций сумын нутагт байрлах Таван толгойн ордод үйл ажиллагаа явуулах Эрдэнэс Тавантолгой ХК-ийн Өмнөговь аймг дахь салбарыг байгуулахаар /Хавсралт 31/-ын дагуу шийдвэрлэжээ.

2021.03.26





2021-03-19

БҮРТГЭЗ-02

Уурхайн салбар	ХАБЗАБО-ны хэлтэс	Уул уурхайн газар-1	Удирдлагын газар-1	Удирдлагын газар-1
	Геологи, хайгуулын хэлтэс			
	Уурхайн төлөвлөлтийн хэлтэс			
Санхүүгийн шийдвэрлэх алба	Эдийн засаг төсвийн хэлтэс	Санхүүгийн удирдлагын газар-	Санхүүгийн газар-1	Санхүү харилцсан дэд захирал-1
	Санхүүгийн хэлтэс			
	Тайлан бүртгэлийн хэлтэс			
Ханган нийлүүлэлтийн алба	Худалдан авалтын ажиглагааны хэлтэс	Худалдан авалтын газар-1	Худалдан авалт харилцсан дэд захирал-1	Дотоод явцат, эрсдлийн удирдлагын газар
	Хангамж, үнийн судалгааны хэлтэс			
	Гэрээ эрх зүйн хэлтэс			
Хамтын ажиглагааны алба	Хууль зүйн зөмчлүүлэлтийн хэлтэс	Хууль эрх зүйн газар-1	Хууль эрх зүйн харилцсан дэд захирал-1	Гүйцэтгэх захирал
	Комплайнсын хэлтэс			
	Завиргааны хэлтэс			
Аж ахуйн алба	Хэвлэл, мэдээлэл олон нийттэй харилцах хэлтэс	Завиргаа удирдлагын газар-1	Завиргаа харилцсан дэд захирал-1	Ерөнхий удирдлага
1072 мэдээллийн алба	Хүний нөөц сургалт, судалгааны хэлтэс			
Сургалтын алба	Мэдээлэл, технологийн хэлтэс			
Хүний нөөцийн алба	Маркетинг борлуулалтын хэлтэс	Борлуулалт, логистикийн газар-1	Борлуулалт, логистикийн газар-1	Стратегийн хөгжил харилцсан дэд захирал-1
	Техникийн алба-3			
Бортолг төслийн нэгж	Тээвэр логистикийн хэлтэс	Бизнес хөгжлийн газар-1	Бизнес хөгжлийн газар-1	Хөрөнгийн удирдлагын газар-1
	Хөрөнгийн удирдлагын хэлтэс			
	Барилга, дэд бүтцийн хэлтэс			
	Төслийн удирдлага хөгжлийн хэлтэс			
	Үнэт цаасны бүртгэлийн хэлтэс			
Хөрөнгө оруулагчидтай харилцах хэлтэс	Хөрөнгө оруулагчидтай харилцах хэлтэс	Үнэт цаас санхүүжилтийн газар-1	Хөрөнгө оруулагчидтай харилцсан дэд захирал-1	Хөрөнгө оруулагчидтай харилцсан дэд захирал-1

Дотоод явцат, эрсдлийн удирдлагын газар

Гүйцэтгэх захирал

ТҮЗ-ийн Ажлын алба
Дотоод бүтцийн алба

ТҮЗ-ийн гүйцэтгэл
Ажлын алба
Б. Доржиев
БНДИГЭХ
Урьдчилсан
2021.03.19

TAVAN
ЗЭВЭНЭС
TAVAN
MONGOLIAN
STOCK EXCHANGE
JSC

2021.03.19



Эрдэнэс Тавантолгой ХК-ийн компанийн дүрмийн 7.1-д заасны дагуу компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байна. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Компанийн санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор зарлан хуралдуулна.

Компанийн дүрмийн 7.4-д заасны дагуу Хувьцаа эзэмшигчдийн хурал нь компанийн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн олонх тухайн хуралд оролцоноор хүчин төгөлдөр болно.

ЗГ-ын 2012 оны 181 дүгээр тогтоолын дагуу Монгол улсын иргэд, аж ахуйн нэгжийн эзэмшиж буй Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн хувьцаа нь хоёрдогч зах зээлийн арилжаа эхлэх хүртэл хугацаанд саналын эрхгүй байгаа тул Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг Монгол улсын төр буюу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар болон Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн яам хэрэгжүүлж байна.

Иргэд, ААН тодорхой хугацаанд саналын эрхгүй ч хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, ХЭХ-ын холбогдох материалуудтай танилцах, асуулт тавьж мэдээлэл авах эрхтэй юм.

Үнэт цаас гаргагч нь Компанийн тухай хууль, компанийн дүрэм, СЗХ-ны "Хаалттай хувьцаат компанийн тухай журам"-ын 5.2-т заасны дагуу "Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам"-аар хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулан ажилладаг.

Компани нь 2020 оны 04 сарын 24-ны өдөр хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаа цахимаар олон нийтэд нээлттэй зохион байгуулж дараах асуудлыг хэлэлцэн баталжээ.

1. Компанийн 2019 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах.
2. Компанийн 2019 оны үйл ажиллагааны талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах.
3. Компанийн нээлттэй хувьцаат компани болгох талаар авах арга хэмжээний тухай хэлэлцэх.
4. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах тухай
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах.

Компани мөн 2020 оны 10 сарын 19-ний өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулж Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчилсэн байна.

Санхүүгийн зохицуулах хорооны Компанийн засаглалын кодекс, Хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн зар хүргэх журам", компанийн дүрэмд нийцүүлэн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 04 сарын 18-ны өдрийн 15 дугаар тогтоолоор "Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах журам" /Хавсралт 32/-ыг баталсан. Энэхүү журам нь хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах болон хурлаар хэлэлцэх асуудал, хувьцаа эзэмшигчид хуралд оролцох, санал өгөх эрхийг эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлыг зохицуулсан.

Төлөөлөн удирдах зөвлөл

Компанийн тухай хуулийн 75.1-т заасны дагуу Хувьцаа эзэмшигчдийн хурлын нөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл байна.



2020.10.17

Компанийн дүрмийн 8.2-т заасны дагуу Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 11 гишүүнтэй ба үүнээс Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Хувьцаа эзэмшигчдийн төрийн төлөөллийг хэрэгжүүлэгч ердийн 7, хараат бус 4 гишүүнтэй байгаа компанийн засаглалын кодекс, холбогдох хууль тогтоомжид нийцэж байна.

Төлөөлөн удирдах зөвлөл нь КТХ-ийн 75 дугаар зүйлийн 75.2 дахь заалт, 75 дугаар зүйлийн 75.3 дахь заалт, 75 дугаар зүйлийн 75.4 дахь заалт, КЗК-ийн 5 дугаар зүйлийн 5.2.3 дахь заалт, КТХ-ийн 75 дугаар зүйлийн 75.6 дахь заалт, 78 дугаар зүйлийн 78.1 дэх заалт, 82 дугаар зүйлийн 82.1 дэх заалт, 75 дугаар зүйлийн 75.8 дахь заалт дахь холбогдох хууль тогтоомжийн болон КЗК-т заасан шаардлагыг хангасан болохыг Хуулийн компанийн дүгнэлтэд дурджээ.

Төлөөлөн удирдах зөвлөлийн компанийн дүрэмд зааснаар улиралд 2-оос доошгүй удаа хуралдаж, компанийн үйл ажиллагаатай холбоотой чухал асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2019 оны 02 сарын 25-ны өдрийн 06 дугаар тогтоолоор батлагдсан "Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам" /Хавсралт 33/-аар ТУЗ-ийн үндсэн чиг үүрэг, бүрэн эрх, ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх этгээдэд тавигдах шаардлага, гишүүдийг сонгох шаардлага, гишүүдийг сонгох журам, ТУЗ-ийн гишүүдийг мэдээллээр хангах журам, үүргээ зохих түвшинд хэрэгжүүлээгүй гишүүнд хүлээлгэх хариуцлага болон ТУЗ-ийн бусад үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулсан байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн чиг үүрэг

Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь Компанийн тухай хуулийн 76.1, компанийн дүрмийн 8.6, ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 3.3-т заасны дагуу дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

- Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох;
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах
- Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдөр болон хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахтай холбогдох бусад асуудлыг шийдвэрлэх;
- Компанийн зарласан хувьцааны төрөл болон тоонд багтаан хувьцаа гаргах;
- Компанийн дүрэмд заасан хувьцаанд хамаарах болон бусад үнэт цаас гаргах;
- Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох;
- Өөрийн гаргасан хувьцаа, бусад үнэт цаасыг худалдан авах буюу эргүүлэн авах;
- Гүйцэтгэх удирдлагыг сонгох, өөрчлөх, түүний бүрэн эрхийг тогтоох;
- Гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөл, түүнд олгох шагнал, урамшуулал, хариуцлагын хэмжээг тогтоох;
- Аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлийг тогтоох;
- Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж, түүнийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж батлуулах;

Ногдол ашгийн хэмжээ, түүнийг төлөх журмыг тодорхойлох;

Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон компанийн засаглалын дотоод журмыг батлах;



2021.03.26

- Компанийн салбар болон төлөөлөгчийн газар байгуулах;
 - Компанийг өөрчлөн байгуулах талаар хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төслийг бэлтгэх, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;
 - Компанийн тухай хуулийн арван нэгдүгээр бүлэгт заасны дагуу иж-комжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
 - Компанийн тухай хуулийн арван хоёрдугаар бүлэгт тодорхойлсон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
 - Компанийн бизнесийн болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах;
 - Компанийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын төсвийг батлах;
 - Компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох;
 - Ногдол ашгийн хэмжээг тогтоох, түүнийг төлөх журмыг батлах;
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, Гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын бодлогыг батлах, тэдгээрт олгох цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоох;
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны төсвийг батлах;
 - Компанийн эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, борлуулалтын орлого, өртөгтэй холбоотой гэрээ, хэлцэл байгуулах бүрэн эрхийг үнийн дүнгээс хамааруулан тогтоох;
 - Охин болон хараат компанийг байгуулах, өөрчлөх, татан буулгах эсэх асуудлаар компанийн хяналтын багцийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчтэй зөвшилцсөний үндсэн дээр шийдвэрлэх;
 - Хараат болон охин компанийн удирдлагыг томилох, чөлөөлөх;
 - Компанийн үндсэн хөрөнгийг актлах, данснаас хасах, худалдах, шилжүүлэх, хөрөнгийн үнэлгээний дүнгээр үнэ цэнийн бууралтыг бүртгэх, хүлээн зөвшөөрөх асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх;
- Гүйцэтгэх удирдлагаас хэлэлцүүлэхээр оруулсан Гүйцэтгэх удирдлагын эрх хэмжээнд үл хамаарах хуульд заасан бусад асуудал.

Үнэт цаас гаргагчийн төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн гишүүдийг 2020 оны 10 сарын 19-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 03 тоот шийдвэрээр 2 жилийн хугацаатай томилсон байна.

ТУЗ-ийн 2020 оны 11 сарын 27-ны өдрийн 40 тоот шийдвэрийн дагуу ТУЗ-ийн даргаар Б.Бат-Эрдэнэ томилогдсон байна.

- Хавсралт 34. ТУЗ-ийн гишүүд болон ТУЗ-ийн дарга томилсон тогтоол

Хүснэгт 13. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд

№	ТУЗ-ийн гишүүдийн нэр	Албан тушаал	ТУЗ дахь албан тушаал	Засаглалын гэрчилгээний дугаар
1	Б.Бат-Эрдэнэ	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Дарга	ТУЗ-ийн дарга	0521082
2	Г.Нандинжаргал	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Төрийн нарийн бичгийн дарга	Ердийн гишүүн	0430384
3	С.Наранцогт	Сангийн яам, Төрийн нарийн бичгийн дарга	Ердийн гишүүн	0520380

ЭРДЭНЭС ТАВАН ТӨМӨР ХК
JSC

Анх 0520380
Б.Бат-Эрдэнэ
111520447.2.2021.02



4	Т.Гантулга	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Дарга	Ердийн гишүүн	0330407
5	Ц.Эрдэнэбаяр	Ашигт малтмал, газрын тосны газар, Орлогч дарга	Ердийн гишүүн	0000251
6	Ц.Баяр-Эрдэнэ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтсийн дарга	Ердийн гишүүн	0130574
7	Б.Ганхуяг	Эрдэнэс-Тавантолгой Гүйцэтгэх захирал ХК	Ердийн гишүүн	0520756
8	П.Өлзийнаран	МоЭнКо ХХК, Төслийн инженер	Хараат бус гишүүн	0520631
9	Ү.Амарбат	Хуульч, өмгөөлөгч	Хараат бус гишүүн	0521077
10	Д.Батхишиг	Нью Гранд Эрдэнэт ХХК, Захирал	Хараат бус гишүүн	0330405
11	Х.Болор-Эрдэнэ	Дорнод газар ХХК, Дарга	Хараат бус гишүүн	0330304
12	Д.Отгонтуяа	Эрдэнэс-Тавантолгой ХК	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	0330403

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь Компанийн тухай хуулийн 75.8-д заасны дагуу компанийн засаглалын сургалтад хамрагдан гэрчилгээ /Хавсралт 35/ авсан байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод

ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг байнгын, тогтмол мэргэшсэн байдлаар зохион байгуулах зорилгоор дараах хороодыг байгуулсан байна.

- Нэр дэвшүүлэх хороо
- Аудитын хороо
- Цалин урамшууллын хороо

Үнэт цаас гаргагч нь КТХ-ийн 81 дүгээр зүйлийн 81.2 дахь хэсэгт "Хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь аудитын, цалин, урамшууллын, нэр дэвшүүлэх хороодтой байх бөгөөд эдгээр хороодын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээс бүрдэнэ", КЗК-ын 5 дугаар зүйлийн 5.5.2 дахь заалтад "Хороо нь тухайн үйл ажиллагааг явуулах өндөр ур чадвар бүхий мэргэшсэн, туршлагатай 3-аас доошгүй гишүүдтэй байх...", 81 дүгээр зүйлийн 81.4 дэх хэсэгт "энэ хуулийн 81.2-т заасан аудитын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн байх" гэсэн холбогдох хууль тогтоомж болон КЗК-т заасан шаардлагыг хангасан байна.

Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн ТУЗ-ийн 2020 оны 11 сарын 27-ны өдрийн 41 тоот тогтоол /Хавсралт 36/-ын дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх дэд хороодын бүрэлдэхүүнийг томилсон байна.

ТУЗ-ийн 2019 оны 02 сарын 25-ны өдрийн 07 тоот тогтоолоор ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааны журам /Хавсралт 37/-ыг батлан аудитын хороог 6 гишүүн, нэр дэвшүүлэх хороог 3 гишүүнтэй байхаар сонгосон. ТУЗ-ийн 2020 оны 11 сарын 27-ны өдрийн 41 тоот тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх дэд хороодын бүрэлдэхүүнийг томилсон байна.





өдрийн 41 тоот тогтоолоор компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн цалин, урамшууллын хорооны гишүүдийн тоог 6 байсныг 3 болгож өөрчлөн баталсан байна.

Дэд хороодын гишүүний бүрэн эрхийн хугацаа нь төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийн хугацаатай адил байна. ТУЗ-ийн дэргэдэх хороод нь КТХ-ийн 81 дүгээр зүйл, Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 3 дугаар бүлэгт заасны дагуу чиг үүргийг гүйцэтгэнэ.

Аудитын хороо

Аудитын хороо нь компанийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын бодлого, хэрэгжилтэд хяналт тавих, сайжруулах, олон улсын стандартад нийцүүлэхэд санал зөвлөмж хүргүүлэх, хараат бус хөндлөнгийн аудиттай хамтран ажиллах, санхүү, эдийн засгийн байдалд үнэн бодит байдалд хяналт тавих үйл ажиллагааг зохицуулна.

Хүснэгт 14. ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны бүрэлдэхүүн

Дарга	Ү.Амарбат	Хараат бус гишүүн
Гишүүд	Г.Нандинжаргал	Ердийн гишүүн
	Ц.Баяр-Эрдэнэ	Ердийн гишүүн
	П.Өлзийнаран	Хараат бус гишүүн
	Х.Болор-Эрдэнэ	Хараат бус гишүүн
	Д.Батхишиг	Хараат бус гишүүн

Хороо нь тодорхой чиг үүргийнхээ хүрээнд тухайн асуудлаар санал боловсруулж хурлаараа хэлэлцэн зөвлөмж, дүгнэлт гаргаж төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулна.

1. Компанийн нягтлан бодох бүртгэл, тайлагналын талаар

- Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих;
- Нягтлан бодох бүртгэл болон санхүүгийн тайлагналтай холбоотой бодлогыг тодорхойлох, удирдлагаас гаргасан мэргэжлийн зохицуулалтын шийдвэрүүдийн хэрэгжилтэнд хяналт тавьж, уг шийдвэрүүдийн компанийн санхүүгийн байдалд нөлөөлөх нөлөөлөлд үнэлгээ өгч, дүгнэлт гаргах;
- Гүйцэтгэх удирдлагын зүгээс улирал, жилийн эцсийн санхүүгийн тайланг бэлтгэх явцад болон тайланг нийтлэхийн өмнөх урьдчилсан мэдэгдлийг хянах;
- Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлоготой холбоотой зөвлөмжийг гаргаж төлөөлөн удирдах зөвлөлд хүргүүлэх ба ялангуяа компанийн жилийн эцсийн санхүүгийн тайлан, санхүүгийн тодруулгад хийсэн дүн шинжилгээ болон аудитын мөрөөр хийгдсэн ажлын үр дүнгийн талаар зөвлөмж гаргаж танилцуулах.


2. Дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны талаар

Дотоод хяналтын албаны удирдлага, ажилтныг томилох, цалин урамшууллыг тогтоох чиглэлээр санал боловсруулах;





0000058



- Компанийн үйл ажиллагаа, санхүү, хууль эрх зүйн гол эрсдэлүүдийг тодорхойлох, үнэлгээ өгөх, дотоод аудитын үйл ажиллагаа, худалдан авалт, түүний зохион байгуулалт, хангамж, хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих, төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтын явцад баримтлах удирдамж, хөтөлбөр, бодлогыг тодорхойлох;
- Компанийн дотоод хяналтын үйл ажиллагааг сайжруулах, боловсронгуй болгох, цар хүрээг нь өргөжүүлэх асуудлаар зөвлөмж боловсруулах;
- Дотоод хяналт болон эрсдэлийн удирдлагын үр дүнгийн ерөнхий байдалд үнэлгээ хийх.

3. Хараат бус хөндлөнгийн аудитын талаар

- Хараат бус хөндлөнгийн аудитын байгууллага сонгох талаар зөвлөмж гаргах;
 - Компани санхүүгийн тайлан болон шаардлагатай бусад баримт бичгийг хөндлөнгийн аудитын байгууллагаар жилд нэгээс доошгүй удаа шалгуулах баталгаажуулах ажлыг зохион байгуулах;
 - Хөндлөнгийн аудитын шалгалтын явцад илэрсэн зөрчил, түүний гаргасан зөвлөмж болон гүйцэтгэх удирдлагын зүгээс тухайн зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээний талаар хэлэлцэн дүгнэлт гаргаж төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд танилцуулах;
 - Хараат бус хөндлөнгийн бусад байгууллагуудаар гүйцэтгүүлэх хөрөнгийн үнэлгээ хийх, зэрэглэл тогтоох зэрэг бусад ажил үйлчилгээг гүйцэтгүүлэхэд компаниас баримтлах бодлогыг тодорхойлох;
4. Компанийн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавьж зөвлөмж, дүгнэлт гаргах;
5. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаас тогтоосон бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих;
6. Холбогдох хууль журмын хүрээнд зохицуулсан болон компанийн дүрэмд заасан, мөн төлөөлөн удирдах зөвлөлөөс шаардлагатай гэж үзсэн бусад асуудал.

Цалин урамшууллын хороо

Хороо нь Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, тэдгээрт олгох цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоох, хэрэгжилтэд нь хяналт тавих, компанийн урамшууллын системийн бодлогыг тодорхойлох чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Хүснэгт 15. ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хорооны бүрэлдэхүүн

Дарга
Гишүүд

Д.Батхишиг
Ц.Эрдэнэбаяр
Ү.Амарбат

Хараат бус гишүүн
Ердийн гишүүн
Хараат бус гишүүн



2021.02.10.30.55

Хороо нь тодорхой чиг үүргийнхээ хүрээнд тухайн асуудлаар санал боловсруулж хурлаараа хэлэлцэн зөвлөмж, дүгнэлт гаргаж төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулна.

- Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, тэдгээрт олгох цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд цалин, урамшуулал олгох санал боловсруулах;
- Компанид мөрдөж байгаа ажлын үр дүнтэй холбогдсон компанийн урамшууллын системийн зорилгыг тодорхойлж, үр дүнг үнэлэх;
- Компанийн нийт ажилчдын цалин, урамшууллын бодлого боловсруулах чиглэлээр компанийн удирдлага болон холбогдох нэгжээс боловсруулсан төсөлд санал өгөх;
- Компанийн хөгжлийн стратеги, санхүү эдийн засгийн боломж, хөдөлмөрийн зах зээлийн байдалд тулгуурлан компанийн цалин, урамшууллын бодлого, шалгуурыг тохиромжтой эсэхэд хяналт тавих;
- Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, гүйцэтгэх захирал, эрх бүхий албан тушаалтан болон нийт ажилтнуудын мөрдөж байгаа цалин урамшууллын бодлого, эрх зүйн акт нь компанийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, стратегийн зорилтыг хэрэгжүүлэхэд оруулсан хувь нэмэр, төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан бизнесийн төлөвлөгөөний хэрэгжилт, тухайн ажилтны ажлын эцсийн үр дүнтэй уялдаж байгаа эсэхэд дүгнэлт санал боловсруулах;
- Холбогдох хууль, журмын хүрээнд зохицуулсан бусал үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллах.

Нэр дэвшүүлэх хороо

Нэр дэвшүүлэх хороо нь ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүн, гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчдэд тавих шаардлагыг тодорхойлох, тухайн шаардлагад нийцэж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх, ТУЗ болон гүйцэтгэх удирдлагыг сонгохтой холбоотой үйл ажиллагааг зохицуулна.

Хүснэгт 16. ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хорооны бүрэлдэхүүн

Дарга	Х.Болор-Эрдэнэ	Хараат бус гишүүн
Гишүүд	Т.Гантулга	Ердийн гишүүн
	Ү.Амарбат	Хараат бус гишүүн

Хороо нь тодорхой чиг үүргийнхээ хүрээнд тухайн асуудлаар санал боловсруулж хурлаараа хэлэлцэн зөвлөмж, дүгнэлт гаргаж төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулна.

- Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага болон гүйцэтгэх захирал, эрх бүхий албан тушаалтан, охин болон хараат компанийн удирдлагад нэр дэвшигчдэд тавигдах шаардлагыг тодорхойлж, тэдгээрийн үр чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтоох;

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон гүйцэтгэх захирал, эрх бүхий албан тушаалтан, охин болон хараат бус компанийн удирдлагад нэр дэвшигчийн үр чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага, харин хараат бус гишүүний хувьд



ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ ХК

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН ЗИРХ
ХАНГАЖ БАЙГАА ЭСЭХЭД

Компанийн тухай хуулийн 79.1-д заасан шаардлагыг хангаж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх;

2021-03-13

- Компанийн тухай хуулийн 59.5-д заасан үндэслэлээр төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх нь дуусгавар болсноос хойш гурван жилийн хугацаанд тухайн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн байсан этгээдийн нэрийг компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд дэвшүүлэхээс татгалзах;
- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг бүртгэн сонгон шалгаруулалт хийж, хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд нэр дэвшүүлэх;
- Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх захирлын үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх;
- Гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний нөхцлийг боловсруулах;
- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээс бусад компанийн эрх бүхий албан тушаалтан, охин болон хараат компанийн удирдлагын ажлын гүйцэтгэлд гүйцэтгэх захирлаас өгсөн үнэлгээнд дүгнэлт гаргах.

Гүйцэтгэх удирдлага

Компанийн дүрмийн 9.1-т заасны дагуу Компанийн гүйцэтгэх удирдлагыг гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ. Гүйцэтгэх захирал нь компанийн дүрэм болон Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, компанийг төлөөлөн хэлцэл хийх, гэрээ байгуулах зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна.

Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн гүйцэтгэх захирал Б.Ганхуяг нь ТУЗ-ийн 2018 оны 04 сарын 04-ний өдрийн хурлын 05 тоот тогтоол /Хавсралт 38/-оор тус компанийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчээр, улмаар ТУЗ-ийн Нэр дэвшүүлэх хорооны 2018 оны 05 сарын 18-ны өдрийн зөвлөмжийг үндэслэн ТУЗ-ийн 2018 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн 12 тоот тогтоол /Хавсралт 38/-оор Гүйцэтгэх захирлаар томилогдон ажиллаж байна.

Б.Ганхуяг нь хууль зүй болон улс төр судлаач мэргэжлээр дээд боловсрол эзэмшсэн ба АНУ-ын Харвардын их сургуульд уул уурхайн чиглэлээр, АНУ-ын Питсбург хуулийн их сургуульд гэрээ хууль, эрх зүйн чиглэлээр мэргэшүүлэх сургалтад хамрагджээ. Гүйцэтгэх захирал нь Эрдэнэс Монгол ХХК болон Эрдэнэс-Тавантолгой ХК-д удирдах албан тушаал эрхэлж байсан, Тавантолгой төслийн Засгийн газрын ажлын хэсэгт гишүүнээр ажиллаж байсан туршлагатай.

Үнэт цаас гаргагч нь КТХ-ийн 83 дугаар зүйлийн 83.2 дахь хэсэгт "Компанийн дүрэмд гүйцэтгэх удирдлагыг багаар хэрэгжүүлэхээр заагаагүй бол хувь хүн хэрэгжүүлнэ", 83 дугаар зүйлийн 83.4 дэх хэсэгт "Компанийн гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлэгч этгээд нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн байж болох бөгөөд төлөөлөн удирдах зөвлөлийн дарга байхыг хориглоно" гэсэн холбогдох хууль тогтоомж болон КЗК-т заасан шаардлагыг тус тус хангасан байна.





0000061

Хүснэгт 17. Гүйцэтгэх удирдлагад тавигдах шаардлага

Мэргэжлийн шаардлага	✓ Уул уурхайн инженер эсхүл санхүү эдийн засаг эсхүл хууль эрх зүй эсхүл бизнесийн удирдлагын чиглэлээр мэргэжил эзэмшсэн байх
Ажлын туршлагын шаардлага	✓ Ажлын туршлага 10-аас доошгүй жил байх ✓ Уул уурхайн салбарт мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан байх ✓ Бизнесийн байгууллагын удирдах албан тушаалд 5-аас доошгүй жил ажилласан байх
Бусад	✓ Зээлийн болон батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй байх ✓ Хууль тогтоомж болон ёс зүйн зөрчил гаргаагүй байх ✓ Бизнесийн нэр хүнд нь компанийг удирдахад харшлахгүй байх ✓ Төлөөлөн удирдах зөвлөлийн нэр дэвшүүлэх хорооноос тодорхойлсон бусад шаардлага

ТУЗ-ийн 2019 оны 04 сарын 22-ны 17 дугаар тогтоол /Хавсралт 39/-оор гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журмыг баталсан байна. Энэхүү журмаар гүйцэтгэх удирдлагын эрх үүрэг, хариуцлага, түүнд тавигдах шаардлага, нэр дэвшүүлж, томилох, гэрээ байгуулах, ажлыг нь тайлагнах, үйл ажиллагаа болон түүний цалин урамшуулалтай холбоотой харилцааг зохицуулсан байна.

Гүйцэтгэх захирлын эрх, үүрэг

- Компанийн стратеги, жил бүрийн бизнесийн болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, төсвийг Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулж, Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан төлөвлөгөө, төсөв, шийдвэрийг хэрэгжүүлэх
- Компанийн хөдөлмөрийн дотоод журам болон үйл ажиллагааны бусад дүрэм, журмыг батлах
- Өөрийн эрх хэмжээний хүрээнд тушаал гаргах
- Хууль тогтоомж, компанийн дүрэм, журам технологийн горимын хэрэгжилт, хөдөлмөрийн аюулгүй байдал болон аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаа, хөрөнгө зарцуулалт, ашиглалтад хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх
- Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарт багтаан ажлын байрны нэр, орон тооны жагсаалт, ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг батлах
- Ажилтныг ажилд томилж хөдөлмөрийн гэрээ байгуулах, сахилгын шийтгэл ноогдуулах, ажлаас чөлөөлөх
- Хууль болон энэхүү дүрэмд заасан Төлөөлөн удирдах зөвлөлөөр шийдвэрлүүлэх асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр санал оруулах
- Төр, хувийн хэвшлийн бусад аж ахуйн нэгж, дотоод, гадаад улсын холбогдох байгууллагатай хамтран ажиллах

Хувьцаа эзэмшигчдэд компанийн дүрэм, журмын дагуу компанийн санхүүгийн тайлантай танилцах боломжоор хангах



2021.03.03



0000062

ERDENES TAVANTOLGOY
MONGOLIAN STOCK EXCHANGE

БҮРТГЭВ-02

- Төлөөлөн удирдах зөвлөлийн өмнө компанийн үйл ажиллагааг бүрэн хариуцаж, улирал бүр компанийн үйл ажиллагааны талаар Төлөөлөн удирдах зөвлөлд тайлан тавьж хэлэлцүүлэх
- Энэ дүрэм болон холбогдох хууль тогтоомж, компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр, үүрэг даалгаврыг биелүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах
- Гүйцэтгэх захирлын эрх, үүргийг хэрэгжүүлэх явцад олж авсан мэдээллийг хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглахгүй байх
- Хууль тогтоомж болон компанийн дүрмээр тогтоосон бусад эрх үүрэг.

Компанийн бүтэц зохион байгуулалаас харахад дараах дэд захирлуудыг томилон /Хавсралт 38/ ажиллаж байна.

Овог, нэр	Эрхэлж буй албан тушаал
Б.Жаргалсайхан	Санхүүгийн удирдлагын газар хариуцсан Тэргүүн дэд захирал
Г.Дэлгэрбаяр	Үйлдвэрлэл, уул уурхайн газар хариуцсан дэд захирал
Б.Батсайхан	Бизнесийн удирдлагын газар хариуцсан дэд захирал
Т.Цогтбаяр	Стратеги, хөгжлийн газар хариуцсан дэд захирал
Ц.Амартүвшин	Хууль зүйн газар хариуцсан дэд захирал
Д.Алтанцэцэг	Ерөнхий нягтлан бодогч
Д.Санчир	Ерөнхий аудитор
Н. Эрдэнэхуяг	Уурхай салбарын захирал
Д.Энхболд	Ерөнхий удирдлагын газар хариуцсан дэд захирал
Х. Нурлат	Дотоод хяналт, эрсдлийн удирдлагын газар хариуцсан захирал

1.8 Эрх бүхий албан тушаалтны мэдээлэл

Компанийн тухай хуулийн 84.2-т заасны дагуу Эрдэнэс-Тавантолгой ХК нь компанийн дүрмийн 10.1-д компанийн эрх бүхий албан тушаалтанд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга, гүйцэтгэх захирал, тэргүүн дэд захирал, дэд захирал, асуудал эрхэлсэн газрын захирал, ерөнхий нягтлан бодогч, уурхайн даргыг тооцохоор заажээ.

Эрх бүхий албан тушаалтнуудын анкетыг Хавсралт 40-аас харна уу.

ГУЗ-ийн гишүүдийн мэдээлэл

Хүснэгт 18. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн мэдээлэл

Овог, нэр	Бат-Өлзийн Бат-Эрдэнэ /ГУЗ-ийн дарга/
Албан тушаал	Засгийн газрын тохируулагч агентлаг-Үндэсний хөгжлийн газар, Дарга





МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE

2021-03-19

БҮРТГЭВ-02

Ажилласан туршлага	2020 оноос одоог хүртэл Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар, дарга 2018 "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга 2018 Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Дэд дарга 2016-2017 Улсын Их Хурлын Тамгын газар, Зөвлөх 2015-2016 Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Дэд дарга 2015 Монгол Улсын Шадар сайдын зөвлөх 2012-2015 МАН-ын дэргэдэх НАМЗХ, Ерөнхий нарийн бичгийн дарга 2011-2012 Мэдээлэл, харилцаа холбоо шуудангийн газар, Зөвлөх 2003-2012 "Силк Роуд Трэвел" ХХК, "Эйр тикет" ХХК, Ерөнхий захирал
Боловсрол	Монгол Улсын их сургууль, Улс төр судлал, докторант 2005-2010 Улаанбаатарын их сургууль, Магистр 1995-1999 Улаанбаатарын их сургууль, Бакалавр

Овог, нэр Ганболдын Нандинжаргал /Ердийн гишүүн/

Албан тушаал	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга
Ажилласан туршлага	2016 оноос одоог хүртэл, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Төрийн нарийн бичгийн дарга 2015-2016 "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Хяналт шалгалтын газар, Захирал 2015 "Эрдэнэс Монгол" ХХК-ийн дэд захирлын баг, Төслийн захирал 2014-2015 Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Хүнсний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Дарга 2013 Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Төрийн захиргааны удирдлагын газар, Дарга 2013 Нийслэлийн эдийн засгийн хөгжлийн газар, Орлогч дарга 2010-2013 Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хотын хөгжлийн бодлогын хэлтэс, Дарга 2003-2010 Монголбанкны Мөнгөний бодлого судалгааны газар, Эдийн засагч
Боловсрол	2007-2009 АНУ, Вашингтон хот, Стрейр их сургууль 1998-2003 Москва хотын Олон улсын харилцааны дээд сургууль

Овог, нэр Санжаагийн Наранцогт /Ердийн гишүүн/

Албан тушаал	Сангийн яам, Төрийн нарийн бичгийн дарга
Ажилласан туршлага	2018 оноос одоог хүртэл Сангийн яам, Төрийн нарийн бичгийн дарга 2015.1-2018.1 Сангийн яам, Газрын дарга 2012.09-2015.01 Хөдөлмөрийн яам, Газрын дарга 2008.10-2012.09 БСШУЯ, Газрын дарга 2003.09-2005.03 Сангийн яам, Хэлтсийн дарга 2000.09-2003.09 "Ай-Си" ХХК, Ерөнхий менежер 1997.05-2000.09 Монголын нээлттэй нийгэм хүрээлэн, Хөтөлбөрийн зохицуулагч 1994.06-1997.05 ШУТМ төв, Ахлах инженер 1993.09-1994.06 Математикийн хүрээлэн, Туслах ЭША
Боловсрол	2005-2008 Seoul national university, Инженерчлэл, доктор 1999-2001 МУИС, магистр 1990-1994 МУИС, Физикч, бакалавр

Овог, нэр Түдэвхүүгийн Гантулга /Ердийн гишүүн/

Албан тушаал	Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга
Ажилласан туршлага	2020 оноос одоог хүртэл Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Дарга 2016-2020 Эрчим хүчний яам, Дэд сайд 2012-2016 Мон Логос ХХК, Гүйцэтгэх захирал



2021.03.19 10:30



ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ ХК
MONGOLIAN HORNGHAIYIN BIRJA
MONGOLIAN STOCK EXCHANGE

2013-2016 МАН-ын удирдах зөвлөл, Ажлын алба, Намын нарийн бичгийн дарга
2009-2012 Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Төрийн нарийн бичгийн дарга
2008-2009 Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Төрийн нарийн бичгийн дарга
2000-2005 МАН-ын удирдах зөвлөл, Ажлын албанд даргын зөвлөх
1994-2000 "Алтай кашмер" ХХК, Ерөнхий захирал
1990-1994 Говь-Алтай аймгийн МАН-ын хороо, Улс төрийн ажилтан
1983-1985 Говь-Алтай аймгийн ХЗЭ-ийн хороо, Байгаль хамгаалал, залуучуудын асуудал хариуцсан зааварлагч
1980-1983 Дорноговь, Зүүнбаян, Зэвсэгт хүчний 201 дүгээр анги, Хугацаат цэргийн албан хаагч, Жагсаалын дарга

Боловсрол ОХУ-ын Ерөнхийлөгчийн дэргэдэх Аюулгүй байдал, батлан хамгаалах эрх, Профессор
2005 Их засаг их сургууль, Дэд профессор
2000 он МУИС, Боловсролын Доктор

2021-03-19

БҮРТГЭВ № 01

Овог, нэр Цэндийн Эрдэнэбаяр /Ердийн гишүүн/

Албан тушаал Ашигт малтмал, газрын тосны газрын орлогч дарга
Ажилласан туршлага 2018 оноос одоог хүртэл Ашигт малтмал, газрын тосны газрын ТЗУХ, Газрын тосны салбарын асуудал хариуцсан орлогч дарга
2016-2018 Ашигт малтмал, газрын тосны газрын ТЗУХ, Газрын тос, шатах ашигт малтмалын шинжилгээ, туршилтын лабораторын дарга, орлогч даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
2016-2018 он "Бэржин Уньт" ХХК, Гүйцэтгэх захирал
2015-2016 МАН, намын ерөнхий нарийн бичгийн даргын орон тооны зөвлөх
2008-2011 Нийслэлийн ИТХ, МАН-ын бүлгийн ажлын албаны дарга
2008-2011 Нийслэлийн МАН-ын хорооны Зохион байгуулалтын хэлтсийн дарга
1998-2006 Монголын цахилгаан холбоо ТӨХК-нд засварчин, техникч, инженер

Боловсрол 2019-2020 Удирдлагын академи, Мэргэшүүлэх бакалавр
2016-2019 Шинжлэх ухаан, технологийн их сургууль, магистр
1998-2004 Шинжлэх ухаан, технологийн их сургууль, бакалавр

Овог, нэр Баттулгын Ганхуяг /Ердийн гишүүн/

Албан тушаал Эрдэнэс-Тавантолгой ХК, Гүйцэтгэх захирал
Ажилласан туршлага 2018 оноос одоог хүртэл Эрдэнэс-Тавантолгой ХК, Гүйцэтгэх захирал
2016-2018 Эрдэнэс-Тавантолгой ХК, Тэргүүн дэд захирал
2014-2017 МУЗГ УИХ-ын тамгын газар, Шадар сайдын зөвлөх, УИХ-ын гишүүний зөвлөх
2014 Эрдэнэт хотын нутгийн зөвлөл, Дарга
2011-2012 Эрдэнэс-Тавантолгой ХК, ТУЗ-н гишүүн
2008-2010 Тавантолгой төслийн ЗГ-ын ажлын хэсэг, Гишүүн
2008-2013 "Эрдэнэс Монгол" ХХК, Дэд захирал
2007-2008 "Эрдэнэс Монгол" ХХК, Захиргааны хэлтсийн дарга
2005-2007 "City Phone" ХХК, Гүйцэтгэх захирал
2005-2008 МУ-ын Ерөнхийлөгчийн тамгын газар, Орон тооны бус зөвлөх
2005-2007 МОХолбоо, Ерөнхийлөгч
2001-2005 МОХолбоо ТББ, Дэд ерөнхийлөгч
1999-2000 МҮХАҮТ, Ажилтан

Боловсрол 2005-2007 МУБИС НШУС, Улс төр судлаач, Магистр
1997-2001 МУИС Хууль зүйн сургууль, Эрх зүй, Бакалавр

Овог, нэр Цэнддаваагийн Баяр-Эрдэнэ /Ердийн гишүүн/

Албан тушаал Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Хэлтсийн дарга
Ажилласан туршлага 2016 оноос одоог хүртэл Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Хэлтсийн дарга

2021.03.03



2015.5-2016.6 МАН, Ерөнхий нарийн бичгийн даргын орон тооны зөвлөх
 2008.10-2011.3 НИТХ, МАН-н бүлгийн ажлын албаны дарга
 2008.8-2011.3 Нийслэлийн МАН-н хороо, Зохион байгууллагын хэлтсийн дарга
 2006.8-2008.8 МАН-н Сургалт, судалгааны хэлтэс, Прогноз төв, Албаны дарга
 2006.3-2006.7 Англи улсын парламентын гишүүний туслах-дадлагажигч
 2012-2014 АНУ-н Страйерын Их сургууль, Төрийн удирдлага, Магистр
 1997-2001 МУИС, Улс төр судлаач, нийгмийн ухааны багш, Бакалавр

Овог, нэр Пүрэвтогтохын Өлзийнаран /Хараат бус гишүүн/

Албан тушаал "МоЭнКо" ХХК-ийн төслийн инженер

Ажилласан туршлага 2007 оноос одоог хүртэл "МоЭнКо" ХХК, Төслийн инженер

2005-2006 "Лэнд Монголиа" ХХК, Төслийн инженер

Боловсрол 2014-2015 Удирдлагын академи, Төрийн удирдлага

2003-2005 БНСУ-н Дунг-А их сургууль, Уул уурхайн инженер, Магистр
 1998-2002 ШУТИС, Уул уурхайн удирдлага, Бакалавр

Овог, нэр Үрцэйхын Амарбат /Хараат бус гишүүн/

Албан тушаал Ананд адвокатс" ХХН, Ахлах хуульч

Ажилласан туршлага 2012 оноос одоог хүртэл Отгонтэнгэр их сургууль, Хуульзүйн тэнхимийн багш

2016 оноос одоог хүртэл Өмгөөллийн "Ананд адвокатс" ХХН, Ахлах хуульч

2016 Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын Тамгын газрын дарга

Боловсрол 2012-2014 Отгонтэнгэр их сургууль, Хуульзүйн магистр

2008-2012 Отгонтэнгэр их сургууль, Эрх зүйч, бакалавр

Овог, нэр Дашнямын Батхишиг /Хараат бус гишүүн/

Албан тушаал "Нью-Гранд Эрдэнэт" ХХК-ийн захирал

Ажилласан туршлага 2018 оноос одоог хүртэл "Нью-Гранд Эрдэнэт" ХХК, Захирал

2017-2020 "Болор-Аграмба" ХХК, Эдийн засагч, хуулийн зөвлөх

2010-2017 "Эрдэнэт үйлдвэр" ХХК-ийн Тамгын хэлтсийн нууцын ажилтан

Боловсрол 2010 "Эрдэнэт үйлдвэр" ХХК-ийн Орон сууцны хэсгийн дарга

2008-2010 Монгол Улсын их сургууль, Эдийн засагч, нягтлан бодогч

2004-2009 Монгол Улсын их сургууль, Эрх зүйч

Овог, нэр Хаянгаагийн Болор-Эрдэнэ /Хараат бус гишүүн/

Албан тушаал "Дорнод газар" ХХК, Гүйцэтгэх захирал

Ажилласан туршлага 2015 оноос одоог хүртэл "Дорнод газар" ХХК, Гүйцэтгэх захирал

2012-2015 "Монгол Росцветмет" ТӨХК, Ерөнхий захирал

2006-2012 "Дорнод газар" ХХК, Захирал-Үүсгэн байгуулагч

2005-2006 Францын Хил хязгааргүй малын эмч олон улсын төсөл, Хуулийн зөвлөх

Боловсрол 2000-2001 Цагдаагийн ерөнхий газар, Мөрдөн байцаагч

2002-2003 Английн коллеж, Англи хэл судлал

2001-2002 Германы Маркетинг менежментийн олон улсын академи, Олон улсын маркетинг менежмент

1995-2000 Цагдаагийн академи, Эрх зүйч

1997-2000 Хүмүүнлэгийн ухааны сургууль, Герман хэл судлал

Овог, нэр Даваанямын Отгонтуяа

Албан тушаал Эрдэнэс-Тавантолгой ХК, ТУЗ-н нарийн бичгийн дарга

Ажилласан туршлага 2020 оноос одоог хүртэл Эрдэнэс-Тавантолгой ХК, ТУЗ-н нарийн бичгийн дарга

2021.03.03





0000066

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE

Боловсрол	2016-2020 Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Засгийн газрын хуралдаан, тогтоол шийдвэрийн албажуулалт хариуцсан Засгийн газрын реферант
	2006-2007 Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын асуудал хариуцсан Засгийн газрын реферант
	2006 МАХН, Боловсон хүчний эрхлэгч
	2005-2006 Нийслэлийн Сүхбаатар дүүргийн засаг даргын тамгийн газар, Хэлтсийн дарга
	2000-2005 МАХН-ын Удирдах зөвлөл, Улс төрийн ажилтан
	1998-2000 "Үнэн" сонины газар, Ерөнхий эрхлэгчийн туслах
	1988-1998 Төв аймгийн Хүмүүн цогцолбор сургууль, Орос хэлний багш
	1983-1988 Багшийн дээд сургууль, Орос хэлний багш
	2004-2005 Удирдлагын академи, Төрийн удирдлагын менежер

Удирдлагын багийн мэдээлэл

Хүснэгт 19. Бусад эрх бүхий албан тушаалтны мэдээлэл

Гүйцэтгэх захирал:

Нэр	Боловсрол	Туршлага
Б.Ганхуяг	МУИС-н Хууль зүйн сургууль, МУБИС-н НШУС-ийг төгссөн.	1999-2000 МҮХАУТанхимд ажилтан, 2001-2005 МОХолбоо ТББ-ын дэд ерөнхийлөгч, 2005-2007 онд МОХолбооны ерөнхийлөгч, 2005-2008 оны МУ-ын Ерөнхийлөгчийн тамгын газарт орон тооны бус зөвлөх, 2005-2007 онд "City phone" ХХК-ийн гүйцэтгэх захирал, "Эрдэнэс Монгол" ХХК-ийн захиргааны хэлтсийн дарга, 2008-2013 онд "Эрдэнэс Монгол" ХХК-ийн дэд захирал, Таван толгой төслийн ЗГ-ын ажлын хэсгийн гишүүн, 2011-2012 онд "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн ТУЗ-ийн гишүүн, 2014 оны Эрдэнэт хотын нутгийн зөвлөлийн дарга, 2014-2017 онд Шадар сайдын зөвлөх, УИХ-ын гишүүний зөвлөх, 2016-2018 Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн тэргүүн дэд захирал, 2018 оноос Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.

Дэд захирлууд:

Б.Жаргалсайхан /Эдийн засаг, санхүүгийн удирдлагын газар хариуцсан тэргүүн дэд захирал/	Москва хотын цэргийн инженерийн их сургуульд химийн инженер мэргэжлээр, МУИС-ийг эрх зүйч мэргэжлээр, Голландын Маастрихтын их сургуулийг бизнесийн удирдлагын чиглэлээр магистрын цол хүртсэн.	1984-1988 онд 0129-р ангийн химийн албаны дарга, 1988-1990 онд Ажилчны районы ХЗЭ-н харьяа нарийн бичгийн дарга, 1996-1999 онд Хууль зүйн яамны төрийн бодлого зохицуулалтын газрын түшмэл, 1999-2000 онд Монголын ардчилсан социалист залуучуудын холбооны ерөнхий нарийн бичгийн дарга, 2005-2008 онд Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын дарга, 2008-2010 МАН-ын ерөнхий нарийн бичгийн даргын ахлах зөвлөх, 2010-2013 Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрийн санхүү, эдийн засаг эрхэлсэн захирал, 2013-2018 онд Финляндын хөрөнгө оруулалтын төслийн зөвлөх, 2018.11 сараас Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн Эдийн засаг, санхүү удирдлагын газар хариуцсан тэргүүн дэд захирлаар ажиллаж байна.
---	---	---



2021.03.03

Т.Цогтбаяр
/Стратеги,
хөгжлийн газар
хариуцсан дэд
захирал/

Хөнгөн үйлдвэрийн
техникумд ноосон
нэхмэлийн технологич,
Хан-Уул дээд сургуульд
Бизнесийн удирдлага,
хэрэглээний математикч
мэргэжлээр, Тайвань
улсын Чонг-Күнг их
сургуульд бизнесийн
удирдлагын чиглэлээр
суралцсан.

1999-2006 онд Монголын үнэт цаасны хороонд мэргэжилтэн, ахлах улсын байцаагч, 2008-2008 онд "Жаст групп" ХХК-н албаны дарга, "Эр Ви Икс" ХХК-ийн гүйцэтгэх захирал, 2010-2011 онд "Опстра Эф Икс" ХХК-ийн хөрөнгө оруулалтын зөвлөх, 2011-2013 онд Үндэсний хөрөнгө оруулалтын банкинд газрын захирал, 2013-2016 онд "Нэйшнл Инвестмент менежмент" ХХК-ийн гүйцэтгэх захирал, 2015 онд Үндэсний хөрөнгө оруулалтын банкны хөрөнгө оруулалт хариуцсан захирал, 2015-2016 онд Үндэсний хөрөнгө оруулалтын банкны ерөнхий аудитор, 2016-2018 онд "Нэйшнл инвестмент тауэр" ХХК-ийн гүйцэтгэх захирал, 2018.10 сараас Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн стратеги, хөгжлийн газар хариуцсан дэд захирлаар ажиллаж байна.

Ц.Амартүвшин
/Хууль, зүйн
газар хариуцсан
дэд захирал/

МУИС-ийн ОУХДС-ийг
англи хэлний мэргэжлээр
дээд, МУИС-ийн ХЗС-ийг
эрх зүйч, мэргэжлээр
бакалавр, магистрын
зэрэгтэй суралцаж
төгссөн байна.

1999-2001 онд УИХ-ын тамгын газарт гишүүний туслах, 1999-2002 онд МАСОХолбоонд хяналтын албаны дарга, 2002-2003 онд Тээврийн прокурорын газар Прокурорын туслахаар, 2003-2009 онд Анод банкны Зээлийн газар болон Захиргаа эрх зүйн албанд ахлах хуульч, дарга, 2009-2011 онд МFC ХХК-д гүйцэтгэх захирал, 2011-2018 онд Монгол Урaniuм ХХК-д дэд ерөнхийлөгч бөгөөд ерөнхий менежер, 2013 оноос Монголын хуульчдын холбооны гишүүн, 2017 оноос Шивээ Овоо ХК-ийн ТУЗ-ийн гишүүн, 2018 оноос Монголын хуульчдын холбооны өмгөөлөгч

Г.Дэлгэрбаяр
/Үйлдвэрлэл, уул
уурхайн газар
хариуцсан дэд
захирал/

МУИС-ийг геологийн
инженер мэргэжлээр
төгссөн.

2010-2018 онд Эрдэнэс-Тавантолгой ХК-д туслах геологичоос ашиглалтын инженер хүртэл дэвшиж ажилласан. 2018.11 сараа Үйлдвэрлэл, уул уурхайн газар хариуцсан дэд захирлаар ажиллаж байна.

Д.Энхболд
/Ерөнхий
удирдлагын газар
хариуцсан дэд
захирал/

Худалдаа үйлдвэрлэлийн
дээд сургуульд
худалдааны удирдлага
чиглэлээр бакалаврын
зэрэг, бизнесийн
удирдлага чиглэлээр
магистрын зэрэг, АНУ-ын
Калифорниагийн их
сургуульд бизнесийн
удирдлага чиглэлээр
магистрын зэрэг хүртсэн.

2003-2004 онд "Асгат сервис" ХХК-д ерөнхий менежер, 2004-2006 онд тус компанийн гүйцэтгэх захирал, 2008-2009 онд УМХГ, ХҮҮХУА-д хэлтсийн дарга, 2009-2010 онд НМХГ СХД-ийн улсын байцаагч, 2000-2013 онд МХЕГ, СААХ-д хэлтсийн дарга, 2017-2018 онд ТОСК-н дэд захирал, 2018.11 сараас ерөнхий удирдлагын газрын дэд захирлаар ажиллаж байна.

Н.Эрдэнэхуяг
/Салбарын
захирал/

ШУТИС-д ашигт малтмал
баяжуулалтын технологи
чиглэлээр бакалаврын
зэрэг, үйлдвэрлэлтийн
менежмент чиглэлээр
магистрын зэрэг авсан.

2001-2014 оны хооронд "Эрдэнэт үйлдвэр" ХХК-д шүүлтүүрийн машинч, хатаагч, ээлжийн мастер, диспетчер хийн дэвшин ажилласан. 2018.12 сараас Эрдэнэс-Тавантолгой ХК-д салбарын захирлаар ажиллаж байна.

Б.Батсайхан
/Бизнесийн
удирдлагын газар

Тагнуулын академид
эрхзүйн бакалавр зэрэг,
МУИС-д сэтгэл судлалын
бакалавр зэрэг, МУИС-д
боловсролын удирдлагын

1997-1998 онд Монголын залуучуудын холбоонд ажилтан, 1998-2006 онд Сэтгэлзүйч оюутан залуучуудын Анима клубын тэргүүн, 2006-2010 онд Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургуулийн захирал, 2010-2012 онд МУИС-н

ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ ХК
JSC

ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ ХК
BILBALEK YON KK
111520447 @ 2021.03

2021.03.03

магистр зэрэг, ОХУ-ын Москвагийн боловсролын их сургуульд боловсролын удирдлагын доктор зэрэг тус тус авсан.

худалдааны сургуулийн захирал, 2012-2016 БСШУЯ-д мэргэжилтэн, 2016-2018, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын референт, 2018.11 сараас Эрдэнэс-Тавантолгой ХК-н Бизнесийн удирдлагын газар хариуцсан дэд захирлаар ажиллаж байна.

Х.Нурлат
/Дотоод хяналт эрсдэлийн удирдлагын газрын захирал/

ШУТИС-д цахилгаан инженер бакалаврын зэрэг, Казахстан улсын Казах үндэсний техникийн их сургуульд ил уурхайн инженер мэргэжлээр бакалавр зэрэг, Нийгмийн ухааны Либерти дээд сургуульд төрийн удирдлагын чиглэлээр магистрын зэрэг хүртсэн.

2007-2008 онд Шубаркөл ХК-д уулын инженер, 2009-2011 онд Эрхэс Майнинг ХХК-уурхайн захирал, 2012-2014 онд Шубаркөл ХК-д ерөнхий инженерийн зөвлөх, 2015-2018 онд Нөхөд ХХК-ийн захирал, 2018 оноос Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын захирлаар ажиллаж байна.

Ерөнхий нягтлан бодогч:

Д.Алтанцэцэг

Нийслэлийн 84-р сургууль, МУИС-ЭЗСургуулийг эдийн засаг мэргэжлээр, СЭЗИС-ийг нягтлан бодогч мэргэжлээр төгссөн.

2002-2004 онд Монголын оюутны холбооны нягтлан бодогч, 2005-2010 онд "ДЦМ" ХХК-ийн нягтлан бодогч, 2011-2012 онд "Эрдэнэс Монгол" ХХК-ийн эдийн засагч, 2018 оноос Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн ерөнхий нягтлан бодогчоор ажиллаж байна.

Ерөнхий аудитор

Д.Санчир

2004-2008 онд ИЗИС-ийг эрх зүйч мэргэжлээр бакалавр, 2019-2021 онд МУИС ХЗС-т хуулийн магистр зэрэг хамгаалсан. Хуульчдын холбооны гишүүн, Олон дотоод аудиторуудын институтийн гишүүн

2002-2003 онд Сүхбаатар дүүргийн цагдаа, 2008-2016 онд Капитал банк, хуульч, 2016-2018 оны Ариг банкинд хуульч, 2018-2018.10 сар Алтай хүдэр компанид хуульч, 2018-2020 онд Инвескор ББСБ-д хуульчаар ажиллаж байсан.

Үнэт цаас хариуцсан, Биржтэй харилцах эртгээдийн танилцуулга

Үнэт цаас хариуцсан, Биржтэй харилцах этгээдээр Үнэт цаас, санхүүжилтийн газрын дарга С.Ашидмөнх болон Маркетинг, борлуулалтын хэлтсийн мэргэжилтэн Т.Лхагванаран нарыг томилсон байна.

Хүснэгт 20. Үнэт цаас хариуцах, биржтэй харилцах этгээдийн танилцуулга

Овог, нэр	Самдановжийн Ашидмөнх
Албан тушаал	Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн Үнэт цаас санхүүжилтийн газрын дарга
Төрсөн огноо	1980/11/04
Ажилласан туршлага	2020 он - одоог хүртэл "Эрдэнэс-Тавантолгой" ХК, Үнэт цаас санхүүжилтийн газрын дарга 2019-2020 он "Эрдэнэс-Тавантолгой Майнинг" ХХК, Санхүү хариуцсан захирал 2018-2019 он "Эрдэнэс-Тавантолгой" ХК, Бизнес төлөвлөлт, инновацийн газрын дарга

2022.10.30



Боловсрол,
мэргэшлийн
бэлтгэл

2015-2018 он "Эрдэнэс-Тавантолгой" ХК, Эдийн засаг, хөрөнгө оруулалтын газрын дарга
 2013-2015 он "Эрдэнэс Оюу Толгой" ХК, Санхүү хариуцсан захирал
 2009-2012 он "Монголын Санхүүгийн Зах Зээлийн Холбоо" ТББ-ын ТУЗ-ийн гишүүн, Багш
 2008-2013 он "Монголросцветмет" ХХК, Ерөнхий эдийн засагч
 2006-2008 он "АБТС" ББСБ, Гүйцэтгэх захирал
 2005-2006 он "Vuteq Монгол" ХХК, програмист
 2015 он Канад Улсын Олон Улсын Эрдэс Баялаг, Хөгжлийн Институт, Эрдэс Баялгийн Удирдлагын Институт, Сертификат
 2015 он Канад дах Их Британийн Колумбын Их Сургууль, Эрдэс баялгийн салбарын тогтвортой хөгжлийн удирдлага, Сертификат
 2011 он Gillies Wu Уул уурхайн технологи, Уул уурхайн эдийн засаг, Сертификат
 2006-2008 он Санхүү Эдийн Засгийн Дээд Сургууль, Санхүүгийн удирдлага мэргэжлээр магистрын зэрэг
 2005 он Association for Overseas Technical Scholarship, Япон улс, CAD/CAM Engineering
 1999-2004 он ШУТИС-ийн харьяа КТМС, Программист мэргэжлээр бакалаврын зэрэг

Овог, нэр Төмөртоогогийн Лхагванаран

Албан тушаал "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн Маркетинг борлуулалтын хэлтсийн мэргэжилтэн

Төрсөн огноо 1995/04/12

2020/11/10-одоог хүртэл "Эрдэнэс-Тавантолгой" ХК, Маркетинг борлуулалтын хэлтсийн мэргэжилтэн

Ажилласан туршлага 2020/07/01-2020/11/09 "Эрдэнэс-Тавантолгой" ХК Хөрөнгө оруулагчидтай харилцах хэлтсийн мэргэжилтэн

2020/01/27-2020/06/30 "Эрдэнэс-Тавантолгой Майнинг" ХХК Хөрөнгө оруулагчидтай харилцах хэлтсийн мэргэжилтэн

2017/05/01-2020/01/24 "ХасБанк" ХХК Санхүү хяналтын хэлтсийн мэргэжилтэн

Боловсрол, мэргэшлийн бэлтгэл 2019 оны 06 сар "Chartered Financial Analyst" I дүгээр түвшний шалгалтад тэнцсэн.

2012-2016 он Санхүү Эдийн Засгийн Дээд Сургууль, Санхүүгийн удирдлага мэргэжлээр бакалаврын зэрэг


Компанийн хүний нөөц

"Эрдэнэс-Тавантолгой" ХК нь 2020 оны жилийн эцсийн байдлаар нийт 897 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байгаагаас төв оффист 244, салбарт 653 ажилтан ажиллаж байна.

Схем 7. Компанийн хүний нөөцийн мэдээлэл



20210303



Улаанбаатар хот 2021-03-19 73.8%

Өмнөговь аймаг 1.4%

Цогтцэций сум 6.8%

Бусад 12.4%

Нийт ажилчдын 73.8% нь Улаанбаатар хотын иргэд, 14.0% тухайн орон нутаг буюу Өмнөговь аймаг, Өмнөговь аймгийн Цогтцэций сумын иргэд юм.

Компани нь мэргэжлийн чадварлаг ажилчдыг татах, ажилчдынхаа хөдөлмөр, эрүүл ахуйн аюулгүй байдал, нийгмийн хамгаалал, хөгжил, мэргэшилд анхааран тогтвор суурьшилтай ажиллах боломжийг нь бүрдүүлэхийг зорин ажилладаг.

Энэ хүрээнд хүний нөөцийн бүрдүүлэлт, сонгон шалгаруулалт, ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, шагнал урамшуулал болон нийгмийн хангамжийн систем, ажилтнуудын сургалт, хөгжил, хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн багц журмуудыг баталгаажуулан мөрдөж, урамшуулал, шагнал, нийгмийн хамгааллын олон ажил, хөтөлбөрүүдийг зохион байгуулан ажиллаж байна.

1.9. Компанийн засаглал

Эрдэнэс-Тавантолгой ХК нь компанийн засаглалын тогтолцоог сайжруулах, засаглалыг илүү нээлттэй ил тод болгон хувьцаа эзэмшигчид, нийт ажилтнууд, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, урт хугацаанд хувьцааны үнэ цэнийг өсгөх, компанийн нэр хүндийг нэмэгдүүлэх, дэлхийн жишигт нийцсэн сайн засаглалыг хэрэгжүүлэхэд анхааран ажиллаж байна.

2019 онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас төрийн өмчит компаниудын засаглалыг үнэлэх ажлыг зохион байгуулсан бөгөөд Эрдэнэс-Тавантолгой ХК нь 69%-ийн үнэлгээгээр нэгдүгээр байрт жагссан байна.

ТУЗ-ийн 2019 оны 04 сарын 18-ны өдрийн 16 тоот тогтоолоор Компанийн засаглалын кодексийг баталсан /Хавсралт 41/ ба дараах чиглэлээр компанийн засаглалыг хэрэгжүүлэн ажиллахаар тусгажээ.

Үнэт цаас гаргагчийн дүрэм, дотоод журмууд нь холбогдох хууль тогтоомж, хорооноос баталсан "Компанийн засаглалын кодекс"-т нийцэж байгаа ба зарим компанийн засаглалын дүрэм журмыг КТХ болон Компанийн засаглалын кодекст нийцүүлэн, үйл ажиллагаатайгаа уялдуулан ХЭХ болон ТУЗ-ийн хурлаараа хэлэлцүүлэн баталж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг зөвлөсөн байна.

Stamp: ТAVAN ERDENES TAVANTOLGOI JSC
Signature: [Handwritten Signature]

Stamp: ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ ХХК
Signature: [Handwritten Signature]

2021.03.19



Компанийн засаглалын кодексийг Монгол улсын хууль тогтоомж, СЗХ-ноос баталсан "Компанийн засаглалын кодекс" болон олон улсын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас (ЭЗХАХБ буюу OECD) гаргасан компанийн засаглалын зарчмууд зэрэг олон улсад танигдсан шилдэг туршлага, зарчмуудад суурилан боловсруулсан ба үйл ажиллагаандаа дагаж мөрдөн ажиллаж байна.

Хүснэгт 21. Компанийн засаглалын зарчмууд, хэрэгжүүлж буй байдал

Засаглалын зарчмууд	Хэрэгжүүлж буй байдал	Анхаарах асуудал
Тайлагнах зарчим	<ul style="list-style-type: none"> Компани нь ээлжит болон ээлжит бус ХЭХ-ыг жил бүр хууль, журмын дагуу зохион байгуулан ажиллаж байна. ТУЗ нь дүрэм, журмын дагуу үүсгэн байгуулагдаж, хурлаа зохион байгуулж, хувьцаа эзэмшигчид үйл ажиллагаа тайлагнан ажиллаж байна. ТУЗ-ийн дэргэдэх хороодыг байгуулан ажиллаж байна. ТУЗ нь 2019 онд нийт 27 удаа хуралдаж 91 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг КТХ, СЗХ-оос баталсан журмын дагуу зохион байгуулж ажилладаг. Компанийн ТУЗ, удирдлагууд ХЭХ-д оролцож, ирц бүртгэн баталгаажуулдаг. 	<ul style="list-style-type: none"> Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан шийдвэр, тогтоолыг бусад жижиг хувьцаа эзэмшигчдэд хүргэх тал дээр анхааран ажиллах шаардлагатай. ТУЗ-ийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгдөг байх. ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын нэр дэвшүүлэх үйл ажиллагааг тодорхой ойлгомжтой болгох

2021.03.19 10:30

TAVAN
ЭРДЭНЭС
ТАВАН
ТӨЛӨГЛИ
ЖСХ
JSC

МХБ-ийн гүйцэтгэл
Андрей
"БНД" ХХК
115320147



Шударга
байх зарчим

- Компанийн хувьцаа эзэмшигчдийн хувь эзэмшлийн тухай үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлан, компанийн танилцуулгад тусгасан.
- Бүх хувьцаа эзэмшигчдийг хуралд оролцох нөхцлөөр хангадаг. Хувьцаа эзэмшигчдэд асуулт тавьж мэдээлэл авах боломжийг олгодог.
- Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг холбогдох дүрэм журмын дагуу хүргэн ажилладаг.
- Компанийн засаглалыг сайжруулж, олон нийтийн хяналт, оролцоог нэмэгдүүлэх, сурталчилах зорилгоор Олон нийтийн зөвлөлийг байгуулсан.
- Ногдол ашгийн журмыг 2019 оны 02 сарын 25-ны өдөр баталсан.
- 2020 оны 02 сарын 17-нд нэг хувьцаанд 90 төгрөг тараахаар шийдвэрлэсэн.
- Төрийн эзэмшлийн хувьцааг төлөвлж буй этгээдүүдийн эрх хэмжээг тусгайлан тогтоох

- Төрийн төлөөллийн үйл ажиллагааг тодорхой болгох
- Жижиг хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрх УИХ, Засгийн газрын дагуу Эрдэнэс Тавантолгой ХК-ийн хувьцаа олон улсын зах зээл дээр арилжих эхлэх хүртэл хаалттай байна.
- Хувьцаа эзэмшиж буй Монгол улсын иргэдийн хувьцааны бүртгэлийг эцэслэн нэгтгэх асуудал удаашралтай байна.

Ил тод
байдал

- Компанийн үйл ажиллагааны тайлан, худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөө тайланг цахим хуудаст нээлттэй байршуулсан
- Компани өөрийн цахим хуудас болон олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр цаг үеийн мэдээллийг хүргэн ажиллаж байна.
- 1072 хувьцаа мэдээллийн төвийг нээн хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэн ажиллаж байна.
- Цахим хуудаст ХЭХ-ын материал, холбогдох материалыг тавьж ажилладаг.
- НББОУС-ын дагуу санхүүгийн тайланг боловсруулдаг.
- Авилгын эсрэг төлөвлөгөө, тайлан, Байгаль орчны менежментийн төлөвлөгөө тайланг цахим хуудаст оруулсан.
- Компанийн дүрэм, журмыг цахим хуудаст байршуулан ажиллаж байна.

- Компани дээр гарсан томоохон өөрчлөлтийг мэдээлэх ажиллагааг журамлах
- Нууц болон нийтэд тод байх мэдээллийг тодорхой болгох
- Компанийн цахим хуудаст хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдад зориулсан тусгай булан байршуулж, журмын дагуу нийтлэх мэдээллийг оруулдаг байх

Үүрэг
хариуцлага

- Компани ажилчид, нийгэм, байгаль, орчинд чиглэсэн нийгмийн хариуцлагын ажлуудыг тогтмол хэрэгжүүлэн ажиллаж байна.
- Орон нутгийн удирдлагуудтай хамтран ажиллаж, орон нутгийн хөгжлийг дэмжих багц хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

- Орон нутгийн иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэх тал дээр шуурхай, үр дүнтэй ажиллах

2021.03.19

Компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ногдол ашиг хуваарилах эсэх талаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

Нэгж хувьцаанд хуваарилах ногдол ашгийн хэмжээг тухайн санхүүгийн жилийн татварын дараах цэвэр ашгийн хэмжээ, компанийн богино болон дунд хугацааны стратегийн төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлага зэргийг үндэслэн тогтооно.

Компани Ногдол ашгийн журмыг ТУЗ-ийн 2019 оны 02 сарын 25-ны өдрийн 05 дугаар тогтоол /Хавсралт 42/-оор баталсан.

Ногдол ашиг хуваарилах нөхцөл

- Ногдол ашиг төлсний дараа компани нь төлбөрийн чадвартай байх;
- Ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, түүний татан буулгалтын үнэ, компанийн дүрэмд заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ зэргийн нийлбэрээс их байх;
- Компани нь эргүүлэн худалдан авах үүрэгтэй үнэт цаасаа худалдан авсан байх;
- Ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь 25 хувиас дээш хувиар багассан тохиолдолд компани нь ногдол ашгийг шилжүүлсэн өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор эзэлдүүлэгчид өөрийн хөрөнгийн хэмжээг бичгээр мэдэгдэнэ.

Ногдол ашиг хуваарилах, мэдээлэх, тайлагнах

- Ногдол ашиг хуваарилах хэлбэр, олгох хугацаа, журам нь хувьцаа эзэмшигчдэд аль болох тохиромжтой байна.
- Ногдол ашгийг төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоосон хугацаанд төлөөгүй бол хувьцаа эзэмшигчийн нэхэмжлэлээр алданги төлнө.
- Тогтоосон хугацаанд ногдол ашгаа аваагүй нь тухайн хувьцаа эзэмшигчийн ногдол ашиг авах эрхийг үгүйсгэх, эсхүл компани ногдол ашиг олгохгүй байх үндэслэл болохгүй.
- Ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр гарсан үед төлбөл зохих ногдол ашгийн хэмжээг хувьцаа эзэмшигчдэд төлөх өр болгон нягтлан бодох бүртгэлд тусгана.
- Ногдол ашгийг ҮЦТХТ ХХК-иар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны хадгаламжийн дансанд шилжүүлэх бодлого баримтлана.
- Компани ногдол ашиг хуваарилахтай холбоотой мэдээллийг хувьцаа эзэмшигчдийн хурлын зар мэдээг хүргэх журмаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хувьцаа эзэмшигчдэд хүргэхээс гадна саадгүй танилцах боломжийг бүрдүүлнэ.

2020 онд Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ногдол ашиг хуваарилах асуудлаар 2 удаа шийдвэр гаргасан.

Эрдэнэс-Тавантолгой ХК
Төлөөлөн удирдах зөвлөл
Г. А. А. А.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
Г. А. А. А.



2020 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн хурлаас нэгж хувьцаанд 90 төгрөгийн ногдол ашиг хуваарилах тухай 09 тоот тогтоолыг баталж, компанийн хувьцааг эзэмшиж буй Монгол улсын иргэн, Аж ахуйн нэгжийн хувьцааны ногдол ашгийн мөнгийг бэлэн мөнгөөр олгох, төрийн мэдлийн хувьцааны ногдол ашгийг бэлэн бусаар буюу үнэт цаасаар олгохоор шийдвэрлэж байсан.

БҮРТГЭВ-02

Харин Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 20 тоот тогтоолоор төрийн мэдлийн хувьцаанд ногдох ногдол ашгийг "Монголын төмөр зам" ХК-ийн гаргасан өрийн бичиг, "Тавантолгой түлш" ХХК-иас авах авлагаар төлөхөөр өмнө гаргасан шийдвэрт өөрчлөлт оруулсан байна.

1.11. Нийгмийн хариуцлагын хүрээнд хийж гүйцэтгэсэн ажил

Эрдэнэс-Тавантолгой ХК нь хариуцлагатай уул уурхай хөтөлбөрийн хүрээнд нийгмийн хариуцлагын ажлыг эрчимжүүлж шинэ түвшинд гарган ажилласнаар компанийн үйл ажиллагаатай холбоотой сөрөг мэдээлэлд бодит дүгнэлт хийж харилцан ойлголцол, хамтын ажиллагаа сайжирч бүтээн байгуулалтын ажилд эерэг нөлөө үзүүлж байна.

Компани 2020 оноос эхлэн компанийн үндсэн үйл ажиллагааны чиглэлд нийцсэн "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн "Нийгмийн хариуцлагын бодлогын баримт бичиг"-ийг батлан мөрдөж ажиллаж байна.

Компани нь орон нутагт томоохон хөрөнгө оруулалт, дэд бүтэц, авто зам барьж байгуулах, нутгийн иргэдийг ажлын байраар хангах, өрхийн үйлдвэрлэл, боловсрол, эрүүл мэндийн салбарыг дэмжих, байгаль орчны нөхөн сэргээлт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хүснэгт 22. Нийгмийн хариуцлагын хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлууд

Орон нутаг, хамтын ажиллагааны чиглэлээр хийгдсэн ажлууд:

2016 он

Цогтцэций сумын хөгжлийн бэрхшээлтэй 30 хүүхэд, "Халуун болор" төвийн тархины саажилттай 60 хүүхдэд тусламж үзүүлээ.

2016 он

Улаанбаатар хот болон орон нутгийн төвлөрсөн халаалтын системд холбогдоогүй орон сууц болон гэрт амьдардаг ажилтнуудын өвөлжилтөд зориулж нүүрс олгох, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт компанийн нийт ажилтныг хамруулсан.

2016 он


Компанийн акталсан хөрөнгөнөөс ЦЕГ-ын сургалтын төвд хэрэгцээтэй эд материалыг шилжүүлэн үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэв.

2016 он

"Эрдэнэс-Таван толгой" ХК-ийн уурхайд орон нутгаас ажилчид авах талаар анхаарч ажилласны хүрээнд Компанийн нийт ажилчдын 20 гаруй хувийг Өмнөговь аймгийн нутгийн иргэдээс бүрдүүлсэн.

2017 он

Өмнөговь аймгийн оюутнуудын дунд уламжлал болгон жил бүр зарлан явуулдаг оюутны тэтгэлэгт хөтөлбөрийг 4 дэх удаагаа зохион байгуулж, Цогтцэций сумын 4 багийн амьжиргааны төвшин доогуур айл өрхийн 10 оюутныг шалгаруулан, сургалтын төлбөрийн тэтгэлгийг гардуулах ажлыг зохион байгуулсан.



2021.03.03



0000075

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ,
MONGOLIAN STOCK EXCHANGE

2017 он

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Түвдэнгийн Борын нэрэмжит 12 жилийн сургуульд 43 нэр төрлийн 134 ширхэг хөдөлмөрийн багаж, хэрэгсэл, Мөрөөдөл 6-р сургуульд 24 нэр төрлийн 42 ширхэг хөдөлмөрийн багаж, хэрэгсэл хүлээлгэн өгч, хөдөлмөрийн кабинетыг иж бүрэн тохижуулах ажлыг хийж гүйцэтгэсэн.

2018 он

Өмнөговь аймгаас 35, Цогтцэций сумаас 25 нийт 60 оюутанд сургалтын тэтгэлэг олгосон.

2018 он

Цогтцэций сумын "Энэрэхүй-Ухаан" Өрхийн эрүүл мэндийн төвийн чийрэгжүүлэлтийн өрөөг бүрэн тохижуулж ашиглалтанд оруулж, хүлээлгэн өгсөн. Мөн нөлөөллийн бүс дэх иргэдийг эрүүл мэндийн үзлэгт хамруулах, дэмжлэг үзүүлэх ажлыг амжилттай зохион байгуулсан.

2018 он

Гүйцэтгэх захирлын тушаалаар Өмнөговь аймгийн Цогтцэций сумын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш нарт "Багшийн хөгжил ба Чанартай сургалт" сэдэвт сургалтыг Монгол улсын Боловсролын Их сургууль, Сургуулийн өмнөх боловсролын сургуультай хамтран 09 сарын 06-08-ны өдрүүдэд зохион байгуулав.

2018 он

Өмнөговь аймгийн ахмадуудыг 2018 оны 09 сарын 14-ний өдөр эрүүл мэндийн үзлэгт хамруулж, амралт сувилалд хамруулах ажилд дэмжлэг үзүүлэн хамтран ажилласан.

2018 он

Өмнөговь аймгийн Даланзадгад сумын Монгол Улсын хурц арслан Гомбо-Аюушийн Дэмүүл агсны нэрэмжит Үндэсний бөхийн барилдааныг Монголын үндэсний бөхийн холбооны Өмнөговь аймаг дахь салбартай хамтран 2018 оны 03 сарын 19-ний өдөр зохион байгуулж дэмжлэг үзүүлсэн.

2018 он

Орон нутгийн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдээс бараа, ажил үйлчилгээний худалдан авалт хийх арга хэмжээг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж нийт 111,732,541 төгрөгийн худалдан авалт хийж дэмжлэг үзүүлсэн.

2019 он

Хамтын ажиллагааны хүрээнд 51 арга хэмжээг хэрэгжүүлж, 16.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт, тусламж дэмжлэг үзүүлжээ.

2019 он

"Ахмадын өдөр"-ийг тохиолдуулан тус сумын харьяат 48 ахмадыг "Ар Үр" сувиллын газарт эрүүл мэндийн үзлэг, оношлогоонд хамруулсан.

2019 он

Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн нэрэмжит "Оюутны тэтгэлэгт хөтөлбөр 2020"-ийг зарлаж, шалгарсан 90 оюутанд тэтгэлэг гардуулсан.

2019 он

Орон нутгийн төрийн байгууллагуудын техник, материаллаг баазыг нэмэгдүүлэх, албан хаагчдын ажил үүргээ гүйцэтгэх нөхцөл боломжийг сайжруулах зорилгоор 3 ширхэг УАЗ-фургон маркийн авто машиныг Өмнөговь аймгийн мэргэжлийн хяналтын газар



2022.10.30



- Цогтцэций сум дахь сум дундын Цагдаагийн хэлтэс 20 гал түймэр унтраах, аврах 44-р ангид тус тус хүлээлгэн өглөө.
- 2019 он Цогтцэций сумын Т.Борын нэрэмжит ЕБС-д Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн нэрэмжит "Технологийн жишиг кабинет" байгууллаа.
- 2020 он Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн нэрэмжит тэтгэлгийг 90 оюутанд олгов.
- 2020 он Цогтцэций сумын Эрүүл мэндийн төвд химийн хортой хаягдал устгах автоклав болон дагалдах хэрэгслүүдийг хандивлалаа.
- 2020 он Цогтцэций сумын 27-р цэцэрлэгийн дуу хөгжмийн кабинетэд шаардлагатай мэргэжлийн даралтат хөгжим, тоног төхөөрөмж дагалдах хэрэгслүүдийн хамт хүлээлгэн өглөө.
- 2020 он Даланзадгад хотын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн мэдээлэл зүйн кабинетыг бүрэн тохижууллаа.
- 2020 он Цогтцэций сумын 6 өрхөд 5 ханатай иж бүрэн гэрийг хүлээлгэн өглөө.
- 2020 он Цогтцэций сумын гал унтраах, аврах 44-р ангид сансрын холбооны ридиум гар утас хүлээлгэн өгөв.

Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр:

- 2020 он 66,1 сая төгрөгийн өртөг бүхий бүтээгдэхүүнийг "Эрдэнэс-Тавантолгой" ХК-тай тээврийн гэрээ байгуулсан компанийн нүүрс тээврийн жолооч нарт тараав.
- 2020 он Өмнөговь аймгийн хэмжээнд "Covid-19" вирусийн халдварын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хилийн боомтод ариутгал, халдваргүйтгэл хийх, шаардлагатай нөөц бүрдүүлэх ажлын зардалд 52.5 сая төгрөгийг хандивлалаа.
- 2021 он Ковид - 19 цар тахлын үед Улаанбаатар хотын гэр хорооллын иргэдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилгоор сайжруулсан шахмал түлшний үнийг 75 хувиар бууруулсан бөгөөд "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн зүгээс нийтдээ 128 тэрбум төгрөгийн нэмэлт санхүүжилт олгов.


Байгаль орчныг хамгаалах чиглэлээр хэрэгжүүлсэн ажлууд:

- 2016 он Ажилчдын "Цанхи" ба "Эрдэнэс" хотхонууд хоорондын 2,500 метр шуудуунд 8,000 хайлаас тарьсан. "Эрдэнэс"-ийн үр сэлгээний талбайд нэмж 7 зүйлийн 3,485 мод тарьсан.
- 2016 он Шимт хөрсний 1,2,7-р овоолгуудад усалгааны систем төлөвлөн байгуулж 3 га зүлэг тарьсан.

2017 оны 09 сарын 29-ний өдөр гамшгийн хэмжээнд хүрээд буй түймрийг унтраах улсын хэмжээний аянд нэгдэн компанийн нийт ажилтан, албан хаагчдын дунд хандивын аян өрнүүлж, хандивыг мөнгөн хэлбэрээр цуглуулсан. Үүний дагуу Онцгой Байдлын алба



2021.02.10 30



хаагчдын ажлыг дэмжин, туулах чадвар сайтай фургон автомашин, авч өгөх ажлыг зохион байгуулсан.

2018 он

"Эрдэнэс Тавантолгой" ХК нь байгаль орчинд учирч болохуйц сөрөг нөлөөлийг бууруулах, арилгах, нөхөн сэргээх зорилготой менежментийн төлөвлөгөөг БОАЖЯ-аар батлуулан Цанхийн уурхайн үйл ажиллагаанд хог хаягдал, ус, тоосжилт, хөрсний элэгдэл, эвдрэл нөхөн сэргээлт зэрэг чиглэлүүдээр төрөлжсөн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажилласан.

2018 он

Шимт хөрсний овоолгын хэлбэржүүлэлт ба ургамалжуулалтын ажлыг амжилттай хийж байна.

2018 он

Цанхийн зүүн уурхайн хөрсний 1 дүгээр овоолго дээрх 5 дугаар шимт хөрсний овоолгыг MNS 5916:2008 стандартын дагуу хэлбэршүүлэн хамгаалах ажлын хүрээнд 13.9 мянган м³ шимэрхэг хөрс, 5.7 мянган м³ сажатай хольж сайжруулсан шимэрхэг хөрс, 6.3 мянган м³ шимт хөрсийг зөөж, нийт 41.2 мянган м³ материалыг зөөн байрлуулж хэлбэржүүлэх ажлыг хийж гүйцэтгэсэн. Мөн тус талбай дээр салхины хаалт үүсгэх зорилгоор 500 ширхэг улиас, 250 ширхэг голт бор тариалсан.

2018 он

Нөхөн сэргээлтийн үрсэлгээний талбайг бий болгохтой холбогдуулан модлог ургамлыг үрээр тарьж ургуулах ажлыг Эрдэнэс хотхоны дэргэдэх мод үрсэлгээний талбайд Жигд 1 кг, Шар хуайс 1 кг, Хайлаас 3 кг үрээр тариалалт хийсэн. Тариалалт хийхдээ хөрсийг урьдчилан боловсруулж, хагалж бэлтгэн био ялзмаг ашиглан модлог ургамлын үрийг тариалсан.

2018 он

"Ногоон говь" хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн хувиараа аж ахуй эрхлэгчдээс 1,000 ширхэг хайлаасны суулгац худалдан авч Цогтцэций сумын иргэдэд "Мод тарих" өдөрт зориулан хандивласан. Нийт 3,500 ширхэг модлог ургамлыг уурхайн оффисын гаднах талбай болон үрсэлгээний талбайд тус тус тариалсан. Мөн Цогтцэций сумын төвд байгуулах "Эрдэнэсийн арал" цэцэрлэгт хүрээлэнд чацаргана, голт бор, хайлаас, бүйлс, гүйлс зэрэг 7 төрлийн 740 ширхэг модлог ургамлыг тариалсан.

2018 он

Байгал орчныг хамгаалах төлөвлөгөөт ажлын хүрээнд зэрлэг амьтдыг хамгаалах биотехникийн арга хэмжээ хэрэгжүүлэхээр Сийрст багийн нутагт орших Хангинахын хөндийн ан амьтдад зориулан 50 боодол өвс, мөс тараан байршуулсан. Өвс тараах ажилд орон нутгийн идэвхитэн байгаль хамгаалагч болон туслан гүйцэтгэгч гэрээт компанийн байгаль орчны мэргэжилтнүүдийг хамтран оролцуулсан.

Хог хаягдлын их цэвэрлэгээг Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу улирал бүр зохион байгуулан ажиллаж байна. Цогтцэций сумын төвөөс урд зүг 6 км-т орших цайны газруудын ойр орчмын хур хог хаягдал, Цогтцэций сумын төвд



2021-03-19



0000078

ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ ХК

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIA OPEN MARKET

байрлах хуучин хогийн цэгүүдийн хог хаягдлыг техник гарган ачиж цэвэрлэн хогын нэгдсэн цэгт хүргэх ажлыг хийж гүйцэтгэсэн. Эрдэнэс-Тавантолгой ХК хог хаягдлын төлбөрт 2,766 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлээд байна.

БҮРТГЭВ-02

2018 он

Тоосонцорын хоногийн хэмжилтийг хийж гүйцэтгэх батлагдсан хуваарийн дагуу нийт 6-н цэгт (ЭТТ-3, ТТJVCо-1, Хишиг арвин-2 цэгт) тогтмол хэмжилт хийж байна. Мөн улирал тутамд худгийн ус, цэвэрлэх байгууламжаас гарсан саарал ус болон хөрснөөс дээж авч мэргэжлийн хяналтын итгэмжлэгдсэн лабораторид өгч шинжилгээнд хамруулж ажиллалаа.

2018 он

"Эрдэнэс-Эко Уурхай" хөтөлбөрийн хүрээнд, шар хуайс, улиас, хайлаас, голт бор, монос зэрэг 33,392 мод тарьж Цогтцэций суманд цэцэрлэгт хүрээлэн байгуулах зорилгоор 2.3 га газрыг хашаажуулан зүлэгжүүлж, 700 ширхэг суулгац тариалсан.

2019-2020 он

Байгаль орчинд учирч болохуйц сөрөг нөлөөлийг бууруулах, арилгах, нөхөн сэргээх зорилготой менежментийн төлөвлөгөөг 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр БОАЖЯ-аар батлуулан Цанхийн уурхайн үйл ажиллагаанд хог хаягдал, ус, тоосжилт, хөрсний элэгдэл, эвдрэл нөхөн сэргээлт зэрэг чиглэлүүдээр төрөлжсөн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Усны зохистой хэрэглээг бий болгох чиглэлээр хэрэгжүүлсэн ажлууд:

2018 он

3,414 тонн усыг мод усалгаа болон ойжуулалтын зориулалтаар, Цанхийн зүүн уурхайгаас шавхан зайлуулсан буюу шүүрлийн ус 20,617 тонн усыг тоосжилт дарах зорилгоор зам усалгаанд дахин ашигласан.

2018 он

Цанхийн уурхайн цогцолбор нь говь нутгийн байгалийн онцлогийг харгалзан үзэж усны зохист хэрэглээг чухалчлан үйл ажиллагаа явуулах үүднээс үйлдвэрлэлийн болон хэрэглээний ус ашиглалтын ухаалаг, дэвшилтэт системийг нэвтрүүлэн ажилласнаар өмнөх оноос 30 хувиар бага усыг өрөмдмөл худгаас ашигласан байна.

2018 он

Малчдын худгийг лайдаж сэргээн засах ажлыг хийж гүйцэтгэн Эрдэнэс-Тавантолгой ХК болон сум орон нутгийн төлөөллийг оролцуулсан ажлын хэсгийг байгуулж Билгэх багийн Ухаа, Улаан, Ихэр худгууд, Цагаан-Овоо багийн Бунхант, Наран, Гоёот зэрэг нийт 6 худгийг сэргээн засварлах ажил хийгдэж дуусгасан.

2018 он


Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Цагаан-Овоо багийн нутагт орших Хужирын хонхорын булгийн эхийг хашиж хамгаалах ажлыг хийж гүйцэтгэсэн нь тус компанийн хашиж хамгаалж байгаа 3 дахь булаг болж байна.



2021.10.30



0000079



Компани орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу ус, хөрс, ургамал, агаарын мониторингийн ажлыг хуваарийн дагуу тогтмол хийж гүйцэтгэж байна. Үүнд:

2018 он

- Малчны худгийн усны түвшин хэмжих;
- Тоосны унац болон ширхэглэгийн хэмжилт;
- Усны тоолуурын баталгаажуулалт хийх;
- Гүний усны цооногийн түвшин хэмжих;
- Хийн төлөвт органик бус бохирдуулагчийн хэмжилт зэрэг болно.

2020 он

"Эрдэнэс-Тавантолгой" хувьцаат компани уурхайн дэд бүтцийн усан хангамжийн эх үүсвэрийг Загийн усны хоолойгоос татаж авах бололцоог бүрдүүлэхээр "Монгол Ус" ТӨҮГ-тай "Санамж бичиг" байгуулсан.

2019-2020 он

Уурхайн үйл ажиллагааны явцад үүсэж буй тоосжилтыг бууруулах зорилгоор сул хөрс, түйрмийг тогтмол хусаж цэвэрлэх, усалгааны давтамж нэмэгдүүлэх, технологийн замуудад хайрга болон улаан шороог дэвсэх зэрэг ажлууд хийж гүйцэтгэсний үр дүнд уурхайн тоосжилт буурч, 5 цэгт хэмжилт хийхэд тоосжилт 10-50 хувиар буурсан.

Нийгмийн хариуцлагын чиглэлээр хэрэгжүүлсэн ажлууд:

2019 он

Олон улсын хүүхдийн "Найрамдал" цогцолборын Хөгжил мэдээллийн ордны спорт заалны засварыг хийж 2019 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр хүлээлгэн өгөв.

2019 он

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 154 дүгээр тогтоолын дагуу "Азийн хүүхдүүд" олон улсын спортын VII их наадмын бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах чиг үүрэг бүхий Нийслэлийн өмчит "Улаанбаатар спорт менежмент" ХК байгуулагдсан бөгөөд уг компаниас ирүүлсэн хүсэлтийн дагуу Усан спортын ордны бүтээн байгуулалтад 5 тэрбум төгрөгийн дэмжлэг туслалцааг үзүүлжээ.


2019 он

Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Мэдээгүйжүүлэлт, хагалгааны нэгдсэн тасгийг тохижуулах ажлыг компанийн зүгээс санаачлан хэрэгжүүлжээ.

2020 он

Монгол Улсын Ерөнхийлөгчийн "Монгол баатарлаг туульсаа дээдлэн дэлгэрүүлэх тухай" 2019 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 13 дугаар зарлигийг хэрэгжүүлэх зорилгоор "Хамтын нөлөө" ТББ-тай хамтран ажиллах гэрээ байгуулж, Монгол баатарлаг туульсаа 10 боть болгон хэвлүүлэх ажилд туслалцаа үзүүлэн хамтран ажиллаж байна.

Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах зорилгоор "Тавантолгой түлш" ХХК-д 2018 оноос дэмжлэг үзүүлэн ажиллаж байгаа бөгөөд нийтдээ 220.9 тэрбум төгрөгийн санхүүжилт хийж, Баруун, Зүүн бүсийн сайжруулсан түлшний үйлдвэр байгуулах, төлөг төхөөрөмж худалдан авахад зарцуулжээ.



2020.03.19

2021-03-19

2.1. Өөрийн хөрөнгө, биет болон биет бус хөрөнгө

"Үндэсний аудитын газар" нь төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1-д заасны дагуу "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн 2019 оны 12 дугаар 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийж гүйцэтгэсэн.

Хавсралт 44. Аудитын байгууллагатай байгуулсан гэрээний хуулбар

"Үндэсний аудитын газар" -ын гүйцэтгэсэн аудитын тайланд тусгаснаар 2019 оны 12 сарын 31-ны өдрийн байдлаар Үнэт цаас гаргагчийн өөрийн хөрөнгө нь 13,029,918,643.63 мянган төгрөг байна. Үүнээс хувьцаат капитал 11,196,000,000 мянган төгрөг, хуримтлагдсан ашиг 1,833,918,643.63 мянган төгрөг байна.

2020 оны 12 сарын 31-ны өдрөөр тасалбар болсон аудитлагдаагүй санхүүгийн тайланд үнэт цаас гаргагчийн өөрийн хөрөнгө 12,110,242,038.64 мянган төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 919,676,604.99 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 23. Үнэт цаас гаргагчийн өөрийн хөрөнгө

мян.төг	2017	2018	2019	2020*
Хувьцаат өмч	11,196,000,000.00	11,196,000,000.00	11,196,000,000.00	11,196,000,000.00
Хуримтлагдсан ашиг	36,820,605.84	807,826,923.20	1,833,918,643.63	914,242,038.64
Нийт өөрийн хөрөнгө	11,232,820,605.84	12,003,826,923.20	13,029,918,643.63	12,110,242,038.64

*Аудитлагдаагүй дүн

2020 оны санхүүгийн тайланд тусгаснаар Үнэт цаас гаргагч нь нийт 12,955,745,849.03 мянган төгрөгийн эргэлтийн бус хөрөнгөтэй ба үүнээс 46,918,974.56 мянган төгрөг үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө 11,138,815,800.46 мянган төгрөг, урт хугацаат хөрөнгө оруулалт 309,341,309.16 мянган төгрөг, хайгуул ба үнэлгээний хөрөнгө 15,941,550.06 мянган төгрөг, хойшлогдсон татварын хөрөнгө 46,014,648.27 мянган төгрөг, бусад эргэлтийн бус хөрөнгө 1,398,713,566.52 мянган төгрөг байна.

Хүснэгт 24. Үнэт цаас гаргагчийн эргэлтийн бус хөрөнгө

Эргэлтийн бус хөрөнгө	2019 /мян.төг/	2020* /мян.төг/
Үндсэн хөрөнгө	37,416,536.45	46,918,974.56
Биет бус хөрөнгө	11,159,414,518.19	11,138,815,800.46
Урт хугацаат хөрөнгө оруулалт	312,187,509.16	309,341,309.16
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	13,711,907.86	15,941,550.06
Хойшлогдсон татварын хөрөнгө	23,302,067.51	46,014,648.27
Бусад эргэлтийн бус хөрөнгө	798,825,099.32	1,398,713,566.52
Нийт эргэлтийн бус хөрөнгийн дүн	12,344,857,638.48	12,955,745,849.03

*Аудитлагдаагүй дүн

Сая төгрөгөөр	2017	2018	2019	2020*
ХӨРӨНГӨ				БҮРТГЭЭ-02
Эргэлтийн хөрөнгө				
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	88,401.23	605,258.48	656,360.02	134,579.82
Дансны авлага	24,184.39	49,626.54	222,962.49	22,843.72
Татвар, НДШ-ийн авлага	10,213.42	65.69	539.42	2,925.86
Бусад авлага	418.07	402.56	26,834.55	581.93
Бусад санхүүгийн хөрөнгө	6,591.68	15,325.99	15,323.47	15,598.87
Бараа материал	178,218.10	104,110.86	105,541.23	129,688.07
Урьдчилж төлсөн зардал/гооцоо	6,607.84	8,725.26	12,334.14	898,673.49
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө	-	392.53	392.53	392.53
Эргэлтийн хөрөнгийн дүн	314,634.73	783,907.92	1,040,287.84	1,205,284.29
Эргэлтийн бус хөрөнгө				
Үндсэн хөрөнгө	20,238.31	31,646.32	37,416.54	46,918.97
Биет бус хөрөнгө	11,194,157.14	11,184,756.41	11,159,414.52	11,138,815.80
Урт хугацаат хөрөнгө оруулалт	583.35	462.01	312,187.51	309,341.31
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	1,224.66	10,649.41	13,711.91	15,941.55
Хойшлогдсон татварын хөрөнгө	10,909.55	62.63	23,302.07	46,014.65
Бусад эргэлтийн бус хөрөнгө	304,790.48	313,157.06	798,825.10	1,398,713.57
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	11,531,903.50	11,540,733.84	12,344,857.64	12,955,745.85
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	11,846,538.23	12,324,641.76	13,385,145.48	14,161,030.14
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ				
Өр төлбөр				
Богино хугацаат өр төлбөр				
Дансны өглөг	80,205.95	94,022.78	184,098.78	373,683.05
Цалингийн өглөг	955.81	6,586.87	8,862.98	8,139.62
Татварын өр	14,428.70	67,551.89	88,455.57	62,676.09
НДШ-ийн өглөг	34.01	83.28	0.00	0.00
Богино хугацаат зээл	121,356.50	-	-	330,000.00
Хүүний өглөг	94,104.20	-	-	150.63
Урьдчилж орсон орлого	149,467.47	106,941.52	23,630.48	339,773.74
Нөөц /өр төлбөр/	-	10,032.03	6,803.15	426.56
Богино хугацаат өр төлбөрийн дүн	460,552.65	285,218.37	311,850.96	1,114,849.69
Урт хугацаат өр төлбөр				
Урт хугацаат зээл	121,356.50	-	-	-
Нөөц /өр төлбөр/	31,808.48	31,808.48	36,602.49	45,516.33
Хойшлогдсон татварын өр	-	3,787.99	6,773.39	10,233.39
Бусад урт хугацаат өр төлбөр	-	-	-	880,188.70
Урт хугацаат өр төлбөрийн дүн	153,164.98	35,596.47	43,375.88	935,938.42
Өр төлбөрийн нийт дүн	613,717.62	320,814.84	355,226.84	2,050,788.10

2021.03.03

ЭЗДИЙН ӨМЧ
 Төрийн өмч
 Хувьцаат өмч

МХУ-ийн (шагнал) ...
 2,050,788.10
 Бүтээгч
 ТЭГЭЭ

Хувь нийлүүлсэн хөрөнгө	11,196,000.00	11,196,000.00	11,196,000.00	11,196,000.00
Хуримтлагдсан ашиг	36,820.61	807,826.92	1,833,918.64	914,242.04
Эздийн өмчийн дүн	11,232,820.61	12,003,826.92	13,029,918.64	12,110,242.04
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	11,846,538.23	12,324,641.76	13,385,145.48	14,161,030.14

*Аудитлагддаггүй дүн

- Үнэт цаас гаргагч нь 2019 оны байдлаар нийт 13.4 их наяд төгрөгийн нийт хөрөнгөтэй, 355.2 тэрбум төгрөгийн өр төлбөр, 13 их наяд төгрөгийн өөрийн хөрөнгөтэй байна. Компанийн нийт хөрөнгийн 8 хувийг эргэлтийн хөрөнгө, 92 хувийг эргэлтийн бус хөрөнгө эзэлж байна.
- Харин 2020 оны байдлаар 14.2 их наяд төгрөгийн нийт хөрөнгөтэй, 2 их наяд төгрөгийн өр төлбөр, 12 их наяд төгрөгийн өөрийн хөрөнгөтэй байна. Компанийн нийт хөрөнгийн 9 хувийг эргэлтийн хөрөнгө, 91 хувийг эргэлтийн бус хөрөнгө эзэлж байна.

2.3 Орлогын дэлгэрэнгүй тайлан

Хүснэгт 26. Орлогын дэлгэрэнгүй тайлан

Сая төгрөгөөр	2017	2018	2019	2020*
Борлуулалтын орлого	1,182,364.02	1,986,874.10	2,660,970.56	1,547,691.72
Борлуулалтын өртөг	381,175.58	680,578.29	695,657.58	672,600.33
Нийт ашиг (алдагдал)	801,188.44	1,306,295.82	1,965,312.98	875,091.39
Түрээсийн орлого	-	77.89	106.15	157.97
Хүүний орлого	1,946.56	4,038.24	27,509.40	24,164.22
Бусад орлого	9,692.10	21,132.41	7,011.03	5,034.50
Борлуулалт, маркетингийн зардал	(159,872.98)	(278,690.23)	(351,069.04)	(324,315.46)
Ерөнхий ба удирдлагын зардал	(10,832.33)	(16,640.43)	(19,605.07)	(18,039.33)
Санхүүгийн зардал	(39,521.26)	(4,587.77)	-	(10,415.29)
Бусад зардал	(16,870.87)	(28,723.30)	(239,569.18)	(286,562.69)
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(31,088.32)	28,877.72	16,341.30	(1,176.90)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(30.11)	(65.89)	(57.09)	(11.37)
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	554,611.22	1,031,714.44	1,405,980.48	263,927.04
Орлогын татварын зардал	93,541.81	224,152.25	370,405.68	102,066.24
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	461,069.41	807,562.20	1,035,574.80	161,860.80

*Аудитлагддаггүй дүн

2.4 Мөнгөн гүйлгээний тайлан

Хүснэгт 27. Мөнгөн гүйлгээний тайлан

Сая төгрөгөөр	2017	2018	2019	2020*
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ				
Мөнгөн орлогын дүн (+)	1,000,260.08	1,748,187.48	2,479,132.36	1,003,642.96
Борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	925,983.24	1,705,463.60	2,390,054.70	988,070.45

ЭРДЭНЭС ТАВАНТӨЛГӨЙ ХК
Гүйцэтгэгч

ЭРДЭНЭС ТАВАНТӨЛГӨЙ ХК
Гүйцэтгэгч

2021.03.26



Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	123.70	47.22	38.57	31.87
Бусад мөнгөн орлого	74,153.13	42,676.66	89,039.10	15,539.73
Мөнгөн зарлагын дүн (-)	(707,405.55)	(983,289.74)	(1,690,340.47)	(1,002,174.57)
Ажиллагчдад төлсөн	(17,114.20)	(22,424.33)	(41,787.15)	(47,613.17)
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	(4,260.37)	(6,686.01)	(11,122.30)	(12,405.00)
Бараа материал худалдан авахад төлсөн	(911.30)	(400,823.02)	(822,185.52)	(441,955.13)
Ашиглалтын зардалд төлсөн	0.00	(37.37)	(22.56)	(28.35)
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	(1,257.28)	(1,608.55)	(2,876.88)	(1,842.46)
Хүүний төлбөрт төлсөн	(34,923.05)	(98,370.44)	-	(10,264.66)
Татварын байгууллагад төлсөн	(213,888.21)	(391,975.59)	(696,821.67)	(471,501.13)
Даатгалын төлбөрт төлсөн	(88.98)	(197.01)	(109.63)	(275.72)
Бусад мөнгөн зарлага	(432,962.15)	(61,167.43)	(115,414.74)	(16,288.96)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	294,584.53	764,897.74	788,791.89	1,467.49
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ				
Мөнгөн орлогын дүн (+)	-	4,027.91	26,402.41	7,401.67
Хүлээн авсан хүүний мөнгөн орлого	-	4,027.91	26,402.41	7,401.67
Мөнгөн зарлагын дүн (-)	(2,358.79)	(41,992.09)	(316,598.55)	157,174.18
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(841.27)	(6,175.31)	(3,266.89)	(21,236.67)
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(1,517.51)	(1,916.78)	(1,606.16)	(2,930.91)
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-	(311,725.50)	6.60
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	(33,900.00)	-	133,000.00
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(2,358.79)	(37,964.18)	(290,196.15)	(149,772.51)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ				
Мөнгөн орлогын дүн (+)	-	-	-	542.00
Мөнгөн зарлагын дүн (-)	(245,621.00)	(239,664.87)	(468,768.36)	(923,555.17)
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	(245,621.00)	(239,664.87)	(468,768.36)	(743,725.00)
Төлсөн ногдол ашиг	-	-	-	(179,830.17)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(245,621.00)	(239,664.87)	(468,768.36)	(381,555.17)
Валютын ханшийн эерүү	-	29,588.57	21,274.15	8,879.98
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	46,874.74	516,857.26	51,101.53	11,521,780.20
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	41,526.48	88,401.23	605,258.48	656,399.02



2021-03-19



Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	88,401.23	605,258.48	656,360.02	134,579.82
---	-----------	------------	------------	------------

2.5. Өмчийн өөрчлөлтийн тайлан

Хүснэгт 28. Өмчийн өөрчлөлтийн тайлан

Сая төгрөгөөр	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	300.00	(416,563.13)	(416,263.13)
НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	(7,685.68)	(7,685.68)
Тайлант үеийн цэвэр алдагдал	-	461,069.41	461,069.41
Өмчид гарсан өөрчлөлт	11,195,700.00	-	11,195,700.00
2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	11,196,000.00	36,820.61	11,232,820.61
НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	(36,555.88)	(36,555.88)
Тайлант үеийн цэвэр алдагдал	-	807,562.20	807,562.20
2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	11,196,000.00	807,826.92	12,003,826.92
НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	(9,483.07)	(9,483.07)
Тайлант үеийн цэвэр алдагдал	-	1,035,574.80	1,035,574.80
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	11,196,000.00	1,833,918.64	13,029,918.64
НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	(1,537.40)	(1,537.40)
Тайлант үеийн цэвэр алдагдал	-	161,860.80	161,860.80
Зарласан ногдол ашиг	-	(1,080,000.00)	(1,080,000.00)
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл*	11,196,000.00	914,242.04	12,110,242.04

*Аудитлагдаагүй дүн

Хавсралт 45-48-аас Компанийн 2017-2019 оны аудитын дүгнэлт, 2020 оны санхүүгийн тайланг үзнэ үү.

2021.03.09



Компанийн санхүүгийн голлох зарим харьцаануудыг 2017-2020 оны хугацаанд тооцсон. 2017 онд компани өнгөрсөн өр зээлийг төлж барагдуулсан, тухайн оноос өмнөх жилүүдэд уналттай байсан нүүрсний үнэ өсөж эхэлсэн зэрэг нөхцлөөс шалтгаалан 2018 оноос компанийн санхүүгийн үзүүлэлтүүд өсөж эхэлсэн байна. Компанийн ерөнхий үзүүлэлтүүд 2018, 2019 онд харьцангуй өндөр байсан бол 2020 онд Коронавирус цар тахлын нөлөөгөөр буурчээ.

Дараагийн жилүүдэд коронавирусын вакцин гарснаас хамааран худалдааны хориг, хязгаарлалууд тавигдан нөхцөл байдал хэвийн үргэлжилснээр компанийн үзүүлэлтүүд тогтворжих боломжтой.

Хөрвөх чадвар

Компанийн хөрвөх чадварын үзүүлэлтүүд ерөнхийдөө харьцангуй зохистой түвшинд байна. 2018-2019 онд өндөр байсан үзүүлэлт 2020 онд коронавирусын цар тахлын нөхцлөөс шалтгаалан буурчээ.

Хүснэгт 29. Хөрвөх чадварын шинжилгээ

	2017	2018	2019	2020
Эргэлтийн харьцаа	0.68	2.75	3.34	1.08
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	0.30	2.38	3.00	0.96

Эргэлтийн харьцаа. Энэ харьцаа нь компани эргэлтийн хөрөнгөө ашиглан богино хугацаат өр төлбөрөө төлөх чадамж ямар түвшинд байгааг хэмждэг. Компанийн эргэлтийн харьцаа нь 2018, 2019 онд дунджаас өндөр байсан.

2020 онд Ковид-19 цар тахлын улмаас компанийн экспортын борлуулалт огцом буурч, мөнгөн хөрөнгийн дутагдал бий болсон тул Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад гадны эх үүсвэрээс зээлийн санхүүжилт авсан. Энэ нь компанийн эргэлтийн харьцаа буурахад голчлон нөлөөлсөн хэдий ч уг харьцаа үзүүлэлт харьцангуй зохистой түвшинд байна.

Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа. Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар (эргэлтийн хөрөнгөөс бараа материалыг хассан үзүүлэлтийг богино хугацаат өр төлбөрт харьцуулсан харьцаа) 1-с их байх нь шаардлагатай үед богино хугацаат өр төлбөрөө төлөх боломжийг харуулдаг. 2020 онд компанийн төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа дээр дурдсан шалтгааны улмаас 3-аас 0.96 болж буурсан ч энэхүү үзүүлэлт харьцангуй зохистой түвшинд байна.

Үйл ажиллагааны үр ашигт байдал

Нийт хөрөнгийн эргэц нь нэг төгрөгийн хөрөнгө ашиглан бий болгож буй орлогын хэмжээг илэрхийлдэг. Иймд эргэц түргэсэх нь үйлдвэрлэлийн үр ашигт байдал сайжирч байгааг илтгэнэ. 2017-2019 оны хооронд компанийн нийт хөрөнгийн эргэц харьцангуй тогтвортой байсан. 2020 оны нөхцөл байдлаас шалтгаалан компанийн экспортын борлуулалтын орлого буурсан нь нийт хөрөнгийн эргэц буурахад нөлөөлжээ.

Компани гэрээт компаниудаар ажил гүйцэтгүүлдэг тул үндсэн хөрөнгийн эргэц харьцангуй өндөр буюу үр ашигтай байна.

ЭРДЭНЭС
ТАВАН
ТОЛГОЙ
ХАА

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
111505447-2052482

2021.03.19

Хүснэгт 30. Үйл ажиллагааны үр ашигт байдлын шинжилгээ

	2017	2018	2019	2020
Нийт хөрөнгийн эргэц	0.19	0.16	0.20	0.11
Үндсэн хөрөнгийн эргэц	58.42	62.78	71.12	32.99

Өрийн харьцаа

Компанийн өр төлбөрийн харьцаа ерөнхийдөө харьцангуй бага түвшинд, өр төлбөр төлж барагдуулах, үйл ажиллагаагаа тогтвортой явуулах чадавхтай байгааг илэрхийлж байна.

Хүснэгт 31. Өр төлбөр, санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээ

	2017	2018	2019	2020
Өрийн харьцаа	0.05	0.03	0.03	0.14
Санхүүгийн хөшүүрэг	1.14	1.04	1.03	1.10

Өрийн харьцаа нь нийт эх үүсвэр дотор зээлийн эх үүсвэрийн эзлэх хувь буюу нийт хөрөнгөд эзлэх зээлийн эх үүсвэрээр санхүүжигдэж байгаа хувь хэмжээг илэрхийлдэг.

Компанийн 2017-2019 онд нийт хөрөнгийн 3-5%-ийг, 2020 онд 14%-ийг өр төлбөр эзэлж байгаа ба өр төлбөрийн харьцаа харьцангуй бага байна.

2020 онд онцгой нөхцөл байдлаас шалтгаалж компанийн борлуулалт огцом буурсан тул Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтэд гадны эх үүсвэрийн санхүүжилт авсан, мөн ногдол ашиг тараах шийдвэр гарсантай холбоотой бусад урт хугацаат төлбөрийн хэмжээ нэмэгдсэн зэрэг хүчин зүйлсээс шалтгаалж компанийн өрийн харьцаа 0.14 болжээ.

Санхүүгийн хөшүүрэг буюу өр төлбөрийг эздийн өмчид харьцуулсан харьцаа нь 1.03-1.14 харьцаатай байгаа нь компанийн өр төлбөр өөрийн хөрөнгийн харьцаа тогтвортой хэвийн түвшинд хадгалагдаж байгааг илтгэж байна. Уг харьцаа нь 2 бүхлээс бага байх тохиолдолд тухайн компанийг санхүүгийн боломжит харьцаатай үйл ажиллагаагаа явуулж байна гэж үздэг бол компанийн уг харьцаа нь 2-оос бага байгаа нь компанийн санхүүгийн бүтцийг үйл ажиллагаа явуулахад тогтвортой байгааг харуулж байна.

Ашигт ажиллагаа

Эрдэнэс-Тавантолгой ХК нь бусад салбарын компаниудын үзүүлэлттэй харьцуулахад ашигт ажиллагаа, цэвэр ашгийн маржин харьцангуй өндөр байдаг. 2020 оны нөхцлөөс хамааран ашгийн маржин буурсан байгаа ба компани дараагийн жилүүдэд цэвэр ашгийн маржины үзүүлэлтийг 30-37% байхаар төлөвлөжээ.

Хүснэгт 32. Ашигт ажиллагааны шинжилгээ

	2017	2018	2019	2020
Цэвэр ашгийн маржин	39%	41%	39%	10%
ROA	3.9%	6.6%	7.7%	1.1%
ROE	4.1%	6.7%	7.9%	1.3%
ROFA	2568%	2949%	3758%	541%
EPS	0.04	0.07	0.08	0.01

Цэвэр ашгийн маржин: Компани "Чалко Трейдинг Хонконг Лимитэд" ХХК-аас 2017 онд 350 сая ам.доллар, МУХБ-аас 2013 онд 200 сая ам.доллар, 2014 онд 54 сая

2021.03.09

Handwritten signature and stamp of TAVAN TOLOIY CO., LTD.

Handwritten signature and stamp of ERDENES TAVANTOLGOI CO., LTD.

ам.долларын зээл авсан бөгөөд зээлийн хүүгийн зардал өндөр, валютын зөрүүнээс хүлээх гарз өндөр байсан тул 2013-2016 оныг хүртэл хуримтлагдсан алдагдалтай ажиллаж ирсэн байдаг. 2017-2018 онд нүүрсний зах зээлийн нөхцөл байдал сэргэж, компанийн орлого нэмэгдсэнтэй холбоотойгоор гадаад, дотоод өр төлбөрийг үе шаттайгаар бүрэн барагдуулж, 2017-2019 оны хооронд компани 39-41 хувийн ашгийн маржинтай ажилласан. 2020 онд Ковид-19 цар тахлын улмаас компанийн борлуулалтын орлого буурч, санхүүгийн хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн тул ашгийн маржин 10 хувьд хүрч буурсан ба дараагийн жилүүдэд тогтвортой өсөлттэй байхаар байна.

Нийт хөрөнгийн өгөөж, эздийн өмчийн өгөөж: Нийт хөрөнгийн өгөөж нь нэг төгрөгтэй тэнцэх хөрөнгийн бий болгож буй цэвэр ашгийн хэмжээ, нийт өөрийн хөрөнгийн өгөөж нь нэг төгрөгтэй тэнцэх хувьцаа эзэмшигчдийн өмчид хэдий хэмжээний цэвэр ашиг ноогдож байгааг харуулдаг. Компанийн нийт хөрөнгийн хэмжээ харьцангуй өндөр байгаагаас шалтгаалж дээрх үзүүлэлтүүд бага байна. Тус үзүүлэлт 2017-2019 онд тогтмол өсөлттэй байсан бол 2020 онд буурсан байна.

Үндсэн хөрөнгийн өгөөж: Энэхүү харьцаа нь татвар, хүүгийн зардлын өмнөх ашгийг үндсэн хөрөнгөд харьцуулж тооцдог. Энэхүү үзүүлэлт өндөр байгаа нь компанийн үр ашигт байдал их байгааг илэрхийлж байна.

TAVAN
ЭРӨНӨС
ТАВАН
ТӨГГӨЙ
JSC

Б. Амарбаясгалант
"БНДИС" УИХ ХУ
11-9205447 & 2052182

2021.03.26



Аудитын дүгнэлтийн хураангуй

ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ ХК
MONGOLIAN TAVANTOLGOI JSC
"MONGOLIAN TAVANTOLGOI"

Хүснэгт 33. 2019 оны аудитын дүгнэлтийн хураангуй

БҮРТГЭС-02

2019 оны Аудитын дүгнэлтийн хураангуй /Хавсралт 47/

Гүйцэтгэсэн: Үндэсний аудитын газар

Дүгнэлт

Үндэсний аудитын газар нь төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн 2019 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

"Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн 2019 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт 27, тусдаа санхүүгийн тайлангийн дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Аудитын гол асуудал

1. Хувьцааны бүртгэлтэй холбоотой асуудал

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 5.1.5, 18 дугаар заалтуудтай нийцэхгүй, "үнэн зөв байх", "үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Эргэн төлөлт хийгдэхгүй байгаа авлагатай холбоотой асуудал

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1 заалттай нийцэхгүй, "эрх ба үүрэг", "оршин байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна

Хүснэгт 34. 2018 оны аудитын дүгнэлтийн хураангуй

2018 оны Аудитын тайлангийн дүгнэлтийн хураангуй /Хавсралт 46/

Гүйцэтгэсэн: Үндэсний аудитын газар

Дүгнэлт

Үндэсний аудитын газар нь төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн 2018 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн аудит хийв.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн 2018 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргасан байна.

Аудитын гол асуудал

1. Олборлогч компанитай тооцоо нийлж чадахгүй байгаа талаар

2021.10.30



0000089

MONGOLIA TAVANTOLGOI EXCHANGE
ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ ХААЛТЫН ХӨРС

Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн Зүүн цанхийн уурхайн олборлогч "Ти Ти Жэй Ви Си Өү" ХХК-тай 2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар хоорондын тооцооны үлдэгдлээ нийлж чадаагүй байна. Олборлогч компанийн үнийн өөрчлөлтийн өсөлт бууралтын тохируулга 9.1 сая ам.доллар буюу хаалтын ханшаар 24.1 тэрбум төгрөгийг нэхэмжилж байгаа боловч Эрдэнэс-Тавантолгой ХК нь өгөх боломжгүй гэж үзэж байгаа.

Хүснэгт 35. 2017 оны аудитын дүгнэлтийн хураангуй

2017 оны Аудитын дүгнэлтийн хураангуй /Хавсралт 45/**Гүйцэтгэсэн: Үндэсний аудитын газар****Дүгнэлт**

Үндэсний аудитын газар нь төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн 2017 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн аудит хийв.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн 2017 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргасан байна.

Аудитын гол асуудал**1. Хувьцааны бүртгэлийн талаар**

"Эрдэнэс Монгол ХХК болон түүний охин компанийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2017 оны 05 сарын 30-ны өдрийн 154 дүгээр тогтоолын 8.2-ыг үндэслэн, "Эрдэнэс Монгол" ХХК-ийн ТУЗ-ийн 2018 оны 03 сарын 14-ний өдрийн удирдамж, Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн ТУЗ-ийн 2018 оны 03 сарын 01-ний өдрийн 01 дүгээр тушаалыг үндэслэн компани хувьцаагаа бүртгэсэн.

Засгийн газрын 2017 оны 05 сарын 30-ны өдрийн 154 дүгээр тогтоолын 8.2-т нэгж хувьцааг 933 төгрөгөөр үнэлж, нийт 11,196,000.0 сая төгрөгөөр бүртгэхийг заасан байна. Бид нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 933 төгрөг байна гэсэн анхны тооцоолол, түүнийг нотлох баримтыг олж авч чадаагүй.

2. Нүүрсний овоолгын бүртгэл, үлдэгдлийн талаар

Нүүрсийг олборлогч нараас авахдаа куб.метрээр тооцоолж авдаг, бүртгэлд тусгахдаа тоннд шилжүүлдэг. Худалдан авагч нарт зарахдаа тонноор хэмждэг. Сар бүрийн үлдэгдлийг маркшэйдрийн куб.метрт суурилж тооцсон хэмжилтээр авдаг. Үүнээс үүдэн нягтлан бодох бүртгэл дэх нүүрсний үлдэгдэл болон маркшэйдрийн хэмжилтээрх үлдэгдлийн хооронд зөрүү үүсдэг байна. Нүүрсний овоолго дуусах бүрд дээрх зөрүүг тогтоон акт үйлдэж, үүссэн зөрүүг дараагийн сарын уулын ажлын тайландаа оруулдаг байна. Энэ нь тухайн овоолго хаагдсан сарын хөрс хуулалтын хэмжээ болон үнийн дүнг бууруулж бодит тоон мэдээлэлд нөлөө орж байна. 2017 онд нийт 35 сард



20210303



нээгдээд хаагдсан зөрүү нь 239.4 мянган тонн. 2017 онд нээгдээд 2018 оны 03 сарын 01-ний байдлаар хаагдсан овоолго 7, зөрүү нь 90.8 мянган тонн, 2017 онд нээгдээд 2018 оны 03 сарын 01-ний байдлаар хаагдаагүй байгаа овоолго 14, зөрүү нь ойролцоогоор 139.6 мянган тонн байна.

3. Нөхөн сэргээлтийн нөөц

НББОУС 37 болон тус компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогод уурхайн нөхөн сэргээлтийн нөөцийг тооцоолохдоо ирээдүйд гарч болзошгүй зардлыг өнөөгийн үнэ цэнээр илэрхийлж бүртгэхээр заасан боловч борлуулалтын орлогоос 1 хувиар тооцож 2016 онд 4,671.2 сая, 2017 онд 11,823.6 сая төгрөгийн нөөцийг бүртгэсэн байна.

4. Нөхөн сэргээлтийн хөрөнгө

Нөхөн сэргээлтийн хөрөнгийн тайлант оны эхний үлдэгдэл 17,169.1 сая төгрөг нэмж 11,823.6 сая төгрөг бүртгэсэн бөгөөд 980.6 сая төгрөгөөр хорогдуулалт тооцсон байна. Компани нөхөн сэргээлтийн хөрөнгийг хорогдуулахдаа лицензийн хугацаа буюу 40 жил болон 20 жилийн хугацаагаар хорогдуулж байна. НББ-д тусгасны дагуу шавхагдлаар тус хорогдуулалт байгуулахаар тусгасан байна. Иймд хорогдуулж буй үнийн дүнгийн хорогдуулалтын суурь болон хорогдол тооцох дүн нь алдаатай байна.

5. Үндсэн хөрөнгө

"Цагаан хад дахь гаалийн талбай" байршилд бүртгэлтэй 5,328.9 сая төгрөгийн өртөгтэй үндсэн хөрөнгө нь компанид үр өгөөж өгөхгүй байна. Компани нь уурхайн амнаас нүүрс борлуулж эхэлснээр хөрөнгүүдийг ашиглахаа больсон. Компанийн удирдлага эдгээр хөрөнгүүдийг цаашид ашиглах эсэх, худалдан борлуулах эсэх талаар ямар нэгэн шийдвэр гаргаагүй байна.

2021.03.02




ТУРАВ ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ

3.1. Дэлхийн нүүрсний зах зээлийн төлөн байдал


3.1.1. Коксжих нүүрсний хэрэглээ, эрэлт, нийлүүлэлт

Дэлхийн коксжих нүүрсний хэрэглээ 2019 онд 1 тэрбум тонн байсан бол 2020 онд 3 орчим хувиар буурч 970 сая тонн болох төлөвтэй байна. БНХАУ-ын нүүрсний салбарын томоохон судалгааны байгууллага болох "Фенвэй Энержи"-ийн үзэж байгаагаар дэлхийн коксжих нүүрсний эрэлт жилд ойролцоогоор 2 орчим хувиар өсч 2025 онд дээд цэгтээ буюу 1,065.2 сая тоннд хүрэх бол урт хугацаанд аажмаар буурч 1,000 сая тонны түвшинд хадгалагдана гэж тооцоолжээ.

Зураг 6. 2015-2050 оны коксжих нүүрсний эрэлт (сая тонн)



Зураг 7. 2015-2050 оны коксжих нүүрсний эрэлт, улсаар (хувь)



Эх сурвалж: Фенвэй Энержи

Дээрх тооцооллоор БНЭУ-ын коксжих нүүрсний эрэлт нэмэгдэх, харин БНХАУ, БНСУ, Япон зэрэг улсуудынх буурах төлөвтэй байна.

Коронавирусээс шалтгаалж 2020 онд дэлхийн коксжих нүүрсний эрэлт бага зэрэг буурах бол 2021 оноос "Цар тахлын дараа дэлхийн улсуудын үйлдвэрлэл эрчимжинэ" гэсэн хүлээлттэй холбоотойгоор өсөх хандлагатай байна.

Хүснэгт 36. Дэлхийн коксжих нүүрсний эрэлт, нийлүүлэлт, балансын таамаглал (сая тонн)

	2019	2020E	2021E	2022E	2023E	2024E	2025E
Нийлүүлэлт	1,024.6	1,024.1	1,061.1	1,066.7	1,065.6	1,071.5	1,076.5
Эрэлт	999.8	970.1	1,024.8	1,047.9	1,057.2	1,059	1,065.2
Баланс	24.8	54	36.2	18.8	8.4	12.5	11.3

Эх сурвалж: Фенвэй Энержи

Дээрх таамаглалаар коксжих нүүрсний эрэлт нийлүүлэлтийн баланс/тэнцэл 2020 онд ихээхэн зөрүүтэй байх бол 2021 оноос зөрүү нь багасах төлөвтэй байна. Өөрөөр хэлбэл коксжих нүүрсний эрэлт нийлүүлэлтийн хэмжээ ойртох хүлээлттэй.

Stamp: ТАНХАА ТАСАА ТАСАА
 ЭРДС-СЭС ТАВАНТӨГӨЙ
 ХК
 115093447 д. 2012482
 15C


Stamp: МХБ-ийн гүйцэтгэл
 Андерригтэй
 Брокер, дэлгэрэнгүй
 "БНДЭС" ТИВ ХК
 115093447 д. 2012482

2021.03.26


Эрчим хүчний нүүрсний хэрэглээ, эрэлт, нийлүүлэлт

Дэлхийн эрчим хүчний нүүрсний хэрэглээ 2019 онд 7.11 тэрбум тонн байсан бол 2020 онд 2.3 хувиар буурч 6.94 тэрбум тонн болохоор байна. БНХАУ-ын нүүрсний салбарын томоохон судалгааны байгууллага болох "Фенвэй Энержи"-ийн үзэж байгаагаар дэлхийн эрчим хүчний нүүрсний эрэлт жил бүр ойролцоогоор 0.2 хувиар өсөж, 2050 он гэхэд 7,700 сая тоннд хүрнэ гэж тооцоолжээ.

Зураг 8. 2015-2050 оны эрчим хүчний нүүрсний эрэлт (сая тонн)



Зураг 9. 2015-2050 оны эрчим хүчний нүүрсний эрэлт, улсаар (хувь)



Эх сурвалж: Фенвэй Энержи

Дээрх таамаглалаар БНЭУ-ын эрчим хүчний нүүрсний эрэлт нэмэгдэхээр байгааг, харин БНХАУ, БНСУ, Япон зэрэг улсуудынх буурахаар байна. Коронавирусээс шалтгаалж 2020 онд дэлхийн эрчим хүчний нүүрсний эрэлт бага зэрэг буурах бол 2021 оноос "Цар тахлын дараа дэлхийн улсуудын үйлдвэрлэл эрчимжинэ" гэсэн хүлээлттэй холбоотойгоор өсөх хандлагатай байна.

Хүснэгт 37. Дэлхийн эрчим хүчний нүүрсний эрэлт, нийлүүлэлт, балансын таамаглал (сая тонн)

	2019	2020E	2021E	2022E	2023E	2024E	2025E
Нийлүүлэлт	7,175.2	7,072.3	7,228.3	7,237.2	7,274.1	7,313.5	7,356.2
Эрэлт	7,109.5	6,942.1	7,171.4	7,214.3	7,263.3	7,300.6	7,341.7
Баланс	65.7	130.2	56.8	22.9	10.8	12.9	14.5

Эх сурвалж: Фенвэй Энержи

Эрчим хүчний нүүрсний эрэлт нийлүүлэлтийн баланс/тэнцэл 2019-2021 онд ихээхэн зөрүүтэй байх бол 2022 оноос зөрүү нь багасахаар байгааг дурдах нь зүйтэй. Өөрөөр хэлбэл эрчим хүчний нүүрсний эрэлт, нийлүүлэлтийн хэмжээ ойролцоо түвшинд байх хүлээлттэй.

3.1.3. Зорилтот зах зээл

БНХАУ-ын нүүрсний үйлдвэрлэл

БНХАУ-ын түүхий нүүрсний үйлдвэрлэл нь 2016 онд нийлүүлэлтээ нэмэгдүүлснээс хойш 3 жил тасралтгүй өсч, 2019 онд 3,850 сая тоннд хүрсэн байна. 2015-2019 оны жилийн дундаж өсөлт нь 0.6%-тай байсан.



2021.03.03


0000093

ЭРДЭНЭС
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE

2021-03-19

БҮРТГЭЭ-02

Зураг 10. БНХАУ-ын түүхий нүүрсний нийт олборлолт (сая тонн, %)



Эх сурвалж: Фенези Энержи

БНХАУ-ын нүүрсний салбарт явуулж буй бодлогын хүрээнд шинэ уурхайнууд ашиглалтад орсноор дотоодын нүүрсний хүчин чадал 2025 оныг хүртэл нэмэгдэх хүлээлттэй. Дотоодын эрчим хүчний хэрэгцээ нэмэгдэж байгаатай холбоотойгоор эрчим хүчний нүүрсний хэрэглээ нь өсөлтийн зарим хэсгийг бүрдүүлэхээр байна. БНХАУ-ын нүүрсний олборлолт 2025 онд 4,042 сая тонн болж, 2019 онтой харьцуулахад 5% хүртэл өсөх төлөвтэй байна.

БНХАУ-ын коксжих нүүрсний эрэлт, нийлүүлэлт

Коксжих нүүрсний нийлүүлэлт 2015-2019 онд 493 сая тонноос 480 сая тонн болж 2015 онтой харьцуулахад 2.5 хувиар, жилд дунджаар 0.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Хүчин чадлыг багасгах, үйлдвэрлэлийг бууруулах бодлогын үр дүнд коксжих нүүрсний нийлүүлэлт 2016 онд огцом буурч, 2017 оноос хойш аажмаар сэргэж байсан боловч 2015 оны түвшинд буцаж хүрээгүй байна.

Цаашдын төлөвийн хувьд БНХАУ-ын гангийн үйлдвэрлэл нэмэгдэж байгаатай холбоотойгоор коксжих нүүрсний нийлүүлэлт 2020 онд 478 сая тонноос 2025 онд 487 сая тонн болж өсөх боловч 2025 оноос хойш аажим буурсаар 2050 он гэхэд 431 сая тонн хүртэл, жилд 0.5 хувиар буурах хандлагатай байна.

20210304



Зураг 11. Коксжих нүүрсний нийлүүлэлт (сая тонн)



Зураг 12. Коксжих нүүрсний эрэлт (сая тонн)



Эх сурвалж: Эн Би Си, Фенвэй Энержи

Коксжих нүүрсний эрэлт 2015-2019 онд 534 сая тонноос 553 сая тонн болж 3.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Цаашдын төлөвийн хувьд эрэлт 2020 онд 559 сая тонн хүртэл бага зэрэг өсөх боловч, дараа нь аажим аажмаар суларч 2025 он гэхэд 544 сая тонн болж 2019 онтой харьцуулахад 1.6 хувиар, жилд дунджаар 0.3 хувиар буурах төлөвтэй байна.

БНХАУ-ын эрчим хүчний нүүрсний эрэлт, нийлүүлэлт

БНХАУ-ын эрчим хүчний нүүрсний нийлүүлэлт 2015 онд 3,066 сая тонноос 2019 онд 3,138 сая тонн болж, жилийн дундаж өсөлт ердөө 0.5% байв. БНХАУ-ын нүүрсний аж үйлдвэр 2016 оноос нийлүүлэлтийн талын шинэчлэлийг хийж эхэлснээр хүчин чадал бууруулах, үр ашигтай үйлдвэрлэлийг бодлогоор барих болсон тул эрчим хүчний нүүрсний нийлүүлэлт 2016 онд 7.9 хувиар огцом буурчээ.

Хэдийгээр үйлдвэрлэл бодлогоор буурсны дараа 2017 онд нүүрсний гаралт сэргэж эхэлсэн ч хурд удаан байсан нь хүчин чадлыг бууруулах ажиллагаа, үйлдвэрлэлийн хатуу хяналт үргэлжилж байсантай холбоотой. Хүчин чадлыг бууруулах даалгаврууд дуусч, хүчин чадлыг солих ажил үргэлжлэх тусам эрчим хүчний нүүрсний үр ашигтай хүчин чадал 2019-2030 онд 3,138 сая тонноос 3,294 сая тонн хүртэл, жилд дунджаар 0.8 хувиар нэмэгдэх төлөвтэй байна. 2025 оны дараа БНХАУ-ын эрчим хүчний бүтэц өөрчлөгдөхөд эрчим хүчний нүүрсний хэрэгцээ аажмаар буурах төлөвтэй байна.

Зураг 13. Эрчим хүчний нүүрсний нийлүүлэлт (сая тонн)



Зураг 14. Эрчим хүчний нүүрсний эрэлт (сая тонн)



Эх сурвалж: Эн Би Си, Фенвэй Энержи

БНХАУ-ын эрчим хүчний нүүрсний эрэлт 2015-2019 онд 3,199 сая тонноос 3,347 сая тонн болж жилд дунджаар 0.9 хувиар өссөн байна. 2016 он гарсны дараа мөнгөний болон төсвийн уян хатан бодлого нь эрчим хүчний нүүрсний эрэлтийг нэмэгдүүлсэн. Үйлдвэрлэл эрчимжиж, улмаар эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлснээр БНХАУ-ын

[Handwritten signature]

БНХАУ-ын
YIBK
117295447 & 2057140

2021.10.30

эрчим хүчний нүүрсний эрэлт 2019-2025 онд 3,347 сая тонноос 3,475 сая тонн хүртэл, жилд 0.6 хувиар өсөх төлөвтэй байна.


БҮРТГЭВ-02

БНХАУ эрчим хүчний анхдагч хэрэглээний бүтэц дэх нүүрсний эзлэх хувийг хянаж байгаа бөгөөд уг хувийг 2020 он гэхэд 58% хүртэл бууруулахыг оролдож байна. Ингэснээр шинэ эрчим хүчний эх үүсвэрийн үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдэж, нүүрсний дулааны хэрэгцээ буурч, эрчим хүчний нүүрсний эрэлт 2050 он гэхэд 3,205 сая тонн болж, 2025 онтой харьцуулахад 7.8 хувиар буурах төлөвтэй байна.

БНХАУ-ын нүүрсний импортын эрэлт, экспорт

Дотоодын нүүрсний үйлдвэрлэлийн хэмжээ нь нэмэгдэж байгаатай холбоотойгоор тус улсын импортыг хязгаарлах бодлого ирээдүйд чангарч магадгүй юм. Импортын аж ахуйн нэгжүүдээс харахад импортын хязгаарлалт нь эцсийн хэрэглэгч биш худалдаачид руу чиглэх хандлагатай.

Зураг 15. БНХАУ-ын нүүрсний импорт ба экспорт (сая тонн)



Эх сурвалж: Эн Би Си, Фенвэй Энержи

БНХАУ-ын импортын нүүрсийг хязгаарлах бодлого удаан хугацаанд хадгалагдах төлөвтэй байна. Нүүрсний импортын хяналт, зохицуулалтын хугацаа, хэмнэл 2017-2019 онд тийм ч хангалтгүй байсан тул жилийн эхэнд хязгаарлалт сул байсан боловч дараа нь чангарсан байдаг. Гаалийн байгууллагууд төрөл бүрийн гааль, боомтуудад дөрөвдүгээр улиралд дуусах үед импортын квот тогтоох, хязгаарлалтын бодлогыг гэнэт нэмэгдүүлэх байдлаар нүүрсний зах зээлийг тасалдуулах болсон.

БНХАУ-ын коксжих нүүрсний импортын эрэлт, экспорт

БНХАУ-ын коксжих нүүрсний импорт 2015 онд 48 сая тонн байснаас 2019 онд 74 сая тонн болж огцом өссөн. Гэсэн хэдий ч сүүлийн жилүүдэд тус улсын нүүрсний салбарт явуулж буй бодлогын хүрээнд шинэ уурхайнууд ашиглалтад орсноор нүүрсний нийлүүлэлт нэмэгдсэн байна. Үүний зэрэгцээ БНХАУ импортын нүүрсний хязгаарлалттай холбоотой өмнөх хязгаарлалтуудаа (квот) сулруулахгүй байх тул коксжих нүүрсний импорт хязгаарлагдсан хэвээр байх төлөвтэй. Гэсэн хэдий ч БНХАУ-ын үнс болон хүхрийн агууламж багатай коксжих нүүрсний нөөц багасаж байгаа тул импортын коксжих нүүрсний эрэлт удаан хугацаанд хадгалагдах болно.



2021.10.30

БНХАУ-ын коксжих нүүрсний импорт 2025 он гэхэд 71 сая тонн болж, жилд дунджаар 0.7 хувиар буурах төлөвтэй байна. Коксжих нүүрсний экспортын хувьд 2025 оноос өмнө жилд 1-2 сая тонн байх бол цаашид аажим аажмаар өсөж 2050 он гэхэд 5 сая тонн хүрэх боломжтой.

Зураг 16. БНХАУ-ын коксжих нүүрсний импорт ба экспорт (сая тонн)



Эх сурвалж: Жи Эй Си, Фенезй Энержи

БНХАУ-ын эрчим хүчний нүүрсний импортын эрэлт, экспорт

БНХАУ-ын импортыг хязгаарлах бодлого 2015 оноос хойш аажмаар чангарсан ч дотоодын хүчтэй эрэлтээс үүдэн импортын эрчим хүчний нүүрсний хэмжээ 2016 онд 156 сая тонн байснаас 2019 онд 225 сая тонн болж 2016 онтой харьцуулахад 44 хувиар, жилд дунджаар 11 хувиар өссөн байна. Цаашдын төлөвийн хувьд тус улсын эрчим хүчний нүүрсний дотоодын нийлүүлэлт хурдацтай нэмэгдэж байгаа тул импортын нүүрсний бодлого 2019 оноос хойш улам чангарч, улмаар эрчим хүчний нүүрсний импорт буурч, 2019-2025 онд жилд дунджаар 2.8 хувиар буурснаар 2025 он гэхэд 187 сая тонн болох төлөвтэй байна.

Эрчим хүчний нүүрсний экспортын хувьд 2020-2025 онд бага түвшинд хадгалагдах төлөвтэй байгаа бол 2025 оноос хойш бага зэрэг өсөх төлөвтэй байна. Энэ нь нэг талаас, БНХАУ-ын эрчим хүчний нүүрс Австрали, Индонезийн эрчим хүчний нүүрсстэй харьцуулахад өрсөлдөх чадвар муутай, нөгөө талаас, БНХАУ-ын дотоодын эрчим хүчний нүүрсний эрэлттэй холбон тайлбарлагдана.


БНХАУ-ын эрчим хүчний нүүрсний экспортын хэмжээ 2025 он хүртэл жилд 5 сая тонн орчим байх бол 2050 онд 17 сая тонн болж өсөх төлөвтэй байна.

2021.03.03

TAVAN
ЭНЭГЭС
TAVAN
JSC

МАН-ын Ерөнхий
Диррэнг
Говьсүмбэр
"БНХАУ-ын
ТЭХХ"
11021447

Зураг 17. БНХАУ-ын эрчим хүчний нүүрсний импорт ба экспорт (сая тонн)



Эх сурвалж: Жи Эй Си, Фенезэй Энержи


3.1.4. Гуравдагч зах зээлийн шинжилгээ

Нүүрсний олон улсын худалдаа 2019 онд 1,483 сая тонн байснаас 40 гаруй хувийг нь Энэтхэг, Япон, БНСУ зэрэг улсуудын импорт бүрдүүлсэн байна. Эдгээр улсуудын нүүрсний эрэлт, нийлүүлэлт, цаашдын төлөв байдлын талаар мэдээллийг доор тусгалаа.

1. Япон Улс

Япон улсын дотоодын нүүрсний үйлдвэрлэл хязгаарлагдмал, ойролцоогоор 1 сая тонн орчим, гол төлөв эрчим хүчний нүүрс байдаг. Өөрөөр хэлбэл тус улсын дотоодын нүүрсний хэрэглээ бараг бүхэлдээ импортын хамааралтай байдаг байна. Япон улсын нүүрсний импорт 2020 онд 186.2 сая тонн байсан нь 2015 оныхоос 2.4 хувиар буурсан үзүүлэлт юм.

Зураг 18. Япон Улсын 2015 болон 2019 он нүүрсний импорт (сая тонн)



Эх сурвалж: Фенезэй Энержи


Нүүрсний төрлөөр авч үзвэл коксжих нүүрсний импорт 41.6 сая тонн, эрчим хүчний нүүрсний импорт 144.6 сая тонн байсан. Импортын бүтцийн хувьд Австрали улсаас 109.3 сая тонн нүүрс импортолсон нь 58.7 хувийг бүрдүүлсэн байна.

Эрдэнэс ТЭВЭН ТӨСӨН ХХК
JSC

МХБ-ийн гишүүн
Диррайдс
Омьс, дугаарын
БНХАУ-ын
ҮИХ ХН
111522447 @ 2021

2021.03.05

Зураг 19. Япон улсын коксжих болон эрчим хүчний нүүрсний импорт



Эх сурвалж: Фенвэй Энержи

Технологийн тасралтгүй дэвшлийн хүчинд өртөг буурах тусам сэргээгдэх эрчим хүчний тэлэлт хурдасч байна. Фукушимиагийн цөмийн ослоос болж өртөг нэмэгдэхтэй холбоотойгоор атомын цахилгаан станцын ажил удааширсан, нүүрсээр ажилладаг эрчим хүчний үйлдвэрлэлийн өсөх орон зай нь хэт дулаан ялгаралтаас болж хязгаарлагддаг.

Дээрх дүгнэлтэд үндэслэн Япон улс "Бага нүүрстөрөгч"-өөс "Декарбонизаци" руу шилжих зорилгоо биелүүлэхийн тулд эрчим хүчний хангамж, эрэлтийн олон талт тогтолцоог бий болгохоор төлөвлөж байна. Урьдчилсан байдлаар Япон улсын нүүрсний импорт буурах хандлагыг харуулж, жилд 2 орчим хувиар буурч 2050 он гэхэд 100 сая тонн болох төлөвтэй байна.

Зураг 20. Япон улсын нүүрсний импортын таамаглал (сая тонн)



Эх сурвалж: Фенвэй Энержи

2. Бүгд Найрамдах Солонгос Улс

БНСУ-ын хувьд мөн ялгаагүй нүүрсний олборлолт хязгаарлагдмал, ойролцоогоор 1 сая тонн орчим хэмжээтэй, ихэвчлэн эрчим хүчний нүүрс байдаг. Өөрөөр хэлбэл Япон улстай ижилхэн дотоодын нүүрсний хэрэглээ нь бараг бүхэлдээ импортын хамааралтай байдаг байна.

ЭРХЭНЭЗ
ТАВАН ТӨЛӨН
УЛААНБААТАР
ТӨСВИЙН 143328
УЛААНБААТАР
JSC

ЭХЭ-ийн тусуу
Анхрынгуу
Бүтээгч
"БНХАУ"
ҮЙС ХН
ТТ1005447 & 1052462
ТТ1005447 & 1052462

ЭХЭ-ийн тусуу
2021.03.04

2020 онд БНСУ-ын нүүрсний импортын хэмжээ 141.4 сая тонн байсан нь 2015 оньхоос дунджаар 6 орчим хувиар буурсан үзүүлэлт юм.

Зураг 21. БНСУ-ын нүүрсний импортын бүтэц (сая тонн)



Эх сурвалж: Фенезэй Энержи

Нүүрсний төрлөөр авч үзвэл коксжих нүүрсний импорт 22.6 сая тонн, эрчим хүчний нүүрсний импорт 118.8 сая тонн байсан. Импортын бүтцийн хувьд Австрали улсаас 51.8 сая тонн нүүрс импортолсон нь 36.6 хувийг бүрдүүлсэн байна.

Зураг 22. БНСУ-ын коксжих болон эрчим хүчний импорт (сая тонн)



Эх сурвалж: Фенезэй Энержи

БНСУ нь 2019 онд "Эрчим хүчний гуравдугаар үндсэн төлөвлөгөө (2019-2040)"-г гаргаснаар 2040 он гэхэд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг одоогийн 7-8 хувиас 30-35 хувь болгон нэмэгдүүлэх санал дэвшүүлжээ. Нүүрсээр ажилладаг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх байдлыг аль болох хурдан бууруулах, цөмийн эрчим хүчний эзлэх хувийг аажим аажмаар бууруулах зорилт тавьсан байна. Ингэснээр БНСУ-ын нүүрсний импорт жилд 1.3 орчим хувиар буурч 2050 он гэхэд 85.6 сая тонн болох төлөвтэй байна.

Handwritten signature and red stamp of the Mongolian Stock Exchange (JSC).

Handwritten signature and red stamp of the Mongolian Stock Exchange (JSC).

2021.03.19

Зураг 23. БНЭУ-ын нүүрсний импортын таамаглал (сая тонн)




Эх сурвалж: Фенвэй Энержи

3. Бүгд Найрамдах Энэтхэг Улс

БНЭУ эрчим хүчний нүүрсний нөөц сайтай боловч коксжих нүүрсний хомсдолтой байдаг. Мөн эрчим хүчний нүүрс нь үнслэг өндөртэй, илчлэг багатай зэрэг сул талуудтай. Коксжих нүүрс маш хомс бөгөөд импортоос шууд хамаардаг байна. БНЭУ-ын нүүрсний эрэлт 2020 онд 979.8 сая тонн байснаас, 869.9 сая тонн буюу 88.8 хувийг нь эрчим хүчний нүүрс, 109.9 сая тонн буюу 11.2 хувийг нь коксжих нүүрс бүрдүүлсэн байна.

Зураг 24. БНЭУ-ын нүүрсний эрэлт, төрлөөр (сая тонн)



Эх сурвалж: Фенвэй Энержи

БНЭУ-ын нүүрсний импортын хэмжээ 2020 онд 249.3 сая тонн байсан нь 2015 оныхоос 9.7 хувиар өссөн үзүүлэлт юм. Нүүрсний төрлөөр ангилбал коксжих нүүрсний импорт 51.3 сая тонн, эрчим хүчний нүүрсний импорт 198.0 сая тонн байсан.

Stamp: ТАВАН
ЭРДИЙНЭС
ТАВАН
ТӨЛГӨӨ
ХХК
Handwritten signature: [Signature]

Stamp: ТЭХБ-ийн Голдуу
Андеррайт
Фонд, Энэтхэг
"БНЭУ-ын
ТЭХБ"
Handwritten signature: [Signature]

20210305


Зураг 25. БНЭУ-ын нүүрсний импорт, гэрлээр (сая тонн)



Эх сурвалж: Фенвэй Энержи

Цаашид тус улсын эрчим хүчний нүүрсний хэрэглээ жилд 8 орчим хувиар нэмэгдэж 2050 он гэхэд 2,240 сая тоннд, коксжих нүүрсний хэрэглээ жилд 5 орчим хувиар нэмэгдэж 300 сая тоннд хүрэх төлөвтэй байна.

Зураг 26. Дэлхийн улсуудын нүүрсний хэрэглээ (сая тонн)



Эх сурвалж: Фенвэй Энержи

3.2. Монгол улсын нүүрсний зах зээлийн төлөв байдал

Монгол Улс нь нүүрсний нөөц баялагтай, үүнээс өндөр чанар бүхий дээд зэргийн коксжих нүүрсний арвин нөөцтэй улсуудын нэг юм. Манай улсын дэлхийн коксжих нүүрсний зах зээлд эзлэх байр суурь өндөр байдаг бөгөөд дэлхийн коксжих нүүрсний үйлдвэрлэл дэх эзлэх хувь 2015 онд 1.3% байснаас 2019 онд 4.4% хүрч 3.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

БНХАУ дэлхийн хамгийн том нүүрс хэрэглэгч юм. БНХАУ руу нүүрс экспортлох нь газарзүйн байршлын хувьд давуу талтай, үйл ажиллагааны зардал багатай. Мөн манай улсын нүүрсний дотоодын хэрэглээ бага байдаг ба нүүрсийг гол төлөв БНХАУ руу экспортолж байгаа нь БНХАУ-ын зах зээлд хүчтэй өрсөлдөх чадвартай болохыг харуулж байна.

Цаашид Монгол улсын нүүрс БНХАУ, ОХУ дахь далайн гарцыг ашиглан Япон улс, БНСУ, Тайвань, БНЭУ-ын зах зээлд нэвтрэх боломжтой.

(Handwritten signature and red stamp)

(Handwritten signature and red stamp)

2021.10.30


БНХАУ-ын зах зээл дэх эрэлт буурсантай холбоотойгоор Монголын нүүрсний үйлдвэрлэл 2014-2015 онд богино хугацаанд уналтад орсон. 2016 он гарснаас хойш БНХАУ нүүрсний салбартаа шинэчлэл хийж дотоодын олборлолтоо бууруулснаар эрэлт нийлүүлэлтийн тэнцвэр хангагдаж, манай улсын нүүрсний үйлдвэрлэлийн салбарт эерэг нөлөө үзүүлсэн байдаг.

Үндэсний статистикийн газрын статистик мэдээ, Фенвэй Энержи компанийн мэдээллээр Монгол Улсын түүхий нүүрсний үйлдвэрлэл 2020 онд 43 сая тонн болсон нь 2015 онтой харьцуулахад 22 хувиар өссөн үзүүлэлт юм. Коксжих нүүрсний үйлдвэрлэл 2020 онд 32 сая тонн буюу 2015 онтой харьцуулахад 34 хувиар, дулааны нүүрсний олборлолт 11 сая тонн буюу 2015 онтой харьцуулахад 7 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байв.

Зураг 26. Монголын нүүрсний олборлолт (сая тонн)



Зураг 27. Монголын нүүрсний олборлолт (сая тонн), олборлолтын өсөлтийн хувь



Эх сурвалж: Үндэсний статистикийн газар, Фенвэй Энержи

Цаашид Тавантолгойн бүлэг ордын олборлолт нэмэгдэхийн хэрээр Монгол Улсын нүүрсний олборлолт нэмэгдэх болно. Гэсэн хэдий ч манай улсын хамгийн том хэрэглэгч бол БНХАУ бөгөөд тус улсын нүүрсний хэрэглээ, ялангуяа коксжих нүүрсний хэрэглээ аажмаар дээд хэмжээндээ хүрч байна.

Монгол Улсын коксжих нүүрсний олборлолт 2025 он гэхэд 67 сая тонн болж, 2019 онтой харьцуулахад 2 дахин өсөх төлөвтэй байна. Эрчим хүчний нүүрсний олборлолт 2025 он гэхэд 13 сая тонн болж, 2019 онтой харьцуулахад 18 хувиар өсөх төлөвтэй байна.

ТАВАН
ЭРДЭНЭС
ТАВАН
ТӨГӨӨ
JSC

Б-ийн Ажилчин
Аутсорсийн
Төвөг
"БНХАУ"
ХЭРЭГ

Зураг 29. Монгол Улсын нүүрсний олборлолт (сая тонн)



Эх сурвалж: Үндэсний статистикийн газар, Феневэй Энержи

3.2.2. Монгол Улсын нүүрсний тээврийн дэд бүтэц

БНХАУ, Монгол хоёр улсын хооронд 14 нисэх онгоцгүй хилийн боомт бий. Тэдгээрийн дотроос Эрээн хот хос ашиглалтын зам /авто зам, төмөр зам/-аар холбогдсон бол үлдсэн хэсэг нь авто замын боомт юм. Өнөөгийн байдлаар БНХАУ руу нүүрсний урсгалын 90 орчим хувь нь Гашуунсухайт-Ганцмод, Шивээ Хүрэн-Секе боомтоор гарч байна.

1. Гашуунсухайт - Ганцмод:

БНХАУ-ын Ганцмод хилээс 10 км зайд орших Гашуунсухайт нь өнөөгийн байдлаар манай улсын нүүрсний экспортын хамгийн том боомт бөгөөд 30 сая тонн нүүрс экспортлох хүчин чадалтай. "Тавантолгой" ХК, "Эрдэнэс-Тавантолгой" ХК, "Энержи Ресурс" ХХК-иуд тус хилээр БНХАУ руу нүүрс экспортолдог. Одоогийн байдлаар авто тээврээр уурхайгаас хил хүртэл нүүрс тээвэрлэдэг. Ганцмод нь БНХАУ-ын Шинхуа Группийн эзэмшдэг Ганкуан төмөр замтай холбогддог бөгөөд уг зам 2022 оны 3 дугаар улиралд ашиглалтад орох төлөвтэй байгаа. Ингэснээр авто замаар жилд 20 сая тонн, төмөр замаар 30 сая тонн нүүрс тээвэрлэх боломж бүрдэнэ. Ганцмод нь "Тав орж тав гарах" толлингийг (Гарц) 2013 онд албан ёсоор ашиглалтад оруулсан бөгөөд 30 сая тонны хүчин чадалтай. Цаашид хилийн нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх шаардлагатай.

2. Шивээ Хүрэн – СЭКЕ:

Манай Улсын Шивээ Хүрэн хилийн боомт нь БНХАУ-ын Секе хилээс 1 км зайд оршдог бөгөөд Гашуунсухайтын дараа орох экспортын хоёр дахь том хилийн боомт юм. Овоот Толгой, Нарийн Сухайт ба Сүмбэрийн уурхай бүгд Шивээ Хүрэн хилээс 40-70 км-ийн зайд байрладаг бөгөөд эдгээр уурхайнуудаас БНХАУ руу нүүрс экспортолдог. Секе боомт нь одоогоор 20 сая тонн хүчин чадал бүхий "Дөрөв орох дөрөв гарах" толлингийг (Гарц) ашиглаж байна.

Овоот толгойн уурхайгаас Шивээ хүрэн - Секе хүртэлх асфальтан замыг 2013 онд "Эс Жи Ар" ХХК барьж, 2015 оны 5 дугаар сарын 08-ны өдөр ашиглалтад оруулсан. Жилд 20 сая тонн нүүрс тээвэрлэх хүчин чадалтай.

3. Хэнги - Мандал

(Handwritten signature and red stamp)

(Handwritten signature and red stamp)

2021.02.10.30.4

Ханги хилийн боомт нь БНХАУ-ын Мандал хилээс 25 км зайтай оршдог. Мандал хилийн боомтыг БНХАУ-ын Төрийн Зөвлөл 2015 оны 5 дугаар сарын 13-ны өдөр байнгын нээлттэй хил болгон баталсан байдаг. Ачааны бүрдүүлэлтийн хүчин чадал нь жилд 5 сая тонн, 2021 он гэхэд 15 сая тонн хүрэх төлөвтэй.

4. Замын-Үүд – Эрээн:

Эрээн хотын гаалийн бүрдүүлэлтийн хүчин чадал нь төмөр замын хувьд 10 сая тонн, авто замын хувьд 2.4 сая тонн байдаг.

5. Булган – Тайкешкен:

Булган нь Шинжан дахь БНХАУ-ын Тайкешкен хилийн боомтоос ердөө 25 км-ийн зайд байрладаг бөгөөд дэд бүтцийн нөхцөл байдал сайн хөгжсөн. БНХАУ-ын Шинжан аймаг болон манай улсын хооронд нүүрсний тээвэрлэлт 2011 онд эхэлсэн байдаг бөгөөд хил дээр нүүрсний тусгай гарцуудтай. "Мо Эн Ко" ХХК Хөшөөтийн уурхайгаас Булган хүртэл асфальтан замыг барьсан байдаг ба жилд 5 сая тонн нүүрс тээвэрлэх хүчин чадалтай.

6. Бусад

Монгол Улсын төмөр замын чиглэлээр баримтлах төрийн бодлогын хүрээнд Тавантолгой- Зүүнбаян чиглэлийн 414 км урттай төмөр зам баригдаж байгааг дурдах нь зүйтэй. Тус зам нь 2021 онд ашиглалтад орох төлөвтэй байна.

3.3. Зах зээлийн үнийн судалгаа, ирээдүйн төсөөлөл

3.3.1. Нүүрсний үнэд нөлөөлөгч хүчин зүйлс

Нүүрсний үнэд нөлөөлөгч хүчин зүйлсийг гадаад ба дотоод гэж 2 ангилдаг. Гадаад хүчин зүйлсэд тухайн компаниас/субъектээс үл хамаарах хүчин зүйлс багтдаг бол дотоод хүчин зүйлсэд тухайн компаниас/ субъектээс хамаарах хүчин зүйлс багтдаг байна. Үүнд:

Гадаад хүчин зүйлс:

- **Дэлхийн зах зээл дэх нүүрсний эрэлт, нийлүүлэлтийн функц:** Дэлхийн нүүрсний зах зээлд нүүрсний экспортын хэмжээгээр Австрали, Индонез, Өмнөд Африк зэрэг улсууд голлодог бол гол хэрэглэгч улсуудад БНХАУ, Япон, БНСУ болон Европын холбооны улсууд багтдаг билээ. Нүүрсний зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн функц өөрчлөгдөхөд дэлхийд худалдаалах нүүрсний тоо хэмжээнд нөлөөлдөг.
- **Нүүрсний чанар:** Нүүрсний чанарын үзүүлэлт нь тухайн нүүрсний үнэлгээнд нөлөөлдөг.
- **Далайн тээвэр:** Далайн эргээс хол орших улсууд голцуу төмөр зам болон авто замаар нүүрс тээвэрлэдэг бол дэлхийд дийлэнх тээврийг далайгаар хийж байна. Далайн тээврийн өртөг нь мөн нүүрсний үнэд нөлөөлдөг.
- **Инфляц:** Нүүрсний үнийн түүхэн мэдээлэл болон инфляц 2 шууд хамааралтай байдаг тул үнийн таамаглал боловсруулахдаа инфляцыг давхар тооцдог.
- **Улс төрийн хүчин зүйлс:** Нүүрсний худалдаа ихэнх улсуудад улс төрийн нөхцөл байдал, геополитик, эдийн засгийн өсөлт, эрчим хүчний бодлогоос хамаардаг.

Дотоод хүчин зүйлс:

Нүүрс олборлохтой холбоотой гарах зардлын хүчин зүйлс багтана. Өөрөөр хэлбэл зардлын хүчин зүйлс нүүрсний үнэ тогтоох гол зүйлсийн нэг юм. Урт хугацаанд нүүрсний үнэ тогтоох арга нь нүүрс олборлох өртөг, зардлыг тооцож тодорхой хэлбэртэй.

2021.03.19

Үйлдвэрлэлийн ашиг тооцсон үнээр тооцдог байна. Үнэт цаас гаргагчийн хувьд нүүрс тээвэрлэх болон олборлохтой холбоотой дэд бүтцийн асуудлуудыг шийдвэрлэхээр ажиллаж байгаа бөгөөд амжилттай шийдвэрлэгдсэн тохиолдолд нүүрсний үнэд эерэг нөлөөтэй байх юм.

Дэлхийд нүүрсний олборлолт болон хэрэглээгээрээ БНХАУ тэргүүлдэг тул тус улсын нүүрсний салбарт явуулж буй бодлого, хэрэглээний түвшингээс их хэмжээгээр шалтгаалдаг. Тус улсын зах зээл дэх нүүрсний үнэд нөлөөлдөг хүчин зүйлсийг доор тусгав.

- **Нийлүүлэлт ба эрэлт:** БНХАУ-д нүүрсний уурхайн хүчин чадлыг бууруулах зорилтууд бүрэн хэрэгжиж, хүчин чадлаа солих ажил өрнөж байгаа тул дотоодын нүүрсний хангамжийн хүчин чадал аажмаар нэмэгдэх болно. Нөгөө талаар түүхий гангийн хэрэглээ дээд цэгтээ хүрч, 2020 оноос аажмаар багасах төлөвтэй байгаа тул дотоодын нүүрсний эрэлт сулрах төлөвтэй байна. Энэ бүхнээс улбаалж 2025 он хүртэл нүүрсний үнэ бууралттай байх төлөвтэй. Харин 2025 оноос тус улсын нүүрсний салбарт оруулсан хөрөнгө оруулалт буурснаар олборлолтын өсөлт суларч улмаар нүүрсний үнэд эергээр нөлөөлөх магадлалтай. Нүүрсний салбарт оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ багасах нь тус улсын "Ногоон эрчим хүчний салбар"-т оруулах хөрөнгө оруулалт нэмэгдэж байгаатай холбон тайлбарлагдана.
- **Бодлого:** Нүүрсний үйлдвэрлэлийн талаарх бодлогын чанга зохицуулалт сулрахгүй бөгөөд энэ нь нүүрсний салбарт хөрөнгө оруулалт хийх, нүүрсний худалдаа, үнийн аргад урт хугацааны гэрээг сурталчлах замаар нөлөөлөх болно. Мөн уурхайн олборлолт болон газрын тос боловсруулах үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд байгаль орчныг хамгаалах нөхцөлийг хэвийн болгох, зарим үе шатанд аюулгүй байдлын хяналт шалгалт хийх, халаалтын улиралд олборлолтын хэмжээг бууруулах зэргээр хязгаарласаар байх болно. Цаашид Монгол Улс коксжих нүүрсний дэлхийн томоохон ханган нийлүүлэгч орны хувьд коксжих нүүрсний үнийн бие даасан индекс тэй болох чиглэлээр бодлого, аргачлал боловсруулах ажлыг "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн баг санаачлан хариуцаж, төрийн холбогдох шатны байгууллагуудтай хамтран ажиллахаар санал боловсруулаад байна.
- **Импорт:** Импортын хязгаарлалтын бодлого нь чангарсаар байх бөгөөд дулааны нүүрснээс гадна коксжих нүүрсэнд тавигдах шаардлага нэмэгдэх төлөвтэй байна. Нүүрсний импортын бодлогод оруулсан өөрчлөлтүүд нүүрсний үнэд нөлөөлөх нь гарцаагүй.
- **Зардал:** Уул уурхайн зардал нь хөдөлмөр, материал, эрчим хүчнээс бүрдэнэ. Цаашид хөдөлмөр болон материалын зардал өсөх хандлагатай байна.
- **Нүүрсний чанар:** Ижил төрлийн нүүрсний үнийн зөрүү нь нүүрсний чанарын зөрүүтэй холбоотой юм. Ерөнхийдөө нүүрсний үнийг үнс, хүхэртэй холбож сөрөг хамааралтай үздэг бол G индекс, илчлэгийн агууламж, CSR-тай эерэг хамааралтай байдаг.

3.3.2. Зорилтот зах зээл дэх нүүрсний үнэ, үнийн төсөөлөл

Нүүрсний үнийн төсөөлөл боловсруулахад жишиг үнийн асуудал чухал байдаг. Өөрөөр хэлбэл тухайн ордын нүүрстэй аль болох ойролцоо чанартай нүүрсийг сонгож авч, цаашид жишиг үнэ гэж нэрлэдэг байна.

Иймд Тавантолгойн бүлэг ордын нүүрстэй ойролцоо чанартай гэдэг үүднээс Шанси мужийн хатуу коксжих болон 1/3 коксжих нүүрсний Жинтан боомт дээрх үнэ болон Чаншаны үнэ, Чинхуандао боомтын 5500 ккал болон 5800 ккал илчлэгтэй эрчим хүчний





2021.03.05

зориулалттай нүүрсний үнийг жишиг үнэ болгон сонгосон байна. Таван толгойн бүлэг ордын нүүрс далайн эргийн зах зээлд хүрэх боломжтой гэдэг үүднээс Жингтан боомтыг сонгосон байна.


Хүснэгт 38. Жишиг үнийн сонголт

	Qnar (ккал/кг)	Ad	Mt	Vdaf	St,d	G	Y	GSR
Коксжих нүүрс:								
Шанхи мужийн коксжих нүүрс, Жингтанг боомтод		8	5.1	25	0.9	85	14	68
Шанхи мужийн 1/3 коксжих нүүрс, Жингтанг боомтод		11	6.5	35	1	75	17	62
Эрчим хүчний нүүрс:								
5500 ккал/кг холилдсон	5500	20		25	1			
5800 ккал/кг холилдсон	5800	15		25	0.6			

Эх сурвалж: Фенвэй Энержи

2015-2020 онд БНХАУ-ын нүүрсний салбарт хийгдсэн шинэчлэлийн хүчинд нийлүүлэлтийн илүүдлээс болж буураад байсан нүүрсний үнэ 2016 оноос хойш өсөж эхэлсэн байдаг. Гэсэн хэдий ч хүчин чадлыг бууруулах даалгаврууд хийгдэж, уурхайнууд шинээр ашиглалтад орсноор нүүрсний нийлүүлэлт аажмаар нэмэгдэж, 2019 оны эхнээс нүүрсний үнэ буурч эхэлсэн байна.

Зураг 30. Коксжих болон эрчим хүчний зориулалттай нүүрсний жишиг үнэ (юанийн)



Эх сурвалж: Фенвэй Энержи

2025 оноос өмнө олон тооны уурхайнууд ашиглалтад орсноор БНХАУ-ын нүүрсний зах зээлд нүүрсний илүүдэл буюу нийлүүлэлтийн илүүдэл бий болох хандлагатай. Үүнээс улбаалж нүүрсний үнэ 2025 оноос өмнө буурах хандлагатай болохыг "Фенвэй Энержи"-ийн шинжээчид онцолсон байна. Дараа нь нүүрсний үйлдвэрлэлийн хүчин чадал нэмэгдэх тусам уурхайн бүтээн байгуулалтын зөвшөөрөл дахин чангарч, улмаар нүүрсний салбарт оруулах хөрөнгө оруулалт багассанаар нүүрсний зах зээл дэх хэт их нийлүүлэлт буурах болно. Иймд нүүрсний үнэ 2025-2030 онд аажмаар өсөх төлөвтэй байна.

TAVAN
ЭРДЭНЭС
ТАСАН
ТӨЛӨЙ
ХС
JSC

МХБ-ийн 1-р үйлдвэр
Андерригтэй
Товчоо, Хөдөлгөөн
"БНХАУ-ын
ХС"
115570447

20210302




Хүснэгт 39. Нүүрсний үнийн төсөөлөл (млн. доллартай)

	2021E	2022E	2023E	2024E	2025E
Эрчим хүчний нүүрс					
Чинхуандао 5500 ккал/кг	77	75	74	73	72
Чинхуандао 5800 ккал/кг	82	80	79	78	77
Коксжих нүүрс					
Жингтанг Шаньси анхдагч коксжих нүүрс	229	224	220	217	216
Жингтанг Шаньси 1/3 коксжих нүүрс	188	184	181	178	176

Эх сурвалж: Фенвэй Энержи

Үнэт цаас гаргагчийн нүүрс экспортод гаргадаг Ганцмод боомтын коксжих нүүрсний үнийн төсөөллийг дараах графикт тусгалаа.

График 14. Нүүрсний үнийн төсөөлөл – Ex-Stock Ганцмод үнэ (юань/тн)



Эх сурвалж: Фенвэй Энержи

Дэлхийн болон ази тив, БНХАУ-д нийлүүлэх коксжих нүүрсний үнийн сагсанд нөлөөлөх нөлөөллийг бий болгох зорилтын хүрээнд Монгол Улсын коксжих нүүрсний үнийн шинэ МГЛ-Кок индексийг дотоодын коксжих нүүрсний уурхайнуудын тогтоосон үнэ, хилийн үнэ, биржийн болон биржийн бус үнэ, Монгол Улсад хэрэглэгддэг компаниудын индекс, аргачлал зэрэгт тулгуурлан бий болгох саналыг "Эрдэнэс-Тавантолгой" ХК санаачилж, төрийн байгууллагуудын зөвлөмж, оролцоо, стандарт тогтоох журмын хүрээнд, жишиг үнийн дагуу зохион байгуулахаар төлөвлөсөн.

3.4. Үнэт цаас гаргагчийн нөхцөл байдлын шинжилгээ

"Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн үйл ажиллагааны гадаад, дотоод орчны нөхцөл байдлын шинжилгээний дүгнэлтийг PEST, SWOT шинжилгээний аргуудыг ашиглан гаргаж, хүчин зүйлсийн нөлөөлөл, компанийн давуу, сул тал, аюул, боломжийг нэгтгэн тодорхойлж, хүснэгтээр үзүүлээ.

2021-2025 онд компанийн үйл ажиллагаанд учрах хамгийн магадлал өндөртэй эрсдэлүүд нь нүүрсний үнэ, валютын ханшийн хэлбэлзэл, нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлсэн төслүүдийн хөрөнгө оруулалтын бизнесийн үр өгөөж, эрчим хүчний нүүрсний борлуулалтын нөхцөл байдал зэрэг байх болно гэж үзэж байна.

Мөн дотоодын нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэл, дэд бүтцийн төслүүдийг дэмжсэн төрийн бодлого, компанийн эдийн засаг, санхүүгийн зэрэг нөхцөл байдал болон БНХАУ-ын зах зээл дээрх нүүрсний эрэлт хэрэгцээ зэрэг хүчин зүйлсийн нөлөөллөөр Тавантолгой ордыг түшиглэсэн дэд бүтэц бүхий аж үйлдвэрийн парк байгуулах, шаардлагатай хөрөнгө оруулалтыг гадаад, дотоодын хөрөнгийн зах зээлээс татан төвлөрүүлэх боломж бүрдэнэ гэсэн хүлээлттэй байна.



2021.03.26

2021-03-19

Хүснэгт 40-PEST шинжилгээ
БҮРГЭВ

Улс төр, хууль эрх зүй	Эдийн засаг
<p>Эерэг</p> <ul style="list-style-type: none"> - Тавантолгой ордыг цогцоор нь хөгжүүлэх төрийн нэгдсэн бодлого - Дотоодын боловсруулах үйлдвэр болон нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжсэн төрийн бодлого - Тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд уул уурхайн салбарыг хөгжүүлэх хандлага <p>Сөрөг</p> <ul style="list-style-type: none"> - Улс төрийн бодлого барих түвшний ажиллагаа, нөлөөлөл - Сонгуулийн цаг хугацааны давтамж, шууд нөлөөлөл - ТУЗ, Гүйцэтгэх удирдлага солигдох, тэдгээрийн ажлын тогтвор суурьшил - Санхүүгийн дарамт, төслийн бус эдийн засгийн шийдвэрүүд - "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн үйл ажиллагаанд оролцох төрийн шууд оролцоо 	<p>Эерэг</p> <ul style="list-style-type: none"> - Улсын эдийн засаг, төсөвт оруулж буй хувь нэмэр - "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн санхүүгийн чадавх, эерэг үзүүлэлтүүд - Коксжих болон эрчим хүчний нүүрсний нөөц - Коксжих болон эрчим хүчний нүүрсний чанарын үзүүлэлт - Ордын байршил зорилтот зах зээлд ойр - Олон улсын болон дотоодын хөрөнгийн зах зээлээс хөрөнгө татан төвлөрүүлэх боломж <p>Сөрөг</p> <ul style="list-style-type: none"> - Инфляцын өсөлт - Валютын ханшийн өөрчлөлт - Дэд бүтцийн сул хөгжил - Нүүрсний үнийн хэлбэлзэл - Нүүрсний нийлүүлэлт эрэлтээс давах магадлал - Нүүрсийг түүхийгээр экспортолж байгаа нь Монголын нүүрсний өрсөлдөх чадварыг сул болгож байгаа байдал
Нийгэм, байгаль орчин	Техник технологи
<p>Эерэг</p> <ul style="list-style-type: none"> - Байгаль орчны нөхөн сэргээлт - Нийгмийн хариуцлагын томоохон төслүүд - Хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, иргэдийн зүгээс компанид тавих анхаарал, сонирхол - Монгол Улсын иргэд, ажилчдад зориулсан ажлын байр, мэргэжил эзэмших боломж - Хот суурин газрын төлөвлөлт, барилга угсралтын ажлууд <p>Сөрөг</p> <ul style="list-style-type: none"> - Усан хангамж - Нөхөн сэргээлтийн өндөр зардал - Дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө - Иргэдээс авах нийгмийн зөвшөөрөл - Иргэдийн баялгийн өмчирхөх үзэл - Хэвлэл, мэдээллийн хэрэгслийн сөрөг хандлага - Компани болон орон нутгийн оролцогч талуудын хоорондын сөрөг харилцаа 	<p>Эерэг</p> <ul style="list-style-type: none"> - Уурхайн нөөцийг тогтоом үйл ажиллагаа, нөөц нэмэгдэх боломж - Дэлхийн шилдэг технологи - Завсрын бүтээгдэхүүнээр эрчим хүч гарган авах боломж - Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, дэд бүтцийн төслүүдийн хэрэгжилт <p>Сөрөг</p> <ul style="list-style-type: none"> - Мэдээллийн аюулгүй байдлын стандарт нэвтрээгүй байдал - Нүүрс олборлолт, тээврийн өртөг өндөр

3.4.2 SWOT шинжилгээ

SWOT шинжилгээний арга ашиглан "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн давуу, сул тал, аюул, боломжийг нэгтгэн тодорхойлсоныг доорх хүснэгтээр үзүүлж байна.

Эрдэнэс-Тавантолгой ХК
JSC

Эрдэнэс-Тавантолгой ХК
"БНДЭС" ҮНХ ХК

2021.03.09

Давуу тал (+)	Сул тал (-) БҮРТГЭВ-02
<ul style="list-style-type: none"> ➢ Сайн чанарын коксжих нүүрсний арвин нөөц ➢ Коксжих нүүрсний хамгийн том хэрэглэгч БНХАУ-тай ойр байршдаг. ➢ Компанийн санхүүгийн үйл ажиллагаа тогтворжиж эхэлсэн. ➢ Уурхайн үйл ажиллагаа 24 цагийн турш тасралтгүй явагддаг. ➢ Ил уурхайн аргаар олборлолтын үйл ажиллагаа эрхэлдэг тул олборлолтын зардал харьцангуй бага. ➢ Олборлолтын хүчин чадал бага тул урт хугацаанд үйл ажиллагаа явуулах боломжтой. ➢ Цэвэр ашгийн харьцаа салбарын дунджаас харьцангуй өндөр ➢ Компанийн засаглалыг сайжруулахад анхаарч эхэлсэн. ➢ Төрийн өмчит компани тул төрөөс дэмжлэг авах боломжтой. ➢ Ажилтнуудын нийгмийн асуудалд анхаарч ажилладаг. ➢ Орон нутагтай хамтын ажиллагааны гэрээ байгуулан хамтарч ажилладаг. ➢ Үйл ажиллагаандаа олон улсын ISO 9001:2015, ISO 14001:2015, ISO 45001:2015 зэрэг стандартуудыг нэвтрүүлсэн тул цаашид компанийн менежмент, ХАБ, эрүүл ахуй, байгаль орчны үйл ажиллагааг сайжруулахад анхаарна. 	<ul style="list-style-type: none"> ➢ Олборлолтын үйл ажиллагааг гэрээт олборлогчдоор гүйцэтгүүлэх зардал өөрсдөө олборлох зардлын тооцооллоос өндөр гарсан. ➢ Нийлүүлэгчдээс хамаарах хамаарал өндөр ➢ Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл хөгжөөгүй. ➢ Тээвэр логистикийн хямд суваг бий болоогүй тул FCA уурхайн ам нөхцөлөөр нүүрс борлуулдаг ➢ Компанийн маркетингийн стратеги бодлогын хүрээнд тодорхойлогдож албан ёсоор баталгаажуулаагүй. ➢ Зах зээлийн судалгааны хувьд зөвхөн өнөөгийн үйл ажиллагаатай холбоотой судалгаа хийгддэг бөгөөд ирээдүйн хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлага, өрсөлдөгчийн талаарх судалгаа хийгддэггүй. ➢ Эцсийн хэрэглэгчдэд бүтээгдэхүүн борлуулдаггүй тул тогтвортой, богино хугацааны хэрэглэгчидтэй. ➢ Уурхайн хөрс тээврийн зай холдож бүтээмж буурсан. ➢ Авто замын хүчин чадал, гаалийн нэвтрүүлэх хүчин чадал, БНХАУ-ын зах зээлийн багтаамжаас бүрэн хараат байдлаар үйл ажиллагаа явуулдаг. ➢ Хуримтлагдаж буй эрчим хүчний нүүрсний ашиглалт, борлуулалт сул. ➢ Группийн хэмжээнд баримтлах нэгдсэн бодлого тодорхойлогдоогүй. ➢ Уурхайн үндсэн үйл ажиллагааны бүтээмжийг нэмэгдүүлж, зардал бууруулахад чиглэсэн техник, технологийн шийдал нэвтрүүлээгүй. Уул, тээврийн ажлын автомат удирдлагын систем нэвтрээгүй. ➢ Санхүү хөрөнгө оруулалтын төсөөллийг зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн тооцоо судалгаанд үндэслэн таамагладаггүйгээс шалтгаалан хэт өөдрөг төлөвлөлт хийх хандлагатай. ➢ Хүний нөөцийн нэгдсэн мэдээллийн систем байдаггүй. ➢ Хүний нөөцийн урт, дунд хугацааны төлөвлөлт, залгамж халаа, карьер хөгжлийн төлөвлөлт хийгдээгүй тул мэргэшсэн чадварлаг ажилтан тогтоон барихад хүндрэлтэй. ➢ Хүний нөөцийн үйл ажиллагааны чиг үүргийн хэрэгжилт бүрэн бус. ➢ Олборлолтын үйл ажиллагаа болон бусад шаардлагатай үйл ажиллагааг бусдаар гүйцэтгүүлдэг тул нарийн мэргэшсэн,

2021.03.09

TAVAN
ЭРДЭНЭС
ТАВАН
ТӨЛӨЙ
ХК
111520547

111520547
111520547

СЗХ
2021.03.03
ОН
CSJ

ТАВАН ТӨЛГӨЙ ХК

БҮРТГЭВ
№ 01

2021.03.19

БҮРТГЭВ 02

	<p>туршлагатай инженер техникийн ажилтнууд цөөнтэй.</p> <ul style="list-style-type: none"> ➤ Тоног төхөөрөмж, сүлжээний дэд бүтцийн хүрэлцээгүй байдлаас шалтгаалан мэдээллийн аюулгүй байдал хангалттай биш. ➤ Эрсдэлийн удирдлагын бодлого, төлөвлөгөө батлуулж, эрсдэлийн сан үүсгээгүй. ➤ Уурхайн хаалтын бодлого төлөвлөлт, хаалтын сангийн асуудал шийдвэрлэгдээгүй. ➤ Компанийн тогтвортой хөгжил, нийгмийн хариуцлагын бодлого тодорхойлогдоогүй.
--	---

Боломж (+)	Аюул (-)
------------	----------

<ul style="list-style-type: none"> ➤ Компанийн гол харилцагч болон БНХАУ-ын эдийн засгийн байдал, нүүрсний эрэлт урт хугацаанд тогтвортойгоор буурах ч дэлхийн зах зээлийн эрэлтийг тодорхойлогч хэвээр байна. ➤ Гуравдагч зах зээлд бүтээгдэхүүн борлуулахтай холбоотойгоор боомтын асуудлыг шийдвэрлэх ➤ БНХАУ-ын нүүрсний импортын татваргүй болгох, хил гаалийн хүчин чадлыг нэмэгдүүлэх чиглэлд арга хэмжээ авах ➤ Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар уурхайн үндсэн үйл ажиллагааны үнэ цэнийг нэмэгдүүлэх ➤ Өөрсдийн баяжуулах үйлдвэр барих хүртэл Монгол болон БНХАУ-ын баяжуулах үйлдвэрүүдтэй хамтран ажиллаж нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, уурхайн нөөцийн зохистой харьцааг хангах ➤ Төрөөс хэрэгжүүлж буй төмөр зам, авто замын төслүүд ашиглалтад орж тээвэрлэлтийн хямд бөгөөд үр ашигтай суваг бий болох ➤ Ордод нарийвчилсан хайгуулын ажил хийх замаар нөөцийн хэмжээг өсгөх ➤ Бүтээмжийг нэмэгдүүлж, зардал бууруулахад чиглэсэн техник, технологийн шийдэл нэвтрүүлэх боломжтой. ➤ Уурхайн хаалтыг оновчтой төлөөлөх замаар орон нутгийн бие даасан тогтвортой байдлыг дэмжсэн, хүрээлэн буй орчинд ээлтэй уурхайн үйлдвэрлэлийг хөгжүүлэх ➤ Төрөөс Тавантолгойн цахилгаан станц барих төсөл хэрэгжүүлсэн тохиолдолд эрчим хүчний нүүрс нийлүүлэх тогтвортой харилцагчтай болох 	<ul style="list-style-type: none"> ➤ Ойрын жилүүдэд буюу 2022-2024 он дэлхийн эдийн засгийн хямрал болох хүлээлттэй байна. ➤ Нүүрсний зах зээлийн үнийн хэлбэлзлээс компанийн ашигт ажиллагаа өндөр хамааралтай байдаг. ➤ Нэг улсаас /БНХАУ/ хараат байдлаар үйл ажиллагаа явуулдаг тул тухайн улсын импортын бодлого, зах зээлийн өөрчлөлтөд мэдрэмж өндөр байх ➤ Улсын нөөц багатай бүс нутагт үйл ажиллагаа эрхэлдэг тул ус ашиглалттай холбоотой хүндрэл тулгарах аюултай ➤ Өвөр Монголын Баяннуур дахь баяжуулах үйлдвэрүүд нь Таван толгойн коксжих нүүрсний ордод түшиглэн байгуулагдсан тул цаашид "Эрдэнэс-Тавантолгой" ХК гаргах баяжуулах нүүрсний борлуулалтыг дэмжихгүй байх, хаалт хийх ➤ Улс төрийн нөлөөллөөс шалтгаалж компанийн санхүүгийн эх үүсвэр болон ашгийг зориулалтын бусаар ашиглан нийгмийн халамжийн үйл ажиллагааг санхүүжүүлэх ➤ Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлээгүйтэй холбоотойгоор сайн чанарын нүүрсний нөөц багасах, ордын ашиглалтын хугацаа богиносгох ➤ Төрөөс хэрэгжүүлж буй төмөр зам, авто замын төслүүд удаашрах ➤ Дэд бүтцийн асуудал шийдвэрлэгдээгүй тохиолдолд орчны бохирдлоос шалтгаалан орон нутгийн иргэд ажилтнуудын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх ➤ Өрсөлдөгч (ОХУ) болон хэрэглэгч (БНХАУ) улсын ашиг сонирхлоос шалтгаалан боомтын асуудал шийдвэрлэгдэхгүй байх. ➤ Гангийн үйлдвэрлэлийн технологийн сонголтоос шалтгаалан коксжих нүүрсний дэлхийн зах зээл дэх эрэлт урт хугацаанд буурах
--	--

2022.10.30

ТАВАН ТӨЛГӨЙ ХК

ЭРДЭНЭС

БҮРТГЭВ

№ 01

БҮРТГЭВ 02

11157447

2021-03-19

3.4.3 TOWS шинжилгээ

SWOT шинжилгээгээр илэрсэн давуу ба сул тал болон боломж, аюулд тулгуурлан TOWS шинжилгээний үр дүнг дараах хүснэгтэд харуулав.

	S - ДАВУУ ТАЛ (+)	W - СУЛ ТАЛ (-)
TOWS ШИНЖИЛГЭЭ	<p>S1: Сайн чанарын коксжих нүүрсний арвин нөөц</p> <p>S2: Том зах зээлтэй ойр, байршлын давуу тал</p> <p>S3: Үндсэн үйл ажиллагааны зардал харьцангуй бага</p> <p>S4: Санхүүгийн үйл ажиллагаа тогтворжсон, цэвэр ашгийн харьцаа салбарын дунджаас өндөр</p> <p>S5: Нэгдсэн менежментийн тогтолцоо нэвтрүүлснээс гадна, компанийн засаглалыг сайжруулахад анхаарч эхэлсэн</p> <p>S6: Ажилтнуудын нийгмийн хангамжийн асуудалд анхаардаг.</p>	<p>W - Сул тал (-)</p> <p>W1: Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл хөгжөөгүй</p> <p>W2: Усны нөөц багатай бус нутагт үйл ажиллагаа эрхэлдэг</p> <p>W3: Гэрээт олборлогчдоос хамаарах хамаарал өндөр</p> <p>W4: Хөрс тээврийн зай холбож бүтээмж буурсан</p> <p>W5: Үйлдвэрлэлийн бүтээмж нэмэгдүүлж, зардал бууруулах технологийн шинэчлэл тогтмол бус</p> <p>W6: Авто зам, хил гаалийн хүчин чадал, БНХАУ-ын зах зээлийн байдлаас хараат</p> <p>W7: Маркетингийн стратеги тодорхойлогдоогүй, зах зээл, өрсөлдөгчийн судалгаа тогтмол биш</p> <p>W8: Компанийн дэмжих үйл ажиллагаа хөгжөөгүй</p> <p>W9: Компанийн борлуулалт нэг хэрэглэгч улсаас хамаардаг</p> <p>W10: Эрчим хүчний нүүрсний эрэлт сул тул борлуулалт бага</p> <p>W11: Мэргэшсэн боловсон хүчин, инженер, техникийн ажилтнууд цөөн</p> <p>W12: Эцсийн хэрэглэгчид бүтээгдэхүүн борлуулдаггүй</p> <p>W13: Компанийн тогтвортой хөгжил, нийгмийн хариуцлагын бодлого тодорхойлогдоогүй</p>
O - БОЛОМЖ (+)	SO - ДАВУУ ТАЛАА АШИГЛАН БОЛОМЖИД ХҮРЭХ	WO - СУЛ ТАЛАА АРИЛГАН БОЛОМЖИД ХҮРЭХ

2021.03.19

TAVAN
ЭРЭН-ЭС
ТАВАН-ТӨЛГӨЙ
JSC

МАН-ИИ ТИШҮҮН
Аудиторантер
БНХАУ-ЫН
БНБХ-ЫН
1115205443

O1: Урт хугацаанд дэлхий болон БНХАУ-ын эдийн засаг харьцангуй тогтвортой байна
O2: Төрөөс төмөр зам, авто замын төслүүдийг хэрэгжүүлж тээвэрлэлтийн хямд суваг бий болгох
O3: БНХАУ-ын нүүрсний импортыг татваргүй болгох, хил гаалийн хүчин чадлыг нэмэгдүүлэх чиглэлд Засгийн газраас дэмжлэг авах
O4: Боомтын асуудлыг шийдвэрлэхэд Засгийн газраас дэмжлэг авч гуравдагч зах зээлд бүтээгдэхүүн борлуулах суваг бий болгох
O5: Өөрсдийн баяжуулах үйлдвэр барих хүртэл Монгол болон БНХАУ баяжуулах үйлдвэрүүдтэй гэрээ байгуулан ажиллаж нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, уурхайн нөөцийн зохистой харьцааг хангах
O6: Ордод нарийвчилсан хайгуулын ажил хийх замаар нөөцийн хэмжээ нэмэгдүүлэх
O7: Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар, уурхайн үндсэн үйл ажиллагааны үнэ цэнийг нэмэгдүүлэх
O8: Олборлолтын үйл ажиллагааг үе шаттайгаар өөрсдөө хариуцах замаар өртөг бууруулах
O9: Бүтээмжийг нэмэгдүүлж, зардал бууруулахад чиглэсэн техник, технологийн шийдэл нэвтрүүлэх боломжтой
O10: Орон нутгийн бие даасан тогтвортой байдлыг сайжруулахад хувь нэмэр оруулсан, хүрээлэн буй орчинд ээлтэй уурхайн үйлдвэрлэлийг хөгжүүлэх
O11: Цахилгаан станцын бүтээн байгуулалт хийгдсэн тохиолдолд эрчим хүчний нүүрсний тогтвортой харилцагч бий болох
O12: Санхүүгийн хөшүүрэг болон бусад арга хэрэгсэл өшиглэх замаар санхүүгийн эх үүсвэр татах боломж бүрдсэн.

SO1: Сайн чанарын коксжих нүүрсний арвин нөөцөд түшиглэн, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар, уурхайн үндсэн үйл ажиллагааны үнэ цэнийг нэмэгдүүлэх
SO2: Сайн чанарын коксжих нүүрсний арвин нөөцөд түшиглэн өөрсдийн баяжуулах үйлдвэр барих хүртэл Монгол болон БНХАУ-ын баяжуулах үйлдвэрүүдтэй хамтран ажиллах
SO3: Том зах зээлтэй ойр байршлын давуу талаа ашиглан БНХАУ-ын импортын нүүрсний зах зээлд эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлэх
SO4: Компанийн санхүүгийн тогтворжилтод тулгуурлан төрөөс хэрэгжүүлж буй төмөр замын төслүүдэд хөрөнгө оруулах замаар хамтран ажиллаж тээвэрлэлтийн хямд суваг бий болгох
SO5: Гуравдагч зах зээлд бүтээгдэхүүн борлуулах суваг бий болгох чиглэлээр ажиллах
SO6: БНХАУ-ын нүүрсний импортыг татваргүй болгох, хил гаалийн хүчин чадлыг нэмэгдүүлэх чиглэлд Засгийн газраас дэмжлэг авах
SO7: Нөмрөгийн боомтоос Владивосток хүртэл болон Гашуунсухайт, Ханги зэрэг боомтоос Тяньжин болон Чинхуандао зэрэг олон Улсын боомтууд хүртэл төмөр замаар нүүрс тээвэрлэх маршрутын зөвшөөрөл болон хөнгөлөлттэй үнийн тарифыг баталгаажуулах ажилд Засгийн газраас дэмжлэг авах

WO1: Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлж, төмөр замын хямд сүлжээ ашиглан эцсийн хэрэглэгчид хүрэх
WO2: Олборлолтын үйл ажиллагааг үе шаттайгаар өөрсдөө хариуцах замаар гэрээт операторуудаас хамаарах хамаарлыг бууруулах
WO3: Компанийн дэмжих үйл ажиллагааг сайжруулах замаар урт хугацаанд тогтвортой үйл ажиллагаа эрхлэх боломжийг бий болгох
WO4: Гуравдагч зах зээлийн судалгааг тогтмолжуулж нэг хэрэглэгчээс хамаарах хамаарлыг бууруулах
WO5: Маркетингийн судалгааг тогтмолжуулж эрчим хүчний нүүрс борлуулах боломжит зах зээлийг бий болгох, Мөн сайн чанарын эрчим хүчний нүүрсний борлуулалт нь боломжгүй бол нүүрсэндээ тулгуурласан ДЦС барьж эрчим хүч болгон борлуулах, экспортлох боломжийг судлах
WO6: Цахилгаан станцын бүтээн байгуулалтыг дэмжих замаар эрчим хүчний нүүрсний тогтвортой хэрэглэгч бий болгох
WO7: Уурхайн хаалтыг оновчтой төлөвлөх замаар орон нутгийн бие даасан тогтвортой байдлыг сайжруулахад хувь нэмэр оруулсан, хүрээлэн буй орчинд ээлтэй уурхайн үйлдвэрлэлийг хөгжүүлэх
WO8: Санхүүгийн хөшүүрэг болон бусад арга хэрэгсэл өшиглөх замаар дэд бүтцийн шаардлагатай төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх

2021.03.03

ЭРДЭНЭЭС ТАВАНТОЛГООН ХК
ТӨСӨЛ
ТЭГЭЭН
УЛС
JSC

ЭРДЭНЭЭС ТАВАНТОЛГООН ХК
ТӨСӨЛ
ТЭГЭЭН
УЛС
JSC



Т-АЮУЛ (-)	ST-ДАВУУ ТАЛАА АШИГЛАН АЮУЛААС ЗАЙЛСХИЙХ	WT-СУЛ ТАЛАА АШИГЛАН АЮУЛААС ЗАЙЛСХИЙХ
<p>T1: Далхийн эдийн засгийн хямрал болох хүлээлттэй</p> <p>T2: Компанийн ашигт ажиллагаа зах зээлийн үнээс өндөр хамааралтай байх</p> <p>T3: Төрөөс хэрэгжүүлж буй төмөр замын төслүүд удаашрах</p> <p>T4: Улс төрийн нөлөөллөөс шалтгаалан компанид үр ашиггүй шийдвэр гаргах</p> <p>T5: Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлээгүйгээс сайн чанарын нүүрсний нөөц буурч ордын ашиглалтын жил богиносох</p> <p>T6: Хоёр хөршийн зүгээс боомтын асуудлыг дэмжихгүй байх</p> <p>T7: Гангийн үйлдвэрлэлийн технологийн сонголтоос шалтгаалан коксжих нүүрсний эрэлт буурах</p> <p>T8: Ордын геотехникийн иж бүрэн судалгаа хийгдээгүйгээс үүдэн их хэмжээний нуралт, гулгалт үүсэх</p> <p>T9: Үйлдвэрийн усны эх үүсвэр шийдэгдээгүй байх</p>	<p>ST1: Ашигт ажиллагаа өндөртэй байгаа давуу талаа ашиглан зах зээлийн үнийн хэлбэлзлээс шалтгаалах эрсдэлийг бууруулах зорилго бүхий сан байгуулах</p> <p>ST2: Компанийн засаглал, менежментийн тогтолцоог сайжруулж эхэлсэн давуу талаа ашиглан компанид үр ашиггүй улс төрийн шийдвэр гаргах явдлыг бууруулахад анхаарах</p> <p>ST3: Санхүүгийн үйл ажиллагааны тогтвортой үеийг ашиглан компанийн мөнгөн хөрөнгийг нэн тэргүүнд нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд зарцуулж нөөцийн хэмжээ буурах эрсдэлээс сэргийлэх</p>	<p>WT 1: Эцсийн хэрэглэгчид бүтээгдэхүүн борлуулах боломж бий болгох замаар нүүрсний зах зээлийн үнийн хэлбэлзлээс хамаарах хамаарлыг бууруулах</p> <p>WT 2: Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлж сайн чанарын нүүрсний нөөц буурах аюулаас сэргийлэх, мөн Бортээг /Өмнөд/ хэсэг болон бусад хэсгүүд дэх сайн чанарын коксжих шинж чанартай давхраасуудад ашиглалтын нарийвчилсан хайгуулыг явуулж чанарын судалгааг хийснээр үр ашигт давхраасын хэмжээг нэмэгдүүлэх</p> <p>WT 3: Компанийн тогтвортой хөгжил, нийгмийн хариуцлагын бодлогыг тодорхойлж хэрэгжүүлэх замаар усны зохистой хэрэглээг бий болгож ирээдүйн нөөц шавхагдахаас сэргийлэх, улс төрийн нөлөөллөөс шалтгаалсан халамжийн үйл ажиллагааг санхүүжүүлэх явдлыг журамлах, мөн боловсруулалт, инноваци шингэсэн үйлдвэрлэлийг дэмжих</p>

2021.03.26

Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны бизнес төлөвлөгөөний тэмдэг

3.5.1. Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн дэлхийн зах зээлд эзлэх байр суурь

"Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн мэдэлд байдаг Тавантолгой бүлэг орд коксжих нүүрсний арвин их нөөцтэй. Дэлхийн коксжих нүүрсний худалдаа 2019 онд 292.9 сая тонн байснаас 15 сая тонныг нь буюу 5.1 хувийг нь үнэт цаас гаргагчийн экспорт дангаараа бүрдүүлсэн бол 2021 онд 7 хувийг, 2023 онд 10.3 хувийг бүрдүүлэх зорилт тавин ажиллаж байна. Ингэснээр үнэт цаас гаргагч нь коксжих нүүрсний худалдаа эрхэлдэг дэлхийн топ 10 компанийн нэг болох бололцоотой.


Хүснэгт 42. Дэлхийн коксжих нүүрсний худалдаа (сая тонн)



Эх сурвалж: Эрдэнэс-Тавантолгой, Фенээй Энержи

Зорилтот зах зээл болох БНХАУ нь 2019 онд нийт 73 сая коксжих нүүрс импортлосноос 20.3 хувийг нь үнэт цаас гаргагч компанийн экспорт бүрдүүлсэн бөгөөд цаашид үнэт цаас гаргагч нь энэхүү үзүүлэлтийг ахиулж 2025 он гэхэд 60 хувьд хүргэхээр төлөвлөсөн.

Хүснэгт 43. БНХАУ-ын коксжих нүүрсний импорт (сая тонн)



Эх сурвалж: Эрдэнэс-Тавантолгой, Фенээй Энержи

ТАВАН
ЭРДЭНЭС
ТАВАН
ТОЛГОЙ
JSC

МХБ-ийн гишүү
Андеррате
Уровер, Илолийн
Уулс
111570447 / 111572483

2021.03.09

2019 онд "Эрдэнэс-Тавантолгой" ХК нь коксжих нүүрс олборлолтын хэмжээгээр Ази тивд 12-т үнэлэгдэж байсан бол 2025 онд "Топ-5"-д буюу 4 дүгээр байранд орохоор зорьж байна. Өөрөөр хэлбэл үнэт цаас гаргагч нь коксжих нүүрсний худалдааны хэмжээгээр дэлхийд эхний 10-т, Ази тивд эхний 4-т тооцогдох томоохон компани болж өргөжин тэлэхээр төлөвлөсөн.

Хүснэгт 44. Азид коксжих нүүрсний олборлолтын хэмжээгээр тэргүүлдэг компаниуд

2019 он		
Эрэмбэ	Компанийн нэршил	Олборлолт
1	Шаньси коксжих нүүрсний групп	89
2	Янкуанг групп	84
3	Шандонг Энержи групп	75
4	Жизонг групп	39
12	"Эрдэнэс-Тавантолгой" ХК	16
2025 он		
1	Шаньси коксжих нүүрсний групп	91
2	Янкуанг групп	86
3	Шандонг Энержи групп	77
4	"Эрдэнэс-Тавантолгой" ХК	47
5	Жизонг групп	40

Эх сурвалж: Эрдэнэс-Тавантолгой, Фенвэй Энержи

3.5.2. Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, хөтөлбөрүүд

Уурхайн хөгжүүлэлтийн төлөвлөгөө

Усны хангамжийн төслүүд



Төслийн нэр: Загийн ус хоолойн гүний усны нөөцийг ашиглах төсөл;
Төслийн ач холбогдол:

- Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт байрлах Загийн усны хоолой дахь гүний усны ордоос зохих хэмжээний усыг эхний ээлжид ашигласнаар нүүрс баяжуулах үйлдвэрийн шаардлагатай усны хэрэглээ хангагдаж үйлдвэрлэл явуулах боломж бүрдэнэ.

Төслийн хэрэгжүүлэх хугацаа: 2021-2022 он

Нийт төсөвт өртөг: 72.7 тэрбум төгрөг



Төслийн нэр: Цагаан цавын гүний усны нөөцөөс ашиглах төсөл;

Төслийн ач холбогдол:

- Дорноговь аймгийн Мандах сумын нутагт байрлах Цагаан цавын гүний усны ордоос зохих хэмжээний усыг эхний ээлжид ашигласнаар нүүрс баяжуулах үйлдвэрийн шаардлагатай усны хэрэглээ хангагдаж үйлдвэрлэл явуулах боломж бүрдэнэ.

Төслийн хэрэгжүүлэх хугацаа: 2021-2024 он

Нийт төсөвт өртөг: 104.5 сая ам.доллар /Урьдчилсан байдлаар/



Төслийн нэр: Хэрлэн тоонот /Гадаргын ус/;

Төслийн ач холбогдол:

- Монгол улсын хамгийн урт гол Хэрлэн гол дээр урсцын тохируулга хийснээр 5-10%-ийг ашиглахад Сайншанд хот, аж үйлдвэрийн парк, олон сумдын төвийн хүн ам, зарим Уул уурхай үйлдвэрийн усны хэрэгцээг цэвэр цэнгэг усаар хангах бүрэн боломжтой.

Төслийн хэрэгжүүлэх хугацаа: 2024-2025 он



2021.10.30

2021-03-19
 15:31



Төслийн ач холбогдол:

- Ачилтын байгууламж ашиглалтад орсноор Тавантолгой-Гашуунсухайт болон Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замаар тээвэр хийх галт тэрэгний цуваанд орчин үеийн, тасралтгүй технологиор, их хэмжээний нүүрсийг богино хугацаанд ачих боломж бүрдэнэ.

Төсөл хэрэгжүүлэх хугацаа: 2021-2023

Нийт төсөвт өртөг: 75.0 сая ам.доллар /Урьдчилсан байдлаар/

Зураг 31. Нүүрс ачилтын байгууламжийн бункер, конвейер



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн "А6-20" бизнес төлөвлөгөө

Үйлдвэрлэлийн дэвшилтэт техник, технологи



Төслийн нэр: Уулын олборлолтын техник

Төслийн ач холбогдол:

- Олборлолтын нэгж өртгийг бууруулна: Уулын ажлыг өөрийн техникээр хийж гүйцэтгэдэг болсноор олборлолтын нэгж өртгийг 25% орчим хувиар бууруулна.
- Олборлолтын зардал хэмнэлт: Өөрийн техниктэй болж уулын ажлыг хийж гүйцэтгэснээр 5 жилийн хугацаанд буюу 2021-2025 онуудад 158 сая \$ олборлолтын зардлаас хэмнэлт үүсгэнэ.

Төсөл хэрэгжүүлэх хугацаа: 2021-2025


Хөрөнгө оруулалтын төлөвлөсөн дүн: 243 сая ам.доллар

2021-03-19 15:30:24

Handwritten signature over a red stamp that reads: ТAVAN ЭРДЭНЭС ТАВАН ТОЛГОЙ МОНГОЛ УРАНГААТАР ҮС ТТСББ & БНББ ЖСC

Handwritten signature over a red stamp that reads: МХБ-ийн гишүүн Андерригтер Прокер, Индустрийн "БНББ" УИХ ХТ 111520447 @ 102482

График 15. Олборлолтын зардлын хэмнэлт жил бүрээр (сая ам.доллар)



Эх сурвалж: Үнэт цаас гаргаагчийн "АБ-20" бизнес төлөвлөгөө

Төслийн нэр: Конвейерийн системийн төсөл

Төслийн ач холбогдол:

- Тээвэрлэлтийн өртөг буурна: Нүүрс болон хөрсний тээврийн зардлыг 30%-иар бууруулна.
- Уулын ажлын /хөрс хуулалт, нүүрс олборлолт/ хүчин чадал нэмэгдэнэ. Цанхийн баруун уурхайд 100 сая.м3 хөрс хямд өртөгөөр тээвэрлэж, хаягдал хөрсний овоолгод байршуулах, жилд 30 сая тн нүүрс олборлох, тээвэрлэх дэд бүтэц бүхий хүчин чадалтай болно.
- Уурхайн дотоод тээврийн ачааллыг бууруулж, бүтээмжийг нэмэгдүүлнэ. Автосамосвалаар богино зайд рейс хийж гүйцэтгэдэг болсноор уурхайн доторх тээврийн ачааллыг багасгаж, автосамосвалын тоо цөөрөн ачаа эргэлт, салгалт хийх хугацаа богиносж бүтээл нэмэгдэх бөгөөд, аюулгүй ажиллагаанд зэрэг нөлөөлөл үзүүлнэ. Мөн тээвэрлэлтийн үеийн тоосноос үүсэх агаарын бохирдол багасч, байгаль орчин, экологид үзүүлэх сөрөг нөлөөлөл эрс багасна.

Төсөл хэрэгжүүлэх хугацаа: 2022-2024

Хөрөнгө оруулалтын төлөвлөсөн дүн: 198.6 сая ам.доллар

Зураг 32. Мөчлөг урсгалт конвейерийн систем



Эх сурвалж: Үнэт цаас гаргаагчийн "АБ-20" бизнес төлөвлөгөө

TAVAN
Нүүрс баяжуулах үйлдвэрийн төсөл
ЭРДЭНЭС
ТӨЛӨСӨ
JSC

МХБ-ийн гшүүр
Андеррайтер
Б.Долор, д.Доржиев
"БНЗС" ХХК
11153-447 д. 10/460

2021.03.03

Төслийн ач холбогдол:

- Ордын нөөцийг жигд ашиглах, насжилтыг уртасгана: Нүүрс баяжуулах үйлдвэр ашиглалтад орсноор Тавантолгой ордын 0, 5, 8, 9-р давхаргуудыг зохистой хэмжээнд олборлох боломжтой болох бөгөөд 2024 оноос эхлэн баяжуулах үйлдвэрийн шаардлагад нийцсэн нүүрсийг олборлохоор уурхайн параметрийг хангаж ажиллана.
- Улс орон болон бүс нутгийн нийгэм эдийн засгийн өсөлтийг дэмжинэ: Төсөл хэрэгжсэнээр улс орон болон бүс нутгийн нийгэм эдийн засгийн өсөлтийг дэмжиж жилд дунджаар 290.4 сая ам.долларыг улс орон нутгийн төсөвт оруулж, улмаар ордын нөөцийг хаягдал багатай, иж бүрэн ашиглах, экспортыг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний чанарт тавигдах шаардлагыг оновчтой байдлаар хангах, экологийн сөрөг нөлөөллийг бууруулах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүни үйлдвэрлэлийн хэмжээ, үр ашиг ихээхэн нэмэгдэх зэрэг олон эерэг давуу тал бий болно.

Төсөл хэрэгжүүлэх хугацаа: 2023-2025

Хөрөнгө оруулалтын төлөвсөн дүн: 10 сая.тн/жил- 335.6 сая.ам доллар, 30 сая.тн/жил - 774.0 сая. ам доллар

Зураг 33. Төслийн талбайн өрөнхий төлөвлөгөө



Эх сурвалж: Үнэт цаас гаргаагчийн "А6-20" бизнес төлөвлөгөө

Дэд бүтцийн төсөл, хөтөлбөрүүд

Төмөр замын төслүүд



Төслийн нэр: Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төсөл;

Төслийн ач холбогдол:

- Нүүрс тээвэрлэлтийн өртөг буурна: Авто болон төмөр замын тээврийн өртгийн зөрүү болох 20-30 ам.доллар/тн-оор борлуулалтын үнийг өсгөж, орлогыг нэмэгдүүлнэ.
- Нүүрс экспортын хэмжээ өснө: Төмөр замаар экспорт хийснээр хил нэвтрэх дарааллын асуудал байхгүй болж, хүчин чадал 30 хүртэлх сая тонн болж өснө.



Төслийн ажил эхэлсэн огноо: 2020 оны 03 дугаар сарын 01-нд;

Төслийн гүйцэтгэл (2021.02.16-ны байдлаар):

- 208 км үндсэн замын гүйцэтгэл: доод бүтцийн ажил 99.4%, дээд бүтцийн ажил 77.6%, 199.6 км төмөр замын үе угсарсан.
- 8 км ачилтын тойргийн хэсгийн гүйцэтгэл: доод бүтэц 66.6%.
- 20 км хил холболтын хэсгийн гүйцэтгэл: газар шорооны ажил 46.8%

Төслийн ашиглалтад орох огноо: 2022 оны 07 дугаар сар;

Нийт төсөвт өртөг: 1,282.01 сая ам доллар;

- Үүнээс 2020 оны байдлаар хийгдсэн санхүүжилт: "Эрдэнэс-Тавантолгой" ХК - 15 тэрбум төгрөг (бэлнээр), 110 сая ам.доллар (бэлнээр), 250 сая ам.доллар (off-take), "МТЗ" ТӨХК - 276 сая ам.доллар (өмнөх ажил)



Төслийн нэр: Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төсөл;

Төслийн ач холбогдол:

- Нүүрс тээвэрлэлтийн шинэ гарц бий болно: Тус зам ашиглалтад орсноор Замын-Үүд боомт буюу шинэ гарцаар нүүрс экспортолж БНХАУ-ын зүүн хойд бүс нутгийн хэрэглэгчдэд нүүрс нийлүүлнэ.
- Дотоодод нийлүүлж буй нүүрсний тээвэрлэлтийн өртөг буурна: Төмөр замын төв магистралтай холбогдож байгаа тул Улаанбаатар болон бусад төмөр зам дагасан байршлуудад нийлүүлж буй нүүрсний тээврийн өртөг буурна.

Төслийн ажил эхэлсэн огноо: 2019 оны 5 дугаар сарын 24-нд

Төслийн гүйцэтгэл (2020 оны эцсийн байдлаар):

- 416.1 км үндсэн замын гүйцэтгэл: доод бүтцийн ажил 100.0%, дээд бүтцийн ажил 54.9%, 228.5 км төмөр зам тавьсан.

Төслийн ашиглалтад орох огноо: 2021 оны 6 дугаар сар

Нийт төсөвт өртөг:

- Гүйцэтгэлээр: 1,944.2 тэрбум төгрөг (үүнээс суурь бүтэц 1,484.1 тэрбум төгрөг).
- ТЭЗҮ-ээр: 2,853.3 тэрбум төгрөг (үүнээс суурь бүтэц 2,393.2 тэрбум төгрөг).
 - Үүнээс 2020 оны байдлаар хийгдсэн санхүүжилт: "Эрдэнэс-Тавантолгой" ХК - 750 тэрбум төгрөг (бонд), 133 тэрбум төгрөг (хөрөнгө оруулалт)



Төслийн нэр: Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг холбох төмөр замын хэсэг;

Төслийн ач холбогдол:

- Тавантолгой ордоос Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замаар тээвэрлэлт хийх нөхцөлийг бүрдүүлнэ.
- Тус төсөл ашиглалтад орсноор Гашуунсухайт боомтыг төмөр замын үндсэн магистралтай холбох ба ирээдүйд БНХАУ-аас импортоор авах барааны тээврийг зохион байгуулж, Замын-Үүд боомтын ачааллыг бууруулах чухал ач холбогдолтой.

Төслийн гүйцэтгэл: ТЭЗҮ боловсруулагдсан.

Нийт төсөвт өртөг: 80.6 сая ам доллар

Авто замын төслүүд



СЭХ
2021 он
БҮРТГЭЭ
№ 31



Авто тээврийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 250 км параллель авто зам, Тавантолгой-Ханги-Мандал чиглэлийн 350 км авто зам болон Тавантолгой-Баруун наран чиглэлийн 32 км замын төгсгөлөөс Цагаандэл уул боомт хүртэлх 270 км авто замын төслүүдийг Үндэсний хөгжлийн газар хариуцан ажиллаж байгаа ба концессоор хэрэгжүүлэх ажлууд хийгдэж байна.

- Компани нь дээрх төслүүдийг бодлогоор дэмжиж ажилласнаар бүтээгдэхүүнээ зорилтот зах зээлд олон сувгаар нийлүүлэх боломж бүрдэнэ.

Хүснэгт 45. Авто замын төслүүдийн ерөнхий мэдээлэл

№	Төслийн нэр	Авто замын барилгын ажил эхлэх хугацаа	Авто замын барилгын ажил дуусах хугацаа	Концесс эзэмшигчийн авто зам ашиглалтын хугацаа	Трассын урт
1.	Тавантолгой-Гашуунсухайт	2019.10.22	2022.04.22	Авто зам ашиглалтад орсоноос хойш 12 жил	240 км
2.	Тавантолгой-Манлай-Ханги	2020.01.22	2022.07.22	Авто зам ашиглалтад орсоноос хойш 27 жил	463 км
3.	Тавантолгой-Цагаандэл уул	2019.11.20	2021.11.20	Авто зам ашиглалтад орсоноос хойш 20 жил	270 км

Эх сурвалж: Үндэсний хөгжлийн газар

Тавантолгойн дулааны цахилгаан станцын төсөл

Төслийн ач холбогдол:

- Оюутолгой уурхайн эрчим хүчний хэрэгцээг дотоодоос хангах: Оюутолгой уурхайн эрчим хүчний хэрэгцээг хангаж, валютын урсгалыг дотооддоо шингээх;
- Төсвийн эрчим хүчний системийн дутагдлыг нөхөх: Төвийн эрчим хүчний системд холбогдож дутагдлыг нөхөх, мөн тус системээр дамжуулан Тавантолгой уурхайн эрчим хүчний хэрэгцээг хангах.

Төслийн зорилт, хүрэх үр дүн:

- Тавантолгойн 450 МВт-ын дулааны цахилгаан станцыг холбогдох дэд бүтцийн хамт 2021-2024 онд барьж ашиглалтад оруулж, эрчим хүчний зориулалтын 1.4 сая тонн нүүрс нийлүүлж, дотоодын цахилгааны хэрэгцээг хангана.

Ажил эхлэх огноо: 2021 оны 2 дугаар улирал

Ашиглалтад орох огноо: 2024 онд

Нийт төсөвт өртөг: 808.2 сая ам.доллар

2021.10.30



Зураг 34. Тэвэнтолгой цахилгаан станцын 3D төлөвлөгөө

2021-03-19
 БҮРТГЭВ-02



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн "АБ-20" бизнес төлөвлөгөө

Кокс-эрчим хүчний үйлдвэрийн төсөл

Төслийн ач холбогдол:

- Нүүрсний гүн боловсруулалтыг нэвтрүүлж, хөгжүүлэх: Нүүрсийг гүн боловсруулснаар экспортын зорилтот зах зээл өргөжиж, Япон, БНСУ, БНХАУ-ын алслагдсан муж зэрэг зах зээлд металлургийн кокс, баяжуулсан нүүрсийг нийлүүлэх боломжийг бий болгоно.
- Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ: Коксын 4 төрлийн бүтээгдэхүүн болон дагалдан гарах эрчим хүчийг үйлдвэрлэж Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлнэ.

Төслийн зорилт, хүрэх үр дүн:

- 2025 оноос жилд 2 сая тонн кокс, 200 МВт суурилагдсан хүчин чадалтай цахилгаан үйлдвэрлэх Кокс-Эрчим хүчний үйлдвэрийн бүтээн байгуулалтыг эхлүүлнэ.

Төсөл хэрэгжүүлэх хугацаа: 2021-2025

Хөрөнгө оруулалтын төлөвлөсөн дүн: 445 сая ам доллар

2021.03.05

TAVAN
 ЭРДЭНЭ
 ТЭВАН
 ТӨЛӨӨ
 ХК

МХБ-ийн гишүүн
 Элсрэгтэй
 Бюмер дугаар
 БНМБГ
 УЦХ ХК
 111520/047 & 2452482



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн "А6-20" бизнес төлөвлөгөө

3.5.3. Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн нүүрсний үнийн төсөвлөл

Өмнө дурдсанчлан нүүрсний үнэ гадаад хүчин зүйлс болон дотоод хүчин зүйлсээс шалтгаалж тогтдог. Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн нүүрсний үнэ бүрдэхэд ихээхэн нөлөөлөл үзүүлдэг хүчин зүйлүүдийн нэг нь тээврийн зардал байдаг. Одоогийн байдлаар тээврийн зардал ихээхэн өндөр байгаа нь хамгийн түрүүнд шийдвэл зохих тулгамдсан асуудал болоод байгаа ба энэхүү асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд төмөр замын төслүүд хэрэгжүүлж байна.

Төлөвлөгөө ёсоор 2021 онд Зүүнбаянгийн төмөр зам, 2022 оны 3 дугаар улиралд Гашуунсухайтын төмөр зам ашиглалтад орсноор нүүрсний үнэд зөргээр нөлөөлөх хүлээлттэй. Нүүрсний үнийн таамаглал гаргахад "Фенвэй Энержи"-ийн гаргасан үнийн таамаглал болон авто зам, төмөр замууд ашиглалтад орохоор гарах өгөөжийг (тээврийн зардал буурна) давхар тооцсон болно.

Хүснэгт 46. Нүүрсний үнийн төсөвлөл, ам.доллар/тн (FCA Уурхай ам)

Огноо	Коксжих нүүрс	Чанар муутай коксжих нүүрс	Зөөлөн коксжих нүүрс	Угаасан коксжих нүүрс	Эрчим хүчний зориулалттай нүүрс
2021	54.8	46.3	43.8	-	7.8
2022	57.1	48.5	45.6	-	12.0
2023	64.2	54.6	51.4	93.5	20.8
2024	62.3	52.9	49.8	91.0	19.8
2025	60.4	51.4	48.3	88.5	18.8

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн "А6-20" бизнес төлөвлөгөө

Хүснэгт 47. Нүүрсний үнийн төсөвлөл, ам.доллар/тн (DAP Гатмод)

Огноо	Коксжих нүүрс	Чанар муутай коксжих нүүрс	Угаасан зөөлөн коксжих нүүрс	Угаасан коксжих нүүрс	Эрчим хүчний зориулалттай нүүрс
-	-	-	-	-	-




2022	80.1	68.1	-	-	29.0
2023	91.2	77.5	92.2	115.2	37.8
2024	89.3	75.9	90.6	113.3	36.8
2025	87.4	74.3	89.1	111.4	35.8

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн "А6-20" бизнес төлөвлөгөө

Нэмэлт тайлбар:

1. Үнийн таамаглал гаргахад 2022 онд параллель авто зам, 2023 оны 1 дүгээр улирлаас төмөр зам ашиглалтад тус тус орно гэж тооцсон болно.
2. ТТ-Ганцмод чиглэлийн төмөр замын зардал ойролцоогоор 10 ам.доллар байхаар тооцоолсон.
3. Параллель авто зам ашиглалтад орж нүүрсийг чингэлэгтэй машинаар чиргүүлтэй тээвэрлэж эхэлснээр тээврийн зардал 5 ам.доллараар, 2023 оноос төмөр замаар тээвэрлэж эхэлснээр тээврийн зардал нэмж 10 ам.доллараар буурах боломжтой гэж үзсэн.

Зураг 36. Үнийн таамаглалын хэлбэлзэл



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн "А6-20" бизнес төлөвлөгөө

Жич: Нүүрсний үнийн таамаглал гаргахад олон улсад ашиглагддаг жишгийн дагуу дээд үнэ, доод үнэ зэргийг гаргаад дээд доод үнийн дунджаар бодит үнийг тооцсон болно. Иймд дээрх хүснэгтэд харуулсан үнэ дээшээ/ доошоо 10 хувиар хэлбэлзэх магадлалтай болохыг анхаарах нь зүйтэй.

3.5.4 Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн Борлуулалтын төлөвлөгөө

Төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилт, Цанхийн уурхайн уул техникийн нөхцөл байдлаас шалтгаалж 2021-2025 онд үнэт цаас гаргагч нь 3, 4-р давхраасын сайн чанарын коксжих нүүрс, 0, 5, 7, 8, 9-р давхраасуудын зөөлөн коксжих чанартай нүүрс, исэлдсэн нүүрс болон баяжуулсан нүүрсийг зах зээлд нийлүүлнэ.

Зураг 37. Дунд хугацааны борлуулалтын төлөвлөгөө (сая.тн)

	2021 (f)	2022 (f)	2023 (f)	2024 (f)	2025 (f)	Нийт
Нийт борлуулалтын хэмжээ, сая.тонн	21.12	28.02	33.18	43.41	46.90	172.64
Баруун Цанхи	7.67	12.00	13.24	16.78	19.80	69.49
Зүүн Цанхи	11.64	11.80	11.46	13.28	13.94	61.12
Бортзэг	1.81	4.22	8.48	13.35	13.17	49.03

Handwritten signature and red stamp of the company.

Handwritten signature and red stamp of the company.

Нийт борлуулалтын орлого, сая \$	921.7	1,561.1	2,286.8	2,892.3	3,080.5	10,742.4
Баруун Цанхи	356.0	710.9	996.8	1,214.1	1,416.0	4,693.8
Зүүн Цанхи	505.6	682.0	857.3	954.1	972.1	3,971.1
Бортээг	60.10	168.2	432.7	724.1	692.4	2,077.5

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн "А6-20" бизнес төлөвлөгөө

Нүүрс баяжуулах үйлдвэрийн эхний 10 сая тонн хүчин чадалтай модулийг 2024 оноос ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна. Баяжуулсан нүүрсний хувьд эхний жилдээ 3, 4, 5-р давхраасуудын хатуу коксжих нүүрс 0, 1, 2-р давхраасуудын зөөлөн коксжих нүүрсийг боловсруулах ба цаашид 7, 8, 9, 10-р давхраасуудын зөөлөн коксжих нүүрс, исэлдсэн нүүрсийг угаах үйлдвэрт боловсруулж, зах зээлд нийлүүлнэ.

Бортээг уурхайгаас олборлох нүүрсийг 2021 оноос хуурай баяжуулах технологиор, 2024 оноос нүүрс баяжуулах үйлдвэрт боловсруулж, зах зээлд нийлүүлнэ. Зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан тооцсон жигнэсэн дундаж үнээр 2021-2025 онд компани нь 10.74 тэрбум ам.долларын мөнгөн орлоготой ажиллахаар төлөвлөсөн.

Зураг 38. Борлуулалтын гэрээний торон

	2021 (f)	2022 (f)	2023 (f)	2024 (f)	2025 (f)	Нийт
Урт хугацаат тогтвортой гэрээний борлуулалт	57%	56%	52%	49%	48%	52%
Чалко	32%	26%	22%	19%	18%	23%
ТТ-ГС төмөр замын санхүүжилт	15%	15%	15%	10%	0%	11%
Бусад	10%	15%	15%	20%	30%	18%
Бусад гэрээний борлуулалт	43%	44%	48%	51%	52%	48%

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн "А6-20" бизнес төлөвлөгөө

Компани нь дунд хугацаанд буюу 2021-2025 онд нийт 172.64 сая тонн нүүрс борлуулах төлөвлөгөөтэй ажиллаж байна. Үүнээс Цанхийн баруун уурхайгаас 69.49 сая тонн, Цанхийн зүүн уурхайгаас 62.12 сая тонн, Бортээгийн уурхайгаас 41.03 сая тонн нүүрсийг борлуулахаар төлөвлөсөн.

Өнөөгийн байдлаар Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн нүүрс тээвэрлэлтийн өртөг зардал хэт өндөр, хэлбэлзэл ихтэй байгаа нь нүүрсний үнэд нөлөөлж, Тавантолгой ордоос тээвэрлэсэн нүүрс зах зээлд өрсөлдөхүйц үнээр хүрч чадахгүй байгаа ба энэ байдал нь Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замууд ашиглалтад орох хүртэл үргэлжлэхээр байна.

Дунд хугацаанд Тавантолгой-Зүүнбаян, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам болон авто зам, Тавантолгой-Ханги чиглэлийн авто зам тус тус ашиглалтад орно. Улмаар нүүрс экспортлох дэд бүтцийн хүчин чадал нэмэгдэж зорилтот зах зээлд нийлүүлэх, нүүрсний борлуулалтыг БНХАУ-ын нүүрсний зах зээлийн гол бүс болох Хэбэй, Жиангсу, Шаньдун, Хэйлунжиан болон Шиньжан зэрэг мужууд руу чиглүүлнэ. Мөн төмөр замуудыг ашиглан гуравдагч зах зээлд тэр дундаа БНЭУ, БНСУ, Япон улс руу нүүрсний экспортыг эхлүүлэх төлөвлөгөөтэй.

Өнгөрсөн хугацаанд гуравдагч зах зээлд нүүрс нийлүүлэх чиглэлээр судалгааны ажлууд хийгдсэн. Тухайлбал, Япон улсын томоохон гангийн үйлдвэрт нийлүүлэх өртөг, зардлын судалгаа, тээвэрлэлтийн маршрут зэрэг багтана. БНЭУ руу нүүрс экспортлох туршилтын

Тавантолгой ХХК
Урьдчилсан
ТЭГЖ

Тавантолгой ХХК
Урьдчилсан
ТЭГЖ

2021.10.30

ажлыг эхлүүлэх хүрээнд 2020 оны 12 дугаар сард Тавантолгой ордоос олборлосон нүүрсний дээжийг тус улсын томоохон гангийн үйлдвэрүүдэд хүргүүлээд байна. 2021 оны I улиралд БНЭУ-ын гангийн үйлдвэрийн техникийн шинжилгээнд зориулж нэг тонн нүүрсний баяжмалын дээжийг илгээнэ. Үүний үр дүнд үндэслэн цаашид хамтын ажиллагааны хэлбэрийг тодорхойлно. БНЭУ-ын коксжих нүүрсний эрэлт дунд хугацаанд 15-20 сая тонноор нэмэгдэх төлөвтэй байгаа ба үүний 50-иас дээш хувийг Тавантолгой ордоос авах сонирхлоо Засгийн газрын түвшинд илэрхийлээд байна.

Нүүрс тээвэрлэлтийн одоогийн байгаа чиглэл:

1. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн авто зам (18-20 сая тонн)
2. Тавантолгой-Чойр чиглэлийн авто зам (18-20 сая тонн)

Дунд хугацаанд нүүрс тээвэрлэлтийн нэмэгдэх чиглэл:

1. Гашуунсухайт-Тавантолгой чиглэлийн авто зам
2. Тавантолгой-Ханги чиглэлийн авто зам
3. Тавантолгой-Цагаандэл-Уул чиглэлийн авто зам
4. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам
5. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам

Эдгээр нүүрс тээвэрлэлтийн чиглэлүүд нэмэгдсэнээр Гашуунсухайт-Ганцмод, Замын-Үүд-Эрэн, Ханги-Мандал, Цагаандэл-Уул-Өлзий, Алтанбулаг-Хиагт боомтуудаар нүүрс экспортлох дэд бүтцийн хүчин чадал бий болно.

Зураг 39. Дунд хугацааны нүүрс борлуулалт, экспортын төрөл

№	Тээврийн төрөл/чиглэл	Нөхцөл	Боомт/зах зээл
Авто замаар			
1	Тавантолгой - Гашуунсухайт	FCA, DAP	БНХАУ-ын Ганцмодны боомт
2	Тавантолгой - Ханги	FCA, DAP	БНХАУ-ын Мандула боомт
3	Тавантолгой - Цагаандэл - Уул	FCA, DAP	БНХАУ-ын Өлзий боомт
Төмөр замаар			
1	Тавантолгой - Гашуунсухайт	DAP+	БНХАУ-ын Ганцмодны боомт
2	Тавантолгой - Зүүнбаян	DAP+	БНХАУ-ын Эрэн боомт ОХУ-ын Хиагт боомт

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн "А6-20" бизнес төлөвлөгөө

Цаашид борлуулалтын хэмжээг нэмэгдүүлэхдээ дараах нөхцөлүүдийг ашиглаж экспортын үр ашгийг нэмэгдүүлнэ. Үүнд:

1. Цагаанхадны гаалийн хяналтын бус /Говь-Повер/-ээр дамжуулж экспортлох:
 - Өөрийн эзэмшлийн гаалийн хяналтын бүсийг ашиглах нь уурхайн нүүрсний овоолгын менежментийг оновчтой байдлаар зохицуулахад онцгой ач холбогдолтой.
 - Хадгалалт, ачилт буулгалтын зардал буурснаар эрчим хүчний нүүрсний борлуулалтыг дэмжиж тээвэр ложистикийн өртгийг бууруулна.

2. Төмөр замын тээвэрлэлтийг эхлүүлж Ганцмодны нүүрсний агуулахаас бүтээгдэхүүнээ борлуулснаар ахиуц ашиг хүртэнэ.

Борлуулалтын орлого, хэмжээ нэмэгдэх нөхцөл бүрдэнэ.

ЭРДЭНЭС
ТАВАН
ТОЛГОЙ
ХК
100

МОНГОЛЫН ХОСЭНГЭЖИЛ БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
1115 05447 2 007460

2021.03.05



3. Эцсийн хэрэглэгчидтэй хамтран ажиллана.

➤ Тогтвортой нийлүүлэлт, урт хугацааны хамтын ажиллагаа шинэ түвшинд хүрнэ.

Дунд хугацаанд нүүрсний борлуулалтын хувьд дараах байдлаар ажиллана.

- Чалко компанитай 2011 онд байгуулсан урт хугацаат гэрээний үндсэн хугацаанд 2022 онд хүртэл Цанхийн уурхайгаас олборлосон нийт бүтээгдэхүүн (исэлдсэн, зөвлөн коксжих болон коксжих чанартай нүүрс)-ийн 80%-ийг нийлүүлэх ба нэмэлт 5 жилийн хугацаанд 2027 он хүртэл 60%-ийг нийлүүлэх.
- Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад шаардлагатай хөрөнгийн санхүүжилтийг нүүрс урьдчилан борлуулах замаар болон бусад эх үүсвэрээр санхүүжүүлэхээр "Эрдэнэс-Тавантолгой" ХК болон "Бодь Интернэшнл" ХХК нь 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр санхүүжилтийн гэрээний хавсралтаар "Нүүрс нийлүүлэх гэрээ" байгуулсан ба энэхүү гэрээний хүрээнд 2021-2024 онд 11.44 сая тонн орчим нүүрсийг нийлүүлэх.
- Тавантолгой ордоос олборлосон нүүрсийг Ханги-Мандал боомтоор дамжуулан БНХАУ-ын зах зээлд экспортлох зорилгоор Тавантолгой-Ханги чиглэлд хатуу хучилттай авто зам байгуулж буй БНХАУ-ын Глори Таун компанитай 2020 онд байгуулсан 3 жилийн хугацаатай нүүрс худалдах, худалдан авах гэрээний хүрээнд 2023 он хүртэл 5.5 сая тонн нүүрс нийлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.
- Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын шаардлагатай хөрөнгийн санхүүжилтийг нүүрс урьдчилан борлуулах замаар болон бусад эх үүсвэрээр санхүүжүүлэх чиглэлээр ажиллана.
- Бусад гэрээнүүдийг сонгон шалгаруулалтын болон шууд гэрээ байгуулах зарчмаар зохион байгуулж, нүүрсний салбарт тогтвортой үйл ажиллагаа явуулах чадамж бүхий, ил тод, нээлттэй компаниудтай нүүрсийг тогтмол нийлүүлэх нөхцөлтэйгөөр хамтран ажиллана.

Зураг 40. Нийт борлуулалтын орлогын задаргаа

	2021 (f)	2022 (f)	2023 (f)	2024 (f)	2025 (f)	Нийт
Нийт борлуулалт	100%	100%	100%	100%	100%	100%
Хатуу коксжих	70%	62%	41%	43%	20%	14%
Бусад давхраас	29%	30%	42%	44%	46%	55%
Исэлдсэн /эрчим хүчний нүүрс/	2%	3%	4%	4%	4%	4%
Баяжмал /Хуурай, нойтон/	0%	4%	9%	6%	25%	24%
Завсрын нүүрс /Хуурай, нойтон/	0%	1%	4%	2%	4%	4%

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн "А6-20" бизнес төлөвлөгөө

Тавантолгой ордын уул, технологийн нөхцөл байдлаас шалтгаалан дунд хугацаанд хатуу коксжих чанартай 5-р давхраас, зөвлөн коксжих чанартай 0, 7, 8-р давхраасуудын нүүрсийг олборлох ба эдгээр нүүрс нь өртөг зардал, тээврийн зардлаас шууд хамаарч ашиг, алдагдал нь тодорхойлогддог.

Дунд хугацаанд үйлдвэр, дэд бүтцийн төсөл хөтөлбөрүүдийн бүтээн байгуулалт дуусч, 2022 оноос Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам, 2024 оноос нүүрс баяжуулах үйлдвэр ашиглалтад орсноор компанийн борлуулалтын үйл ажиллагаанд зэрэг нөлөө үзүүлж, дээр дурдсан давхраасуудын нүүрсийг 2024 оноос нүүрс баяжуулах үйлдвэр ашиглалтад орох үед боловсруулж, борлуулах боломж



2021.02.18

Тухайлбал дунд хугацаанд нэрлэсэн 2 чиглэлийн төмөр зам ашиглалтад орсноор, исэлдсэн нүүрс болон, бусад давхраасын зөөлөн коксжих нүүрсийг төмөр замаар тээвэрлэж, өртөг зардлыг бууруулж, ашгийг нэмэгдүүлж, цаашид олон улсын худалдааны FCA нөхцөлөөс гадна DAP нөхцөлөөр борлуулах нөхцөл бүрдэнэ.

Исэлдсэн нүүрсний хувьд өнгөрсөн хугацаанд нийт борлуулалтын 1-2%-ийг эзэлж байсан нь тээвэрлэлтийн өртөг, зардалтай шууд холбоотой ба дунд хугацаанд шинэ авто зам, төмөр замууд ашиглалтад орсноор исэлдсэн/эрчим хүчний болон бусад давхраасын зөөлөн коксжих нүүрсийг зах зээлд өрсөлдөхүйц үнээр нийлүүлэх боломж бүрдэх ба 2023 оноос нийт исэлдсэн/эрчим хүчний болон зөөлөн коксжих чанартай нүүрсийг 100% хүртэл төмөр замаар тээвэрлэж, тээвэрлэлтийн өртгийг бууруулж, борлуулах төлөвлөгөөтэй ажиллана.

3.5.5 Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн орлого, ашгийн төлөвлөгөө

"Эрдэнэс-Тавантолгой" ХК нь 2021-2025 онд 186.1 сая тонн нүүрс олборлож, 172.6 сая тонн борлуулж, нийт 10,742.4 сая ам.долларын орлоготой, 3,664.4 сая ам.долларын цэвэр ашигтай ажиллаж, улсын төсөвт 2,482.1 сая ам.доллар төвлөрүүлэх зорилго тавин ажиллаж байна.

График 16. 2021-2025 оны төлөвлөгөө /сая ам.доллар/



Эх сурвалж: Үнэт цаас гаргаагчийн бизнес төлөвлөгөө

Компанийн үйл ажиллагааны зардалд 5,586.9 сая ам.долларыг зарцуулах төлөвлөгөөтэй байгаа бөгөөд нийт зардлын 85.8%-ийг олборлолтын зардал, 4.1%-ийг үйл ажиллагааны тогтмол зардал, үлдсэн 10.1%-ийг баяжуулах болон төмөр замын тээвэрлэлтийн зардал эзэлж байна.

Хүснэгт 48. Үнэт цаас гаргаагчийн 2021-2025 оны орлого, ашгийн төлөвлөгөө

Үзүүлэлт	Нэгж	2021	2022	2023	2024	2025	Нийт
Нийт борлуулалтын орлого	сая \$	921.7	1,561.1	2,286.8	2,892.3	3,080.5	10,742.4
Цанхийн баруун уурхай	сая \$	356.0	710.9	996.8	1,214.1	1,416.0	4,693.8
Цанхийн зүүн уурхай	сая \$	505.6	682.0	857.3	954.1	972.1	3,971.1
Бортээгийн уурхай	сая \$	60.1	168.2	432.7	724.1	692.4	2,077.5
Үйл ажиллагааны зардал	сая \$	632.8	849.0	1,085.4	1,452.5	1,522.8	5,542.6



Цанхийн баруун уурхайн хувьсах зардал	сая \$	229.4	337.1	415.5	507.9	580.8	2,070.4
Цанхийн зүүн уурхайн хувьсах зардал	сая \$	316.7	310.9	314.6	394.0	384.1	1,720.3
Бортээгийн уурхайн хувьсах зардал	сая \$	45.6	104.3	206.3	303.4	306.2	965.7
Баяжуулах зардал	сая \$	-	-	-	55.0	55.0	110.0
Үйл ажиллагааны тогтмол зардал	сая \$	41.2	43.3	45.4	47.7	50.1	227.7
Төмөр замын тээвэрлэлтийн зардал	сая \$	-	53.5	103.6	144.6	146.8	448.5
Хүү, татвар, элэгдэл хорогдлын өмнөх ашиг (EBITDA)	сая \$	288.8	712.1	1,201.4	1,439.8	1,557.6	5,199.8
EBITDA түвшин	сая \$	31%	46%	53%	50%	51%	46%
Элэгдлийн зардал	сая \$	14.1	16.1	21.9	26.5	32.1	110.73
Хүү, татварын өмнөх ашиг (EBIT)	сая \$	274.7	696.0	1,179.6	1,413.2	1,525.6	5,089.1
Хүүгийн зардал /Арилжааны банк/	сая \$	38.3	52.9	52.1	51.5	-	194.7
Татварын өмнөх ашиг	сая \$	236.4	643.1	1,127.5	1,361.8	1,525.6	4,894.3
ААНОАТ	сая \$	59.1	160.8	281.9	340.4	381.4	1,223.6
ЦЭВЭР АШИГ	сая \$	177.3	482.3	845.6	1,021.3	1,144.2	3,670.7

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн "А6-20" бизнес төлөвлөгөө

Үнэт цаас гаргагчийн бизнес төлөвлөгөөг Хэвсралт 49-өөс харна уу.

3.6. Техник эдийн засгийн үндэслэл

Эрдэнэс-Тавантолгой ХК нь 2011 онд Цанхийн Зүүн хэсгийн ашиглалтын ТЭЗҮ, 2012 онд Цанхийн баруун хэсгийн ашиглалтын ТЭЗҮ, 2012 оны АНУ-ын Norwest Corporation компанийн хараат бус техникийн тайланг, 2019 онд Бортээгийн ТЭЗҮ-ийг мэргэшсэн шинжээч, мэргэжилтнээр гүйцэтгүүлэн ажиллаж байна.

Түүнчлэн компаниас нөөцийн тайлан, хараат бус техникийн тайлан болон Цанхийн баруун, зүүн хэсгийн ашиглалтын ТЭЗҮ зэргийг шинэчлэн боловсруулахаар ажиллаж байгаа тухай мэдэгдсэн.

3.6.1. Зүүн Цанхийн ТЭЗҮ

Захиалагч: "Эрдэнэс Монгол" ХХК

Боловсруулсан: "Абсолютмайнинг" ХХК, "Эрдэнэс Монгол" ХХК, Уул уурхайн баг

Огноо: 2011 он

Баталгаажуулсан:

- Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2011 оны 04 сарын 08-ны өдрийн 02 дугаар дүгнэлт
- Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын 2011 оны 04 сарын 25-ны өдрийн 080 дугаар тушаал


- Хэвсралт 50. Тавантолгойн Цанхийн зүүн хэсгийг ашиглах уурхайн ТЭЗҮ 2011 он
- Хэвсралт 51. ТЭЗҮ-ийг баталгаажуулсан эрх бүхий этгээдийн шийдвэр
- Хэвсралт 52. Ашигт малтмалын тухай хуулийн 4.1.26-д заасан мэргэшсэн мэргэжилтэн, шинжээч болох тухай нотлох баримт

Нүүрсний нөөцийн тооцоо

ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ ХК
JSC

ХК-ийн гүйцүү
Алдеррагтер
Дорж Доржиев
БНМАУ-ын
ҮИХ ХК
1118205417 д. 2017.02

2021.03.02



Таван толгойн ордод 1978-1993 он хүртэлх хугацаанд үе шаттай явуулсан геологи хайгуулын ажлын нөөцийн тооцооны нэгтгэлд үндэслэн тодотгосон тооцоог хийж гүйцэтгэсэнээр Цанхи, Бортээгийн зүүн хэсгийн нийт нөөцийг А+В+С зэрэглэлээр 760.4 сая тонн байхаар үнэлсэн. Үүнээс А зэрэглэлээр 174.9 сая тонн, В зэрэглэлээр 493.4 сая тонн, А+В зэрэглэлээр 668.3 сая тонн, С зэрэглэлээр 82.1 сая тонноор тогтоосон байна. Мөн P₁ зэрэглэлээр тогтоосон баялгийг 219.4 сая тонноор үнэлсэн бөгөөд А+В+С+P₁ зэрэглэлээр нийт 969.9 сая тонноор байхаар тооцжээ.

Нүүрсний давхаргууд

Таван толгойн ордын Цанхийн зүүн хэсэг нь нүүрсгүй хурдас чулуулгийн нарийн үеүдээр зааглагдан салбарласан нүүрсний арван нэгэн давхаргаас (давхарга 0-оос давхарга Х хүртэл) тогтдог байна. Тэдгээрээс үйлдвэрлэлийн ач холбогдолтой давхарга нь 0, III, IV, VIII, IX болно.

Нүүрсний чанар

1999 онд Норвестийн судалгааны ажлын хүрээнд 1980-д онд өрөмдсөн хуучин цооногуудаар илэрсэн давхаргуудын ойролцоо 5 цооног өрөмдөн дээжийг Канадын Калгари дахь Лорин лабораторид шинжилжээ. Энэ ажлын хүрээнд өмнө нь БНМАУ болон ЗСБНХУ-ын лабораториудад хийгдсэн шинжилгээнүүдийн хариуг олон улсын стандартад тохируулан хөрвүүлэх ажлыг хийсэн байна.

2005 оны 4-р сард Мицуи корпорацийн нүүрсний хэсэг, Австралийн Жохарко Интернэйшнл компани болон Рунжи компаниудтай байгуулсан гэрээний дагуу Жохарко компани Таван толгойн нүүрсний орд газарт судалгаа явуулж, таван толгойн орд газар дээр бага диаметртэй цооног өрөмдөж кернүүдэд шинжилгээ хийсэн байна. Үүний хүрээнд 700 гаруй килограмм дээж Австралийн баталгаатай шинжилгээний лабораторид илгээж 1999 онд Норвестийн хийсэн судалгааны дүнтэй харьцуулсан дүгнэлт гаргажээ.

Хүснэгт 49. Норвест, Жохарко харьцуулалт 1

Давхарга	Норвест Үнс, %	Жохарко Үнс, %	Норвест ҮМ, %	Жохарко ҮМ, %	Норвест FC, %	Жохарко FC, %
IX	26.05		26.41		44.0	
VIII	21.69	22.6	26.63	28.6	48.6	47.5
IV	17.74	23.4	26.48	24.6	54.0	50.5
III	10.96	15.7	24.18	22.4	62.3	60.4
0	28.12		20.89		48.2	

Давхарга	Норвест S, %	Жохарко S, %	Норвест к.Кал	Жохарко к.Кал	Норвест P, %	Жохарко P, %
IX	0.82		5506		0.01	
VIII	1.22	0.99	6077	6042	0.06	0.055
IV	0.77	0.87	6664	6266	0.04	0.043
III	0.56	0.48	7336	7105	0.04	0.038
0	0.83		5764		0.02	

Хүснэгт 50. Норвест, Жохарко харьцуулалт 2



Семифузинит Мацерал Инерт Семифузинит

2021.03.03



ЭРДЭНЭС

0000130

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE

2021-03-19

БҮРТГЭВ-02

III	1.19 (Норвест) 1.18 (Жохарко)	15.1	0.9	22.7	
IV	1.06 (Норвест) 1.06 (Жохарко)	15.2	0.3	22.8	
VIII	0.95 (Норвест) 0.96 (Жохарко)	14.2	1.5	21.5	1.5

Хүснэгт 51. Норвест, Жохарко харьцуулалт 3

Үнсний Анализ	2005	1999	2005	1999	2005	1999
	Жохарко Давхарга III	Норвест III	Жохарко Давхарга IV	Норвест IV	Жохарко VIII	Норвест VIII
SiO ₂	55.7	55.9	61.0	65.3	54.4	56.8
Al ₂ O ₃	25.1	27.7	18.0	19.4	23.5	24.3
FeS, O	3.6	2.56	8.4	19.4	4.7	6.11
CaO	4.4	3.25	3.8	1.89	7.0	3.76
MgO	2.4	1.05	1.50	0.71	3.70	1.64
Na ₂ O	0.45	0.89	0.33	0.67	0.25	0.73
K ₂ O	1.10	0.9	0.99	0.93	0.55	0.57
TiO ₂	1.4	1.03	1.0	0.58	1.1	0.5
Mn ₂ O ₄	0.06	0	0.19	0.092	0.11	0.092
SO ₃	2.9	1.13	1.80	5.16	1.20	5.16
P ₂ O ₅	1.2	1.74	1.5	0.75	1.4	0.75
SrO	0.27		0.16		0.36	
BaO	0.14		0.08		0.09	

Хүснэгт 52. Норвест, Жохарко харьцуулалт 4

Давхарга Гарц	III дээд	III доод	IV	VIII
1999 Норвест	77.0	84.1	78.5	55.5
Жохорка (3% хольц)	77.3	85.4	77.7	63.8
Зөрүү (%)	+0.3	+1.3	-0.8	+8.3

Мицуй компанийн судалгааны ажлын гол дүгнэлтүүд:

- Норвест болон Жохоркагийн хийсэн шинжилгээний үр дүнд Таван толгойн ордоос олборлож баяжуулсан нүүрс нь сайн чанарын хатуу коксжих нүүрс болно.
- Норвест болон Жохоркагийн хийсэн шинжилгээний дүнгээр Таван толгойн ордоос баяжуулсан нүүрсний дээжүүд хоорондоо төстэй Ромакс буюу витринитийн гэрэл ойлгох чадварын хэмжээ зааж, коксжих маш сайн шинж чанар агуулж байна.

1999, 2005 онуудад хийгдсэн шинжилгээгээр нүүрсний үнсний найрлага, чанарын үзүүлэлтүүд хоорондоо бага зэрэг зөрж байгаа боловч нүүрсний зэвэглэлийн хувьд зах зээлийн шаардлага хангах талаар ноцтой өөрчлөлт гарахгүй.



2021-03-19



ЭРДЭНЭС

0000131

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE

БҮРТГЭВ-02

Тавантолгойн нүүрсний бүтээгдэхүүн дэх үнсний шинж чанарыг хэрэглэгчийн шаардлагаас өөрчилж болох боловч Жохаркогийн боловсруулалтаас үзэхэд үнсний хэмжээ нь хатуу коксжих нүүрсний чанарын шаардлагад хүрээд байна.

- Нүүрсний дэгдэмхий чанар, хүхэр, фосфорын агуулга нь энэ төрлийн нүүрсний хувьд дундаж хэмжээнд байна.
- Үнсний шинжилгээний үр дүнгээр бүтээгдэхүүн дэх СаО болон төмрийн хэмжээ бага гарсан нь коксжих нүүрсний чанар нь зах зээлийн өндөр үзүүлэлттэй бүтээгдэхүүн үйлдвэрлэгдэх боломжийг илтгэж байна.
- Тавантолгойн ордын нүүрсний хүхрийн хэмжээ нь нийт давхаргуудын хэмжээнд 0.8-аас доош хувьтай байгаа нь коксжих нүүрсний хувьд боломжтой дээд үзүүлэлт юм.

Уурхайг ашиглах стратеги

Өмнө хийгдсэн судалгааны ажлуудын тайлан, дүгнэлт, уул уурхайн салбарын эрдэмтэн судлаачдын өгсөн санал зөвлөмж, урьд хийгдсэн зураг төслүүдийн ололттой талуудыг судалсаны үндсэн дээр уулын ажлын төлөвлөлтөнд дараах стратегийг баримталж ажиллахаар тусгажээ. Үүнд:

Схем 9. Зүүн Цанжийн уурхайг ашиглах стратеги

	Ашиглалтын нөхцөл: Ил уурхай		Хүчин чадлыг тогтвортой нэмэгдүүлж жилийн 15 сая тоннд хүргэх
	Ашиглалтын хугацаа: 30 жил		Бүтээгдэхүүн: - Коксжих нүүрс - Эрчим хүчний нүүрс
	Хөрс хуулалтын коэффициентийг ашиглалтын нийт жилүүдийн хугацаанд тогтвортой байлгах		

Уулын ажлын төлөвлөлт


Уурхайн ашиглалтын нийт хугацааг хамарсан, тухайн жилд аль доголлуудад ашиглалт явуулахыг тодорхойлсон дэлгэрэнгүй календарьчилсан төлөвлөгөөг программ хангамж ашиглан хийж гүйцэтгэсэн байна. Уг төлөвлөлтийг хийхдээ дараах үндсэн шалгуур үзүүлэлтүүдийг харгалзаж үзжээ. Үүнд:

- Хүчин чадлыг аажмаар нэмэгдүүлж 5 дахь жилээс 15 сая т/жил-д хүргэх;
- Хөрс хуулалтын коэффициентийг ашиглалтын нийт жилүүдэд харьцангуй тогтвортой, дунджаар 3.2 тн/м³ түвшинд байлгах;
- Хөрс хуулалтыг эхний жилүүдэд бага, коксжих нүүрсний олборлолтын хэмжээг их, дэд бүтэц ба тоног төхөөрөмжийн хэрэгцээ шаардлагыг бага байлгах үүднээс уулын ажлын "Эрдэнэс МГЛ" ХХК-ийн одоо ашиглалт явуулж буй талбайд

ТАВАН эхлүүлэх.



2022.03.26



Хүснэгт 53. Уулын ажлын хэмжээ олборлолтын жилүүдээр

Үе шат	Үе шатанд хамаарах жил	Олборлолт /мян.тн/	Хөрс хуулалт /мян.м³/	Хөрс хуулалтын коэффициент
I	1	1,000	3,300	3.30
II	2	3,000	10,300	3.43
III	3	6,000	20,600	3.43
IV	4	10,000	43,000	4.30
V	5	15,000	48,000	3.20
VI	6-10	75,000	245,000	3.27
VII	11-15	75,000	245,000	3.23
VIII	16-20	75,000	234,000	3.12
IX	21-25	75,000	230,000	3.07
X	26-30	75,000	226,100	3.01

Баяжуулах үйлдвэрийн төлөвлөлт

Баяжуулах үйлдвэрийг 4 дэх жилээс ашиглалтад оруулахаар төлөвлөсөн бөгөөд баяжуулах үйлдвэрийн эцсийн бүтээгдэхүүний жинлэсэн дундаж гарц 66.94 хувь байхаар тооцжээ.

Хүснэгт 54. Уулын ажлын хэмжээ олборлолтын жилүүдээр

Төрөл	Нэгж	Жил 4	Жил 5	Жил 6-10	Жил 11-20	Жил 21-30	Дүн	Гарц %
Олборлох нүүрс	мян.тн	10,000	15,000	75,000	150,001	149,999	400,000	
Коксжих нүүрс	мян.тн	3,084	4,222	28,901	55,218	47,811	139,239	34.81%
Хагас зөөлөн коксжих нүүрс	мян.тн	0	0	0	4,999	21,480	26,480	6.62%
Эрчим хүчний нүүрс	мян.тн	4,590	4,053	20,133	43,058	30,185	102,021	25.51%
Дүн	мян.тн	7,675	8,275	49,035	103,277	99,477	267,741	66.94%

Тавантолгойн ордын Цанхийн зүүн хэсгийн уурхайн Нүүрс баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаар дараах бүтээгдэхүүнийг гарган авахаар төлөвлөсөн.

Хүснэгт 55. НБҮ-ээс гарах бүтээгдэхүүнүүд түүрийн эх үүсвэр

Бүтээгдэхүүн

Сайн коксжих нүүрс

Коксжих нүүрс

Дунд зэрэг коксжих нүүрс

Үнслэгийн хэмжээ, %

8-10

11-13

7-9

Давхарга

III, IV

O-C

VII, IX





Эрчим хүчний нүүрс
Завсрын бүтээгдэхүүн

17-21
Дунджаар 28-33



Нүүрсний тээвэр

Монгол улсын нийт төмөр замын урт нь 1,835 км байдаг. Үүнээс Сүхбаатар-Замын үүдийн гол шугам-1,110 км, Дархан-Шарын голын зам-62 км, Салхит-Эрдэнэтийн зам-164 км, Багаханга-Багануурын зам-95 км, Сайншанд-Зүүнбаянгийн зам-50 км, Эрээнцав-Баянтүмэнгийн зам-238 км тус тус урттай байна. Төмөр замын гол шугам Улаанбаатар-Замын үүдийн хэсгийн тээх чадвар нь жилд 15-19 сая тонн бөгөөд жилд явж байгаа ачааны хэмжээ 2011 онд 10-12 сая тонн хүрэх магадлалтай байна. Үүнээс гадна орд газруудаас нэмэгдэх 14-16 сая тонн ачааг тооцвол гол шугамаар тээх ачааны хэрэгцээ жилд 24-28 сая тонн буюу нэг зам бүхий шугамын тээх, нэвтрүүлэх дээд хүчин чадал хүрэлцэхгүй.

Иймд Монгол улсын засгийн газраас төмөр замын дэд бүтцийг шинээр барих чиглэлийг тогтоохдоо стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд газрууд, боловсруулах үйлдвэрүүдийн ачаа тээвэрлэлтийн эрэлт хэрэгцээг хангах, ашигт малтмалын эрэлт ихтэй зах зээлд хүргэх, нэг зах зээлээс хамааралгүй байдлыг хангах зорилготой бодлого боловсруулсан. Үүнд:

- ОХУ, БНХАУ-ын төмөр замын тээврийн сүлжээг ашиглан гуравдагч зах зээлд хүрэх далайн боомтуудын гарцтай болох;
- Төмөр замын нэвтрүүлэх чадвар дээшилж, уул уурхайн бүтээгдэхүүн, дамжин өнгөрөх ачаа тээвэр болон экспорт, импортын ачаа эргэлтийг үр дүнтэй хангах тээвэрлэлтийн оновчтой зохион байгуулалт бүхий төмөр замын дотоодын нэгдсэн сүлжээтэй болох;
- Ашигт малтмалын томоохон орд газруудтай төмөр замаар холбогдсон аж үйлдвэрийн цогцолбор байгуулах, ашигт малтмалыг боловсруулж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, эдийн засгийн эргэлтийг хангах, экспортыг дэмжих замаар дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх;
- Монгол улсын нутгаар дамжин өнгөрүүлэх чадавхийг нэмэгдүүлж, Ази-Европыг холбосон өрсөлдөх чадвартай транзит тээврийн шинэ замнал /коридор/ бий болгох.

ТЭЗҮ-д Таван толгойн ордыг Монголын төмөр зам (МТЗ)-тай холбох зураг төслийг хийж, барих, ашиглалтанд оруулахад 3 орчим жилийн хугацаа шаардлагатай гэж үзээд ашиглалтын эхний гурван жилд нүүрсийг Таван толгой-Гашуунсухайтын боомт хүртэлх хүнд даацын автомашины хатуу хучилттай замаар тээвэрлэхээр төлөвлөсөн. Энэ хугацаанд коксжих түүхий нүүрс борлуулах ба төмөр зам тавигдаж, нүүрс баяжуулах үйлдвэр ашиглалтанд орсоноор угаасан нүүрс борлуулж эхлэхээр тусгажээ.

Хөрөнгө оруулалтын задаргаа

Зүүн-Цанхийн төсөл хэрэгжих 30 жилийн хугацаанд нийт 1,357.7 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөсөн бөгөөд эхний 4 жилийн хөрөнгө оруулалт болох 735.3 сая ам.долларыг өөрийн хөрөнгөөр 185.78 сая ам.доллар, зээлээр 433.48 сая



0210307



ам.доллар (12.5%-ийн хүүтэй), үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээгээр 116.02 сая ам.доллараар тус тус санхүүжүүлэх бөгөөд 5 дахь жилээс үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээгээр 100 хувь санхүүжүүлэхээр тооцжээ.

Шаардагдах хөрөнгө оруулалт нь (1) уурхайн тоног төхөөрөмж (анхны хөрөнгө оруулалт болон цаашид гарах хөрөнгө оруулалтын зардлууд), (2) уурхайн дэд бүтэц, нүүрс баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмж, (3) уурхайн барилга байгууламжийн зардал гэсэн үндсэн 3 хэсэгт ангилагдаж байна.

Хүснэгт 56. Хөрөнгө оруулалтын зарцуулалт

	Нэгж	Дүн
Тоног төхөөрөмж	сая ам.доллар	902,248
Баяжуулах үйлдвэр, уурхайн дэд бүтэц, үйлдвэрийн тоног төхөөрөмж	сая ам.доллар	342,240
Уурхай байгуулах зардал	сая ам.доллар	113,175
Нийт	сая ам.доллар	1,357,663

Хүснэгт 57. Өөрийн хөрөнгөөр болон эзэнээр хийх санхүүжилтийн тооцоо

	Жил 1	Жил 2	Жил 3	Жил 4
Шаардагдах санхүүжилт				
Хөрөнгө оруулалт	65,826.91	238,278.90	169,515.13	210,621.36
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	1,252.73	49,779.63	(22,866.13)	(93,151.00)
Шаардагдах санхүүжилт	67,079.64	288,058.53	146,649.00	117,470.36
Санхүүжилтийн эх үүсвэр				
Өөрийн хөрөнгө /30%/	20,123.89	86,417.56	43,994.70	35,241.11
Зээл /70%/	46,955.75	201,640.97	102,654.30	82,229.25
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээнээс	-	-	22,866.13	93,151.00
ДҮН	67,079.64	288,058.53	169,515.13	210,621.36

Үр ашгийн тооцоо

Борлуулах 1 тонн коксжих нүүрсний үнэ нь төсөл хэрэгжих 30 жилийн хугацаанд дунджаар 145 ам.доллар, эрчим хүчний нүүрсний үнэ дунджаар 45 ам.доллар байхаар тооцоолсон. Бүтээгдэхүүний бүрэн өөрийн өртөг тонн тутамд дунджаар 68.8 ам.доллар байхаар тооцжээ. Цанхийн зүүн хэсгийн уурхайн үйл ажиллагааны шууд зардлыг уулын ажлын төлөвлөгөө, тоног төхөөрөмжийн сонголт, үйлдвэрлэлтийн хуваарь, тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацаа, ажиллах хүчний тоо зэргийг үндэслэн зардлын төрөл болон үйлдвэрлэлийн дамжлагаар тус бүр 30 жилийн дунджаар тооцоолжээ.

Хүснэгт 58. Нэгж бүтээгдэхүүнд ногдох шууд зардлын задаргаа /үйлдвэрлэлийн дамжлагаар/



Төрөл

Нэгж бүтээгдэхүүний зардал (ам.доллар/тонн)
Тогтмол зардал



2021.10.30



Цалин хөлс	0.63
Гэрээт ажил	0.04
Хуулийн дагуу төлөх татвар, төлбөр, хураамж	0.12
Уурхайн хаалтын зардал	0.02
Бусад	0.86
Хувьсах зардал	
Ус шүүрүүлэлт	0.27
Өрөм/тэсэлгээ	2.67
Хөрс хуулалт	9.11
Нүүрс олборлолт	2.46
Баяжуулалт	4.00
Хөдөлмөр хамгаалал	0.45
Засвар болон туслах тоног төхөөрөмж	0.85
Овоолго болон туслах үйлчилгээ	1.43
Нөхөн сэргээлт	1.06
Бүтээгдэхүүний шууд зардлын дүн	23.95

Дээрх тооцоог ашиглан мөнгөн урсгалын тооцоо болон өнөөгийн үнэ цэнийг дискаунтын хэд хэдэн түвшингээр тооцож үзэхэд Цанхийн зүүн хэсгийн уурхайг ашиглах нь үндсэн нөхцөлийн дагуу эдийн засгийн хувьд үр ашигтай гарсан.

Хүснэгт 59. Өнөөгийн мөнгөний үнэ цэнийн тооцоо

Хорогдуулах (дискаунтын) хувь	Төслийн ӨҮЦ (сая ам.доллар)
0%	9,495.7
12%	1,490.0
Өнөөгийн үнэ цэнэ	1,162.7
15%	1,031.5
16%	7,917.3
Өгөөжийн дотоод түвшин (IRR)	47.8%

Дүгнэлт

Зүүн Цанхийн 2011 оны техник эдийн засгийн үндэслэлийг хийж гүйцэтгэсэн "Абсолютмайнинг" ХХК, "Эрдэнэс Монгол" ХХК, уул уурхайн багийн зүгээс дараах дүгнэлтийг боловсруулсан байна. Үүнд:

- Монгол Улсын Их Хурлын 2010 оны 39-р тогтоолоор баталсан "Таван толгойн ордыг ашиглах зарим асуудлын тухай" тогтоолыг хэрэгжүүлэх, мөн Таван толгойн нүүрсний уурхайг хөгжүүлэх талаар Монгол Улсын Засгийн Газрын мөрийн хөтөлбөрт тусгасан бодлогыг үндэс болгож Таван толгойн нүүрсний орд газрыг цогц байдлаар хөгжүүлэн бүс нутгийн тогтвортой хөгжлийг хангах төсөл юм.
- Төслийн нийт хөрөнгө оруулалт 1,357 тэрбум ам.доллар байх бөгөөд үүнээс барилга байгууламж 455.4 сая ам.доллар, машин механизм, техник тоног төхөөрөмж 902.2 сая ам.доллар байна. Эхний дөрвөн жилд шаардагдах



2021.03.19



санхүүжилтийг өөрийн хөрөнгө болон жилийн 12.5% хүүгэй эзэл, авч санхүүжүүлэх бөгөөд хөрөнгө оруулалтаа 7 дахь жилдээ бүрэн нөхөх болно.

- Төслийг хэрэгжүүлэхэд сонгож авсан техник, төхөөрөмжүүдийн үнийг бууруулах боломжийг нарийвчлан судлах нь хөрөнгө оруулалтын зардлыг хэмнэх ур ашгийг нэмэгдүүлж эрсдэлийг бууруулах ач холбогдолтой.
- Энэ төсөл хэрэгжсэнээр улсын төсөвт татвар, хураамжаар 5.2 тэрбум ам.доллар, ногдол ашгаар 4.8 тэрбум ам.доллар оруулахаар байна. Таван толгойн ордын Цанхийн зүүн хэсгийн төсөл эхэлснээр шууд ажлын байр 815 бий болох ба үүний 10% хүртэлх ажилчдыг аймаг, орон нутгийн иргэдийг мэргэжлийн сургалтанд хамруулж ажиллуулна.
- Төслийн ашгийг жилийн 15 хувиар хорогдуулан, өнөөгийн мөнгөнд шилжүүлсэн цэвэр ашгаар тооцвол өнөөгийн үнэ цэнэ 1,031 тэрбум ам.доллар болж байна. Төслийн үргэлжлэх хугацаанд орж ирэх үйл ажиллагааны нийт бэлэн мөнгөний урсгал нь 9,495 тэрбум ам.доллар орчим болох бөгөөд энэ нь нийт борлуулалтын 33%-тай тэнцэнэ.
- Төслийг хэрэгжүүлснээр Монгол улсын нүүрсний экспортын хэмжээ төслийн хүчин чадлаа бүрэн эзэмшсэн үед 9-10 хүртэл сая тонноор буюу 2 дахин нэмэгдэх боломжтой байна.

3.6.2. Баруун Цанхийн ТЭЗҮ

Захиалагч: "Эрдэнэс -Тавантолгой" ХК
Боловсруулсан: Эм Эм Маркет ХХК
Огноо: 2020 он

- Хавсралт 53. Цанхийн баруун хэсгийг ашиглах уурхайн ТЭЗҮ 2020 он
- Хавсралт 54. Ашигт малтмалын тухай хуулийн 4.1.26-д заасан мэргэшсэн мэргэжилтэн, шинжээч болох тухай нотлох баримт

Нүүрсний нөөцийн тооцоо

Энэхүү Цанхийн баруун хэсгийг ашиглах ТЭЗҮ-ийн тодотголыг Тавантолгой чулуун нүүрсний бүлэг ордын MV-016881, MV-016882 тусгай зөвшөөрлийн талбайд хамаарах нөөцөд тулгуурлан гүйцэтгэсэн байна. Дээрх тусгай зөвшөөрлийн талбайнуудад хамаарах 1200 м-ийн түвшингээс дээшхи хэсгийн нийт цэвэр нүүрсний нөөцийн хэмжээ 952.5 сая тонн байгаагаас 758.3 сая тонныг коксжих нүүрс, 194.3 сая тонныг эрчим хүчний нүүрс эзэлж байна. Нийт нөөцийн 208.6 сая тонн нь баттай буюу А, 592.1 сая тонн нь В буюу боломжтой, 151.8 сая тонн нь С буюу боломжтой ангилалд тооцогджээ.

Нүүрсний давхаргууд

Таван толгойн ордын Цанхийн баруун хэсэг нь нүүрсгүй хурдас чулуулгийн нарийн үеүдээр зааглагдан салбарласан нүүрсний арван нэгэн давхаргаас (давхарга 0-оос давхарга XIII хүртэл) тогтдог байна.

Уурхайг ашиглах стратеги

Уурхайг ашиглах стратегид дараах стратегийг баримталж ажиллахаар тусгасан байна.



2021.03.19



Ашиглалтын нөхцөл:
Ил уурхай



Хүчин чадлыг тогтвортой нэмэгдүүлж
 жилийн **20 сая тонн**д хүргэх



Ашиглалтын хугацаа:
43 жил



Бүтээгдэхүүн:
 - **Коксжих нүүрс**
 - **Эрчим хүчний нүүрс**



Хөрс хуулалтын коэффициентийг ашиглалтын нийт
 жилүүдийн хугацаанд **тогтвортой байлгах**

Уурхайн ажлын төлөвлөлт

Цанхийн баруун хэсгийг ашиглах дарааллыг уурхайн хөрс хуулалтын дундаж хэмжээг баримтлан нүүрсний давхаргын тогтоц, уурхайн жилийн хүчин чадал, дотоод овоолго хийх боломж, уурхайн нөхөн сэргээлтийн технологи зэргийг үндэслэн тогтоосон байна.

2020-2022 онуудыг уулын ажлын өрнөлийн эхний үе шат, компани өөрсдийн хүчээр уулын ажлыг явуулж эхлэх, олборлосон нүүрсийнхээ 20-75%-ийг баяжуулан уурхайн ам нөхцлөөр борлуулах буюу дэд бүтцийн бүтээн байгуулалт бүрэн хийгдэх буюу 2023-2024 онуудыг 2-р үе шат, коксжих болон сул коксжих нүүрсээ бүрэн хэмжээнд баяжуулж, хилийн нөхцөлөөр борлуулах, үйл ажиллагаа бүрэн жигдрэх буюу 2025-2062 оныг 3-р үе шатанд тус тус хамааруулсан.

Хүснэгт 60. Уулын ажлын хэмжээ олборлолтын жилүүдээр

№	Ашиглалтын жилүүд	Хөрс хуулалт /сая.м3/	Олборлолт /сая.тн/	Хөрс хуулалтын коэффициент м ³ /тн
1	1	43.79	8.44	1.62
2	2	71.24	15.35	1.5
3	3	73.11	18.09	1.85
4	4	78.03	20.54	4.72
5	5	86.68	20.11	3.35
6	6-10	381.16	100.29	3.72
7	11-15	339.19	97.50	3.3
8	16-20	375.72	101.91	2.34
9	21-43	2,231.75	447.29	2.72
	Дүн	3,680.67	829.54	4.44

Баяжуулах үйлдвэрийн төлөвлөлт

Нүүрс баяжуулах үйлдвэрийн цогцолборыг байгуулахдаа хуурай болон нойтон аргын технологи бүхий бие даасан үйлдвэрийн шугамуудыг барьж байгуулан ашиглалтад оруулахаар төлөвлөсөн ба энэхүү төслийн хүрээнд тус бүр нь 3.0 сая тн/жил хүчин чадалтай хуурай аргын технологи бүхий ZM-600 үйлдвэрийн 2 шугам, тус бүр нь 5.0 сая тн/жил хүчин чадалтай нойтон аргын технологи бүхий үйлдвэрийн 4 шугамыг тус бүр

Handwritten signature and red stamp of ERDEN'S TAVAN TOLGOI LLC.

Handwritten signature and red stamp of ERDEN'S TAVAN TOLGOI LLC.

2021.03.28 10:30

ашиглалтад оруулах бөгөөд Цанхийн баруун хэсгийн ил уурхайн хүчин чадлын хүрээнд нойтон аргын технологи бүхий үйлдвэрийн 4-н шугамыг ашиглана.

Цанхийн баруун хэсгийн уурхайгаас олборлох нийт нүүрсний 50%-иас багагүй хэсгийг үнслэг өндөртэй сул коксжих нүүрс эзэлж байгаа бөгөөд эдгээр үнслэг өндөр, чулуулаг ихтэй нүүрсийг хуурай аргын ZM-600 үйлдвэрт нийлүүлэн баяжуулж, үнслэг чулуулгийн агуулгыг нь бууруулан нойтон аргын технологи бүхий үйлдвэрт гүйцээн баяжуулж, экспортын шаардлага хангах сул коксжих нүүрсний баяжмал үйлдвэрлэнэ.

Хүснэгт 61. Хуурай аргын үйлдвэрлэлийн мэдээлэл

Ашиглалтын хугацаа	Түүхий нүүрсний хэмжээ, тн	Түүхий нүүрсний илчлэг, ккал	ZM-600 төхөөрөмжийн бүтээгдэхүүн	Бүтээгдэхүүний илчлэг ккал
2021	1,645.4	5,610.2	677.5	7,158.2
2022	4,454.9	5,746.0	1,815.6	7,710.9
2023	6,121.1	5,698.8	2,494.9	7,657.1
2024	6,121.1	5,701.9	2,492.6	7,702.5
2025-2029	30,605.4	5,672.5	12,421.4	7,827.2
2029-2034	30,605.4	5,790.5	12,154.8	7,523.4
2035-2039	30,605.4	5,741.0	12,452.2	7,784.6
2040-2062	134,663.6	5,538.3	53,420.0	7,296.4
Нийт	244,822.2	5,627.2	97,929.1	7,467.6

Нойтон аргын технологи бүхий НБҮ-ийн 1-р шугамыг 2022 онд ашиглалтад оруулах бөгөөд үйлдвэрийн хүчин чадлыг жил бүр 5.0 сая тн-оор нэмэгдүүлж, 2025 онд сүүлийн 4-р шугамыг ашиглалтад оруулж, нийтдээ 20.0 сая тн түүхий нүүрс баяжуулах хүчин чадал бүхий НБҮ-ийн цогцолборыг бий болгохоор төлөвлөжээ.

Хүснэгт 62. Нойтон аргын үйлдвэрлэлийн мэдээлэл

Ашиглалтын хугацаа	Түүхий нүүрсний хэмжээ, тн	Түүхий нүүрсний илчлэг, ккал	Баяжмал /хатуу коксжих нүүрс/	Бүтээгдэхүүний илчлэг ккал
2022	3,330.6	5,874.8	2,038.1	7,150.9
2023	8,777.4	4,859.0	5,399.5	6,070.2
2024	7,359.0	6,046.5	4,607.3	7,038.9
2025-2029	39,040.2	5,675.9	23,110.6	7,354.3
2029-2034	43,935.4	5,823.4	25,016.8	7,960.1
2035-2039	31,612.1	5,645.9	17,618.5	8,029.3
2040-2062	213,824.7	5,896.1	122,389.1	7,972.1
Нийт	347,879.5	5,816.3	200,179.8	7,823.1

Нүүрсний тээвэр

Тавантолгой чулуун нүүрсний бүлэг ордын хэмжээнд одоогийн байдлаар Энержи ресурс ХХК-ийн ухаа худгийн нүүрсний ил уурхай болон Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн Цанхийн баруун болон зүүн хэсгийн ил уурхай, Тавантолгой ХК-ийн ил уурхай гэсэн нийт 4-н ил уурхайд олборлолтын ажил хийгдэж байгаа бөгөөд нүүрс тээврийг Тавантолгой-Гашуун сухайтын хатуу хучилттай авто замаар гүйцэтгэж байна. Тус автозамын төслийн хүчин чадал 18 сая тн нүүрс тээвэрлэх боломжтой боловч одоогийн бодит хүчин чадал 23 сая тн нүүрс тээвэрлэж байна. Эрдэнэс-Тавантолгой ХК нь уг замын нийт ачаа урсгалын 70%-д нь буку жилд 15 сая тн тээвэрлэх бүрэн боломжтой байна.

Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн албан ёсны хатуу хучилттай авто замаар гүйцэтгэж байна. Тус автозамын төслийн хүчин чадал 18 сая тн нүүрс тээвэрлэх боломжтой боловч одоогийн бодит хүчин чадал 23 сая тн нүүрс тээвэрлэж байна. Эрдэнэс-Тавантолгой ХК нь уг замын нийт ачаа урсгалын 70%-д нь буку жилд 15 сая тн тээвэрлэх бүрэн боломжтой байна.

Алсравчтар
МЭР. Д.Эрхман
"БНДСЕР"
УХАА
1115205447
1115205448

2021.03.26



Хөрөнгө оруулалт

Төслийн нийт хугацаанд 8,646.65 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай. Уурхайн хүчин чадлаа бүрэн эзэмших хүртэлх эхний 4 жилийн хугацаанд 3,378.63 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардагдахаар байна. Уг төсөл нь ашиглалтын дөрөв дэх жилээс бүрэн хүчин чадлаараа ажиллаж эхлэх бөгөөд үүнтэй холбоотойгоор 2022-2024 онуудад баяжуулах үйлдвэр, тэсрэх бодисын үйлдвэр, засвар механикийн төв, конвейерийн байгууламж, усан хангамжийн систем, цахилгаан эрчим хүч хангамжийн систем болон бусад байгууламжийн хөрөнгө оруулалт хийгдэнэ. Мөн уурхайн ахилт, тээврийн зайнаас хамаарч автосамосвалын тоо нэмэгдэх шаардлагатай болж байгаагаас уурхайн олборлолт, тээвэрлэлтийн техник тоног төхөөрөмж худалдан авах, парк шинэчлэх хөрөнгө оруулалт хийгдэнэ. Ашиглалтын 5-43 дахь жилүүдэд нийтдээ 5,269.23 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэнэ.

Үр ашгийн тооцоо

Цанхийн баруун хэсгийн уурхайн ашиглалтын зардлыг нь хөрс хуулалт, нүүрс олборлолт гэсэн үйлдвэрлэлийн процессуудын нийлбэр зардалд үндэслэн уурхайн хүчин чадлаа бүрэн эзэмших хүртэлх хугацааны тооцоог хүснэгтээр харуулав. Тав дахь жилээс үйл ажиллагаа тогтворжсоноор нэгж бүтээгдэхүүнд ногдох зардал тогтмол байна.

2021.03.26



СЭХ
2021.03.26 өдөр
БҮРТГЭВ
№ 01

0000140

ЭРДЭНЭС-ТАВАНТӨЛГӨЙ

Хэмжих нэгж	Хууль	Ашиглалтын жилүүд	Нийт								
Хэмжих нэгж	Хууль	V жил	VI-X жил	XI-XV жил	XVI-XX жил	XXI - XLIII жил	Нийт				
1	Нүүрс олборлолт	8,440	15,351	18,085	20,540	20,115	100,288	97,502	101,913	450,543	833
2	Бүтээгдэхүүн борлуулалт	8,440	14,620	15,483	16,059	14,723	65,512	62,744	64,501	292,088	534
2.1	Байжуулсан коксжих нүүрс		2,038	2,038	5,399	4,607	23,111	25,017	17,618	122,389,000	200
2.2	Байжуулсан сул коксжих нүүрс					3,148	27,476	24,284	34,901	97,564	187
2.3	Байжуулалтын завсрын бүтээгдэхүүн			0,167	0,432	0,684	5,368	5,280	6,225	23,284	41
2.4	Шууд борлуулах коксжих нүүрс	5,938	10,129	5,596							21,663
2.5	Шууд борлуулах сул коксжих нүүрс	0,433	1,241	3,337	7,689	1,352					14
2.6	Исэлдсэн болон эрчим хүчний нүүрс	2,069	3,249	4,353	2,539	4,932	9,557	8,164	5,757	48,860	9
3	Нийт борлуулалт орлого	977,397	1,992,242	2,028,831	3,152,929	2,924,117	15,351,298	16,507,291	17,923,110	131,055,958	181,913,174
4	Үйлдвэрлэлийн зардал	568,986	942,539	1,102,516	1,024,998	1,161,022	6,449,651	7,444,139	7,239,067	46,790,941	72,723,868
5	Үйлдвэрлэлийн ашиг (БО-ҮЗ)	408,401	1,049,703	926,315	2,127,931	1,763,095	8,901,647	9,063,153	10,684,043	84,265,017	119,189,305
6	Үйл ажиллагааны зардал	180,966	327,799	250,349	549,629	466,902	1,673,046	1,517,123	1,617,324	12,342,510	18,925,649
7	НГАТ буцаан олголт	48,224	80,891	84,132	49,871	59,024	330,423	366,418	365,213	2,333,898	3,719,094
8	Татварын өмнөх ашиг	276,659	2,795	760,098	1,628,174	1,355,216	7,559,023	7,912,447	9,431,932	74,256,404	103,982,750
	АННОАТ	68,265	199,799	189,125	406,143	337,904	1,885,258	1,973,612	2,353,483	18,559,601	25,973,187

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЛЭГ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2021-03-19
БҮРТГЭВ-02

ЭРДЭНЭС-ТАВАНТӨЛГӨЙ
JSC
Хүндэтгэсэн
2021.03.26

Хүндэтгэсэн
2021.03.26
БҮРТГЭВ-02

СЗХ
2021-03-16 өдөр
БҮРТГЭВ
№01

MONGOLIAN STOCK EXCHANGE
0000141
2021-03-19
БҮРТГЭВ-02

ЭРДЭНЭС-ТАВАНТӨЛГӨЙ ХК

ERDNES
TAVANTOLGOI
JSC
Цэвэр ашиг
11
Орон нутагтай
хилтэй ажиллах
зардал
12
Үйл ажиллагааны
мөнгөн урсгал
13
Үйл ажиллагааны
хуримтлагдсан
мөнгөн урсгал
14
Хөрөнгө
оруулалтын
зардал
15
Хөрөнгө
оруулалтын
дараах мөнгөн
урсгал
16
Хөрөнгө
оруулалтын
дараах
хуримтлагдсан
мөнгөн урсгал
17
Санхүүжилтын
мөнгөн урсгал
17.1
Зээлийн
орлого
17.2
Зээлийн
төлөлт
18
Нийт ашгийн
тувшин
19
Цэвэр ашгийн
тувшин
20
NPV (10%)
21
IRR
22
Хөрөнгө
оруулалтаа
нөхөх хугацаа


сая төг	208,394	602,997	570,974	1,222,030	1,017,312	5,673,763	5,938,835	7,078,449	55,696,803	78,009,562
сая төг	100	100	100	200	200	1,000	1,000	1,000	2,000	5,700
сая төг	213,080	618,797	610,518	1,386,208	1,199,174	6,624,043	7,218,835	3,045,512	60,568,074	86,484,251
сая төг	213,080	831,887	1,442,405	2,828,612	4,027,786	10,651,830	17,870,664	25,916,177	86,484,251	
сая төг	(92,915)	(443,676)	(737,981)	(2,104,055)	(403,813)	(151,869)	(1,048,940)	(63,778)	(3,599,521)	(8,646,647)
сая төг	120,175	175,121	(127,463)	(717,847)	795,261	6,472,174	6,169,895	7,981,734	56,968,554	77,837,604
сая төг	120,175	295,296	167,833	(550,014)	245,247	6,717,421	12,887,316	20,869,050	77,837,604	
сая төг			2,104,055							2,104,055
сая төг				334,029	372,682	1,397,344				2,104,055
%	28.30%	40.30%	37.50%	51.60%	46.30%	49.20%	47.90%	52.60%	56.70%	54.20%
%	21.30%	30.30%	28.10%	38.80%	34.80%	37.00%	36.00%	39.50%	42.50%	40.60%
сая төг										9,731,233
%										111.40%
жол										4.8

МАНГАЛАГАР КОД
МЭБ-ийн гишүүн
Андэсрайтэр
Бүлэг, дилрийн
УБНДИСК
ҮШ ХК
11520547-205
2021-03-19



Дүгнэлт:

Таван толгой нүүрсний ордын Цанхийн баруун хэсгийн 2020 оны техник эдийн засгийн үндэслэлийг хийж гүйцэтгэсэн "Эм Эм Маркет" ХХК нь дараах дүгнэлтийг боловсруулсан байна. Үүнд:



- Цанхийн Баруун хэсгийн ил уурхайн хүрээ хязгаарын оновчлол, үйлдвэрлэлийн нөөцийн тооцоо болон төлөвлөлтийг албан ёсны эрхтэй Datamine Studio OP программаар гүйцэтгэсэн бөгөөд оновчлолоор тогтоогтсон ил уурхайн хүрээн дэх геологийн нөөцийн хэмжээ /A+B+C/ нөөц 827.65 сая тн байна.
- Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дахь Тавантолгой чулуун нүүрсний бүлэг ордын Цанхийн Баруун хэсгийн талбайд хамаарах хэсгийг ил аргаар ашиглах төслийг хэрэгжүүлэх хугацаан дахь нийт хөрөнгө оруулалтын зардал 8,646.65 тэрбум төгрөг болж байна.
- Төслийн нийт хугацаанд үйлдвэрлэлийн зардал 72,723.87 тэрбум төгрөг, үйл ажиллагааны зардал 18,925.65 тэрбум төгрөг болж, 191,913.2 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллана. Үүнээс борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал нь 47.7 мөнгө болж байгаа нь төслийн үр ашиг өндөр байгааг илтгэж байна.
- Төсөл хэрэгжих нийт хугацаанд татварын дараах үзүүлэлтээр 78,009.56 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, цэвэр ашгийн түвшин 40.6% болж хөрөнгө оруулалтаа 4.8 жилийн хугацаанд нөхөхөөр тооцоо гарч байна.
- Энэхүү төслөөр нийтдээ 1771 хүнийг байнгын ажлын байраар хангах бөгөөд нэг ажилтны сарын дундаж цалин 5.2 сая төгрөг байна. Төсөл хэрэгжих нийт хугацаанд улс, орон нутгийн төсөвт нийтдээ 57,603.47 тэрбум төгрөгийг татвар төлбөр хэлбэрээр төвлөрүүлэх бөгөөд энэ нь жилд дундажаар 1,339.6 тэрбум төгрөг болж байна.
- Төслийн өнөөгийн цэвэр үнэ цэнийг 10% -ийн хорогдуулалтын нормоор тооцоход 9,732.23 тэрбум төгрөг, өгөөжийн дотоод нор (IRR) 111.4% болж байгаа ба цэвэр ашгийн түвшин 40.6% байгаа нь төсөл тогтвортой хэрэгжих боломжтойг харуулж байна.
- Иймд дээрх эдийн засгийн тооцооллыг үндэслэн уг төслийг хэрэгжүүлэх бүрэн боломжтой хэмээн дүгнэж байна.

2021.03.26





Эрсдэлийн хүчин зүйлс, удирдлага

ЭРДЭНЭС 11 МОНГОЛЫН ХОРОНГИЙН АИРГА
MONGOLIAN STOCK EXCHANGE

0000143

2021-03-19

БҮРТГЭВ 02

"Эрдэнэс-Тавантолгой" ХК нь "Эрсдэлийн менежмент – Зарчим ба заавар ISO31000:2009", "Эрсдэлийн менежмент – Эрсдэлийн менежментийн арга ISO31010:2009" олон улсын стандартыг 2012 онд MNS болгон монгол хэл дээр орчуулан, Стандартчиллын үндэсний зөвлөлийн тогтоолоор батлагдсан "Эрсдэлийн менежмент – Зарчим ба заавар" MNS ISO 31000:2011 Монгол улсын стандарт, "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн дүрэм болон эрсдэлийн удирдлагын чиглэлээр гарсан бусад холбогдох эрхзүйн баримт бичгийг үндэслэн "Эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичиг"-ийг боловсруулж, баталсан. Мөн "Эрсдэлийн удирдлагын журам"-ыг 2020 оны 01 сарын 28-ны өдөр нэмэлтээр баталсан. /Хэвсрэлт 55/

Компанийн эрсдэлийн удирдлагын бодлого нь учирч болзошгүй эрсдэлийг урьдчилан таамаглаж, учир шалтгааныг олж тогтоон түүнээс урьдчилан сэргийлэхэд компанийн хүний, санхүүгийн, мэдээллийн болон бусад нөөц бололцоог зөв хуваарилж, гарах алдагдал, эрсдэлийг хамгийн бага түвшинд байлгаж, эрсдэлийг бууруулах замаар компанийн эдийн засгийн өсөлт, бүтээмж, ашигт ажиллагааг дэмжихэд чиглэгдэнэ.

Эрсдэлийн удирдлагын зохион байгуулалт

Компани нь эрсдэлийн удирдлагыг дараах хүснэгтэд үзүүлсэн бүтэц, зохион байгуулалтын дагуу хэрэгжүүлнэ.

Хүснэгт 63. Эрсдэлийн удирдлагын зохион байгуулалт

Төлөөлөн Удирдах Зөвлөл		
Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн эрсдэлийн бодлого, эрсдэлийн хүлээн зөвшөөрөх түвшинг тогтоох, компанийн эрсдэлийн удирдлагын нэгжийн эрсдэлийг удирдах аливаа үйл ажиллагааг хараат бусаар үнэлэн ажиллах бүтэц тогтолцоог бүрдүүлэх эрхийг хэрэгжүүлж, компанийн эрсдэлийн удирдлагын ерөнхий чиг хандлагыг тодорхойлно.		
Гүйцэтгэх захирал		
Гүйцэтгэх захирал нь компанийн эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг зохион байгуулж, холбогдох журам, зааврыг батлах, эрсдэлийн удирдлагыг үр дүнтэйгээр дэмжин нэвтрүүлэх дотоод орчныг бүрдүүлж ажиллана.		
Эрсдэлийн удирдлагын хороо		
Компанийн Гүйцэтгэх захирлын тушаалаар компанийн гүйцэтгэх удирдлагын багийн гишүүдээс бүрдсэн Эрсдэлийн удирдлагын хороо байгуулагдан ажиллаж болно. Компанийн эрсдэлийн удирдлагын баримт, мэдээллүүдтэй танилцах, эрсдэлийн удирдлагын талаар бие даан шийдвэр гаргах, хэрэгжилтийг хангуулах эрхийг Эрсдэлийн удирдлагын хороо хэрэгжүүлж ажиллана.		
Компанийн дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын нэгж болон компанийн зохион байгуулалтын бусад нэгжүүд		

Компанийн дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын нэгж нь жил бүр компанийн үйл ажиллагаанд тодорхой шалгуурын дагуу эрсдэлийн үнэлгээ өгч, дүн шинжилгээ хийх, эрсдэлүүдийн сөрөг нөлөөллийн түвшин, хүлээгдэж буй хандлагыг урьдчилан илрүүлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээний талаар тасалт боловсруулах, эрсдэлийн

Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын нэгж болон компанийн зохион байгуулалтын бусад нэгжээс компанийн үйл ажиллагаанд үүсэж болох эрсдэлд тогтмол хяналт тавьж, эрсдэлийн арга хэмжээ авах явцад болон арга

Компанийн зохион байгуулалтын нэгжүүд үйл ажиллагааныхаа чиг үүргийн дагуу өөрсдийн үйл ажиллагаатай холбоотой эрсдэлийг илрүүлэх чиглэлээр ажиллах, Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын нэгжтэй ажлаа уялдуулах туслалцаа үзүүлэх, холбогдох мэдээ, мэдээллийг тогтоосон

2021-03-19

<p>мэдээллийн сан, хэрэгжүүлсэн өргө хэмжээний үр дүн, гүйцэтгэл, хэрэгжилтийн талаар хараат бусаар Эрсдэлийн удирдлагын хороонд тайлагнаж ажиллана.</p>	<p>хэмжээ авсны дараа эрсдэлийн үнэлгээг хийж үр дүнг танилцуулж ажиллана.</p>	<p>хугацаанд хяналтыг хяналтын стандартуудыг бий болгох, эрсдэлийг ажилд хамтран эрсдэлийг чиглэгдсэн үйл ажиллагааг бие даан хэрэгжүүлнэ.</p>
--	--	--

Эрсдэлийн ангилал

Компани нь үндсэн 9 эрсдэлийг тодорхойлж, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

1. Санхүү, эдийн засгийн эрсдэл



Санхүү, эдийн засгийн эрсдэл нь санхүүгийн нийцэл, хөрвөх чадвар, төлбөрийн чадвар, зээл, санхүүгийн төлөвлөлт, төсөв, тайлагнал, хөрөнгө оруулагчдын харилцаа, хөрөнгө оруулалтын зардлын өсөлт, инфляц, дефляц, валютын ханшийн өөрчлөлт, хүүгийн зэрэг дэд эрсдэлүүдэд ангиллагдана.

2. Үйлдвэрлэл, үйл ажиллагааны эрсдэл



Үйлдвэрлэл, үйл ажиллагааны эрсдэлийг олборлолт, хайгуул, дэд бүтэц, төсөл, худалдан авалт, хүний нөөц, зах зээлийн үнийн өөрчлөлт, борлуулалт, чанар, тээвэр, ложистик, гүйцэтгэгчээс хамаарсан дэд эрсдэлүүдэд ангилна.

3. Хууль, эрх зүй, нийцлийн эрсдэл



Хууль, эрх зүй, нийцлийн эрсдэлийг хууль тогтоомж, бодлого, дүрэм, журмын нийцэл, гэрээний удирдлага, эрх зүйн маргаан, иргэдийн гомдол, торгууль, шийтгэл зэрэг дэд эрсдэлүүдэд ангилна.

4. Нийгэм, улс төр, орон нутгийн эрсдэл



Нийгэм, улс төр, орон нутгийн эрсдэлийг олон нийтийн харилцаа, менежментийн болон нэр хүнд унах зэрэг дэд эрсдэлүүдэд ангилна.

5. Хөдөлмөр, аюулгүй байдал, эрүүл ахуйн эрсдэл



Хөдөлмөр, аюулгүй байдал, эрүүл ахуйн эрсдэлд үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад гарч болзошгүй үйлдвэрлэлийн осол гэмтэл, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчлөл зэрэг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэд эрсдэлүүд орно.

6. Байгаль орчны эрсдэл



Байгаль орчны эрсдэлд экосистем, ургамал, амьтан, амьдрах орчинд сөрөг нөлөө үзүүлэх дэд эрсдэлүүд багтана.

7. Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл

Stamp: TAVAN ERDENI TAIVAN TOYGOY JSC with a signature.

Stamp: ERDENI TAIVAN TOYGOY JSC with a signature.

2021.03.02



0000145

МОНГОЛЫН АСРЭНГЭЙН БИРЭГ
MONGOLIAN STOCK EXCHANGE

Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлд мэдээлэл устгах, алдагдах, халдлагад өртөх, мэдээллийг сөргөөр ашиглах зэрэг эрсдэлүүд орно. 19

БҮРТГЭВ-02



8. Гадаад хүчин зүйлсийн буюу давагдашгүй хүчин зүйлсийн эрсдэл

Гадаад хүчин зүйлсийн буюу давагдашгүй хүчин зүйлсийн эрсдэлд байгалийн гамшиг, онцгой байдал, улс төр, гадаад улсын төрийн бодлогын шийдвэр, үйл ажиллагаа, макро эдийн засгийн дэд эрсдэлүүд хамаарна.



9. Бусад эрсдэл

Компанийн дотоод үйл ажиллагаанаас хамааралгүй үүссэн боловч компанийн үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөл үзүүлдэг эрсдэлүүдийг ойлгоно. Тухайлбал: харилцагч талын ажлын зохион байгуулалтын алдаа, санхүүгийн хүндрэл зэргээс үүсэж үзүүлэх нөлөөлөл.

Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх алхмууд

Компани нь дээр тодорхойлсон 5 эрсдэлийг дараах 6 үе шаттайгаар эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж ажиллана. Эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа нь эрсдэлийн удирдлагын хороо болон компанийн зохион байгуулалтын бүх нэгжүүдийн хүрээнд хэрэгжинэ.

Схем 11. Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх алхмууд



1. Эрсдэлийг илрүүлэх

Эрсдэлийг илрүүлэх үйл ажиллагаагаар тухайн эрсдэлийг удирдах боломжтой эсэхээс үл хамаарч учирч болох бүх эрсдэлийг цуглуулж судална. Эрсдэлийг тухай бүр болон судалгаа шинжилгээгээр илрүүлж, хяналт тавихаас гадна дараах эх үүсвэрээс илрүүлнэ.



- a. Мэдээллийн санд бүртгэгдсэн эрсдэлийн мэдээлэл;
- b. Компанийн тайлан мэдээ;
- c. Судалгаа шинжилгээ;



- d. Харилцагчийн санал гомдлын мэдээлэл /санал хүсэлтийн хайрцаг, дэвтэр, интернет, лавлах утас/;
- e. Мэдээллийн хэрэгсэл;
- f. Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын нэгжээс компанийн зохион байгуулалтын нэгжүүдэд хийсэн шалгалтын материал;
- g. Мэргэжлийн хяналт, хөндлөнгийн аудитын шалгалтын акт, дүгнэлт;
- h. Бусад;

Эрсдэлийн ангиллаас хамаарч тохирох арга хэрэгслүүдийг ашиглан эрсдэлийг илрүүлнэ.

2. Эрсдэлийг бүртгэлжүүлэх ба эрсдэлийн мэдээллийн сан үүсгэх

Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын нэгж нь эрсдэлийг илрүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд илэрсэн эрсдэлүүдийн нэгтгэх, үнэлэх, хянах зорилгоор тухай бүр бүртгэж эрсдэлийн мэдээллийн санг үүсгэнэ. Компанийн зохион байгуулалтын нэгжүүд нь өөрсдийн үйл ажиллагаатай холбогдон гарсан эрсдэлийн тохиолдлын мэдээллийг тухай бүр батлагдсан маягтын дагуу гаргаж эрсдэлийн нэгжид холбогдох журмын дагуу хүргүүлнэ. Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын нэгж нь хэлтэс, нэгжүүдтэй хамтран компанийн үйл ажиллагаанд учрах эрсдэлд хяналт тавьж, зөрчлүүдийг баримтжуулж мэдээллийн санг баяжуулна.

3. Эрсдэлийн шинжилгээ

Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын нэгж нь эрсдэлийн мэдээллийн санд бүртгэгдсэн эрсдэлийн мэдээллүүдэд шинжилгээ хийж, дүгнэлт гаргах ажлыг зохион байгуулна. Эрсдэлийн шинжилгээний зорилго нь компанийн зорилго, зорилт, төлөвлөгөө ба үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх эрсдэлүүдийг илрүүлэхэд оршино. Компанийн эрсдэлийн шинжилгээг эрсдэлийн мөн чанарт нь тохирсон аргачлалын дагуу хийнэ. Тухайлбал:

- a. Тоон шинжилгээ;
- b. Чанарын шинжилгээ;
- c. Хосолсон аргачлал (Дээрх 2 шинжилгээг);

4. Эрсдэлийн дүгнэлт гаргах

Компанийн эрсдэлийн дүгнэлт гаргах үйл ажиллагааны зорилго нь тодорхойлж, шинжилсэн эрсдэлүүдийг үнэлгээнийх нь дагуу харьцуулах, эрэмбэлэх, тэдгээрийг компанийн эрсдэлийг хүлээн зөвшөөрөх түвшинтэй харьцуулан дүгнэлт гаргахад оршино. Эрсдэлийн дүгнэлтийг дараах хүрээнд харьцуулан гаргана. Үүнд:

- a. Хүлээн зөвшөөрөгдөх эрсдэл;
- b. Хянах шаардлагатай сэргийлэх эрсдэл;
- c. Бууруулах, шилжүүлэх эрсдэл;
- d. Зайлсхийх эрсдэлийг тогтоох;



2021.03.26

2021.03.26

БҮРТГЭВ

№ 01 5. Эрсдэлийн арга хэмжээ авах

Компани түүний зохион байгуулалтын нэгжүүд нь эрсдэлийг удирдахдаа эрсдэлийг шинжлэх ухааны үндэсдэслэлтэй баталгаа, нотолгоонд тулгуурлан тогтоож, эрсдэлийг бууруулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, түүнээс үүсэх хохирол, сөрөг нөлөөллийг багасгах зорилгоор дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

- Эрсдэлийг ихэсгэж байгаа үйл ажиллагаанаас татгалзах, маш ноцтой эрсдэлээс сэргийлэх, эрсдэлээс зайлсхийх шийдвэр гаргах, эрсдэлийн эх үүсвэрийг арилгах;
- Эрсдэлийг бууруулах, түүний магадлал ба нөлөөллийг багасгах;
- Эрсдэлийг бусадтай хуваалцах, эрсдэлийг бусдад шилжүүлэх;
- Хяналттайгаар эрсдэлийг хүлээн зөвшөөрөх гэх мэт холбогдох эрсдэлүүдэд тохирсон арга хэмжээнүүдийг төлөвлөж, хэрэгжүүлнэ.



Тухайн эрсдэлийн удирдлагын арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд шаардагдах зардал, өртгийн тооцоог хийж, тухайн эрсдэлийн удирдлагын арга хэмжээг авч хэрэгжүүлэх боломжтой эсэхийг тооцно. Компани, түүний зохион байгуулалтын нэгжүүд компанийн эрсдэлийн хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнээс давсан эрсдэлүүдийг үнэлгээний дагуу эрэмбэлж, өндөр оноотойгоос нь эхлүүлэн эрсдэлийг бууруулах, үр нөлөөг багасгах боломжуудыг судалж, шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлэх эрсдэлийн удирдлагын төлөвлөгөөг боловсруулна.

6. Эрсдэлийн арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх

Эрсдэлийн арга хэмжээний төлөвлөгөө нь сонгож авсан эрсдэлийн арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлэхийг тусгасан баримт бичиг болно. Эрсдэлийн удирдлагын хороо нь эрсдэлийн арга хэмжээг хэрэгжүүлэх аргаас нь хамаарч дараах байдлаар ангилж хэрэгжүүлнэ.

- Бодлогын арга хэрэгсэл: Эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар саналаа зохих байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлэх, шаардлагатай дүрэм, журмыг батлах санал хүргүүлэх, туршлагаа хуваалцах, хөдөлмөр зохион байгуулалтыг оновчтой болгон хуваарилах, үйл ажиллагааг эрэмбэлэх зэрэг удирдлагын аргаар шийдвэрлэх шийдвэрүүд;
- Техникийн арга хэрэгсэл: шаардлагатай нөөц хөрөнгийг батлах, техникийн шаардлагыг тодорхойлж, арга хэмжээ авах этгээд, хугацаа, арга замыг тодорхойлж өгөх шийдвэрүүд.



2021.03.26
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01



ЭРДЭНЭС Т МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
ERDENEGS TAVAN TOLGOY CO. LTD. MONGOLIAN STOCK EXCHANGE

0000148

с. Компани нь эрсдэлийн арга хэмжээний олон хувилбарыг дангаар нь эсвэл хослуулан авч үзэж, хэрэглэж болно.

2021-03-19
БҮРТГЭВ-02

Эрсдэлийн удирдлагын арга хэмжээний төлөвлөгөөнд тухайн эрсдэлийг үүсгэж буй нөхцөл байдал, гүйцэтгэлийн хэмжүүрийг тодорхойлж өгөх бөгөөд арга хэмжээний төлөвлөгөөнөөс үүдэн бий болох боломжтой эрсдэлийг мөн адил үнэлж хянана. Компани болон түүний зохион байгуулалтын нэгжүүд эрсдэлийн удирдлагын арга хэмжээг хэрэгжүүлж компанийн эрсдэлийг хүлээн зөвшөөрөх түвшингээс бага байлгахыг зорьж ажиллана. Түүний дараа үлдэх эрсдэлийг дахин үнэлж, хэрэв үлдэгдэл эрсдэлийн үнэлгээ эрсдэлийн хүлээн зөвшөөрөх түвшингээс өндөр байвал тухайн эрсдэлийг удирдах арга хэмжээ хангалтгүй гэж үзнэ. Ийм тохиолдолд нөхцөл байдалд тохируулан эрсдэлийг бууруулах нэмэлт арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

2021.03.19

TAVAN
ЭРДЭНЭС
ТАВАН
ТОЛГОЙ
CO. LTD.
[Signature]

МАН-ийн тэнгэр
Аудитрийн
эрхээр дансанд
YIB №
[Signature]



2021-03-26
БҮРТГЭВ
№ 01

Эрдэнэс-Тавантолгой ХК нь Компанийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1, 41.2 дахь заалт, 42 дугаар зүйлийн 42.1, 42.4 дүгээр заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх заалт, Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2021 оны 02 сарын 02-ний өдрийн 03 тоот тогтоолыг үндэслэн нийт 2,000,000,000,000 /2 их наяд/ төгрөг хүртэлх үнийн дүн бүхий 20,000,000 хүртэлх ширхэг бондыг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгүүлэн Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан нийтэд санал болгон нээлттэй арилжихаар хүсэлт гаргаж байгаа болно.

Компани бондын татан төвлөрүүлсэн хөрөнгөөр Засгийн газраас 2020-2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төмөр зам, цахилгаан станц, сайжруулсан түлшний үйлдвэрийн төсөл зэрэг томоохон төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхээр төлөвлөж байна.

Томоохон төслүүдийг хэрэгжүүлснээр ашигт малтмалыг дотооддоо боловсруулан байгалийн баялгаа зүй зохистой, өндөр технологиор ашиглан, үнэ цэнийг өсгөх, улс орны төсвийн орлого нэмэгдүүлэх, ажлын байр бий болох, нэмүү өртөг шингэсэн бараа, ажил үйлчилгээгээр гадаад дотоод зах зээлийг хангах, улмаар дэлхийн зах зээлд өрсөлдөх хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх ач холбогдолтой.

4.1. Бонд гаргах эрх бүхий этгээдийн шийдвэр

Үнэт цаас гаргагчийн төрийн мэдлийн хувьцааны эрхийг хэрэгжүүлэгч Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам нь "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийг Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан томоохон төслүүд болох төмөр зам, цахилгаан станц, сайжруулсан түлшний төслийн санхүүжилтыг шийдвэрлэх зорилтын хүрээнд дотоодын зах зээлд бонд гаргах асуудлыг дэмжиж буйгаа илэрхийлсэн байна. Мөн Сангийн яам болон Хууль зүй, дотоод хэргийн яамтай зөвшилцөн дараах санал, чиглэлийг ирүүлсэн байна. Үүнд:

Дотоодод гаргах үнэт цаасыг компанийн хэрэгжүүлэх төслүүдийн хэрэгжилттэй уялдаатайгаар үе шаттайгаар нээлттэй хэлбэрээр гаргах, дунд хугацаанд компанийн үйл ажиллагааны ашигт нөлөөлөх зардал, эрсдэлийн шинжилгээг нарийвчлан хийсний үндсэн дээр шинээр гаргах үнэт цаасын эргэн төлөх төлөвлөгөөг нарийвчлан тооцож, тухайн үнэт цаасны эргэн төлөлттэй холбоотой аливаа хугацаа хэтэрсэн болон болзошгүй өр төлбөр үүсгэхгүй байхад анхаарах чиглэлийг өгсөн байна.

Хавсралт 56. УУХҮЯ-ны 2021 оны 02 сарын 10-ны өдрийн 01/346 тоот албан бичиг

Хавсралт 57. ХЗДХЯ-ны 2021 оны 02 сарын 09-ны өдрийн 1/651 тоот албан бичиг

Хавсралт 58. СЯ-ны 2021 оны 02 сарын 09-ний өдрийн 8-1/480 тоот албан бичиг

Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 02 сарын 02-ний өдрийн хурлын 03 тоот тогтоол /Хавсралт 59/-ын дагуу үнэт цаас гаргах шийдвэрийг гаргасан байна.

1. Тавантолгой ордыг түшиглэн хэрэгжүүлэх томоохон төсөл, хөтөлбөрүүдэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх, компанийн үндсэн үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор 2.0 (хоёр их наяд) хүртэлх төгрөгийн өрийн бичгийг нийтэд санал болгон гаргахыг үндэслэн үнэт цаасны захирал Б.Ганхуягт зөвшөөрсүгэй.

- Өрийн бичиг гаргах бэлтгэл ажлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хангах, үнэт цаасны танилцуулга, бусад баримт бичгийг боловсруулах болон татан төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг тухай бүр Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Гүйцэтгэх захирал Б.Ганхуягт үүрэг болгосугай.
- Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо (Ү.Амарбат)-нд даалгасугай.

4.2. Бондын нөхцөл

Эрдэнэс-Тавантолгой ХК нь дараах нөхцөл бүхий бондыг нээлттэй нийтэд санал болгож байна.

Үнэт цаас гаргагч	"Эрдэнэс-Тавантолгой" Хаалттай ХК
Үнэт цаасны төрөл	Өрийн бичиг
Үнэт цаасны арилжаа	Нийтэд нээлттэй санал болгох
Нэгжийн нэрлэсэн үнэ	Төгрөгийн бонд: 100,000 төгрөг Долларын бонд: 100 ам.доллар
Нийт тоо ширхэг	20,000,000 ширхэг хүртэлх
Нийт үнийн дүн /хүртэлх/	2,000,000,000,000 төгрөг хүртэлх /ам.доллар, төгрөг хосолсон/
Жилийн хүү	Төгрөг: 10.0 % Ам.доллар: 6.8 %
Хүү төлөх хугацаа	Хагас жил тутам
Хугацаа	24-36 сар
Эргүүлэн авах нөхцөл	Хугацаанаас өмнө эргэн дуудах нөхцөлтэй
Үндсэн болон хүүгийн төлбөрийн хугацаа хэтрэлт	Хүү төлөх өдрөөс хугацаа хэтэрсэн хоног тутамд хүүгийн төлбөрөөс 0.02%-р алданги нэмж тооцон хүүг алдангийн хамт Үнэт цаас эзэмшигчид төлнө.
Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт	Бүтээн байгуулалтын төслүүдийг санхүүжүүлэх
Баталгаа	Борлуулалтын орлого
Арилжаалах зах зээл	"Монголын Хөрөнгийн бирж" ТӨХК
Хадгаламж, бүртгэл төлбөр тооцоо	"Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК
Андеррайтер	Тэргүүлэх андеррайтер: БиДиСЕК ҮЦК ХК

4.3. Үнэт цаасаар гэрчилгэдэх эрх, үүрэг

Бонд эзэмшигчийн эрх, үүрэг:

- Бонд эзэмшигч нь Бонд гаргагчийн санхүүгийн тайлан, мэдээлэлтэй танилцах эрхтэй.
- Бондын хүүгийн төлбөрийг хагас жил бүр хүлээн авах, төлөхийг шаардах эрхтэй



3. Бонд эзэмшигч нь өөрийн эзэмшиж буй бондыг хоёрдогч зах зээл дээр чөлөөтэй арилжиж, захиран зарцуулах эрхтэй.
4. Хугацааны эцэст бондын үндсэн болон хуримтлагдсан хүүгийн төлбөрийг хүлээн авах эрхтэй.
5. Бондын үндсэн болон хүүгийн төлбөрийг төлөхийг Үнэт цаас гаргагчаас шаардах эрхтэй.
6. Хууль журамд заасан холбогдох эрх
7. Үнэт цаас гаргагчаас бондыг эргүүлэн дуудахаар шийдвэрлэсэн бол бондоо Үнэт цаас гаргагчид эргүүлэн худалдах үүрэгтэй
8. Бонд эзэмшигч нь бондыг эргүүлэн дуудах ажиллагаатай холбогдон гарах өөрт хамаарах эрх бүхий байгууллагын шимтгэл, төлбөр болон бусад татвар хураамжийг хариуцан төлөх үүрэгтэй.

Бонд гаргагчийн үүрэг

1. Бондыг хугацааны эцэст хөрөнгө оруулагчаас буцаан худалдаж авах, хуримтлагдсан хүүгийн төлбөрийг бүрэн төлж барагдуулах үүрэгтэй.
2. Хагас жил тутамд бондын хүүгийн төлбөрийг төлөх үүрэгтэй.
3. Компанийн санхүү болон үйл ажиллагааны талаар үнэн зөв мэдээлэл хүргэх үүрэгтэй.
4. Бонд борлуулан татан төвлөрүүлсэн хөрөнгийг зөвхөн үнэт цаасны танилцуулгад тусгагдсан зорилтын дагуу зарцуулах үүрэгтэй.
5. Бондын үүрэг гүйцэтгэлтэй холбоотой асуудал үүссэн тохиолдолд зохих арга хэмжээг авч Үнэт цаас эзэмшигчийн хүү болон үндсэн төлбөрийг барагдуулах үүрэгтэй.
6. Бонд гаргагч нь холбогдох гэрээнүүд дээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас Үнэт цаас эзэмшигчид учруулсан аливаа хохирол, алдангийг үл маргах журмаар төлж барагдуулах үүрэгтэй.
7. Үнэт цаас гаргагч нь энэхүү бондтой ижил төстэй санхүүгийн хэрэгслийн хүү зах зээл дээр буурч, бондын хүүнээс бага болсон тохиолдолд бондыг эргүүлэн дуудахаар шийдвэрлэж болно.
8. Бондыг хугацаанаас өмнө эргүүлэн дуудахаас 1 сарын өмнө бонд эзэмшигчид мэдэгдэх үүрэгтэй.
9. Бондын анхдагч зах зээлийн арилжаа дуусч бондыг эзэмшсэн хугацаа тооцож эхэлснээс хойш 1 жилийн дараа Үнэт цаас гаргагч нь бондыг эргэн дуудах эрхтэй.

4.3. Бондын арилжаа

Үнэт цаасыг бүртгэх зохицуулагч байгууллагуудын зөвшөөрөл гарсны дараа бондыг олон нийтэд санал болгоно. Бондын анхдагч зах зээлийн арилжаа нь Санхүүгийн Зохицуулах Хорооны "Үнэт цаасны бүртгэлийн журам" болон МХБ-ийн "Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам"-ын дагуу явагдана.

Анхдагч зах зээлд санал болгох хуваарийг Үнэт цаас гаргагч болон Андеррайтер нь МХБ, СЗХ-той зөвшилцөн тухай бүр тогтоож, үнэт цаас гаргах тухай бүр нийтэд танилцуулж ажиллана.





Бондын анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулах хэлбэр

Бондын анхдагч зах зээлийн арилжааг МХБ-ийн "Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам"-ын 3 дугаар бүлэгт заасны дагуу үнэ хаялцуулах дуудлага арилжааны аргаар зохион байгуулна. Үнэт цаас гаргагч болон Андеррайтер нь зах зээлийн нөхцөл байдал, бондын эрэлтийг харгалзан МХБ-тэй зөвшилцөн бусад арга хэлбэртэй хослуулан бондыг анхдагч зах зээлд санал болгож болно.

Зураг 41. Бондыг анхдагч зах зээлд байршуулах явц



Үнэт цаасыг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагчид өөрийн харилцдаг үнэт цаасны компаниар дамжуулан бондыг худалдан авах боломжтой.

Зураг 42. Бонд захиалах заавар



Хүснэгт 64. Мөнгө шилжүүлэх заавар

Гүйлгээний заавар	
Хүлээн авагч банк:	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв /... кодтой банк/
Хүлээн авах данс:	(ҮЦК-ийн код) (Харилцагчийн үнэт цаасны дансны дугаар)
Хүлээн авагч:	Харилцагчийн нэр
Утга:	"Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн бонд худалдан авах мөнгө

Official stamps and signatures are present on the form.

2021-03-19

Бондыг анхдагч зах зээлд байршуулснаас хойш ажлын 15 хоног дотор анхдагч зах зээлийн арилжааг амжилттай хэрэгжүүлсэн тухай тайланг холбогдох бүх байгууллагууд болон олон нийтэд хүргэнэ. Хоёрдогч зах зээлийн арилжааг нээснээр бондыг нээлттэй арилжих боломжтой болно.

Бондыг худалдан авсан хөрөнгө оруулагчид нь өөрийн харилцдаг үнэт цаасны компаниар дамжуулан бондыг МХБ-ийн хоёрдогч зах зээл дээр нээлттэй арилжих боломжтой.

Татварын асуудал

Ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэг, Монгол улсад байршдаг албан татвар төлөгчийн гадаад, дотоодын үнэт цаасны анхдагч Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн гадаад, дотоодын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалах өрийн хэрэгсэл, нэгж эрх худалдан авсан албан татвар төлөгчийн хүүгийн орлогод Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 20.2.5-д 10 хувиар, Хувь хүний орлогын албан татварын 21.5-д заасны дагуу 5 хувиар татвар ногдуулахаар заасан.

Хөрөнгө оруулагч хувь хүн нь бондын хүүгийн орлогоос 5 хувийн албан татвар төлөх ба энэхүү татварыг үнэт цаас гаргагч суутган шилжүүлнэ. Аж ахуйн нэгжийн хувьд хүүгийн орлогыг өөрөө мэдүүлнэ.

Бондын хугацааны туршид хөрөнгө оруулагч нь бондоо хоёрдогч зах зээл дээр худалдах тохиолдолд худалдаж буй үнэ нь тухайн хөрөнгө оруулагчийн уг бондыг худалдаж авсан үнэ болон тухайн хугацаанд хуримтлагдсан хүү, холбогдох арилжаанд оролцоход гарсан зардлуудын нийлбэрээс илүү гарсан тохиолдолд Хувь хүний орлогын албан татварын тухайн хуулийн 10.1.4, 17.1.3 дугаар зүйл, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 10.1.3, 18.3-д зааснаар хөрөнгө борлуулсны орлогод ногдох албан татвар төлнө.

4.5 Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт

Үнэт цаас гаргагч нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй төгрөгийн бонд, 100 ам.долларын нэрлэсэн үнэтэй долларын бондыг нийтэд нээлттэй санал болгон арилжаалсанаар нийт 2 их наяд төгрөг хүртэлх санхүүжилт татан төвлөрүүлнэ.

"Эрдэнэс-Тавантолгой" ХК нь бондыг 3 үе шатаар нийтэд санал болгохоор төлөвлөсөн бөгөөд бондын үе шат тус бүрд санал болгох анхдагч зах зээлийн нөхцөл, хуваарийг "Үнэт цаасны танилцуулга"-н 4.4-т тусгаснаар тухай бүр Монголын хөрөнгийн биржтэй зөвшилцөн тодорхойлж мэдээллийг нийтэд танилцуулж ажиллана.

Схем 12. Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт

Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт

<p>972.7 тэрбум төгрөг /хүртэлх/ Дэд бүтцийн төслүүд</p>	<p>371 тэрбум төгрөг /хүртэлх/ Уурхайн хөгжүүлэлт</p>	<p>650.6 тэрбум төгрөг /хүртэлх/ Эргэлтийн хөрөнгө</p>
---	--	---

ТАНИЛЦУУЛГА

2021.03.19

Төсөл

Дэд бүтцийн төслүүд:

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн үлдэгдэл санхүүжилт

Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын холбох холболтын төмөр замын санхүүжилт (\$75.2 сая-ийн 30%)

450 МВт-ын хүчин чадалтай Тавантолгойн дулааны цахилгаан станцын бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалт (\$105.6 сая)

Уурхайн хөгжүүлэлт:

Олборлолтын техник, тоног төхөөрөмж худалдан авах хөрөнгө оруулалт

Төмөр замд нүүрс ачих байгууламжийн бүтээн байгуулалтын санхүүжилт (\$75.0 сая-ийн 30%)

Өмнөговь аймгийн Цогтцэций, Цогт-Овоо сумдын нутагт орших "Загийн усны хоолой" гүний усны ордоос ус татах шугам хоолойн бүтээн байгуулалтын санхүүжилтын урьдчилгаа

Нүүрс баяжуулах үйлдвэрийн эхний 10 сая тонны блокын санхүүжилтийн 16% (\$42.6 сая)

Дорноговь аймгийн Мандах сумын нутагт орших "Цагаанцав"-ын гүний усны ордоос ус татах шугам хоолойн бүтээн байгуулалтын санхүүжилтын урьдчилгаа

Эргэлтийн хөрөнгийн санхүүжилт:

Нийт

972.7 тэрбум төгрөг
601.1 тэрбум төгрөг

65.4 тэрбум төгрөг

306.2 тэрбум төгрөг

371.0 тэрбум төгрөг

50.0 тэрбум төгрөг

65.3 тэрбум төгрөг

16.2 тэрбум төгрөг

123.5 тэрбум төгрөг

116.0 тэрбум төгрөг

650.6 тэрбум төгрөг

1,994.3 тэрбум төгрөг

Тэргүүлэх ээлжний зарцуулалт

Үнэт цаас гаргагч нь бондын тэргүүн ээлжний зарцуулалтыг Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төсөл, компанийн эргэлтийн хөрөнгө, холболтын төмөр зам, олборлолтын техник тоног төхөөрөмжийн худалдан авалт болон нүүрс ачилтын байгууламжид байршуулна.

Үнэт цаас гаргагч нь 2021 онд Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төсөл, 2022 онд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төсөл болон холболтын төмөр замын төслийг тус тус ашиглалтад оруулж, 2021-2022 онд нүүрс ачилтын байгууламжийн тодорхой хэсгийг гүйцэтгэснээр 2021-2024 онд 135.6 сая тонн нүүрс олборлож, 125.8 сая тонн нүүрс борлуулж, нийт 7,662 сая ам.долларын борлуулалтын орлоготой, 2,521 сая ам.долларын цэвэр ашигтай ажиллахаар төлөвлөсөн.

Иймд эдгээр төслүүд нэн тэргүүнд хэрэгжих нь бондын эргэн төлөлтийн үеийн буюу 2021-2024 оны мөнгөн урсгалд гол үр нөлөө үзүүлэх, компанийн орлого ашгийн үзүүлэлтийг нэмэгдүүлсэнээр өөрийн мөнгөн урсгалаар бусад төслүүдийн санхүүжилтийг хэрэгжүүлэх боломж олгох зэрэг чухал ач холбогдолтой.

Хүснэгт 66. Тэргүүн ээлжинд санхүүжүүлэх төслүүд.

Төслийн нэр:	2021-2025 онд төлөвлөсөн хөрөнгө оруулалтын мөнгөн урсгал:	Бондоос санхүүжүүлэх хувь:	Бондоос санхүүжүүлэх дүн:
			

№	Төмөр замын төрөл	Хэмжээ	Хувь	Нийт
1.	Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төсөл	601.1 тэрбум төгрөг	100%	601.1 тэрбум төгрөг
2.	Эргэлтийн хөрөнгө	330 тэрбум төгрөг	100%	330 тэрбум төгрөг
3.	Холболтын төмөр зам	75.2 сая ам доллар	30%	65.4 тэрбум төгрөг
4.	Олборлолтын техник тоног төхөөрөмж	211.4 сая ам доллар	8%	50.0 тэрбум төгрөг
5.	Загийн усны хоолой	72.7 тэрбум төгрөг	22%	16.2 тэрбум төгрөг
Нийт				1,062.7 тэрбум төгрөг

Хүснэгт 67 Төмөр замын төслүүдийн хэрэгжилтийн явц

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам	Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам
Төслийн ажил эхэлсэн огноо: 2020 оны 3 дугаар сарын 01-нд	Төслийн ажил эхэлсэн огноо: 2019 оны 5 дугаар сарын 24-нд
Төслийн гүйцэтгэл (2021.02.16-ны байдлаар):	Төслийн гүйцэтгэл (2020 оны эцсийн байдлаар):
<ul style="list-style-type: none"> 208 км үндсэн замын гүйцэтгэл: доод бүтцийн ажил 99.4%, дээд бүтцийн ажил 77.6%, 199.6 км төмөр замын үе угсарсан. 8 км ачилтын тойргийн хэсгийн гүйцэтгэл: доод бүтэц 66.6%. 20 км хил холболтын хэсгийн гүйцэтгэл: газар шорооны ажил 46.8% 	<ul style="list-style-type: none"> 416.1 км үндсэн замын гүйцэтгэл: доод бүтцийн ажил 100.0%, дээд бүтцийн ажил 54.9%, 228.5 км төмөр зам тавьсан.
Төслийн ашиглалтад орох огноо: 2022 оны 7 дугаар сар	Төслийн ашиглалтад орох огноо: 2021 оны 6 дугаар сар

Төслүүдийн компанид бий болгох үр нөлөө:

1. Тээврийн өртөг буурч компанийн тонн тутмаас олох ашиг нэмэгдэнэ.

Үнэт цаас гаргагч нь 2021 онд Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг, 2022 онд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам, эдгээр төмөр замуудыг холбох холболтын төмөр замыг ашиглалтанд оруулахаар төлөвлөсөн. Эдгээр төмөр зам ашиглалтад орсноор 20-30 ам.доллар/тн тээвэрлэлтийн өртгийн хэмнэлт бий болгох, эцсийн хэрэглэгчдэд бүтээгдэхүүнээ нийлүүлэх, DAP нөхцөлөөр борлуулалт хийх боломж бүрдэнэ.

2. Тээвэрлэлт болон экспортын хүчин чадал нэмэгдэнэ.

Үнэт цаас гаргагчийн нүүрс тээвэрлэлтийн хүчин чадал одоогоор 18-20 сая тонн байгаа нь экспортын хэмжээг хязгаарлаж буй гол хүчин зүйлсийн нэг байна. 2021 онд Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам ашиглалтанд орсноор нүүрс тээвэрлэлтийн хүчин чадал 15 сая тонноор, 2022 онд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам ашиглалтанд орсноор нүүрс тээвэрлэлтийн хүчин чадал 30 сая тонноор тус тус нэмэгдэхээр байна.

3. Экспортын шинэ гарц нээнэ.

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам 2021 онд ашиглалтанд орж "УБТЗ" ХНН-ийн гол замтай холбогдон төмөр замын нэгдсэн сүлжээ ашиглалтад орсноор БНХАУ-ын зүүн хойд бүс нутгийн хэрэглэгчдэд хүрэх, БНХАУ болон ОХУ-ын газар нутгаар дамжин далайн чанад дахь зах зээлд хүрч экспортын хоёр ба гурав дахь шинэ гарцуудыг бий болгох, эцсийн хэрэглэгчид шууд хүргэх, далайн боомт нөхцөлөөр бүтээгдэхүүнийг борлуулах нөхцөл бүрдэнэ.

4. Үйл ажиллагааны үр ашигт байдлыг нэмэгдүүлнэ.

Б. Ч. Х. Х.
115285447
0742002715285447

Үнэт цаас гаргагч нь төмөр замд нүүрс ачих байгууламжийн төслийг 2021-2023 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Төсөлд нийт 75 сая ам.долларын санхүүжилт шаардлагатай, үүний 30%-ийг буюу 65.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг бондын эх үүсвэрээр шийдвэрлэхээр тусгасан. Ачилтын байгууламж ашиглалтад орсноор Тавантолгой-Гашуунсухайт болон Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замаар тээвэр хийх галт тэрэгний цуваанд орчин үеийн, тасралтгүй технологиор, их хэмжээний нүүрсийг богино хугацаанд ачих боломж бүрдэнэ.

Үнэт цаас гаргагч нь 2021-2025 онд нийт 211.4 сая ам.долларын техник, тоног төхөөрөмж худалдан авахаар төлөвлөсөн. Үүний 8.3% орчимд ногдох 50 тэрбум төгрөгийн санхүүжилтийг бондын эх үүсвэрээр санхүүжүүлэхээр тусгасан. Компани нь уулын ажлыг өөрийн техникээр хийж гүйцэтгэдэг болсоноор олборлолтын нэгж өртгийг 25 орчим хувиар бууруулах боломжтой.

5. Ордын нөөцийг жигд ашиглах, насжилтыг уртасгана.

Үнэт цаас гаргагч нь 2021-2022 онд Загийн ус, Цагаан цавын гүний усны төслүүдийг хэрэгжүүлж нүүрс баяжуулах үйлдвэрийн шаардлагатай усны хэрэглээг хангах, үйлдвэрлэл явуулах боломж бүрдүүлэхээр төлөвлөсөн. Эдгээр усны төслүүдэд нийт 125.2 сая ам.долларын санхүүжилт төлөвлөсөн бөгөөд үүний 37% орчмыг буюу 132.2 тэрбум төгрөгийг бондын эх үүсвэрээр санхүүжүүлэхээр тусгасан.

Үнэт цаас гаргагч нь 2024 онд нүүрс баяжуулах үйлдвэрийн төслийн эхний 10 сая тонн нүүрс боловсруулах хүчин чадалтай хэсгийг ашиглалтад оруулахаар төлөвлөсөн. Ингэснээр компанийн борлуулалтын орлогод баяжуулсан нүүрсний бүрдүүлэх хувь хэмжээ 2024 онд 6%-тай байх бол 2025 онд 25%-д хүрч нэмэгдэхээр тооцсон байна. Төсөлд 2025 оныг хүртэлх хугацаанд нийт 635.0 сая ам.долларын хөрөнгө оруулалт төлөвлөсөн бөгөөд үүний 6.7% орчим буюу 123.5 тэрбум төгрөгийг бондын эх үүсвэрээр санхүүжүүлэхээр төлөвлөсөн.

Нүүрс баяжуулах үйлдвэр ашиглалтад орсноор 2024 оноос эхлэн баяжуулах үйлдвэрийн шаардлагад нийцсэн нүүрсийг олборлохоор уурхайн параметрийг хангаж ажиллах, ордын нөөцийг жигд ашиглах, насжилтыг уртасгах боломж бүрдэнэ.

Бондын эрэлт хангалтгүй тохиолдолд хэрэгжүүлэх арга хэмжээ:

1. Off-take гэрээний санхүүжилт.

Үнэт цаас гаргагч нь Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын 250 сая ам.долларын санхүүжилтийг off-take гэрээгээр шийдвэрлэж ажилласан туршлагатай. 2021-2025 оны мөнгөн урсгалын төсөөлөлд компани нь Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын үлдэгдэл санхүүжилт 647.1 сая ам.долларыг off-take гэрээгээр шийдвэрлэж ажиллахаар тооцсон. Тодруулбал, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад шаардлагатай хөрөнгийн санхүүжилтийг нүүрс урьдчилан борлуулах замаар санхүүжүүлэхээр "Эрдэнэс-Тавантолгой" ХК болон "Бодь Интернэшнл" ХХК нь 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр санхүүжилтийн гэрээний хавсралтаар "Нүүрс нийлүүлэх гэрээ" байгуулсан ба энэхүү гэрээний хүрээнд 2021-2024 онд 11.44 сая тонн орчим нүүрсийг нийлүүлэх, Чалко компанитай 2011 онд байгуулсан урт хугацаат гэрээний үндсэн хугацаанд 2022 онд хүртэл Цанхийн уурхайгаас олборлосон нийт бүтээгдэхүүн (исэлдсэн, зөөлөн коксжих болон коксжих чанартай нүүрс)-ийн 80%-ийг нийлүүлэх ба нэмэлт 5 жилийн хугацаанд 2027 он хүртэл 60%-ийг нийлүүлэхээр тус тус төлөвлөсөн.

Үнэт цаас гаргагчийн нээлттэй бондын эрэлт хангалтгүй нөхцөлд Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын санхүүжилтийг дунд хугацааны борлуулалтын төлөвлөгөө хэсэгт дурдсаны дагуу нүүрс урьдчилан борлуулах замаар шийдвэрлэх бололцоотой.

2. Банкны зээл:

Банкуудын зээлийн хүү нь бондын хүүгээс өндөр байх боловч банкуудын төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү 2016 оны 11 сард 20.6%-тай байснаас 2021 оны 01 сард 15.4%-д, валютын зээлийн жигнэсэн дундаж хүү 2016 оны 08 сард 13.3% байснаас 2021 оны 01 сард 9.0%-д тус тус хүрч тасралтгүй буурсан нь компанийн хувьд санхүүжилтийн таатай нөхцөлийг бүрдүүлж байна. Иймд үнэт цаас гаргагч нь нээлттэй бондын эрэлт хангалтгүй нөхцөлд банкны зээлээр санхүүжилтийг шийдвэрлэх бололцоотой.

3. Охин компани болон төслүүдээс олох ашиг

Мөн компани нь Тавантолгой төмөр зам ХХК-ийн 66%, Гашуунсухайтын авто зам ХХК-ийн 40%, Тавантолгой Дулааны цахилгаан станц ХХК-ийн 30%, Зүүнбаян төмөр зам ХХК-ийн 66%-ийг тус тус эзэмшдэг. 2021-2025 оны мөнгөн урсгалын төсөөлөлд компани нь охин компани болон төслүүдээс 270 сая ам.долларын нэмэлт ашиг олохоор тусгасан. Иймд охин компани болон төслүүдээс орж ирэх ашгаар бусад төслүүдийн санхүүжилтийн тодорхой хэсгийг шийдвэрлэх бололцоотой.

4.6 Бондын эргэн төлөлтийн эх үүсвэр

Үнэт цаас гаргагч нь 2021-2024 онд 135.6 сая тонн нүүрс олборлож, 125.8 сая тонн нүүрс борлуулж, нийт 7,662 сая ам.долларын борлуулалтын орлоготой, 2,521 сая ам.долларын цэвэр ашигтай ажиллахаар төлөвлөсөн. Энэ нь бондын хугацаанд эргэн төлөлт хийхэд бүрэн бололцоотой үзүүлэлт байна.

Хүснэгт 2. 2021-2024 оны орлого ашгийн төлөвлөгөө /сая ам.доллар/

	Нэгж	2021	2022	2023	2024	Нийт
Борлуулалтын орлого	сая ам.доллар	922	1,561	2,287	2,892	7,662
Цэвэр ашиг	сая ам.доллар	172	482	846	1,021	2,521

Үнэт цаас гаргагчийн 2021-2024 оны мөнгөн урсгалын төсөөллөөр нийт 7,662 сая ам.долларын борлуулалтын орлого олж, 4,020 сая ам.долларыг үйл ажиллагааны зардалд зарцуулж, үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн урсгал 2,605 сая ам.долларын үзүүлэлттэй байхаар байна. Компани бондын эргэн төлөлтийг мөнгөн урсгалын төлөвлөгөөнд тусгасан.

Хүснэгт 3. 2021-2024 оны бондын эргэн төлөлтийн төлөвлөгөө /сая ам.доллар/

	Нэгж	2021	2022	2023	2024	Нийт
Нийт борлуулалтын орлого	сая ам.доллар	921.7	1,561.1	2,286.8	2,892.3	7661.9
Үйл ажиллагааны зардал	сая ам.доллар	632.8	849.0	1,085.4	1,452.5	4,019.7
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн урсгал	сая ам.доллар	191.4	498.5	867.5	1,047.9	2,605.3
Бондын эргэн төлөлт	сая ам.доллар	-	-	-	(666.2)	(666.2)

Үнэт цаас гаргагч нь ойрын жилүүдэд буюу 2021-2024 онд дараах дэд бүтцийн төсөл төлөвлөгөөг ашиглалтанд оруулахаар төлөвлөсөн. Тухайлбал:

2021 онд Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг ашиглалтанд оруулсанаар нүүрс тээвэрлэлтийн шинэ гарц бий болгох, нүүрс экспортын кумин



2021.03.05



0000158

МОНГОЛЫН АСОНГИЙН БИРГ
MONGOLIAN STOCK EXCHANGE

чадлыг 15 сая тонноор нэмэгдүүлэх, нүүрс тээвэрлэлтийн өртгийг бууруулах, уг төмөр замаар DAP нөхцөлөөр борлуулалт хийж ажиллахаар төлөвлөсөн.

- 2022 онд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замыг ашиглалтанд оруулсанаар хил нэвтрэх дарааллын асуудлыг шийдвэрлэж, нүүрс экспортын хүчин чадлыг 30 сая тонноор нэмэгдүүлэх, төмөр замаар тээвэрлэснээр 20-30 ам.доллар/тн тээвэрлэлтийн өртгийн хэмнэлт бий болгох, эцсийн хэрэглэгчдэд бүтээгдэхүүнээ нийлүүлэх зэрэг таатай нөхцөлүүдийг бий болгох хүлээлттэй. Мөн уг төмөр замаар DAP нөхцөлөөр борлуулалт хийж ажиллахаар төлөвлөсөн.
- 2021-2022 онд Үндэсний хөгжлийн газраас Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 240 км параллель авто зам, Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн 463 км авто зам, Тавантолгой-Цагаандэл уул чиглэлийн 270 км авто замуудыг ашиглалтанд оруулахаар ажиллаж буй нь үнэт цаас гаргагчийн нүүрс тээвэрлэлтийн чиглэлийг нэмэгдүүлэх, нүүрс тээвэрлэлтийн хүчин чадлыг 30-40 сая тонноор нэмэгдүүлэхээр байна.

Дээрх дэд бүтцийн төслүүд амжилттай хэрэгжсэнээр нүүрсний тээвэрлэлтийн 5 шинэ чиглэл нэмэгдэх, нүүрс тээвэрлэлтийн хүчин чадал 18 сая тонноос 75-85 сая тонноор өсөх, FCA/DAP нөхцөлөөр экспорт хийх боломж бүрдэхээр байна.

Хүснэгт 70. Нүүрс борлуулалт, экспортын төрөл

№	Тээврийн төрөл/чиглэл	Нөхцөл
Одоогийн нүүрс тээвэрлэлтийн чиглэл:		
Авто замаар		
1	Тавантолгой - Гашуунсухайт	FCA
2	Тавантолгой - Чойр	FCA
Дунд хугацаанд нүүрс тээвэрлэлтийн нэмэгдэх чиглэл:		
Авто замаар		
1	Тавантолгой - Гашуунсухайт /параллель/	FCA, DAP
2	Тавантолгой - Ханги	FCA, DAP
3	Тавантолгой - Цагаандэл - Уул	FCA, DAP
Төмөр замаар		
1	Тавантолгой - Гашуунсухайт	DAP+
2	Тавантолгой - Зүүнбаян	DAP+

2022.02.10.3005

Үнэт цаас гаргагч нь эдгээр дэд бүтцийг хэрэгжүүлсэнээр нүүрс тээвэрлэлтийн чиглэлийг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүнийг дундын зуучлалгүйгээр эцсийн хэрэглэгчдэд хүргэх, эцсийн хэрэглэгчидтэй шууд хамтран ажиллах, тогтвортой нийлүүлэлт хийх, урт хугацааны хамтын ажиллагааг хөгжүүлэх, тээвэр логистикийн хямд, найдвартай сүлжээг бий болгох бололцоотой.

Төслүүдийн бий болгох эдгээр эерэг үр нөлөөгөөр компанийн 2021-2024 оны орлого, ашгийн тооцоо нь үндэслэл бүхий, бондын эргэн төлөлтийг гүйцэтгэхэд хангалттай түвшинд байна.

Үнэт цаас гаргагч нь дээрх дэд бүтцийн төслүүдээс гадна нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор нүүрс баяжуулах үйлдвэр барих болон уурхайн үр ашигт байдлыг нэмэгдүүлэхтэй холбоотой нүүрс ажилтын байгууламж, уулын олборлолтын техник, конвейерийн систем нэвтрүүлэх зэрэг төслүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нь компанид нэмэлт эерэг үр нөлөө бий болгох бололцоотой.

Handwritten signature and red stamp of the issuer.

Handwritten signature and red stamp of the Mongolian Stock Exchange.

5.1. Тэргүүлэх андеррайтер компанийн танилцуулга

Хүснэгт 71. Тэргүүлэх андеррайтер компанийн мэдээлэл

Компанийн нэр:	"БиДиСЕК ҮЦК" ХК
Улсын бүртгэлийн дугаар:	9010001030
Регистрийн дугаар:	2052482
Үйл ажиллагааны чиглэл:	Брокер, дилер, хөрөнгө оруулалтын зөвлөх, андеррайтер

- Хавсралт 60. Тэргүүлэх андеррайтер компанийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар

БиДиСЕК ҮЦК ХК нь Монгол Улсад өмч хувьчлал явагдаж Хөрөнгийн зах зээлийн харилцаа бий болсон цагаас үүсэн байгуулагдаж өнөөг хүртэл 30 жилийн турш тасралтгүй үйл ажиллагаа явуулж буй, салбартаа тэргүүлэгч үнэт цаасны компани юм.

Компани нь 2006 онд Монголын Хөрөнгийн Бирж дээр IPO хийснээр нийтэд үнэт цаасаа нээлттэй санал болгосон хамгийн анхны үнэт цаасны компани болсон.

БиДиСЕК ҮЦК ХК нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос олгосон Андеррайтер, Брокер Дилер, Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг бөгөөд 2017 онд гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах тусгай зөвшөөрөл авснаар үнэт цаасны зах зээлийн цогц үйлчилгээг харилцагчиддаа санал болгон ажиллаж байна.

Одоогийн байдлаар компани нь Улаанбаатар хот болон 8 аймагт хөрөнгийн зах зээлийн үйлчилгээг түгээх зөвшөөрөлтэй ба дотоод, гадаадын нийт 310 орчим мянган харилцагчдад үйлчилдэг Монгол улсын хамгийн өргөн брокерийн сүлжээг бий болгоод байна.


2011-2020 онуудад МХБ-ийн үнэт цаасны арилжааны нийт гүйлгээний 8-91%-ийг гүйцэтгэснээс 2012 онд хамгийн өндөр буюу үнэт цаасны гүйлгээний 91%-ийг гүйцэтгэсэн.

Мөн Монголын хөрөнгийн биржид шинээр хувьцаа гарган санхүүжилт татан төвлөрүүлэх ажиллагааны 23.4%-д, нэмэлт хувьцаа гаргах ажиллагааны 90.9%-д, нээлттэй компанийн бондын 24.4%-д нь андеррайтерийн үйлчилгээ үзүүлэн ажилласан туршлагатай.

Тусгай зөвшөөрөл

"БиДиСЕК ҮЦК" ХК-ийн 2005 онд хуучнаар Үнэт цаасны Хороо-ны шийдвэрээр 32 тоот андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаатай авсан ба улмаар Санхүүгийн Зохицуулах Хорооны 2008 оны 06 сарын 12 өдрийн 136 тоот тогтоолоор андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг 3 жил, 2011 оны 06 сарын 12-ны өдрийн 170 тоот тогтоолоор 3 жилийн хугацаагаар тус тус сунгасан.





2013 оны 05 сарын 24-ний өдөр "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль"-ийг шинэчлэн найруулж УИХ-аас баталсан бөгөөд үүнтэй холбоотой холбогдох журмууд шинэчлэгдэж андеррайтерийн тусгай зөвшөөрөл хугацаагүй олгогддог болсон ба тусгай зөвшөөрлийн гэрчилгээ /Хавсралт 61/-г шинэчлэн авсан.

Андеррайтер компанитай байгуулсан гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг

Үнэт цаас гаргагч Эрдэнэс-Тавантолгой ХК нь 2019 оны 11 сарын 12-ны өдөр БиДиСЕК ҮЦК ХК болон Эм Ай Си Си ҮЦК ХХК-тай андеррайтерийн гэрээ /Хавсралт 62/ байгуулсан. Гэрээний дагуу талууд дараах эрх, үүргийг хүлээнэ.

Андеррайтер компанийн эрх, үүрэг:

- Андеррайтер нь гэрээний 2.1-т заасан үйл ажиллагааг Монгол улсын хууль тогтоомжид нийцүүлэн мэргэжлийн түвшинд, тогтоосон хугацаанд хийж гүйцэтгэнэ.
- Андеррайтер нь гэрээнд заасан үйл ажиллагаатай холбогдуулан үнэт цаас гаргагчид мэргэжлийн зөвлөгөөг өгч, үнэт цаасны танилцуулга бэлтгэх, холбогдох журам, заавар боловсруулах, шийдвэр гаргахад энэхүү гэрээ болон холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллана.
- Гэрээт ажлын асуудлаар үнэт цаас гаргагчид зөвлөгөө өгч буй аудит, үнэлгээний болон бусад хөндлөнгийн байгууллага, хуулийн зөвлөх байгууллагатай хамтран ажиллаж, шаардлагатай арга хэмжээг шуурхай шийдвэрлэх үүрэгтэй.
- Үнэт цаасны танилцуулга, холбогдох баримт бичигтэй холбоотойгоор үнэн зөв, алдаагүй хариулах ба үүнээс үүдэн захиалагч болон гуравдагч этгээдэд учруулсан хохироог хариуцна.
- Гэрээнд заасан ажлын гүйцэтгэлийн явцын талаар мэдээлэх, танилцуулах, компанийн саналыг боломжит байдлаар тусгах үүрэг хүлээнэ.
- Үйлчилгээний хөлсийг гэрээгээр тогтоосон хэмжээгээр, тохирсон хугацаанд төлүүлэхээр шаардах эрхтэй.
- Үйлчилгээг үзүүлэх зайлшгүй шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг компаниас шаардан авах эрхтэй. Мэдээлэл, баримт бичгийг шаардлагатай хугацаанаас ажлын хоёроос доошгүй хоногийн өмнө үнэт цаас гаргагчид мэдэгдсэн байна.
- Андеррайтер нь үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай компаниас авсан мэдээлэл, баримт бичгийг гуравдагч этгээдэд задруулахгүй, нууцлалыг чандлан хадгалах үүрэгтэй.
- Гэрээг хэрэгжүүлэх хугацаанд андеррайтер нь үнэт цаас гаргагчийн зөвшөөрөлгүйгээр Үнэт цаас гаргагчийн нэрийн өмнөөс ямар нэгэн баталгаа гаргах болон төлөөлөх эрхгүй.

2021.03.25

• Ү Гэрээний 5.5-д заасны дагуу андеррайтер нь үнэт цаас гаргагч компанид үнэт цаасны данс нээн өгч, олон нийтэд санал болгох компанийн бондын анхдагч зах зээлийн арилжааны нийлүүлэлтийг гүйцэтгэх үүрэгтэй.





- Андеррайтер нь энэхүү гэрээ байгуулагдсан өдрөөс хойш гэрээгээс татгалзах эрхгүй бөгөөд гэрээгээр хүлээсэн аливаа үүргээ бусдад бүхэлд нь болон хэсэгчлэн шилжүүлэхгүй байх үүрэгтэй.



Үнэт цаас гаргагчийн эрх, үүрэг:

- Үнэт цаас гаргагч нь дараах үйл мэдээлэл, баримт бичгүүдийг андеррайтерт гаргаж өгнө. Үүнд:
- Ирээдүйн 3-5 жилийн бизнес төлөвлөгөө;
- Үйл ажиллагаа явуулах зах зээлийн судалгаа, мэдээлэл, тоо баримт;
- Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомж болон холбогдох журмуудаар шаардагдах мэргэжлийн байгууллагуудын хараат бус дүгнэлтүүд;
- Компанийн тухай хуулийн 87.1-т заасан их хэмжээний хэлцэлд тооцогдох бусадтай байгуулсан гэрээ хэлцлүүд;
- Санхүүгийн нөхцөл байдал, авлага, өр төлбөрийн байдал, нарийвчилсан задаргаа;
- Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнуудын талаар эрх бүхий байгууллагаас шаардсан мэдээлэл;
- Толгой компани болон зэргэлдээ компаниудын талаарх эрх бүхий байгууллагаас шаардсан мэдээлэл;
- Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлэхэд хууль журмын хүрээнд зайлшгүй шаардагдах бусад бүх мэдээлэл.
- Үнэт цаас гаргагч нь бэлтгэн өгч буй мэдээ, мэдээллийн үнэн зөвийг хариуцах ба уг мэдээллийн үнэн бодит байдалтай нийцэхгүйгээс үүдсэн аливаа хохирлыг үнэт цаас гаргагч хариуцна.
- Андеррайтерын үйлчилгээтэй холбоотой үйл ажиллагааны явцын талаар бүрэн мэдээлэл авах эрхтэй.
- Андеррайтераас гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй бөгөөд Үнэт цаас гаргагч нь олон нийтэд санал болгох компанийн бонд байршуулах үнэт цаасны дансыг тэргүүлэх андеррайтераар нээлгэж, компанийн бондын анхдагч зах зээлийн арилжааны нийлүүлэлтийг гүйцэтгэнэ.

5.2 Дэд андеррайтер, санхүүгийн зөвлөх компанийн танилцуулга

Хүснэгт 72. Эм Ай Си Си ҮЦК ХХК-ийн товч мэдээлэл

Компанийн нэр:	Эм Ай Си Си ҮЦК ХХК
Улсын бүртгэлийн дугаар:	9011472094
Регистрийн дугаар:	5011558
Үйл ажиллагааны чиглэл:	Брокер, дилер, хөрөнгө оруулалтын зөвлөх андеррайтер

Кавсрагт 63. Дэд андеррайтер компанийн улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар





Эм Ай Си Си ҮЦК ХХК нь хувьцааны болон зээлийн санхүүжилт, мөн IPO болон компанийн нэгдэх, худалдан авахад зуучлах хэлцлүүдийг амжилттай хэрэгжүүлсэн. Төрийн болон хувийн хэвшлийн аж ахуй нэгжүүдэд, мөн монгол улсад хөрөнгө оруулалт хийх сонирхолтой гадаадын томоохон корпорациудад зөвлөгөө өгөх чиглэлээр мэргэшсэн.

Санхүүгийн зөвлөх үйлчилгээ

- Дотоодын зах зээлд хамгийн сайн холбоо, мэдээлэлтэй,
- Гадны байгууллагуудтай хамтран ажиллаж байсан туршлагатай, ажлын гүйцэтгэл өндөр.
- Олон улсын тэргүүлэгч хувьцаа болон зээлийн санхүүжүүлэгч байгууллагууд, санхүүгийн мэргэжилтнүүдтэй харилцан уялдаатай ажиллаж, олон улсын банкуудтай стратегийн түншлэл үүсгэсэн.

Голлох салбарууд

- Уул уурхай, худалдаа үйлчилгээ, хөдөө аж ахуй, үл хөдлөх хөрөнгө, харилцаа холбоо зэрэг салбаруудад мэргэшсэн.

Үнэт цаасны арилжаа

- Монголын хөрөнгийн бирж болон олон улсын ASX, HKEx, TSXV зэрэг биржүүд дээр ажилттай IPO гүйцэтгэсэн.
- Монголын хөрөнгийн бирж болон олон улсын бирж дээр IPO болон үнэт цаас худалдах хоёрдох саналууд дээр хөрөнгө оруулах хүсэлтэй хөрөнгө оруулагчилтай тусгайлан ажилладаг.
- Монголд үйл ажиллагаа явуулж буй, гадны хөрөнгийн бирж дээр арилжаалагддаг уул уурхайн томоохон компаниудын талаар хамгийн өргөн мэдлэг туршлагатай баг хамт олон.

Судалгаа шинжилгээ


- Зах зээлийн болон чухал үйл явдлуудад дүн шинжилгээ хийх, МХБ болон гадаадын хөрөнгийн бирж дээр хувьцааны шинжилгээ хийдэг.
- Дэлхийн эдийн засгийн чиг хандлага, дотоодын зах зээл дэх мэдлэг болон сан дээр суурилсан анализ хийж Монгол улсын бизнесийн салбаруудад үнэлгээ хийдэг.

Тусгай зөвшөөрөл

"ЭМ АЙ СИ СИ ҮЦК" ХХК -ийн 2007 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн Санхүүгийн Зохицуулах Хорооны шийдвэрээр 169 дугаар тогтоолоор брокер, диллерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авсан ба улмаар Санхүүгийн Зохицуулах Хорооны 2011 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 353 тоот тогтоолоор брокер, диллерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар, 2013 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 501 тоот тогтоолоор 3 жилийн хугацаагаар тус тус сунгасан. Санхүүгийн Зохицуулах Хорооны 2010 оны 10 дугаар сарын 27 өдрийн 307 тоот тогтоолоор андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг 3 жил, 2012 оны 07 дүгээр сарын 30-ны өдөр 3 жилийн хугацаагаар сунгав. 2013 оны 05 сарын 24-ний өдөр



2021.03.29



"Үнэт цаасны зах зээлийн тухай хууль"-ийг шинэчлэн найруулж УИХ-аас баталсан бөгөөд үүнтэй холбоотой холбогдох журмууд шинэчлэгдэж андеррайтерийн тусгай зөвшөөрөл хугацаагүй олгогддог болсон. /Хавсралт 64/

Гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг

Дэд андеррайтер, санхүүгийн зөвлөх нь Үнэт цаас гаргагч, БиДиСЕК ҮЦК ХК-тай 2019 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр байгуулсан андеррайтерийн гэрээний дагуу Тэргүүлэх андеррайтертай адил эрх, үүргийг хүлээнэ.

Андеррайтерын дүгнэлтийг Хавсралт 65-аас үзнэ үү.

5.3. Үнэлгээний компанийн танинцуулга

Хүснэгт 73. Үнэлгээний компанийн мэдээлэл

Компанийн нэр:	"БДО Аудит" ХХК
Улсын бүртгэлийн дугаар:	9018001010
Регистрийн дугаар:	2546442
Үйл ажиллагааны чиглэл:	Аудит, бизнес, хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагаа /64990/

- Хавсралт 66. Үнэлгээний компанийн улсын бүртгэлийн гэрчилгээ

"БДО Аудит" ХХК нь аудит, нягтлан бодох бүртгэл, зөвлөх үйлчилгээний дэлхийн тав дахь том сүлжээ юм. БДО-ийн дэлхий даяарх 60,000 гаруй ажилчид дэлхийн 152 орон дахь 1,328 салбар оффисоороо дамжуулан харилцагчидтайгаа хамтран ажилладаг байна.

БДО сүлжээ нь 1963 онд мэдлэг туршлага солилцон, өргөжүүлж харилцагчдад илүү сайн үйлчилгээ үзүүлэхийн тулд Их Британий Нэгдсэн Вант Улс болон Канадын байгууллагууд нэгдсэнээр анх үүсгэн байгуулагдсан юм. БДО нь Бейндер Дикер Отте & Ко гэж нэрээ солихоос өмнө буюу 1973 он хүртэл Бейндер Сайдман Интернэйшл гэдэг нэрээр дэлхийд танигдсан.

БДО-ийн Монгол дахь оффис 2012 оны 12 сард Улаанбаатар хотноо БДО Монгол нэртэйгээр Монгол улсын аудит, нягтлан бодох бүртгэл, зөвлөх үйлчилгээний салбарт 15 жилийн туршлагатай "Итгэлт Аудит" ХХК-ийн суурин дээр үүсгэн байгуулагдсан. "БДО Аудит" ХХК нь чиглэл чиглэлээр мэргэшсэн зэрэг, цолтой 2 партнер, 40 орчим мэргэжилтнүүд бүхий чадварлаг багийн туршлага, мэдлэгээр дамжуулан үйлчлүүлэгчдийн бизнесийг дэмжин ажилладаг.

Үнэлгээ ба шинжилгээ, аудит ба баталгаажуулалт, дотоод, гадаад аутсорсинг, бизнесийн зөвлөх үйлчилгээ, татвар ба хууль зүйн зөвлөх үйлчилгээ зэрэг үйлчилгээг үйлчлүүлэгчиддээ үзүүлж, хамтран ажилладаг байна.

"БДО Аудит" ХХК нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос тавигддаг шаардлагыг хангаж, дараах салбарт ажиллах жагсаалтад бүртгэгдсэн. Үүнд:

- Монголын үнэт цаасны зах зээл дээр үнэт цаас гаргагчдад аудитын үйлчилгээ үзүүлэх
- Монголын үнэт цаасны зах зээл дээр үнэт цаас гаргагчдад хөрөнгийн болон бизнесийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх



2021.03.26

Тусгай зөвшөөрөл

2021-03-19

"БДО Аудит" ХХК-д Сангийн сайдын 2012 оны 12 сарын 27-ны өдрийн 287 тоот тушаалаар 3 жилийн хугацаатайгаар аудитын үйл ажиллагаа эрхлэх 009-1997 дугаартай тусгай зөвшөөрлийн гэрчилгээг олгосон байна. Сангийн сайдын 2015 оны 325 дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг 2015 оны 12 сарын 27-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар, 2018 оны 12 сарын 26-наас 3 жилийн хугацаатайгаар тус тус сунгажээ. /Хавсралт 67/

"БДО Аудит" ХХК-ийн үнэлгээчин Гомбо овогтой Баянмөнхөд Сангийн сайдын 2010 оны 12 сарын 20-ний өдрийн 280 тоот тугаалаар 3 жилийн хугацаатай хөрөнгийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрлийн гэрчилгээг олгосон. 2013 оны 286 дугаар тушаалаар 2013 оны 12 сарын 20-ний өдрөөс 3 жилийн хугацаагаар, 2017 оны 07 дугаар тушаалаар 2017 оны сарын 11-ний өдрөөс 3 жилийн хугацаагаар, 2019 оны 262 дугаар тушаалаар 2019 оны сарын 17-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар тус тус сунгасан.

"БДО Аудит" ХХК-ийн үнэлгээчин Жамсранжав овогтой Энхчимэгт Сангийн сайдын 2010 оны 12 сарын 20-ны өдрийн 280 тоот тугаалаар 3 жилийн хугацаатай хөрөнгийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрлийн гэрчилгээг олгосон. 2013 оны 286 дугаар тушаалаар 2013 оны 12 сарын 20-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар, 2017 оны 07 дугаар тушаалаар 2017 оны 01 сарын 11-ний өдрөөс 3 жилийн хугацаагаар, 2019 оны 262 дугаар тушаалаар 2019 оны 12 сарын 17-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар тус тус сунгасан.

Үнэлгээний компанитай байгуулсан гэрээний эрх, үүрэг

Үнэт цаас гаргагч Эрдэнэс-Тавантолгой ХК болон БДО аудит ХХК-ийн хооронд 2019 оны 12 сарын 13-ны өдөр байгуулсан ЭТТ-2019/850 тоот "Хөрөнгийн үнэлгээний зөвлөх үйлчилгээний гэрээ" /Хавсралт 72/-ний дагуу Үнэлгээний байгууллага болон Үнэт цаас гаргагч нь дараах эрх, үүргийг хүлээнэ.

Үнэлгээний компанийн эрх үүрэг


- Зөвлөх нь Гэрээний 2.1-т заасан үйл ажиллагааг монгол улсын хууль тогтоомж, олон улсын стандартад нийцүүлэн мэргэжлийн түвшинд, тогтоосон хугацаанд хийж гүйцэтгэнэ.
- Зөвлөх нь гэрээнд заасан үйл ажиллагаатай холбогдуулан Захиалагчид мэргэжлийн зөвлөгөө өгч, Үнэт цаасны танилцуулга бэлтгэх, холбогдох журам, заавар боловсруулах, шийдвэр гаргахад энэ гэрээ болон холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллах үүрэгтэй.
- Захиалагчийн хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбогдон гаргах шаардлагатай тогтоол, шийдвэрийн төсөл, загварын бэлтгэн өгөх үүрэгтэй.
- Зөвлөх нь Захиалагчийг хөрөнгийн үнэлгээтэй холбоотой боломжит бүхий л мэдээллээр хагаж, зөвлөгөө өгч ажиллана.

• Гэрээт ажлын асуудлаар Захиалагчид зөвлөгөө өгч буй бусад Зөвлөхүүд андеррайтер, аудитор болон хуулийн зөвлөх байгууллага зэрэгтэй хамтран ажиллаж шаардлагатай арга хэмжээг шуурхай шийдвэрлэх үүрэгтэй.

2021-03-19



0000165



- Үнэт цаасны танилцуулга болон холбогдох баримт бичгийг бэлтгэхэд өөрийн чиг үүргийн хүргээнд оролцох, өөрийн гүйцэтгэсэн ажилтай холбоотойгоор бусдад учруулсан хохирлыг хариуцна.
- Гэрээнд заасан ажлын явцын гүйцэтгэлийн талаар мэдээлэх, танилцуула, Захиалагчийн саналыг боломжит байдлаар тусгах үүрэг хүлээнэ.
- Үйлчилгээний хөлсийг гэрээгээр тогтоосон хэмжээгээр, тохирсон хугацаанд төлүүлэхээр шаардах эрхтэй.
- Үйлчилгээг үзүүлэх зайлшгүй шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг Захиалагчаас шаардан авах эрхтэй. Мэдээлэл баримт бичиг шаардлагатай байгаа талаар ажлын 2 /хоёр/-оос доошгүй хоногийн өмнө Захиалагчид мэдэгдсэн байна.
- Зөвлөх нь хөрөнгийн үнэлгээний үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай компаниас авсан мэдээлэл, баримт бичгийг гуравдагч этгээдэд задруулахгүй, нууцлалыг чандлан хадгалах үүрэгтэй.
- Гэрээг хэрэгжүүлэх хугацаанд Зөвлөх нь Захиалагчийн зөвшөөрөлгүйгээр ямар нэгэн баталгаа гаргах болон төлөөлөх эрхгүй.
- Зөвлөх нь хөрөнгийн үнэлгээний тайланг монгол, англи хэл дээр боловсруулах үүрэгтэй.
- Зөвлөх нь өөрийн гүйцэтгэсэн ажилтай холбоотойгоор бусдад учруулсан хохирлыг хариуцна.

Үнэт цаас гаргагчийн эрх, үүрэг

- Үнэт цаас гаргагч нь дараах мэдээлэл, баримт бичгүүдийг Зөвлөхөд гаргаж өгнө. Үүнд:
 - Компанийн биет болон биет бус хөрөнгийн бүртгэл
 - Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох хууль журмуудаар шаардагдах мэргэжлийн байгууллагуудын хараат бус дүгнэлтүүд
 - Компанийн тухай хуулийн 87.1-т заасан их хэмжээний хэлцэлд тооцогдох бусадтай байгуулсан гэрээ хэлцлүүд
 - Сүүлийн 3-5 жилийн санхүүгийн тайлан, тодруулга, санхүүгийн нөхцөл байдал, авлага, өр төлбөрийн байдал, нарийвчилсан задаргаа
 - Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнуудын талаар эрх бүхий байгууллагаас шаардсан мэдээлэл
 - Толгой компани болон охин компаниудын талаарх эрх бүхий байгууллагаас шаардсан мэдээлэл
 - Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлэхэд хууль журмын хүрээнд зайлшгүй шаардагдах бусад бүх мэдээлэл

Үнэт цаас гаргагч нь энэ гэрээний 5.1-т заасан мэдээ, мэдээллийн үнэт зөвийг хариуцах ба уг мэдээллийн үнэн бодит байдалтай нийцээгүйгээс үүдэн гарах аливаа үр дагаврыг захиалагч хариуцна.



2021.03.08 14:03:00



0000166

ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ ХК

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN HERENGIYAN BIIRJH
MONGOLIAN HERENGIYAN BIIRJH

2021-03-19

БҮРТГЭЭ-02

- Хөрөнгийн үнэлгээний үйлчилгээтэй холбоотой үйл ажиллагааны явцын талаар Зөвлөхөөс бүрэн мэдээлэл авах эрхтэй.
- Гэрээний хавсралт №1-т заасан Үйлчилгээний төлөвлөгөөний хуваарийг дагаж мөрдөхийг Зөвлөхөөс шаардах эрхтэй.
- Зөвлөхөөс гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй.
- Зөвлөх гэрээнд заасан үүргээ биелүүлээгүйн улмаас Захиалагчид хохирол учирсан бол хохирлыг зөвлөхөөс шаардах эрхтэй.
- Захиалагч нь сүүлийн 3 жилийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг агуулсан цахим мэдээллийн санд нэвтрэх эрхийг Зөвлөхөөс сонгогдсон мэргэжилтэнд олгоно.

5.4. Харааг бүс үнэлгээний тайлангийн хураангуй

5.4.1. Бизнесийн үнэлгээ

2021 оны 03 сард БДО аудит ХХК болон Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн нарын хооронд байгуулсан №ЭТТ-2019/850 дугаартай Үнэлгээний зөвлөх үйлчилгээний гэрээ, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай гэрээний дагуу 2020 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болгон Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн бизнесийн 100 хувийн өмчид хамаарах бизнесийн үнэлгээг хийж гүйцэтгэсэн. Бизнесийн үнэлгээний тайлан нь Эрдэнэс Тавантолгой ХК-ийн 2021 онд Монголын Хөрөнгийн Бирж дээр арилжаалахаар төлөвлөж буй Компанийн бондыг бүртгүүлэхэд зориулан тусгайлан бэлтгэгдсэн болно.

Үнэлгээний арга, хандлага

БДО аудит ХХК нь бизнесийн 100 хувийн хувь оролцооны үнэлгээг бэлтгэхдээ орлогын хандлага болон зах зээлийн хандлагыг авч үзсэн.

- *Орлогын хандлага (ХЧМУ-хорогдуулсан чөлөөт мөнгөн урсгалын арга):* Бизнесийн бий болгож чадах эдийн засгийн өгөөж буюу мөнгөн урсгалд үндэслэн үнэлгээг гаргадаг тул компанийн ирээдүйд үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэх төсөөлөлтэй нийцдэг. Мөн ирээдүйд бүтээн босгох үйлдвэрийн ажилд шаардагдах капитал, хугацааны мэдээллийг тусгахад хамгийн зохистой байдаг.
- *Зах зээлийн хандлага (ЖКАЗ-жишиг компанийн арга зүй, ЖААЗ-жишиг арилжааны арга зүй):* Бизнесийн үнийн мэдээлэл нь бэлэн олдоцтой байгаа, ижил буюу жиших боломжтой бизнесийн орц мэдээлэлд үндэслэн үнэлгээг тооцдог тул бизнесийн хувьд хамгийн бодитой, ул үндэслэлтэй үнэ цэнийн дүгнэлт гаргах боломж олгодог. Салбарын өнөөгийн төлөв байдал, зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэр, хөрөнгө оруулагчдын хандлагыг тусгахад илүү тохиромжтой байдаг.

БДО аудит ХХК нь Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн өмчийн зах зээлийн үнэ цэнийг үнэлгээний өдрийн байдлаар орлогын хандлагаар 13,629 тэрбум төгрөг, зах зээлийн хандлагын ЖКАЗ-ээр 12,132.0 тэрбум төгрөгөөр, зах зээлийн хандлагын ЖААЗ-ээр 16,973.1 тэрбум төгрөгөөр тооцоолсон.



2021-03-19

Үнэлгээний компани нь мэргэжлийн багийн түвшинд шүүн тунгаасны үндсэн дээр, Орлогын хандлагад суурилсан үнэлгээний үр дүн нь компанийн 100%-ийн өмчийн зах зээлийн үнэ цэнийг илүү төлөөлж байна гэж дүгнэсэн. Иймд нэгж хувьцааны үнэ 1,135.72 (нэг мянга нэг зуун гучин зургаан төгрөг) байх үндэслэлтэй болохыг тооцсон байна.

	ЖКАЗ	ЖААЗ	ХЧМУ
Хяналтын эрхгүй нэгж хувьцааны зах зээлийн үнэ цэнэ	1,011.00 төгрөг	1,149.94 төгрөг	1,135.72 төгрөг
Хяналтын эрхтэй нэгж хувьцааны зах зээлийн үнэ цэнэ	1,243.53 төгрөг	1,414.43 төгрөг	

Орлогын хандлага: Хорогдуулсан чөлөөт мөнгөн урсгалын аргаар тооцсон үр дүн

Үнэлгээний компани нь өөрсдийн үнэлгээний шинжилгээ, удирдлагаас хүлээн авсан санхүүгийн мэдээлэлд суурилан Эрдэнэс Тавантолгой ХК-ийн ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийг тооцож, 100%-ийн хувь оролцооны үнэ цэнийг хорогдуулсан чөлөөт мөнгөн урсгалын аргаар тодорхойлсон.

Эрдэнэс Тавантолгой ХК-ийн бизнесийн үнэлгээний зорилго нь хөрөнгийн зах зээлд шинээр хувьцаа гаргаж зарах зорилго агуулаагүй учраас мөнгөн урсгалын загварт хяналттай нэмэгдэл, хяналтгүйн болон хөрвөх чадваргүйн хорогдуулга тооцох нь тохиромжгүй гэж үзсэн байна.

Мөнгөн урсгалын прогнозыг удирдлагаас ирүүлсэн түүхэн санхүүгийн мэдээлэл болон 5 жилийн бизнес төлөвлөгөөнд үндэслэн боловсруулсан бөгөөд капиталын жигнэсэн дундаж өгөөжийг 17.3%, өмчийн өртгийг капитал хөрөнгө үнэлгээний загвар (КХҮЗ)-ийг ашиглан 18.7%-аар тооцсон. Мөн түүнчлэн дараах арга зүй, параметруудийг мөнгөн урсгалын прогнозад ашигласан байна. Үүнд:

- Терминал үнэ цэнийг Гордоны тогтмол өсөлтийн загвар ашиглан тооцсон.
- Урт хугацааны өсөлтийн параметрийг сонгохдоо Сангийн яам болон Дэлхийн Банкны хамтарсан урт хугацааны эдийн засгийн өсөлтийн судалгаанд үндэслэн судалгааны дунджаас доогуур түвшинд 3% байхаар сонгон авсан.
- Эрдэнэс Тавантолгой ХК нь олсон цэвэр ашигаа 100% ногдол ашигт олгоно.

Хорогдуулсан мөнгөн урсгалын загварын үр дүнгээс дүгнэхэд үнэлгээний өдрийн байдлаар Эрдэнэс Тавантолгой ХК-ийн бизнесийн 100%-ийн хувьцаа эзэмшигчдийн өмчийн нийлбэр бодит үнэ цэнэ 13,629 тэрбум (арван гурван их наяд зургаан зуун хорин есөн тэрбум) төгрөг, нэгж энгийн хувьцааны үнэ 1,135.72 (нэг мянга нэг зуун гучин зургаан төгрөг) төгрөг байх үндэслэлтэй байна.

Хүснэгт 74. Хорогдуулсан мөнгөн урсгалын загвараар тооцсон үнэлгээний үр дүн

Үнэлгээний өдрөөр Өмчийн үнэ цэнэ:	Өмчийн 100% үнэ цэнэ		Нэгж Хувьцааны Үнэ цэнэ
	Мян.дол	Сая.төг	Төг.мөн
ААНЧМУ-г КҮЖДӨ-өөр	4,781,998	13,628,694	1,135.72
ААНЧМУ-г ТӨҮЦ	4,340,242	12,369,689	1,030.81
ӨЧМУ-г Өмчийн өртгөөр	3,893,699	11,097,042	924.75
Ногдол ашгийг Өмчийн өртгөөр	3,950,083	11,257,737	938.74

Эрдэнэс Тавантолгой ХК-ийн захирлын гарын үсэг

Эрдэнэс Тавантолгой ХК-ийн захирлын гарын үсэг

Сонгосон үнэ цэнэ	4,781,998	13,628,694	1,135.72
Бизнесийн үнэ цэнэ (EV)	4,813,306	13,717,923	
Мөнгө	47,221	134,580	
Өр	-444,242	-1,266,089	
Өмчийн хөрөнгө оруулалт	365,712	1,042,280	
Өмчийн бодит үнэ цэнэ	4,781,998	13,628,694	
Гаргасан энгийн хувьцааны тоо/сая.ш/	12,000	12,000	
Нэгж энгийн хувьцааны бодит үнэ цэнэ (төг.мөн)	\$0.40	1,135.72	1,135.72

5.4.2 Хөрөнгийн үнэлгээ

2019 оны 12 сарын 23-нд БДО аудит ХХК болон Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн нарын хооронд байгуулсан гэрээний дагуу БДО аудит ХХК нь 2019 оны 09 сарын 30-ний өдрөөр тасалбар болгон Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн хөрөнгийн үнэлгээний тайланг хийж гүйцэтгэсэн.

Хөрөнгийн үнэлгээний тайланд өртгийн хандлага хэмээн нэрлэгддэг хөрөнгөд суурилсан хандлагын үр дүнг тайлагнасан. Хөрөнгийн хандлага нь дангаар бизнесийн зах зээлийн үнэ цэнийг төлөөлж чаддаггүй бөгөөд зөвхөн гарааны компаниуд болон хөрөнгөд суурилсан бизнестэй компаниудын бизнесийг үнэлэхэд хааяа ашигладаг хандлага юм.

Өртгийн хандлага: Тохируулсан цэвэр хөрөнгийн арга

Үнэлгээний компани нь бизнесийн хувь оролцоог үнэлэхдээ үнэлгээний өдрөөрх компанийн хөрөнгө, өр төлбөрийн дансны үнийг үнэлэгдсэн хөрөнгө тус бүрийн үнэлгээний үр дүн рүү шилжүүлэн тохируулсан байна. Үүнд:

- Компанийн үндсэн хөрөнгийн бүлгийн үл хөдлөх хөрөнгө, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслэлийн ангид багтсан бүх хөрөнгийн бодит үнэ цэнийг өртгийн хандлагын элэгдэл тооцсон нөхөн орлуулах өртгийн аргаар үнэлж, хөрөнгийн үнэлгээний тайланд тусгасан.
- Харин биет бус хөрөнгийн бүлэгт багтсан хөрөнгүүдийг эхлээд НББОУС 38-аар шаардсан биет бус хөрөнгийн шалгуур хангаж байгаа эсэхийг нягталж, биет бус хөрөнгийн шинжийг илэрхийлж байгаа биет бус хөрөнгүүдийг хөрөнгийн үнэлгээний тайланд өртгийн хандлагаар тусгасан. Харин биет бус хөрөнгийн шинжгүй зүйлсийн бодит үнэ цэнийг 0 байна гэж үзсэн. Учир нь биет болон биет бус хөрөнгийн шинж агуулаагүй зүйлс нь тухайн зардал гарсан тайлант жилд зардлаар хүлээн зөвшөөрөгдөж ашигийг бууруулах нөлөө үзүүлэх юм.
- Компанийн санхүүгийн тайланд Хувьцаа гэсэн нэрээр бүртгэгдсэн биет бус хөрөнгө /Ашиглалтын тусгай зөвшөөрлөөр эзэмшиж буй ордуудыг ашиглах эрх/ийн дансны үнэ нь 11,157.1 тэрбум төгрөг буюу тооцоолсон бодит үнээс материаллаг хэмжээгээр илүү илэрхийлэгдсэн байна. Эрдэнэс Тавантолгой ХК ба БДО Аудит ХХК-ийн хооронд байгуулсан ЭТТ-2019/850 дугаартай гэрээний 2.1.1-д "ашигт малтмалын ордын үнэлгээ орохгүй" гэж заасан учраас үнэлгээний компани нь Эрдэнэс Тавантолгой ХК-ийн ордын үнэлгээний үр дүнг энэхүү үнэлгээний тайланд тусгах үүрэг хүлээгээгүй болно. Эдгээр ордуудын түүхэн өртөг нь ашиглалтын тусгай зөвшөөрөл гэсэн ангилалд тусгагдсан учраас "хувьцаа" нэрээр бүртгэгдсэн биет бус хөрөнгийн өртөг 0 (тэг) гэж тооцон үнэлгээнд ашигласан байна.

- Компанийн охин, хараат, хамтарсан компаниудад оруулсан хөрөнгө оруулалтыг нягтлан бодох бүртгэлийн Өмчийн аргыг ашиглан анхны хөрөнгө оруулалтыг



2021-03-19

тохируулж үнэлсэн. Үнэлгээний үр дүнг мөн хөрөнгийн үнэлгээний тайланд тусгасан.

- Компанийн уурхайн хөрөнгө болон уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн нөөцийг ирээдүйн олборлолт хийх жил бүрийн таамагласан мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнээр үнэлж, үр дүнг нь хөрөнгийн үнэлгээний тайланд тусгасан.
- Эцэст нь компанийн үлдсэн эргэлтийн ба эргэлтийн бус хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэнд үнэ цэнийн бууралт байгаа эсэхэд үнэлгээний тест гүйцэтгэж, шаардлагатай тохиолдлуудад холбогдох үнэлгээний тохируулга хийсэн байна.

Үнэлгээний компани нь өртгийн хандлагаар Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн цэвэр өөрийн хөрөнгийн үнэлгээг 1.61 их наяд төгрөг байхаар тооцоолсон байна. Үнэт цаас гаргагч нь 11.2 их наяд төгрөгийн балансын үлдэгдэл бүхий биет бус хөрөнгө /ашиглалтын тусгай зөвшөөрлөөр эзэмшиж буй ордуудыг ашиглах эрх/-тэй. Үнэлгээний компани нь үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээнд ашигт малтмалын ордын үнэлгээг хийхгүй байхаар тусгасан тул Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн 1.61 их наяд төгрөгийн цэвэр өөрийн хөрөнгийн үнэлгээ нь уг биет бус хөрөнгийн үнэлгээг багтаагүй дүн болно.

Үнэлэгдсэн хөрөнгүүдийг үр дүнгээр Тохируулга хийсэн цэвэр хөрөнгийн үр дүнг нэгтгэсэн Санхүүгийн хөрөнгө, эх үүсвэрийн хураангуйг хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 75. Хяналтын нэмэгдэлийн тохируулгын дараах нэгж хувьцааны үнэ

Хөрөнгийн анги	Үнэлэхээс өмнө 9/30/2019 МЯН.ТӨГ	Үнэлгээний Тохируулга МЯН.ТӨГ	Тохируулсан дүн 9/30/2019 МЯН.ТӨГ
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгөн хөрөнгө	1,272,397,120		1,272,397,120
Дансны авлага	121,512,939	(1,644,611)	119,868,328
Татвар_НДШ	64,695		64,695
Бусад авлага	485,174		485,174
Бусад санхүүгийн хөрөнгө	15,479,408		15,479,408
Бараа материал	107,652,271		107,652,271
Урьдчилж төлсөн зардал, тооцоо	170,133,881	(161,593,481)	8,540,400
Борлуулах зорилгоор эзэмшиж буй бүлэг хөрөнгө	392,534	(169,784)	222,750
Нийт эргэлтийн хөрөнгө	1,688,118,023	(163,407,876)	1,524,710,147
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	35,289,417	(1,972,638)	33,316,779
Биет бус хөрөнгө	11,164,940,050	(11,153,716,350)	11,223,700
Урт хугацаат хөрөнгө оруулалт	15,762,009	539,757,501	555,519,510
Хайгуул, үнэлгээний хөрөнгө	16,029,861		16,029,861
Хойшлогдсон татварын хөрөнгө	190,579		190,579
Уурхайн хөрөнгө	392,273,205	286,961,883.5	679,235,088
Бусад эргэлтийн бус хөрөнгө	156,060,844	(94,618,360)	61,442,484
Нийт эргэлтийн бус хөрөнгө	11,780,545,965	(10,423,587,964)	1,356,958,001
Нийт хөрөнгө	13,468,663,988	(10,586,995,840)	2,881,668,148
Өр төлбөр:			
Эргэлтийн өр төлбөр	411,097,328	539,016,800	

Handwritten signature and red stamp of the company.

Handwritten signature and red stamp of the auditor.

2021.03.26

СЭХ
2021.03.26
СЭР

0000170

БҮРТГЭВ

№ 01



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE

Уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн нөөц	31,808,480	286,961,883	318,770,363
Хойшлогдсон татварын өр	5,802,444		5,802,444
Нийт өр төлбөр	448,708,252	825,978,683	1,274,686,935
Нийт эздийн өмч	13,019,955,736	(11,412,974,524)	1,606,981,212
Нийт өр ба эздийн өмчийн дүн	13,468,663,988	(10,586,995,840)	2,881,668,148

Дэлгэрэнгүй тайланг Хавсралт 71-оос үзнэ үү.

5.5. Хуулийн компанийн танилцуулга

Хүснэгт 76. Хуулийн компанийн мэдээлэл

Компанийн нэр:	Өмгөөллийн "Батбаяр энд партнерс" ХХН
Улсын бүртгэлийн дугаар:	000075952
Регистрийн дугаар:	5722292
Үйл ажиллагааны чиглэл:	Хууль зүйн зөвлөгөө, туслалцаа, өмгөөллийн үйл ажиллагаа /6910/

- Хавсралт 68. Хуулийн компанийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар

Өмгөөллийн Батбаяр энд Партнерс ХХН ("Хуулийн фирм"), бизнесийн мэргэшсэн хуулийн фирм нь Монгол Улсад Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль (2013) батлагдсанаар өөрчлөн байгуулагдсан, Монголын Хуульчдын Холбооны гишүүн хуульч, өмгөөлөгчдийн үүсгэн байгуулсан хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл юм.

Тус Хуулийн фирм нь Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн №72 тоот тогтоолын дагуу үнэт цаасны зах зээлийн оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх тусгай зөвшөөрөл авсан, үнэт цаасны зах зээлийн оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх, хөндлөнгийн дүгнэлт гаргаж өгөх үйлчилгээ үзүүлэх эрхтэй болно.

Хуулийн фирм нь байгууллагын хэрэглэгчдэд санхүүгийн эрх зүй, компанийн эрх зүй, компанийн засаглал, хөрөнгийн зах зээл, үнэт цаас, анхдагч зах зээл дээр хувьцааг нийтэд санал болгох (IPO, Pre-IPO, бонд, үүсмэл санхүүгийн хэрэгсэл г.м.), бизнесийн ашигт ажиллагаа, өөрчлөн байгуулалт (M&A), даатгал, эрсдэлийн удирдлага, бүтээн байгуулалт (төмөр зам, авто зам, угаах үйлдвэр, эрчим хүчний г.м) дэд бүтэц, төслийн санхүүжилт, эрчим хүч, уул уурхайн олборлолт, хуулийн магадлан шалгах дүн шинжилгээ (Due Diligence), шүүхийн маргаан (татварын харилцаа, иргэний болон захиргааны хэрэг, маргаан)-ны асуудлаар мэргэшсэн бөгөөд олон улс, хил дамнасан гэрээ, хэлцэлд болон уул уурхай, эрдэс баялгийн салбарт хууль зүйн зөвлөгөө өгч ажилласан, гадаад, дотоодын хөрөнгийн биржид хувьцаа, өрийн бичиг, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах хэд хэдэн удаагийн ажлуудыг амжилттай хийж гүйцэтгэсэн туршлагатай, зах зээлд тэргүүлэгч мэргэшсэн фирм юм.

Тусгай зөвшөөрөл

Санхүүгийн Зохицуулах Хорооны 2014 оны 03 сарын 12-ны өдрийн 72 тоот тогтоолын дагуу Монгол Улсад үнэт цаасны эрх зүйн зохицуулалтын талаар үйлчлүүлэгчдэд зөвлөгөө өгөх эрх авч, бүртгэгдсэн. /Хавсралт 69/

2021.03.26



Өмгөөллийн нөхөрлөлийн тусгай зөвшөөрөл

Гэрчилгээ олгосон огноо	Тогтоолын дугаар	Эрхлэх үйл ажиллагаа
2015 оны 01 сарын 01	039	Өмгөөллийн хуулийн этгээдийн үйл ажиллагаа
2014 оны 03 сарын 12	72	ҮЦ33-д оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх

2021-03-19

БҮРТГЭВ-02

Хуульчдын тусгай зөвшөөрөл

Хүснэгт 78. Хуулийн компанийн хуульчдын тусгай зөвшөөрөл

№	Хуульчдын нэрс	Албан тушаал	Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх гэрчилгээний дугаар	Өмгөөлөгчийн шүүхэд төлөөлөх эрхийн гэрчилгээний дугаар	ҮЦ33-д оролцогчид үйлчилгээ үзүүлэх гэрчилгээний дугаар
1.	Г.Батбаяр	(Ерөнхий захирал, Хуульч, өмгөөлөгч)	№2494	№13 0689	№0730143
2.	Б.Баасандорж	(Захирал, Хуульч, өмгөөлөгч)	№4927	№15 2037	№17029
3.	Д.Хулан	(Хуульч, өмгөөлөгч)	№2977	№18 2821	№17032

Хуулийн компанийн гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг

Үнэт цаас гаргагч Эрдэнэс-Тавантолгой ХК болон Өмгөөллийн Батбаяр энд Партнерс ХХН-ийн хооронд 2019 оны 11 сарын 12-ны өдөр байгуулсан ЭТТ-2019/781 тоот "Хуулийн зөвлөх үйлчилгээний гэрээ" болон 2021 оны 02 сарын 23-ны өдрийн 01 тоот гэрээний нэмэлт өөрчлөлтийн /Хавсралт 70/-ний дагуу Хуулийн компани болон Үнэт цаас гаргагч нь дараах эрх, үүргийг хүлээнэ.

Үнэт цаас гаргагчийн хувьцааг Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн үнэт цаасны бүртгэлд бүртгэхтэй холбоотой асуудлаар хууль зүйн дүгнэлт гаргана. Үүнд:

- Тухайн компанийн улсын бүртгэл, татвар төлөгчийн болон нийгмийн даатгалын шимтгэл төлөгчийн бүртгэлтэй холбоотой зөрчил байгаа эсэх;
- Үнэт цаас гаргагч нь хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж, бүртгэгдсэн эсэх;
- Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан нь холбогдох хууль тогтоомж болон Хорооноос баталсан "Монголын компанийн засаглалын кодекс"-т заасан шаардлага хангасан болон гэмт хэрэгт холбогдож байсан эсэх, тэдгээрийн удирдах чадвар, дадлага туршлагын байдал;

- Үнэт цаас гаргагчийн дүрэм, дотоод журмууд нь холбогдох хууль тогтоомж, Хорооноос баталсан "Монголын компанийн засаглал кодекс"-т нийцсэн эсэх;

2021.03.26

2021.03.26

БҮРТГЭЭ

№01



МОНГОЛЫН БИРЖИЙН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК-ийн Хувьцаа
ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ ХК EXCHANGE

0000172

2021-03-19

БҮРТГЭЭ-02

- Бусадтай байгуулсан худалдах болон худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, зээлийн гэрээ болон үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад гэрээ, контракт нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх;
- Сүүлийн 3 жил дотор хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл нь холбогдох хууль, тогтоомжийн дагуу хийгдсэн эсэх;
- Үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах;
- Аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн зэргээр үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болохуйц нөхцөл буй эсэх;
- үнэт цаас, үл хөдлөх болон бусад эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн эсэх;
- Үнэт цаасыг бүртгүүлэх өргөдөл, танилцуулгад тусгагдсан мэдээлэл нь хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байгаа эсэх;
- Компанийн толгой, охин, хараат, зэрэгцээ компанийн талаарх мэдээлэлд үндэслэн үнэт цаас гаргагч компанийн хяналтыг хэрэгжүүлэгч этгээдийг тодорхойлох.

5.6. Хуулийн дүгнэлтийн хураангуй

Өмгөөллийн Батбаяр энд Партнэрс ХХН, хуулийн фирм нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6, 10.7 дахь хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.2 дахь заалт, Монголын хөрөнгийн биржийн "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 2 дугаар зүйлийн 2.6 дахь хэсэгт заасны дагуу Эрдэнэс Тавантолгой ХК-ийн нээлттэй өрийн хэрэгсэл гарган дотоодын хөрөнгийн зах зээлийн арилжаа эрхлэх, зохицуулагч байгууллагын бүртгэлд буюу Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн Үнэт цаасны бүртгэлийн журмын дагуу нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгүүлэх ажиллагаанд хуулийн зөвлөхийн үйлчилгээ үзүүлж, дараах асуудлаар хөндлөнгийн дүгнэлтийг гаргасан байна.

Үнэт цаас гаргагчийн үнэт цаасны тухай

Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 02 сарын 02-ны өдрийн №03 тоот Үнэт цаас гаргах зөвшөөрөл олгох тухай тогтоолоор Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2018 оны 10 сарын 19-ний өдрийн №02 тоот Тогтоолын хэрэгжилтийг хангах тухай тогтоолын 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэгт Тавантолгойн нүүрсний ордын үнэ цэнийг өсгөх үйл ажиллагааны хүрээнд холбогдох дэд бүтцийн болон шаардлагатай бусад төсөл, хөтөлбөрийн тодорхой хэсгийг санхүүжүүлэх, нүүрс-хими, кокс химийн үйлдвэр, усан хангамж, авто зам, төмөр зам зэрэг төслүүдийг эхлүүлэх ажлыг зохион байгуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгаж шийдвэрлэснийг баримтлан нийтэд санал болгон гаргах 2,000,000,000,000 (хоёр их наяд) хүртэлх төгрөгийн өрийн бичгийг нийтэд санал болгон гаргахыг Гүйцэтгэх захирал Б.Ганхуяг зөвшөөрч шийдсэн байна.

2021.03.19



ЭРДЭНЭС
ТАВАН
ТОЛГОЙ
ХК

НИЛЦУУЛГА



МХБ-ийн гишүүн
Андеррайтер
Брокер, дилерийн
БҮЛЭСЭН
ҮЦК ХК

Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиар Санхүүгийн зохицуулах хороо болон хөрөнгийн биржээс тогтоосон шалгуурыг хангасан компани нийтэд санал болгон өрийн хэрэгсэл гаргаж болохыг зөвшөөрсөн байгаа тул Үнэт цаас гаргагч нь хууль тогтоомжид нийцүүлэн өрийн бичиг гаргах боломжтой бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгүүлсэн нөхцөлд үнэт цаасны анхдагч зах зээл дээр олон нийтэд нээлттэй санал болгож хөрөнгө татан төвлөрүүлэх боломжтой байна.

Компанийн тухай хуулийн холбогдох зохицуулалтын дагуу компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол зарласан хувьцаанаас гүйлгээнд гаргах, компанийн дүрэмд заасан бусад төрлийн үнэт цаас болон өрийн бичиг гаргах тухай шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл гаргах зохицуулалттай байна. Хуулийн дүгнэлт гаргах өдрийн байдлаар Үнэт цаас гаргагчийн дүрмийн холбогдох зохицуулалтаас харвал тус дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт өрийн бичиг болон бусад үнэт цаасыг гаргах асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэхээр зохицуулжээ. Үнэт цаас гаргагч Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2018 оны 10 сарын 19-ний өдрийн №02 тоот Тогтоолын хэрэгжилтийг хангах тухай тогтоолын 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсгийг үзвэл Тавантолгойн нүүрсний ордын үнэ цэнийг өсгөх үйл ажиллагааны хүрээнд холбогдох дэд бүтцийн болон шаардлагатай бусад төсөл, хөтөлбөрийн тодорхой хэсгийг санхүүжүүлэх, нүүрс-хими, кокс химийн үйлдвэр, усан хангамж, авто зам, төмөр зам зэрэг төслүүдийг эхлүүлэх ажлыг зохион байгуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгаж шийдсэн байх бөгөөд тус асуудлын хүрээнд Төлөөлөн удирдах зөвлөлд дэд бүтцийн төслүүдийг эхлүүлэхтэй холбоотой санхүүжилт татах асуудлыг олгосон байна гэж ойлгож үзлээ. Тус асуудлыг ээлжит хувьцаа эзэмшигчдийн хурлаар тайлагнаж, гаргасан үнэт цаасны нийт хэмжээг баталгаажуулах нь цаашдын үйл ажиллагаанд зэрэг нөлөөтэй гэж Хуулийн фирмийн зүгээс санал болгож Үнэт цаас гаргагчид зөвлөмж болгон хүргүүлж байгааг хүлээн авна уу.

Нэг. Үнэт цаас гаргагч нь хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж, бүртгэгдсэн эсэх болон Үнэт цаас гаргагчийн улсын бүртгэл, татвар төлөгчийн болон нийгмийн даатгалын шимтгэл төлөгчийн бүртгэлтэй холбоотой зөрчил байгаа эсэх асуудлаар:

Улсын бүртгэл

Тус асуудлын хүрээнд Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн ҮЦТХТ-өөс гаргуулж авсан 2021 оны 03 сарын 01-ний өдрийн №01/201 тоот Мэдээлэл хүргүүлэх тухай албан бичгээс харвал Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн хувьцааны бүртгэл 2021 оны 02 сарын 23-ны өдрийн байдлаар дараах байдлаар бүртгэгдсэн болохыг тодорхойлж гаргаж өгсөн.

Хүснэгт 1. Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц

№	Хувьцаа эзэмшигч	Хувьцаа эзэмшигчдийн тоо	Тоо ширхэг	Хувь хэмжээ
1.	Төрийн мэдлийн хувьцаа	1	9,779,874,440	65.19%
2.	Аж ахуй нэгжийн хувьцаа	486	7,065,038	0.05%
3.	Иргэдийн хувьцаа	2,512,768	2,213,060,522	14.76%
4.	Зарласан боловч гаргаагүй хувьцаа	-	3,000,000,000	20.00%
	Нийт		- 15,000,000,000	100.00%

Эрдэнэс-ТАВАНТОЛГОЙ ХК-ийн Гүйцэтгэх захирал
Т.Сүхбаатар
САНЛЦУУЛГА
JSC

Улаанбаатар хот
АХБ-ийн Гүйцэтгэх захирал
Андрей Игоревич
Төрөл, дэглэлийн
"БМДЭС" ХК-ийн
Гүйцэтгэх захирал
111520447 д. 002453

20210305



ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ ХК-ийн БҮРТГЭЭ-02 №0000174

Тус лавлагаа болон өмнө дурдсан СЗХ-ны тодорхойлолтоос үндэслэн Үнэт цаас гаргагчийг төрийн өмчийн оролцоотой хаалттай хувьцаат компани гэж үзэж дүн шинжилгээг хийлээ.

БҮРТГЭЭ-02

Үнэт цаас гаргагч Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээнээс үзвэл дараах байдлаар бүртгэгдсэн байна. Тус хуулийн этгээдийг үүсгэн байгуулагчийн 2010 оны 10 сарын 28-ны өдрийн №425 тоот шийдвэр/тогтоолоор Эрдэнэс-Тавантолгой оноосон нэртэйгээр, №9010001097 тоот улсын бүртгэлийн дугаартайгаар хувьцаат компанийн хэлбэрээр 2010 оны 12 сарын 23-ны өдөр хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэсэн байна. Компанийн регистрийн дугаар №5435528, үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл ашигт малтмалын хайгуул хийх болон ашигт малтмалын ашиглалт байх бөгөөд үйл ажиллагаагаа хугацаагүй эрхлэхээр бүртгэгдсэн байна. Улсын бүртгэлийн гэрчилгээнээс үзвэл өөрийн хөрөнгийн хэмжээг 300,000,000 (гурван зуун сая) төгрөгөөр бүртгэсэн байх бөгөөд тус бүртгэлд 2019 оны 04 сарын 11-ний өдөр өөрчлөлт оруулж өөрийн хөрөнгийн хэмжээг 11,195,700,000,000 (арван нэгэн их наяд нэг зуун ерэн таван тэрбум долоон зуун сая) төгрөгөөр нэмэгдүүлж нийт 11,196,000,000,000 (арван нэгэн их наяд нэг дуун ерэн зургаан тэрбум) төгрөг болгож 2019 оны 04 сарын 11-ний өдөр бүртгүүлсэн байна.

Тус өөрчлөлтийн хүрээнд тодорхойгүй асуудал байгааг Үнэт цаас гаргагчид мэдэгдэн уламжилж байна. Та бүхэн судалж өөрсдийн зүгээс эрсдэлтэй гэж үзсэн нөхцөлд холбогдох нэмэлт арга хэмжээг авч ажиллахыг санал болгож байна. КТХ-ийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа зохицуулалтаас үзвэл компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах тухай бүрд компанийн дүрэмд өөрчлөлт оруулах бөгөөд хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрт үндэслэн өөрчилдөг.

- I. нэгж хувьцааны нэрлэсэн үнийг өсгөх, эсхүл бууруулах;
- II. хувьцаа нэмж гаргах замаар өсгөх;
- III. өөрийн гаргасан хувьцааг эргүүлэн худалдан авч, хүчингүй болгох замаар бууруулах.

Тус өөрчлөлтийн хувьд дээрх хуулийн аль зохицуулалтын дагуу өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлсэн нь тодорхойгүй байх тул хууль тогтоомжид нийцүүлэн холбогдох өөрчлөлтийг хийх зөвлөмжийг үүгээр хүргүүлж байна.

Компанийн үйл ажиллагаа эрхлэн явуулах албан ёсны хаягийн хувьд Чингэлтэй дүүрэг, 1 хороо, жигжиджавын гудамж, финанс төв, 302 тоот болохыг бүртгэсэн байна.

Хуулийн этгээдийн дүрмийн хувьд шинэчилсэн дүрмийг 2018 оны 05 сарын 14-ний өдөр болон 2018 оны 10 сарын 22-ны өдөр тус тус бүртгүүлсэн байна. Үнэт цаас гаргагчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээд буюу Гүйцэтгэх захирлаар Монгол Улсын иргэн Баттулгын Ганхуяг (Рег.№.ФМ75081915) бүртгэлтэй байна.

Мөн Өмнөговь аймгийн Цогтцэций сум, Цагаан овоо багт байрлах салбарыг 2011 оны 10 сарын 14-ний өдөр хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлж 2014 оны 09 сарын 03-ны өдөр бүртгэлээс хассан улмаар тус салбарыг 2018 оны 12 сарын 18-ны өдөр дахин хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлсэн тэмдэглэл хийгдсэн байна.

Үнэт цаас гаргагчийн дүрмийн хувьд авч үзвэл Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2018 оны 10 сарын 19-ний өдрийн №01 тоот тогтоолоор баталсан дүрмийг хуулийн этгээдийн улсын бүртгэлд 2018 оны 10 сарын 22-ны өдөр бүртгэсэн

Handwritten signature and red stamp of the company.

Handwritten signature and red stamp of the broker/dealer.

2020.02.20.2020

байна. Тус дүрмийг өмнө дурдсан дагуу Хуулийн фирмийн зүгээс хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа дүрэм гэж үзэж ашиглалаа.

Хуулийн фирм Үнэт цаас гаргагчийн гаргаж өгсөн баримт материалд үндэслэн улсын бүртгэлд дараах зөрчил байна гэж үзсэн. Хуулийн фирм нь Засгийн газрын Улсын бүртгэлийн нэгдсэн архиваас 2021 оны 03 сарын 04-ний өдөр Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн улсын бүртгэлийн дэлгэрэнгүй лавлагааг гаргаж өгсөн. Тус лавлагаанаас үзвэл Төрийн мэдэлд байгаа Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн хувьцааны тоо хэмжээг дараах байдлаар тодорхойлогдсон байна.

Хүснэгт 2. Улсын бүртгэлийн байгууллагад бүртгэгдсэн хувьцаа эзэмшигчдийн бүтэц

№	Хувьцаа эзэмшигч	Эзэмшиж буй хувьцааны нийт дүн	Хувь хэмжээ
1.	Төр	9,125,403,455.4	81.5%
2.	Хуулийн этгээд	6,591,680.5	0.1%
3.	Иргэд	2,064,004,864	18.4%
4.	Эрдэнэс монгол	3,000,000,000	100.0%

Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн ҮЦТХТ-өөс гаргуулж авсан 2021 оны 03 сарын 01 өдрийн №12/201 тоот Хариу хүргүүлэх тухай албан бичгээс харвал төвлөрсөн хадгаламжид бүртгэлтэй Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн хувьцааны бүртгэл 2021 оны 02 сарын 23-ны өдрийн байдлаар дараах байдлаар бүртгэгдсэн болохыг тодорхойлж гаргаж өгсөн.

Хүснэгт 3. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад бүртгэгдсэн хувьцаа эзэмшигчдийн бүтэц

№	Хувьцаа эзэмшигч	Хувьцаа эзэмшигчдийн тоо	Тоо ширхэг	Хувь хэмжээ
1.	Төрийн мэдлийн хувьцаа	1	9,779,874,440	65.19%
2.	Аж ахуй нэгжийн хувьцаа	486	7,065,038	0.05%
3.	Иргэдийн хувьцаа	2,512,768	2,213,060,522	14.76%
4.	Зарласан боловч гаргаагүй хувьцаа	-	3,000,000,000	20.00%
Нийт		-	15,000,000,000	100.00%

Эдгээр лавлагаанаас үзвэл хуулийн этгээдийн улсын бүртгэлийн байгууллагад байгаа бүртгэлийн мэдээлэлд Үнэт гаргагчийн төрийн эзэмшлийн буюу мэдлийн хувь хэмжээ Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-ийн албан бичигт дурдсан хувь хэмжээнээс зөрүүтэй, иргэдийн эзэмшиж буй хувьцаа мөн ялгаатай харагдаж байна. Иймд тус асуудлыг ижил нэг мөр болгон бүртгэлийн ялгааг арилгах нь зүйтэй хэмээн үзэж зөвлөмж хүргүүлж байна.

Татвар төлөгчийн болон нийгмийн даатгалын шимтгэл төлөгчийн бүртгэл

Хуулийн фирмийн зүгээс Үнэт цаас гаргагчийн татвар төлөгчийн болон нийгмийн даатгалын шимтгэл төлөгчийн бүртгэлтэй холбоотой зөрчил байгаа эсэх асуудлаар харьяа төрийн эрх бүхий байгууллагаас лавлагаа, тодорхойлолт хүссэн бөгөөд Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны 03 сарын 04-ний өдрийн №213 тоот нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөргүй, шимтгэл төлөгчийн бүртгэлгүй холбоотой зөрчилгүй гэсэн тодорхойлолт зэрэг баримтыг үндэслэн татварын болон нийгмийн даатгалын бүртгэлийн байгууллагад бүртгэлтэй холбоотой зөрчил байхгүй байна гэж үзсэн болно.

Дүгнэж үзвэл тусгайлан дурдсанаас бусад асуудлаар Хуулийн фирм Үнэт цаас гаргагч нь хуулийн этгээдийн улсын бүртгэлийн байгууллага, татвар, нийгмийн даатгалын

Тавантолгой ХК
Гүйцэтгэх захирал
[Signature]

МХБ-ийн гүйцэтгэл
[Signature]

2021.03.26

байгууллагад бүртгүүлсэн байх бөгөөд бүртгэлтэй холбоотой аливаа зөрчил байхгүй байна гэж үзлээ.

2021-03-19

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд хамаарах бусад эрх бүхий байгууллагын лавлагаа

БҮРТГЭЛТ-02

Бусдад төлөх өр төлбөрийн хувьд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас тодорхойлолт, лавлагаа гаргаж өгөхийг хүссэн бөгөөд тус газрын 2021 оны 02 сарын 25-ны өдрийн №2040 тоот Тодорхойлолтоос үзвэл Эрдэнэс-Тавантолгой ХК нь шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд төлөх өр төлбөргүй болохыг тодорхойлсныг нэмж дурдаж байна.

Хоёр. Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан нь холбогдох хууль тогтоомж болон Хорооноос баталсан "Компанийн Засаглалын Кодекс"-т заасан шаардлага хангасан эсэх болон тэдгээрийн удирдах чадвар, дадлага туршлагын байдал асуудлын хувьд үзвэл:

Төлөөлөн удирдах зөвлөл

Үнэт цаас гаргагч Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт "Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл байна", 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт "Төлөөлөн удирдах зөвлөл нь 11 (арван нэгэн) гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн 4 (дөрвөн) нь хараат бус гишүүн байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэг удаа улируулан сонгож болно" гэж заасан байх бөгөөд эдгээр зохицуулалт нь дээрх хууль тогтоомжийн хүрээнд нийцсэн байна гэж үзэх үндэслэлтэй байна.

Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 10 сарын 19-ний өдрийн ээлжит бус хурлын №20/03 тоот тогтоолоор тус Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр Г.Наңдинжаргал, Б.Энх-Амгалан, Б.Бат-Эрдэнэ, Ц.Эрдэнэбаяр, Б.Ганхуяг, Ц.Баяр-Эрдэнэ, Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр П.Өлзийнаран, Ү.Амарбат, Д.Батхишиг, Х.Болор-Эрдэнэ нарыг тус тус сонгосон байна.

Эдгээр гишүүдээс Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэгч Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны 12 сарын 24-ний өдрийн №Б-12 тоот тушаалаар Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дэд дарга Б.Энх-Амгалангийн хүсэлтийг үндэслэн Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн төрийг төлөөлөх гишүүний үүрэгт ажлаас чөлөөлж, тус Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн төрийг төлөөлөх гишүүнээр Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогтыг томилж өөрчлөлт оруулсан байна.

Тус асуудлын хувьд КТХ-ийн 2 дугаар зүйлийн 2.4 дэх хэсэгт төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой, компанид төрийн болон орон нутгийн төлөөллийг хэрэгжүүлэх журмыг ТБОНӨТХ-иар, хараат бус гишүүнийг КТХ-иар зохицуулахаар заажээ. ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэг, 21.2.1 дэх хэсэг, 21.2.2 дахь хэсэгт төрийг төлөөлөх этгээдийг нэр дэвшүүлэх хороонд санал болгон төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилуулахаар хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулахаар зохицуулжээ.

Түүнчлэн Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалтад төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох асуудлыг зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэхээр

Эрдэнэс-Тавантолгой ХК
БҮРТГЭЛТ
УДИРДАХ ЗӨВЛӨЛ
Г.Наңдинжаргал
2021-03-19

Эрдэнэс-Тавантолгой ХК
БҮРТГЭЛТ
УДИРДАХ ЗӨВЛӨЛ
С.Наранцогт
2021-03-19

2021-03-04

зохицуулсан байх тул Төлөөлөн удирдах зөвлөлд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын тушаалаар төрийг төлөөлөх гишүүнээр сонгогдсон этгээдийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталгаажуулж ажиллах нь зүйтэй гэж Хуулийн фирмээс үзэж санал болгож байна. Та бүхэн судалж үзэн өөрсдийн үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн хэрэгжүүлнэ үү.

Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын хувьд Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 11 сарын 27-ны өдрийн №40 тоот тогтоолоор Компанийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1 дэх хэсэг, хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэгч Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2020 оны 11 сарын 26-ны өдрийн №20/23 тоот удирдамжыг тус тус үндэслэн Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Б.Бат-Эрдэнийг сонгосон байгааг дурдаж байна.

Компаниас ирүүлсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын анкет, засаглалын сургалтад хамрагдсан гэрчилгээний хуулбарыг үзвэл Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Б.Бат-Эрдэнэ, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Т.Гантулга, Г.Нандинжаргал, С.Наранцогт, Ц.Эрдэнэбаяр, Б.Ганхуяг, Ц.Баяр-Эрдэнэ, Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн П.Өлзийнаран, Д.Батхишиг, Ү.Амарбат, Х.Болор-Эрдэнэ болон Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Д.Отгонтуяа нар нь Компанийн засаглалын сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байх тул Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байх шаардлагыг хангасан байна гэж үзлээ.


Төлөөлөн удирдах зөвлөлийн дэд хороод

Компанийн тухай хуулиар хувьцаат компанийн хэлбэрээр үйл ажиллагаа эрхэлж байгаа компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь аудитын, цалин, урамшууллын, нэр дэвшүүлэх хороодтой байх бөгөөд эдгээр хороодын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээс бүрдэхээр зааж өгсөн бөгөөд Компанийн засаглалын кодексоор эдгээр хороодын дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн байхыг эрмэлзэх нь зүйтэй байхаар тусгайлан зохицуулж өгсөн байдаг.

Үнэт цаас гаргагчийн дүрмээс үзвэл тус дүрмийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсэгт Үнэт цаас гаргагч нь өөрийн үйл ажиллагааг байнгын, тогтмол, мэргэшсэн байдлаар зохион байгуулах зорилгоор нэр дэвшүүлэх хороо, аудитын хороо, цалин урамшууллын хороо гэсэн 3 хороо байхаар заасан байна. Тус хороодын дарга нарын хувьд Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 11 сарын 27-ны өдрийн №41 тоот тогтоолын дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнийг шинэчлэн баталж дарга, гишүүдийг сонгосон байх бөгөөд цалин урамшууллын хорооны бүрэлдэхүүнд даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн Д.Батхишиг, гишүүдээр Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Ц.Эрдэнэбаяр, Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн Ү.Амарбат нарыг, нэр дэвшүүлэх хорооны бүрэлдэхүүнд даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн Х.Болор-Эрдэнэ, гишүүдээр Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Т.Гантулга, Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн Ү.Амарбат нарыг сонгож баталгаажуулжээ. Аудитын хорооны хувьд Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 12 сарын 22-ны өдрийн №42



Т. ГАНБУЛГА



тоот Аудитын хорооны бүрэлдэхүүнийг өөрчлөн батлах тухай тогтоолын дагуу хорооны даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн Ү.Амарбат, гишүүдээр Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Г.Нандинжаргал, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Ц.Баяр-Эрдэнэ, Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн Х.Болор-Эрдэнэ, Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн П.Өлзийнаран, Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн Д.Батхишиг нарыг тус тус сонгож баталгаажуулсан байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх эдгээр хороодыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээр даргалуулсан нь засаглалын шаардлагыг хангасан байна гэж үзэх үндэслэлтэй байна гэж үзлээ.

Гүйцэтгэх удирдлага

КТХ-ийн 83 дугаар зүйлийн 83.3 дахь хэсэгт "Хувь хүн гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлж байгаа тохиолдолд уг этгээд нь гүйцэтгэх захирал байна" гэж хуульчилсан. Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгээс үзвэл "Компанийн гүйцэтгэх удирдлагыг гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ"-ээр тусгасан байна.

КТХ, Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн дүрэм, Гүйцэтгэх захирлын анкет болон тэдгээрт холбогдох баримт материалаас үзэхэд Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн гүйцэтгэх удирдлагыг Гүйцэтгэх захирал Б.Ганхуяг хэрэгжүүлж байна.


Б.Ганхуяг нь Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 04 сарын 04-ний өдрийн хурлын №05 тоот тогтоолоор тус компанийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчээр томилогдсон байна. Улмаар тус Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Нэр дэвшүүлэх хорооны 2018 оны 05 сарын 18-ны өдрийн зөвлөмжийг үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 05 сарын 18-ны өдрийн №12 тоот тогтоолоор Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн Гүйцэтгэх захирлаар Б.Ганхуяг томилогдсон бөгөөд тус бүртгэлийг Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээнд 2018 оны 05 сарын 22-ны өдөр бүртгэгдэж, тэмдэглэгдсэн байна.


Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх заалтад Гүйцэтгэх захирал нь тодорхой шалгуурыг хангасан байхаар тусгасан ба хуулийн фирмд гарган ирүүлсэн Гүйцэтгэх захирлын анкет, диплом, гэрчилгээнээс үзвэл Компанийн дүрэмд тусгагдсан мэргэжлийн болон ажлын туршлагын шаардлагыг хангасан гэж үзэх үндэслэлтэй байна гэж үзсэн. Б.Ганхуяг нь Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга нарт зориулсан Компанийн засаглалын сургалтад 2018 оны 09 сард хамрагдаж №0520756 дугаартай гэрчилгээ авсан байна.

Эрх бүхий албан тушаалтан

Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт "Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга, ерөнхий аудитор, гүйцэтгэх захирал, тэргүүн дэд, дэд захирал, асуудал эрхэлсэн газрын захирал, ерөнхий нягтлан бодогч, уурхайн дарга нарыг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно" гэж заасан байна.

Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 05 сарын 28-ны өдрийн №27 тоот Засгийн газрын 2020 оны №146 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах тухай тогтоолын дагуу Эрдэнэс-Тавантолгой Майнинг ХХК-ийн үйл ажиллагааг зогсоож, түүний эрх, үүрэг, хариуцлагыг Эрдэнэс-Тавантолгой ХК-д нэгтгэх замаар өөрчлөн байгуулж шийдвэрлэсэнтэй холбоотойгоор Эрдэнэс-Тавантолгой Майнинг ХХК-ийн





2021.08.30

ажилтнуудыг Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн орон тооны хязгаарт багтаан шилжүүлж
Компанийн зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн баталсан болон бусад бүтэц зохион
байгуулалт өөрчлөгдсөн нөхцөл, журмыг удирдлага болгон эдгээр баримт бичгээс
харгалзан эрх бүхий албан тушаалтнуудыг тодорхойлсон байна.

БҮРТГЭ-9-02

Хүснэгт 4. Эрх бүхий албан тушаалтнууд нь шаардлага хангаж буй эсэх тухай

№	Эрх бүхий албан тушаал	Эрх бүхий албан тушаалтны нэрс	Компанийн тухай хууль (КТХ)				Компанийн засаглалын кодекс (КЗК)
			Компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан эсэх (КТХ 75.8) Тийм/Үгүй/ N/A*	Төрийн болон нутгийн захиргааны байгууллагад удирдах албан тушаал хашдаг эсэх (КТХ 84.3.1) Тийм/Үгүй	Ял шийтгэл эдэлж байгаа эсэх (КТХ 84.3.2) Тийм/Үгүй	ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх удирдлагыг хувь хүн хэрэгжүүлдэг эсэх (КТХ 77.3, 83.2, 83.3) Тийм/Үгүй/ N/A	ТУЗ-ийн гишүүд нь КЗК 5.2.1-т заасан чиглэлээр мэргэшсэн эсэх (КЗК 5.2.1) Тийм/Үгүй/ N/A
Нэг. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд							
	ТУЗ-ийн дарга	Бат-Өлзийн Бат-Эрдэнэ	Тийм	Тийм	Үгүй	Тийм	Тийм
	ТУЗ-ийн гишүүн	Санжаагийн Наранцогт	Тийм	Тийм	Үгүй	Тийм	Тийм
	ТУЗ-ийн гишүүн	Ганболдын Нандинжаргал	Тийм	Тийм	Үгүй	Тийм	Тийм
	ТУЗ-ийн гишүүн	Түдэвхүүгийн Гантулга	Тийм	Тийм	Үгүй	Тийм	Тийм
	ТУЗ-ийн гишүүн	Цэндийн Эрдэнэбаяр	Тийм	Тийм	Үгүй	Тийм	Тийм
	ТУЗ-ийн гишүүн	Баттулгын Ганхуяг	Тийм	Тийм	Үгүй	Тийм	Тийм
	ТУЗ-ийн гишүүн	Цэнддаваагийн Баяр-Эрдэнэ	Тийм	Тийм	Үгүй	Тийм	Тийм
	ТУЗ-ийн хараат бус гишүүн	Дашнямын Батхишиг	Тийм	Үгүй	Үгүй	Тийм	Тийм
	ТУЗ-ийн хараат бус гишүүн	Үүрцайхын Амарбат	Тийм	Үгүй	Үгүй	Тийм	Тийм
	ТУЗ-ийн хараат бус гишүүн	Пүрэвтөгтохын Өлзийнаран	Тийм	Үгүй	Үгүй	Тийм	Тийм
	ТУЗ-ийн хараат бус гишүүн	Хаянгаагийн Болор-Эрдэнэ	Тийм	Үгүй	Үгүй	Тийм	Тийм
Хоёр. Бусад эрх бүхий албан тушаалтан							
	Гүйцэтгэх захирал	Баттулгын Ганжуур	Тийм	Үгүй	Үгүй	Тийм	Тийм
	Эдийн засаг, санхүүгийн ТАВАН	Буян-Өлзийн Жаргалсайхан	N/A	Үгүй	Үгүй	N/A	N/A

2021.08.30

Б. Амарбат
БҮРТГЭ-9-02

Б. Амарбат
БҮРТГЭ-9-02
111505445 3305248

ИЛЦУУЛГА

2021-03-19

БҮРТГЭВ-02

удирдлагын газар хариуцсан Тэргүүн дэд захирал						
Стратеги, хөгжлийн газар хариуцсан дэд захирал	Тамжидын Цогтбаяр	N/A	Үгүй	Үгүй	N/A	N/A
Үйлдвэрлэл, уул уурхайн газар хариуцсан дэд захирал	Ганбатын Дэлгэрбаяр	N/A	Үгүй	Үгүй	N/A	N/A
Бизнесийн удирдлагын газар хариуцсан дэд захирал	Бэхбатын Батсайхан	N/A	Үгүй	Үгүй	N/A	N/A
Хууль зүйн газар хариуцсан дэд захирал	Цэгмидийн Амартүвшин	N/A	Үгүй	Үгүй	N/A	N/A
Ерөнхий удирдлагын газар хариуцсан дэд захирал	Доржийн Энхболд	N/A	Үгүй	Үгүй	N/A	N/A
Салбарын захирал	Наваандэмбэрэлийн Эрдэнэхуяг	N/A	Үгүй	Үгүй	N/A	N/A
Ерөнхий нягтлан бодогч	Даваадоржийн Алтанцэцэг	N/A	Үгүй	Үгүй	N/A	N/A
Дотоод хяналт, зрсдэлийн удирдлагын газрын захирал	Хожабергенын Нурлат	N/A	Үгүй	Үгүй	N/A	N/A
Дотоод аудитын албаны дарга бөгөөд ерөнхий аудитор	Даваадоржийн Санчир	N/A	Үгүй	Үгүй	N/A	N/A
Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга	Даваанямын Отгонтуяа	Тийм	Үгүй	Үгүй	N/A	N/A

2021.03.19

ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОМ
JSC

МХБ-ийн гишүүн
Андрагайнар
Сонордалагийн
"ТЭНЭС"
ҮНБ-ХБ

Энэ асуудлын хувьд зайлшгүй дурдах асуудал нь хэдийгээр КТХ-аар хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд нь төрийн болон нутгийн захиргааны байгууллагад удирдах албан тушаал хашдаггүй байх шаардлага тавигдсан боловч төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн хувьд ТБОНӨТХ-аар төрийн төлөөллийг хэрэгжүүлэх өөр журмыг тогтоож өгсөн байгааг дурдаж байна.

ТБОНӨТХ-ийн зохицуулалтаас үзвэл тус хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэгт зааснаар төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн өмчийн оролцооны хувь хэмжээтэй хувь тэнцүүлэн тухайн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд төрийг төлөөлөх гишүүнийг томилохоор хуульчилсан байх тул Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд төрийн болон нутгийн захиргааны байгууллагад удирдах албан тушаал хашдаг этгээд орох хуулиар тогтоосон боломжтой болохыг дурдаж байна.

Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн төрийг төлөөлөх гишүүний үүргийг гүйцэтгэхэд шаардагдах мэдлэг, чадвартай байх болзлын хувьд энэхүү дүгнэлтэд тусгагдсаны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн төрийг төлөөлөх гишүүд нь удирдах албан тушаал эрхлэхэд шаардагдах мэргэжлийн боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн түүхтэй байна гэж үзсэн болохыг дурдаж байна.

Төрийн өмчийн оролцооны хувь хэмжээтэй хувь тэнцүүлэн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд төрийг төлөөлөх гишүүнийг томилох асуудлын хувьд ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 21.2.3-д зааснаар төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх этгээдийг Засгийн газар тогтоох бөгөөд төрийн өмчийн оролцооны хувь хэмжээтэй хувь тэнцүүлэн тухайн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд төрийг төлөөлөх гишүүний нэрийг төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж байгаа этгээд тухайн компанийн нэр дэвшүүлэх хороонд санал болгох бөгөөд нэр дэвшүүлэх хороо тэрхүү нэр дэвшигдэж байгаа этгээд нь хуульд заасны дагуу төрийг төлөөлөх этгээд мөн бол Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилуулахаар хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд оруулах үүрэгтэйгээр хуульчилсан байна. Засгийн газрын 2018 оны 08 сарын 08-ны өдрийн №245 тоот "Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолоор Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрыг томилсон байна. Тус өөрчлөлтийг Үнэт цаас гаргагч нь дүрэмдээ тусгасан байх бөгөөд Үнэт цаас гаргагчийн хүчин төгөлдөр үйлчилж буй дүрмийн 2 дугаар зүйлийн 2.6 дахь хэсэгт 19 зааснаас үзвэл Компанийн төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх этгээд нь Засгийн газрын тогтоосноор (i) Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам; (ii) Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар байгааг мөн дурдаж байна.

Эрх бүхий албан тушаалтнууд ял шийтгэл эдэлж байгаа эсэх асуудлын хувьд авч үзвэл Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.3.2 дахь хэсэгт ял шийтгэл эдэлж байгаа этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалтнаар ажиллахыг хориглох хуулийн зохицуулалттай байна. Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн эрх бүхий албан тушаалтнуудын гаргаж өгсөн баталгаанд үндэслэн эрх бүхий албан тушаалтнууд нь ял шийтгэл эдлээгүй хэмээн үзэж дүгнэсэн болно.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн мэргэшсэн дадлага, туршлагын шаардлагын талаар КЗК-ийн 5 дугаар зүйлийн 5.2.1 дэх заалтад аудит эсвэл нягтлан бодох бүртгэл


JSC


11152056

2021.03.26

санхүү, хууль, эрх зүй, хөрөнгө оруулалтын чиглэлээр мэргэшсэн дадлага, туршлага бүхий хувь хүнийг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгон ажиллуулах зүйтэй гэж нарийвчилсан зохицуулалттай байх бөгөөд Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн мэдээлэл, анкетад үндэслэн Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд нь санхүү, хууль, эрх зүй, инженер, бизнесийн удирдлагын чиглэлээр мэргэшсэн бөгөөд эдгээр албан тушаалтнууд нь удирдах албан тушаал эрхлэхэд шаардагдах мэргэжлийн боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн түүхтэй байна гэж үзлээ. Бусдаар Хуулийн фирм нь Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, Гүйцэтгэх удирдлага, бусад дурдагдсан эрх бүхий албан тушаалтнуудын удирдах байдал, дадлага туршлагыг үнэлэх боломжгүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн зүгээс гаргаж өгсөн дээрх материалаас үзвэл эдгээр албан тушаалтнууд нь удирдах албан тушаал эрхлэхэд шаардагдах мэргэжлийн боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн түүхтэй байсан гэж үзлээ.

Гурав. Компанийн дүрэм, дотоод журмууд, үнэт цаасаа анх удаа нийтэд санал болгон гаргаж байгаа компанийн хувьд хувьцаат компанийн дүрмийн төсөл, бусад дотоод журмуудын төсөл нь хууль тогтоомж, Хорооноос баталсан "Монголын Компанийн Засаглал кодекс"-т нийцсэн эсэх асуудлын хувьд үзвэл:

Тус асуудлын хүрээнд Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн зүгээс гаргаж өгсөн баримт материалуудыг дараах байдлаар ангилж дүн шинжилгээг хийлээ. Үүнд:

1. Үнэт цаас гаргагчийн компанийн дүрмээр тогтоосон асуудал нь хууль тогтоомж болон Компанийн засаглалын кодекс нийцэж байгаа эсэх;
2. Компанийн засаглалд хамаарах дүрэм, журмууд нь хууль тогтоомж болон Компанийн засаглалын кодекс нийцэж байгаа эсэх;
3. Үнэт цаас гаргагчийн гаргаж өгсөн Компанийн менежментийн үйл ажиллагаанд хамаарах дотоод дүрэм, журмууд нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх.

Үнэт цаас гаргагчийн компанийн дүрэм:


Хуулийн дүгнэлт гаргах өдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн дүрэм нь тус компанийн хувьцаа эзэмшигчдийн 2018 оны 10 сарын 19-ний өдрийн ээлжит бус хурлаар батлагдсан байна.

Үнэт цаас гаргагчийн дүрмийн хувьд авч үзвэл 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт "Төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн жил дууссанаас хойш 3 сарын дотор ногдол ашиг хуваарилах эсэх талаар хэлэлцэн шийдвэрлэнэ" гэж заасан нь КТХ-ийн 46 дугаар зүйлийн 46.5 дахь хэсэгт "Төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн жил дууссанаас 50 хоногийн дотор ногдол ашиг хуваарилах эсэх талаар хэлэлцэн шийдвэрлэсэн байна" гэж зааснаас өөрөөр зохицуулсан байх бөгөөд тус хугацааг КТХ-д нийцүүлэн өөрчлөхийг зөвлөж байна. Эдгээр тусгайлан дурдсанаас бусдаар хууль тогтоомж, Компанийн засаглалын кодекс нийцсэн байна гэж Хуулийн фирм үзлээ.

Компанийн засаглалд хамаарах дүрэм, журмууд:

Эрдэнэс-Тавантолгой ХК-аас Компанийн засаглалд хамаарах дүрэм, журмыг ирүүлэхийг хүсэхэд өнөөдрийн байдлаар дараах 9 (есөн) журмыг ирүүлсэн байна. Үүнд:

1. Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн Компанийн засаглалын кодекс;
2. Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам;



2021-03-19

017113-02

- № 03. Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах тухай журам;
4. Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн Ногдол ашгийн журам;
 5. Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Цалин уламшууллын хорооны журам;
 6. Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Нэр дэвшүүлэх хорооны журам;
 7. Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны журам;
 8. Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журам;
 9. Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн Эрсдэлийн удирдлагын журам.

Хуулийн фирм нь Компаниас ирүүлсэн эдгээр 9 (есөн) журам нь КТХ болон Компанийн засаглалын кодекст нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийхэд дор тусгайлан дурдаж санал болгосноос бусад асуудлаар КТХ болон Компанийн засаглалын кодекст нийцсэн байна гэж үзлээ.

Компаниас баталж, мөрдвөл зохих (i) Мэдээллийн үйл ажиллагааны журам болон (ii) Хувьцаа эзэмшигчдийн хувьцаагаа эргүүлэн худалдах шаардах эрхийг хэрэгжүүлэх (iii) Мэргэжлийн хөрөнгө оруулагчдын үйл ажиллагаатай холбогдох сонирхлын зөрчлийг зохицуулах журам, (iv) Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын үйл ажиллагааны журам, (v) Нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх хэлцэл, сонирхлын зөрчлийг зохицуулах бодлого, журам, (vi) Төлөөлөн удирдах зөвлөлийн ёс зүйн кодексийг (vii) Хөндлөнгийн аудиторыг томилох үйл ажиллагааны дотоод журам, (viii) Дотоод аудитын албаны дүрмүүдийг тус тус Хуулийн фирмд ирүүлээгүй болохыг дурдаж байна.

Энэхүү хуулийн дүгнэлт гаргах өдрийн байдлаар Компанийн засаглалын кодекст заасан хувьцаат компанийн баталж, мөрдвөл зохих дээр дурдсан журмуудыг Компаниас ирүүлээгүй тул эдгээр журмуудыг Компани нь батлан, мөрдүүлээгүй байна гэж Хуулийн фирм үзлээ. Гэхдээ тус асуудлын хүрээнд зайлшгүй дурдах асуудал нь Компанийн засаглалын кодексийг шинэчлэн батлах тухай тогтоолд заасны дагуу тус кодексийг хөрөнгийн биржийн "А" самбарт бүртгэгдсэнээс бусад хувьцаат компаниуд зайлшгүй дагаж мөрдөх шинжгүй бөгөөд хэрхэн биелүүлж байгаагаа тайлбарлаж ажиллах үүрэгтэй байхаар зохицуулсан тул эдгээр засаглалын дүрэм журмыг баталж мөрдөөгүй байх нөхцөл нь Үнэт цаас гаргагчид шууд үүрэг хариуцлага үүсгэхгүй бөгөөд өрийн бичгийг нийтэд санал болгож буйтай холбогдуулан цаашид дагаж мөрдөж ажиллахыг санал болгон Хуулийн фирмээс зөвлөмж хүргүүлж байгааг дурдаж байна.

Иймд Эрдэнэс-Тавантолгой ХК нь Компанийн засаглалын кодексийг цаашид баримтлан ажиллахаар шийдсэн, нийтэд өрийн бичиг санал болгон үнэт цаасны анхдагч зах зээл дээр худалдахаар төлөвлөж байгаатай холбогдуулан дээрх компанийн засаглалын дүрэм, журмыг КТХ болон үйл ажиллагаатайгаа уялдуулан ХЭХ болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаараа хэлэлцүүлэн баталж, Компанийн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг зөвлөж байна.

Үүнээс гадна Компанийн засаглалын кодексийн 4 дүгээр зүйлийн 4.1.4-т Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах журмыг Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлан мөрдөхөөр заасан боловч Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах журмыг Төлөөлөн удирдах зөвлөлийн

МОНГОЛЫН ХӨРӨНГӨ БИРЭГ
МОНГОЛЫН ХӨРӨНГӨ БИРЭГ
MONGOLIAN FOREIGN EXCHANGE
1115205447 4 20210319

20210319

хурлаар баталсан нь Компанийн засаглалын кодекст заасан шаардлагыг хангахгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна гэж үзсэн бөгөөд Компанийн засаглалын кодексийн 4 дүгээр зүйлийн 4.1.4-т нийцүүлэн Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах журмыг Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлуулан, мөрдөж ажиллахыг зөвлөж байна.

Эрдэнэс-Тавантолгой ХК-аас ирүүлсэн засаглалын журмууд нь энд тусгайлан дурдсанаас бусдаар КТХ болон Компанийн засаглалын кодекст нийцсэн байна гэж Хуулийн фирм үзлээ.

Хуулийн фирмийн зүгээс тус Компанийн засаглалын асуудлаар дараах асуудлыг Үнэт цаас гаргагчийн цаашдын үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой байж болзошгүй хэмээн үзэж дэлгэрүүлэн дурдаж байна. Хуулийн фирмийн ойлгож байгаачлан Засгийн газар, түүний бүтцэд байгаа аливаа этгээд Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа, удирдлагад оролцохдоо төрийн өмчийн төлөөлөгчөөрөө дамжуулан хэрэгжүүлэх хуулийн заалттай байх тул цаашид Үнэт цаас гаргагч нь засаглалын хувьд дээрх журмын дагуу өөрийн үйл ажиллагааг удирдах нь эрсдэл болон бусад хууль тогтоомжтой нийцэж байна хэмээн үзэж Хуулийн фирмийн зүгээс санал болгож байна.

Эрдэнэс-Тавантолгой ХК нь өөрийн үйл ажиллагаа, менежментийн үйл ажиллагаанд хамаарах нийт 72 (далан хоёр) дүрэм, журам, Гүйцэтгэх захирлын болон салбарын захирлын тушаалаар батлагдсан нийт 45 (дөчин таван) горим, 62 (жаран хоёр) зааврыг гарган ирүүлсэн.

Компаниас ирүүлсэн эдгээр дүрэм, журмыг дэлгэрүүлэн судалж үзээд дараах хүснэгтэд дурдсан төрлөөр ангилан, холбогдох хууль, тогтоомжид нийцсэн эсэхэд дүн шинжилгээ хийлээ. Компанийн одоогийн үйл ажиллагаандаа мөрдөж буй уул уурхайн үйл ажиллагаанд хамаарах дүрэм, журмууд, хөдөлмөрийн харилцаа, хүний нөөцөд хамаарах дүрэм журмууд, гэрээ хэлцэл, худалдан авах ажиллагааны дүрэм, журмууд, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж буй дүрэм журмууд, бичиг хэрэг, архивын үйл ажиллагаанд хамаарах дүрэм журмууд, олон нийттэй харилцах үйл ажиллагаанд хамаарах дүрэм, журмууд, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйд хамаарах дүрэм журмууд нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна гэж үзсэн байна. Хуулийн фирм нь компанийн үйл ажиллагаанд шаардлагатай зарим журмыг баталж, дотооддоо мөрдөн ажиллахыг зөвлөсөн.

Дөрөв. Үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн зэргээр үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болохуйц нөхцөл буй эсэх асуудлаар:

АМГТГ-ын 2021 оны 03 сарын 01-ний өдрийн №8/740 тоот Тодорхойлолтоос харвал геологи, уул уурхайн кадастрын хэлтсийн мэдээллийн санд 2021 оны 02 сарын 26-ны өдрийн байдлаар шүүлт хийхэд танай компанийн эзэмшилд Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт ашигт малтмал ашиглалтын дараах 8 (найман) тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр бүртгэлтэй бөгөөд тусгай зөвшөөрлийг цуцлах, дуусгавар болох болон бусад бэрхцаалсан нөхцөл бүрдээгүй болохыг тодорхойлсон байна.

Тус мэдээллийг үндэслэн Үнэт цаас гаргагч Эрдэнэс-Тавантолгой ХК нь ашигт малтмал ашиглах 8 (найман) тусгай зөвшөөрөл эзэмшдэг бөгөөд эдгээр тусгай зөвшөөрлүүд нь





хүчин төгөлдөр бөгөөд хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн зэргээр үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болохуйц нөхцөл байхгүй байна гэж дүгнэлээ.

Зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг

Оюуны өмчийн газрын 2021 оны 02 сарын 25-ны өдрийн №2/99 тоот лавлагааг тус асуудлаар ирүүлсэн бөгөөд Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн нэр дээр бүртгэгдсэн бүртгэлийн №40-0020826 дугаартай 1 (нэг) барааны тэмдэг эзэмшдэг болохыг тодорхойлж гаргаж өгсөн.

Мөн Оюуны өмчийн газрын 2021 оны 02 сарын 25-ны өдрийн №5/100 тоот тодорхойлолтоос харвал зохиогчийн эрхийн мэдээллийн санд улсын бүртгэлийн 11553 дугаартай Тээвэр ложистикийн систем болон улсын бүртгэлийн 11593 дугаартай Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн эмхэтгэл гэсэн зохиогчийн эрхийн гэрчилгээнүүд олгогдсон талаар тодорхойлсон байна.

Үнэт цаас гаргагчийн нэр дээр бүртгэлтэй барааны тэмдэг нь аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн эсэх асуудлын хувьд ХЭХБЭБХБТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт заасны дагуу хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны мэдэгдлийн бүртгэх цахим мэдээллийн сангийн 2020 оны 01 сарын 10-ны өдрийн байдлаарх бүртгэлээс хайлт хийж үзвэл Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн нэр дээр бүртгэлтэй барааны тэмдгийн барьцаатай холбоотой мэдээлэл байхгүй болохыг дурдаж байна. Иймд хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны мэдэгдлийн бүртгэх цахим мэдээллийн сангийн бүртгэлд дээр үндэслэн Хуулийн фирм нь Үнэт цаас гаргагчийн нэр дээр бүртгэлтэй барааны тэмдэг нь аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээгээгүй байна гэж үзлээ.

Тав. Үнэт цаас, үл хөдлөх болон бусад эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн эсэх асуудлаар:

Үнэт цаас, хөрөнгө оруулалт

Тус асуудлын хүрээнд Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн зүгээс эзэмшил, өмчлөлдөө аливаа төрлийн үнэт цаас буюу үнэт цаасны зах зээлд арилжаалагдах боломжтой санхүүгийн хэрэгсэл эзэмшдэггүй талаар Хуулийн фирмд мэдэгдсэн. Хуулийн фирмийн зүгээс Үнэт цаас гаргагч нь төвлөрсөн хадгаламжид данстай эсэх, үнэт цаас эзэмшдэг эсэхийг тодруулахаар гаргасан хүсэлтийн дагуу ирүүлсэн ҮЦТХТ-ийн 2021 оны 03 сарын 01-ний өдрийн №01/201 тоот албан бичгээс үзвэл Эрдэнэс-Тавантолгой ХК нь төвлөрсөн хадгаламжид данс нээлгэж үнэт цаас эзэмшдэггүй болохыг тодорхойлсон байна.

Үнэт цаас гаргагчийн гаргаж өгсөн баримт материалтай танилцах явцад Эрдэнэс-Тавантолгой ХК нь Монголын төмөр зам ТӨХК-ийн хаалттай хүрээнд санал болгон гаргаж буй 1,000,000 (нэг сая) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 750,000 (долоон зуун тавин мянган) ширхэг 750,000,000,000 (долоон зуун тавин тэрбум) төгрөгийн үнийн дүн бүхий хаалттай өрийн хэрэгслийг эзэмшиж байгаа талаар мэдээллийг холбогдох гэрээ, хэлцлийн хамт гаргаж өгсөн. Тус мэдээллийг дэлгэрүүлж лавласан бөгөөд Үнэт цаас гаргагчийн зүгээс 2019 оны жилийн эцсийн байдлаар нийт 357,000,000,000 (гурван зуун тавин долоон) тэрбум төгрөгийг Монголын төмөр зам ТӨХК-ийн хаалттай хүрээнд санал болгон гаргасан үнэт цаасны төлбөрт төлсөн байна. Тус өрийн хэрэгслийн хувьд дэлгэрүүлж судалж үзвэл СЗХ-ны 2019 оны 12 сарын 27-ны өдрийн №407 тоот Хаалттай өрийн хэрэгсэл бүртгэх тухай тогтоолын дагуу ҮЦЗЗТХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх



№ (хэсэг, Засгийн газрын 2019 оны 04 сарын 10-ны өдрийн №135 тоот тогтоолыг үндэслэн Монголын төмөр зам ТӨХК-ийн хаалттай хүрээнд санал болгон гаргаж буй 1,000,000 (нэг сая) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 750,000 (долоон зуун тавин мянган) ширхэг өрийн хэрэгслийг үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг зөвшөөрч шийдвэрлэсэн байна.

БҮРТГЭВ-02

Энэхүү өрийн хэрэгслийг бие даасан Монголын төмөр зам ТӨХК-ийн зүгээс хаалттай хүрээнд санал болгон гаргасан, холбогдох зөвшөөрлийг олгосон байх тул Хуулийн фирм нь үнэт цаасны талаар дэлгэрэнгүй дүн шинжилгээ хийгээгүй бөгөөд өмчлөх эрх нь хүчин төгөлдөр гэж үзлээ. Хуулийн фирмд ирүүлсэн мэдээлэлд үндэслэн тус үнэт цаасаар аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээгээгүй гэж үзсэн болохыг уламжилж байна.

Үл хөдлөх эд хөрөнгө

Эрдэнэс-Тавантолгой ХК нь эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгэгдсэн, эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээтэй аливаа үл хөдлөх эд хөрөнгө байхгүй гэдэг мэдээллийг Хуулийн фирмд ирүүлсэн. Тус асуудлын хүрээнд Хуулийн фирм нь эдгээр үнэлгээнд хамрагдсан Үнэт цаас гаргагчийн үл хөдлөх эд хөрөнгүүдийн талаар тодруулж холбогдох төрийн эрх бүхий байгууллагаас лавлагаа, тодорхойлолт хүсэж гаргуулж авсан. УБЕГ-ын Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын Чингэлтэй дүүргийн бүртгэлийн хэлтсийн 2021 оны 02 сарын 24-ний өдрийн №003337678 тоот нэгдмэл сангийн тодорхойлолтоос үзвэл эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн санд тус Компанийн нэр дээр буюу өмчлөлд бүртгэлтэй аливаа үл хөдлөх эд хөрөнгө байхгүй болохыг тодорхойлсон байна.

Авто тээврийн хэрэгсэл

Тээврийн хэрэгслийн хувьд АТҮТ-ийн 2021 оны 01 сарын 24-ний өдрийн №38 тоот Хариу хүргүүлэх тухай албан бичгээс үзвэл Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн нэр дээр бүртгэлтэй 112 (нэг зуун арван хоёр) тээврийн хэрэгсэл байгааг тодорхойлсон байна.

Үнэт цаас гаргагчийн нэр дээр бүртгэлтэй тээврийн хэрэгслүүд нь аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн эсэх асуудлын хувьд тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн байгууллага болох АТҮТ-ийн 2019 оны 12 сарын 25-ны өдрийн №415 тоот Хариу хүргүүлэх тухай албан бичигт хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны мэдэгдлийн бүртгэх цахим мэдээллийн сангийн бүртгэлд хандахыг хүссэн. Тус зааврын дагуу Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны мэдэгдлийн бүртгэх цахим мэдээллийн сангийн бүртгэлээс үзвэл Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн нэр дээр бүртгэлтэй тээврийн хэрэгслийн барьцаатай холбоотой мэдээлэл байхгүй болохыг дурдаж байна. Үнэт цаас гаргагчийн зүгээс тээврийн хэрэгслийг аливаа үүргийн гүйцэтгэлд барьцаалсан эсэх талаар аливаа мэдээллийг Хуулийн фирмд мэдээлээгүй бөгөөд барьцаа, батлан даалт зэрэг үүргээс ангид байгаа талаар мэдээлэл өгсөн. Эдгээр мэдээлэл дээр үндэслэн Хуулийн фирм нь Үнэт цаас гаргагчийн өмчлөл, эзэмшилд байгаа тээврийн хэрэгслүүд нь аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээгээгүй байна гэж үзлээ.

Өмчлөх эрхийг баталгаажуулах боломжгүй бусад хөрөнгийн хувьд Хуулийн фирмийн зүгээс тусгайлан дүгнэлт хийгээгүй бөгөөд шалгуур асуултын хүрээнд Үнэт цаас гаргагчийн эзэмшиж байгаа үнэт цаас, үл хөдлөх болон бусад эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн эсэх асуудлаар

2021.03.05



холбогдох баримт материал, төрийн эрх бүхий байгууллагын баримт материал дээр үндэслэн дүн шинжилгээ хийсэн болохыг дурдаж байна.

2021-03-19

Дүгнэж үзвэл Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн өмчлөлд байгаа аливаа үнэт цаас, үл хөдлөх болон бусад эд хөрөнгө өмчлөх эрх хүчин төгөлдөр бөгөөд тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах нөхцөл байдал үүсээгүй, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээгээгүй байна.

Зургаа. Үнэт цаасыг бүртгүүлэх өргөдөл, танилцуулгад тусгагдсан мэдээлэл нь хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байгаа эсэх асуудлын хувьд үзвэл:

Хуулийн фирм нь андеррайтер компани болох БиДиСЕК ҮЦК ХК-ийн бэлтгэсэн Үнэт цаасны танилцуулгатай танилцаж дүн шинжилгээ хийсэн бөгөөд Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан хууль зүйн ач холбогдол бүхий Үнэт цаас гаргагчийн оноосон нэр, оршин байгаа газрын шуудангийн болон холбоо барих хаяг, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн болон регистрийн дугаар, бүртгэсэн он, сар, өдөр, эзэмшиж буй тусгай зөвшөөрлүүд, нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн мэдээлэл, хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл, хувь нийлүүлсэн хөрөнгийн хувь хэмжээ, Үнэт цаас гаргагчийн бүтэц, зохион байгуулалт, эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл, зарласан болон гаргасан үнэт цаасны тоо, төрөл, нэрлэсэн үнэ болон өөрийн хөрөнгийн хэмжээ, нийтэд санал болгож байгаа үнэт цаасаар гэрчлэгдэх эрх, үүрэг, биет болон биет бус хөрөнгийн талаарх мэдээллүүд нь Хуулийн фирмд Үнэт цаас гаргагчийн зүгээс гаргаж өгсөн баримттай нийцэж байх тул үнэн зөв тусгагдсан байна гэж үзлээ.

Эдгээр дурдсан хууль зүйн ач холбогдолтой мэдээллээс бусад Үнэт цаас гаргагчийн санхүүгийн үзүүлэлт, борлуулалтын хэмжээ, ашиг, алдагдал зэрэг бизнесийн үйл ажиллагаа, ордын нөөцийн үнэлгээ, Үнэт цаас гаргагчийн бизнес төлөвлөгөө зэрэг агуулагдсан макро эдийн засгийн ерөнхий мэдээлэл, салбарын үзүүлэлтүүд, Үнэт цаас гаргагчийн талаар олон нийтэд ил, тодорхой үйл баримт, үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд тусгагдсан баталгаажуулах боломжгүй тоон үзүүлэлтүүд болон хараат бус байгууллагуудын хийсэн дүн шинжилгээ, санхүүгийн тооцоолол, нийтэд санал болгож байгаа үнэт цаасыг арилжих нөхцөл, журам, төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрүүд зэрэг мэдээлэлд Хуулийн фирмийн зүгээс дүн шинжилгээ хийгээгүй болохыг дурдаж байна.

Долоо. Үнэт цаас гаргагч Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн хяналтыг хэрэгжүүлэгч этгээдийн хувьд үзвэл:

Үнэт цаас гаргагчийн хяналтыг хэрэгжүүлэгч этгээдийг тодорхойлох асуудлын хүрээнд Хуулийн фирм нь Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдэгдэж байгаа аливаа асуудлаар саналын давуу эрхтэй, эцсийн шийдвэрийг гаргахад саналын давуу эрхээрээ шууд нөлөөлөх боломжтой хувьцаа эзэмшигчийг жинхэнэ хяналт хэрэгжүүлэгч этгээд гэж тооцож авч үзэж тогтоохыг зорьсон.

ҮЦТХТ-ийн 2021 оны 03 сарын 01-ний өдрийн №01/201 тоот Хариу хүргүүлэх тухай албан бичгээс Үнэт цаас гаргагчийн гаргасан энгийн хувьцааны бүртгэлийг харвал төвлөрсөн хадгаламжид Эрдэнэс Тавантолгой ХК-ийн хувьцааны бүртгэл 2021 оны 02 сарын 23-ны өдрийн байдлаар үнэт цаас гаргагчийн гаргасан нийт энгийн хувьцааны 65.19%-д ногдох хувьцааг төр өөрийн мэдэлдээ эзэмшиж байна. Үлдсэн энгийн хувьцааг 486 (дөрвөн зуун наян зургаан) ширхэг аж ахуй нэгж болон Монгол Улсын 2512768 (хоёр сая таван зуун арван хоёр мянга долоон зуун жаран найм) иргэн эзэмшиж байна.

2021.03.04

Хуулийн дүгнэлт гаргаж өгөх өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй тогтоолуудаас харахад иргэд, аж ахуй нэгжийн эзэмшиж байгаа Үнэт цаас гаргагчийн гаргасан хувьцааны 14.80% болох 2,219,288,901 (хоёр тэрбум хоёр зуун арван есөн сая хоёр зуун наян найман мянган есөн зуун нэг) ширхэг хувьцаа нь саналын эрхгүй байна гэж дүгнэх хууль зүйн үндэслэлтэй байна.

Эдгээр мэдээлэл дээр тулгуурлан харвал Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн нийт гаргасан хувьцааны 65.19%-ийг эзэмшиж байгаа этгээд дангаараа хувьцааны хоёрдох зах зээлийн арилжаа эхлэх хүртэл хугацаанд хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэх этгээд байна гэж Хуулийн фирмээс дүгнэж үзлээ.

Хуулийн дүгнэлт гаргах өдрийн байдлаар Засгийн газрын 2018 оны 08 сарын 08-ны өдрийн №245 дугаар тогтоолоор Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн төрийн мэдлийн хувьцааны хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрыг томилсон баримтыг Үнэт цаас гаргагч танилцуулсан. Иймээс нэгтгэж дүгнэж үзвэл Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн хяналтыг хэрэгжүүлэгч этгээд нь төр, түүнийг төлөөлж Засгийн газрын томилсноор төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар байна гэж Хуулийн фирмээс үзлээ.

Засгийн газрын 2018 оны 08 сарын 29-ний өдрийн хуралдааны №36 тоот тэмдэглэлээс харвал төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэхэд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам 70%, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар 30% оролцоотой байхаар хэлэлцсэн үйл баримтыг Үнэт цаас гаргагчаас гаргаж өгсөн болохыг давхар уламжилж байна.

Тус асуудлын хүрээнд дурдах асуудал нь ҮЦТХТ-ийн тодорхойлолт албан бичгээс харвал төрийн мэдлийн хувьцааны эрхийг хэрэгжүүлэгч төрийн өмчийн төлөөлөгчөөр Эрдэнэс Монгол ХХК-ийг бүртгэж тодорхойлсон байна. Иймд тус бүртгэлд өөрчлөлт оруулж Засгийн газрын томилсноор төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрыг бүртгүүлэх нь цаашдын үл ойлголцол үүсэхээс сэргийлэх ач холбогдолтой гэж үзэж Үнэт цаас гаргагчид зөвлөмж болгон үүгээр уламжилж байна.

Мөн түүнчлэн Үнэт цаас гаргагчийн гаргаж өгсөн мэдээлэл, эдгээр компаниудын дүрэм, хуулийн этгээдийн бүртгэлийн дэлгэрэнгүй лавлагаанаас харвал Эрдэнэс-Тавантолгой ХК нь дараах хуулийн этгээдүүдийн энгийн хувьцааг эзэмшдэг болохыг дурдаж байна.

Хүснэгт 5. Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн эзэмшиж буй хувьцаа, хөрөнгө оруулалтын задаргаа

№	Компанийн нэр	Хувь оролцоо
1.	Гашуун сухайт авто зам ХХК	40%
2.	Тавантолгой төмөр зам ХХК	66%
3.	Гашуун сухайт төмөр зам ХХК	17%
4.	Тавантолгой дулааны цахилгаан станц ХХК	30%
5.	Зүүнбаян төмөр зам ХХК	66%

КТХ-ийн 6 дугаар зүйлд хараат болон охин компанийн талаарх зохицуулалтыг хуульчилсан байдаг. Тус зохицуулалтын дагуу компанийн нийт гаргасан энгийн хувьцааны 20-50 хувийг өөр /толгой/ компани дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа тохиолдолд уг компанийг хараат компани, 50 аас дээш хувийг өөр /толгой/ компани дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдтэй

2021.03.26

хамтран эзэмшдэг бие даасан компанийг охин компани гэж тооцохоор хуульчилсан байна. Эдгээр мэдээлэл дээр үндэслэж харвал Үнэт цаас гаргагч нь Зүүнбаян төмөр зам ХХК, Тавантолгой төмөр зам ХХК гэсэн 2 (хоёр) охин компанитай байх бөгөөд Гашуун сухайт авто зам ХХК, Тавантолгой дулааны цахилгаан станц ХХК гэсэн 2 (хоёр) хараат компанитай байна.

Үнэт цаас гаргагчтай зэргэлдээ компаниудын хувьд КТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.15 дахь хэсэгт "Нэг толгой компанийн хараат болон охин компаниуд, эсхүл нэг этгээд дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран хувьцааных нь хяналтын багцыг эзэмшдэг компаниудыг зэргэлдээ компани гэнэ" гэж тодорхойлсон байх тул Үнэт цаас гаргагч Эрдэнэс-Тавантолгой ХК нь төрийн эзэмшилд хяналтын багц нь байгаа төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой компаниудтай зэргэлдээ компанид тооцогдоно гэж үзлээ.

Дэлгэрэнгүй мэдээллийг Хуулийн дүгнэлтээс харна уу.

2021.03.26

ТAVAN
ЭРДЭНЭС
ТАВАН
ТОЛГОЙ
ХК
ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ
ХК

УЛААНБААТАР ӨДТ
МХБ-ийн гишүүн
Андеррайтер
Брокер, дилерийн
"БНДСХ"
ҮЦХ ХК
15205447 д. 205241

- | № | Хавсралтын нэр |
|------------|---|
| I | Улсын бүртгэлтэй холбоотой мэдээлэл |
| 1 | Улсын Их Хурлын 2010.07.07-ны №39 тогтоол |
| 2 | Засгийн газрын 2010.10.20-ны №272 тогтоол |
| 3 | Төрийн өмчийн хорооны 2010.10.28-ны №425 тогтоол |
| 4 | Эрдэнэс Монгол ХХК-ийн ТУЗ-ийн 2010.12.07-ны №07 тогтоол |
| 5 | Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн 2018 оны 10 сарын 19-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 01 дугаар тогтоол |
| 6 | Санхүүгийн Зохицуулах Хорооноос ирүүлсэн 2020 оны 01 сарын 03-ний өдрийн албан бичиг |
| 7 | Улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар батлуулсан хуулбар |
| 8 | Улсын бүртгэлд бүртгэгдсэн дүрмийн хуулбар |
| II | Хувь нийлүүлсэн хөрөнгө, хувьцаа эзэмшигчтэй холбоотой |
| 9 | Засгийн газрын 2012.05.30-ны №181 тогтоол |
| 10 | Засгийн газрын 2017.05.30-ны №154 тогтоол |
| 11 | Улсын их хурлын 2018.06.29-ны өдрийн №73 тогтоол |
| 12 | Засгийн газрын 2018.08.08-ны №245 тогтоол |
| III | Холбоотой этгээдийн мэдээлэл |
| 13 | Тавантолгой төмөр зам ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар |
| 14 | Тавантолгой төмөр зам ХХК-ийн дүрмийн хуулбар |
| 15 | Засгийн газрын 2019.04.10-ны №135 тогтоол |
| 16 | Засгийн газрын 2019.07.24-ний №304 тогтоол |
| 17 | Эрдэнэс Тавантолгой ХК-ийн ТУЗ-ийн 2019.07.30-ны №31 тогтоол |
| 18 | Гашуунсухайт авто зам ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар |
| 19 | Гашуунсухайт авто зам ХХК-ийн дүрмийн хуулбар |
| IV | Ордтой холбоотой |
| 20 | Монгол Улсын Их Хурлын 2007.02.06-ны өдрийн №27 тогтоол |
| 21 | Тусгай зөвшөөрлийн гэрчилгээнүүд |
| V | Нөөцийн тайлан |
| 22 | Тавантолгой бүлэг ордын нөөцийн тайлангийн нэгтгэл 2018 он |
| 23 | Ашигт малтмалын тухай хуулийн 4.1.26-д заасан мэргэшсэн мэргэжилтэн, шинжээч болох тухай нотлох баримт |
| 24 | Нөөцийн тайланг баталгаажуулсан АМГТГ-ийн тогтоол 2018 он |
| VI | Үйл ажиллагаатай холбоотой |
| 25 | 2016 оны үйл ажиллагааны тайлан |
| 26 | 2017 оны үйл ажиллагааны тайлан |
| 27 | 2018 оны үйл ажиллагааны тайлан |
| 28 | 2019 оны үйл ажиллагааны тайлан |
| 29 | 2020 оны 3-р улирлын байдлаар үйл ажиллагааны тайлан |
| VII | Бүтэц, зохион байгуулалт, Эрх бүхий албан тушаалтантай холбоотой |
| 30 | Бүтэц зохион байгуулалт, тогтоол |
| 31 | Салбарын гэрчилгээ |
| 32 | Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах журам |
| 33 | ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, тогтоол |
| 34 | ТУЗ-ийн гишүүд, ТУЗ-ийн дарга, ТУЗ-ийн нарийн бичгийн дартомилсон тогтоол |
| 35 | ТУЗ-ийн гишүүд, нарийн бичгийн даргын засаглалын гэрчилгээ |
| 36 | ТУЗ-ийн дэргэдэх хороод томилсон тогтоол |
| 37 | ТУЗ-дэргэдэх хороодын үйл ажиллагааны журам, тогтоол |
| 38 | Компаний удирдлагын багийг томилсон тогтоолууд |
| 39 | Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журам |
| 40 | Эрх бүхий албан тушаалтнуудын анкет |

2021.03.26

Эрдэнэс Тавантолгой ХК-ийн Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журам
Эрх бүхий албан тушаалтнуудын анкет

МХБ-ийн гишүүн
Андеррайтер
Брокер, Инвестицийн
"БИЛСЭК"
ХХК
1115205147-111520400

2021-03-19

БҮРТГЭВ-02

- VIII Компанийн засаглал, Ногдол ашиг**
- 41 Компанийн засаглалын кодекс, тогтоол
- 42 Компанийн эрх бүхий байгууллагаар батлуулсан ногдол ашгийн бодлого, тогтоол
- 43 ТУЗ-ийн 2020 оны 02 сарын 17-ны өдрийн 09 тоот тогтоол
- IX Санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой**
- 44 Аудитын байгууллагатай байгуулсан гэрээний хувилбар
- 45 2017 оны аудитын тайлан, дүгнэлт
- 46 2018 оны аудитын тайлан, дүгнэлт
- 47 2019 оны аудитын тайлан, дүгнэлт
- 48 2020 оны санхүүгийн тайлан
- X Бизнес төлөвлөгөө**
- 49 Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн бизнес төлөвлөгөө
- XI ТЭЗҮ**
- 50 Тавантолгойн Цанхийн зүүн хэсгийг ашиглах уурхайн ТЭЗҮ, 2011 он
- 51 ТЭЗҮ-ийг баталгаажуулсан эрх бүхий этгээдийн шийдвэр
- 52 Ашигт малтмалын тухай хуулийн 4.1.26-д заасан мэргэшсэн мэргэжилтэн, шинжээч болох тухай нотлох баримт
- 53 Тавантолгойн Цанхийн баруун хэсгийг ашиглах уурхайн ТЭЗҮ, 2020 он
- 54 Ашигт малтмалын тухай хуулийн 4.1.26-д заасан мэргэшсэн мэргэжилтэн, шинжээч болох тухай нотлох баримт
- XII Эрсдэлийн удирдлагатай холбоотой**
- 55 Эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичиг, журам, баталсан тогтоол
- XIII Үнэт цаас гаргахтай холбоотой**
- 56 Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны 02 сарын 10-ны өдрийн 01/346 тоот албан бичиг
- 57 Хууль зүй, дотоод хэргийн яамны 2021 оны 02 сарын 09-ны өдрийн 1/651 тоот албан бичиг
- 58 Сангийн яамны 2021 оны 02 сарын 09-ний өдрийн 8-1/480 тоот албан бичиг
- 59 Төлөөлөн удирдах зөвлөлийн үнэт цаас гаргах тогтоол
- XIV Үнэт цаас гаргах ажиллагаанд оролцсон этгээд, тэдгээрийн дүгнэлт**
- 60 Тэргүүлэх андеррайтерийн компанийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
- 61 Тэргүүлэх андеррайтер компанийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар
- 62 Андеррайтерийн компаниудтай байгуулсан гэрээний хуулбар
- 63 Дэд андеррайтер, санхүүгийн зөвлөх компанийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
- 64 Дэд андеррайтер, санхүүгийн зөвлөх компанийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар
- 65 Андеррайтерын дүгнэлт
- 66 Үнэлгээний байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
- 67 Үнэлгээний байгууллагын тусгай зөвшөөрлийн хуулбар
- 68 Хуулийн компанийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
- 69 Хуулийн компанийн тусгай зөвшөөрлийн хуулбар
- 70 Хуулийн компанитай байгуулсан гэрээний хуулбар
- 71 Хөрөнгийн болон бизнесийн үнэлгээний тайлан
- 72 Үнэлгээний байгууллагатай хийсэн гэрээний хуулбар

2021.03.19

TAVAN
ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ ХК
JSC

МХБ-ийн гишүүн
Андеррайтер
Боркер, олонийн
"БНДЭС" ХХК-ийн
1110201417 а.т.х.